Барилга, хот байгуулалтын яам
(БХБЯ)

Үндэсний Хөгжлийн газар
(ҮХГ)

Японы Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага
(ЖАЙКА)

# Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл

## Эцсийн тайлан
## Эцсийн тайлан: Нэмэлт тайлан

2021 оны 12-р сар

RECS International Inc.
PADECO Co., Ltd.
Nippon Koei Co., Ltd.

Валютын ханш (2021 оны 05-р сарын 20-ны байдлаар):
1.00 төгрөг = 0.00038 ам. доллар
1.00 төгрөг = 0.04 иен
Эх үүсвэр: OANDA.COM (http://www.oanda.com)

Бүлэг 1 Төслийн танилцуулга .......... 1-1
1.1 Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн хэрэгжилтийн хугацааг сунгах талаар Хэлэлцүүлгийн тэмдэглэлд өөрчлөлт оруулах .......... 1-1
1.2 Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацааны үйл ажиллагаа .......... 1-2
Бүлэг 2 ХАНСХЕТ, БХБ-ын төсөлд хүргүүлсэн санал, зөвлөмж .......... 2-1
2.1 БХБЯ, БХТ, ҮХГ-тай хийсэн үйл ажиллагаа .......... 2-1
2.2 БХБЯ, БХТ-д хүргүүлсэн, тэднээс ирүүлсэн бичгүүд болон нэмэлт мэдээлэл 2-3
2.3 ҮХГ-т хүргүүлсэн, тэднээс ирүүлсэн бичгүүд болон нэмэлт мэдээлэл .......... 2-4
2.4 Төслийн сүүлийн зөвлөлдөх хурал .......... 2-4
Бүлэг 3 Хяналт-шинжилгээ, үнэлгээ .......... 3-1
3.1 Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт .......... 3-1
3.1.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ .......... 3-1
3.1.2 Хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, хариуцлагын хуваарилалт .......... 3-1
3.1.3 ТХҮБ 2030-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дагаж мөрдөх хууль, дүрэм, журам .......... 3-3
3.1.4 Бусад бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ .......... 3-6
3.1.5 Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан .......... 3-11
3.2 Япон Улсын үндэсний хөгжлийн төлөвлөгөөнүүд .......... 3-12
3.3 Санал, зөвлөмж .......... 3-15
Бүлэг 4 Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг тусгах .......... 4-1
4.1 "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, ХАНСХЕТ, БХҮБ .......... 4-1
4.2 Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулах .......... 4-10
4.3 Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт ба ҮХЦТ-нд тусгасан гол төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа .......... 4-13
4.4 Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг .......... 4-16
4.5 АХБ-ны Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах төсөлтэй хамтран ажиллах, уялдаа холбоог хангах нь .......... 5-1
4.6 Уялдаа холбоог хангах үйл ажиллагаа .......... 5-1
4.7 Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөө .......... 5-4
4.8 Тодорхой асуудлуудыг шийдвэрлэх .......... 5-5
Бүлэг 5 ҮХЦТ-г сурталчлан таниулах үйл ажиллагаа .......... 6-1
5.1 Сурталчлан таниулах семинар .......... 6-1
5.2 ҮХЦТ-г сурталчлан таниулах видео танилцуулга .......... 6-14
Бүлэг 6 Дүгнэлт .......... 7-1
6.1 Төслийг хэрэгжүүлсэн хугацаа болон хөгжлийн шинэ загвар руу шилжих хэрэгцээ, шаардлага .......... 7-1
6.2 ҮХЦТ-ний хүрээнд хөгжлийн шинэ загвар руу шилжих нь .......... 7-1
6.3 ҮХЦТ ба хөгжлийн шинэ загвар руу шилжихтэй холбоотой сорилт .......... 7-2

Зураг 3.2.1 Бүсчилсэн хөгжлийн хяналтын тогтолцоог Үндэсний хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд шинэчилсэн дүр зураг .......... 3-14
Зураг 7.3.1 Тээвэр, логистик, харилцаа холбооны сүлжээнд үр дүнтэйгээр холбосон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластер .......... 7-4

Хүснэгт 2.1.1 Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд (2021 оны 7-12 сар) хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаа ........................................ 2-1
Хүснэгт 2.1.2 Төслийн багийн Япон мэргэжилтнүүдийн Монгол Улсад дахь үйл ажиллагаа (2021 оны 10-р сарын 10~29) .............................. 2-2
Хүснэгт 3.1.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчийн эрх, үүрэг (хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх)................................................ 3-2
Хүснэгт 3.2.1 “Эргэлтийг дэмжсэн газрын сан” концепцэд тулгуурласан Япон улсын үндэсний хөгжлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний индексүүд.................................................................... 3-14
Хүснэгт 4.1.1 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй хөгжлийн алсын хараа........................................................... 4-1
Хүснэгт 4.1.2 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан хөгжлийн хувилбарууд, оновчтой хувилбар ................................. 4-2
Хүснэгт 4.1.3 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд тооцсон ДНБ, хүн амын хэтийн төлөв .................................................................. 4-3
Хүснэгт 4.1.4 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан макро түвшний хөгжлийн зорилтууд............................................. 4-3
Хүснэгт 4.1.5 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан хөгжлийн стратеги ........................................................................ 4-4
Хүснэгт 4.1.6 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан хөгжлийн хувилбарууд.................................................................. 4-5
Хүснэгт 4.2.1 ҮХЦТ болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан авто замын төслүүд ......................................................................4-11
Хүснэгт 4.3.1 Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт ба ҮХЦТ-нд тусгасан гол төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа ............................. 4-13
Хүснэгт 5.3.1 Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн багтай хийсэн хэлэлцүүлэг, санал болон ЖАЙКА-гийн Төслийн багийн тодруулга......................................................................................... 5-5
Хүснэгт 6.1.1 ҮХЦТ боловсруулах төслийн семинарт оролцогчдын санал, зөвлөмж........................................................................................ 6-3

# Бүлэг 1 Төслийн танилцуулга

## 1.1 Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн хэрэгжилтийн хугацааг сунгах талаар Хэлэлцүүлгийн тэмдэглэлд өөрчлөлт оруулах

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг (ҮХЦТ) үе шаттайгаар сайжруулан боловсруулсан. ҮХЦТ боловсруулах төслийн Дунд хугацааны тайланг 2019 оны 12 дугаар сарын 15-нд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. ЖАЙКА-гийн Төслийн баг болон Монголын талын хамтран ажиллагч байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд ҮХЦТ боловсруулах төслийн Эцсийн тайлангийн төсөл 1 болон Салбарын тайланг боловсруулж, 2020 оны 6 дугаар сарын 30-нд холбогдох байгууллагуудад хүлээлгэж өгсөн. Төслийн Хамтарсан зохицуулах хорооны (ХЗХ) 4 дүгээр хурал дээр Эцсийн тайлангийн төсөл 1-ийг танилцуулж, хэлэлцүүлсэн бөгөөд Монголын тал тус тайланд тусгасан хөгжлийн загвар, алсын харааг ерөнхийд нь дэмжсэн. Төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурлаар УИХ-ын сонгуулийн дараа шинээр эмхлэгдэн байгуулагдах Засгийн газарт ҮХЦТ боловсруулах төслийн Эцсийн тайлангийн төсөл 1-ийг танилцуулах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд Монгол, Японы талууд ҮХЦТ-г илүү боловсронгуй болгох тал дээр хамтарч ажилласаар байна.

Төслийн ХЗХ-ны гишүүдээс ҮХЦТ боловсруулах төслийн Эцсийн тайлангийн төсөл 1-тэй холбоотойгоор олон тооны санал ирүүлсэн. ҮХЦТ боловсруулах төслийн Салбарын тайлан болон Эцсийн тайлангийн төсөл 1-д эдгээр саналуудыг тусгаж, Эцсийн тайлангийн төсөл 2-ын эхний хувилбарыг боловсруулж, 2020 оны 12 дугаар сарын 15-нд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусгаж, Төслийн Эцсийн тайлангийн төсөл 2-ыг боловсруулан 2020 оны 2 дугаар сарын 28-нд холбогдох байгууллагуудад хүлээлгэж өгсөн.

Төслийн Эцсийн тайлангийн төсөл 2-ыг Төслийн ХЗХ-аар хэлэлцүүлээгүй боловч холбогдох бүх яам, агентлаг, ХАНСХЕТ-ийн Зөвлөх багийн гишүүдээс санал ирүүлсэн. Бүхий л саналыг тусгаж, ҮХЦТ-ний төслийн Эцсийн тайлангийн төсөл 3 болон Салбарын тайланг боловсруулж, 2021 оны 6 дугаар сарын 29-нд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Үүний зэрэгцээ БХБЯ, БХТ, ҮХГ-тай цуврал уулзалтуудыг зохион байгуулж, Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан төлөвлөлт, саналыг БХБЯ, БХТ-ийн боловсруулж буй Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл болон ҮХГ-ын боловсруулж буй Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд хэрхэн тусгах талаар хэлэлцсэн.
Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл болон Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах ажил төлөвлөсөн хугацаанаасаа хоцорсон тул ЖАЙКА нь БХБЯ, ҮХГ-тай хэлэлцэж, ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийн хугацааг “Төсөл хэрэгжүүлэх хугацааг сунгахтай холбоотой цаашдын үйл ажиллагаа”-нд заасны дагуу сунгахаар тохиролцов (Хавсралт А). Тиймээс 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр гарын үсэг зурсан Хэлэлцүүлгийн тэмдэглэлд 2021 оны 6 дугаар сарын 30-нд нэмэлт өөрчлөлт оруулсан.

## 1.2 Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацааны үйл ажиллагаа

ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийн хугацааг 2021 оны 7 дугаар сараас 12 дугаар сарыг дуустал сунгах хугацааны Үйл ажиллагааны төлөвлөгөөг (Хавсралт B) боловсруулж, БХБЯ болон ҮХГ-т хүргүүлсэн. ЖАЙКА-гийн Төслийн багаас төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурлын өмнөх уулзалтыг зохион байгуулж, Үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар хэлэлцэхийг санал болгосон боловч Монгол Улсад COVID-19 халдварын тархалтыг хязгаарлах арга хэмжээ болон Үндэсний баяр наадмын амралтын өдрүүдээс шалтгаалан тус уулзалтыг зохион байгуулаагүй болно. ЖАЙКА-гийн Төслийн баг нь БХБЯ, БХТ болон ҮХГ-тай ХАНСХЕТ, БХҮБ боловсруулах ажлын талаар албан бичгээр санал солилцсон.

Бүлэг 2-т үзүүлснээр БХБЯ, БХТ болон ҮХГ-ын зүгээс ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг ХАНСХЕТ, БХҮБ-д хэрхэн тусгах талаар санал солилцсон. 2021 оны 8 дугаар сарын 27-нд төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурлын өмнөх уулзалтыг цахимаар зохион байгуулсан. Уулзалтаар ҮХГ болон БХТ-ийн зүгээс ХАНСХЕТ, БХҮБ-ыг боловсруулж буй ажлын явцын талаар танилцуулж, ХАНСХЕТ, БХҮБ-ыг боловсруулахад тулгамдаж буй асуудал болон нэмэлт мэдээлэл шаардлагатай байгаа талаар дурдлаа. ЖАЙКА-гийн Төслийн баг боломжит нэмэлт мэдээллийг хүргүүлсэн.

Монгол Улсад томилолтоор ажиллах хугацааны ажлын төлөвлөгөөг боловсруулж, ажлын хуваарийг БХБЯ, БХТ, ҮХГ-тай зөвшилцсөн. Ялангуяа төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурал, төслийн семинарын товыг тогтож, хөтөлбөрийг хамтран боловсруулсан. 12 дугаар сарын 10-наас 29-ны хооронд Монгол Улсад томилолтоор ажилласан. Төслийн багийн гишүүд Улаанбаатар хотод хүрэлцэж ирээд тусгаарлагдах хугацаандаа төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурал, төслийн семинарын хуваарь, хөтөлбөрийг нарийвчлан боловсруулж, холбогдох мэргэжилтнүүдтэй и-мейлээр болон цахимаар холбогдож төслийн видео танилцуулгыг бэлтгэсэн.

“Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны (ТХЗХ) тавдугаар хурлыг 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Төрийн ордонд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга даргалж хуралдуулав. Төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурлын үеэр Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд тусгасан төлөвлөлт, саналуудыг хэрэгжүүлэх зорилгоор Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, ҮХЦТ-г өргөн хүрээний оролцогч талуудад танилцуулж, Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд санал болгож буй хөгжлийн шинэ загварын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх талаар хоёр тал санал нэгдэв. “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны тавдугаар хурлын тэмдэглэлийг Хавсралт С-д үзүүлэв. Бүлэг 6-д ҮХЦТ-ний хүрээнд зохион байгуулсан семинар болон төслийн видео танилцуулгын талаар дэлгэрэнгүй тайлбарлав.

Хавсралт А: ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэх үйл ажиллагаа

## 1. ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэх үйл ажиллагаа (ҮХГ-тай тохиролцсон)

(Төслийн хэрэгжилтийг сунгах талаар судалж байгаа бөгөөд Төслийн багтай зөвшилцөнө)

Удиртгал

1) ЖАЙКА-гаас баталсан удирдамжид заасан бүх шаардлагыг хангаж байгаа тул ҮХЦТ боловсруулах төслийн Эцсийн тайлангийн төсөл 2-ыг 2021 оны 2 дугаар сард холбогдох байгууллагуудад хүргүүлэхэд бэлэн болсон.

2) 2021 оны 6 дугаар сард холбогдох байгууллагуудаас төслийн Эцсийн тайлангийн төсөл 2-т ирүүлсэн саналд үндэслэн Эцсийн тайланг боловсруулах ажил үлдэж байна. Ирүүлсэн саналтай холбогдуулан Монголын тал болон ЖАЙКА-гийн төслийн баг хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд мөн хариу тайлбарыг хүргүүлсэн болно.

3) БХБЯ-ны боловсруулж буй ХАНСХЕТ, ҮХГ-ын боловсруулж буй БХҮБ-д ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг хэрхэн тусгах вэ гэдэг асуудал тулгарч байна.

4) ХАНСХЕТ болон БХҮБ-ыг боловсруулж, УИХ-д өргөн барихад дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл хэрэгжих хугацааг сунгахаар төлөвлөж байгаа бөгөөд төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэх үйл ажиллагааг тодорхойлсон.

(1) Төслийн хэрэгжилтийн хугацааг сунгах болон төслийн Эцсийн тайлангийн төсөл 3-ыг боловсруулж, хүргүүлэх

Төслийн Эцсийн тайлангийн төсөл 3-ыг холбогдох байгууллагуудад хүргүүлсний дараа төслийн хэрэгжилтийн хугацааг 6 сараар сунгаж, ҮХЦТ боловруулах төсөл 2021 оны 12 дугаар сарыг дуустал үргэлжилнэ.

(2) БХҮБ/БХНХ-ын төслийг боловсруулах

2021 оны 6 дугаар сарыг дуустал төсөл хэрэгжих хугацаанд ҮХГ нь ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг тусгаж Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (БХҮБ) болон Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийн (БХНХ) төслийг боловсруулна.

ҮХГ нь эхний ээлжинд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дараа нь Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг тус тус боловсруулж, УИХ-д өргөн барина. Тиймээс ҮХГ болон ЖАЙКА нь БХҮБ, БХНХ-ийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх талаар санал нэгдсэн бөгөөд ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХГ-аас ирүүлсэн БХНХ боловсруулахтай холбоотой санал, хүсэлтэд зөвлөгөө өгнө.

(3) ЖАЙКА-гийн Төслийн багийн ажил үүрэг

ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд ЖАЙКА-гийн төслийн баг ҮХГ-т БХҮБ, БХНХ-ийн төслийг эцэслэн боловсруулахад зөвлөгөө өгөх бөгөөд ҮХГ-тай хамтран БХҮБ, БХНХ-тэй холбоотой олон нийтийн санал хүсэлтэд хариу тайлбар өгөх, УИХ-ын чуулганаар хэлэлцэх үед асуултад хариулах зэргээр дэмжлэг үзүүлнэ. ЖАЙКА-гийн Төслийн баг нь ҮХЦТ болон БХҮБ, БХНХ-д тусгагдсан аливаа зөрүүтэй төлөвлөлт, саналыг ҮХГ-т мэдэгдэх

болно.

(4) Тоо мэдээлэл болон ЖАЙКА-гийн Төслийн багийн зөвлөгөө

ҮХГ нь БХҮБ, БХНХ-ийн төслийг боловсруулахтай холбогдуулан ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан төлөвлөлтийн тоо мэдээллийг авах хүсэлтэй байгааг ЖАЙКА хүлээн зөвшөөрсөн. ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-г боловсруулахад ашигласан хөрш зэргэлдээ аймгуудын ижил төстэй байдлын үнэлгээ, аймгуудын хөгжлийн дүн шинжилгээнд ашигласан мэдээлэл зэрэг бүх тоо мэдээлэл нь төслийн Эцсийн тайлангийн төсөл 2-т тусгагдсаныг танилцуулсан.

ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХГ-ын хүссэн сумын түвшний нарийвчилсан мэдээлэлд үндэслэсэн дүн шинжилгээ, аргачлал нь ҮХЦТ боловсруулах ажлын удирдамжид зааснаар хамааралгүй болохыг тодруулж, тайлбарласан. ЖАЙКА-гийн Төслийн баг нь ҮХГ-ын хүсэлтийн дагуу ҮХЦТ боловсруулахад ашигласан тоо мэдээлэлд үндэслэсэн дүн шинжилгээ, аргачлалыг тайлбарлана.

(5) Төсөл хэрэгжиж дууссаны дараах үйл ажилалгаа

Төслийн хэрэгжилтийг сунгасан нь онцгой тохиолдолд тооцогдох бөгөөд ЖАЙКА болон ҮХГ нь Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулж, УИХ-д өргөн барих хүртэл хүчин чармайлт гарган ажиллана. Төслийн хэрэгжилтийн хугацааг цаашид дахин сунгахгүй бөгөөд төсөл хэрэгжиж дууссаны дараа ҮХГ нь БХҮБ, БХНХ-ийн төслийг эцэслэн боловсруулна.

## 2. ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэх үйл ажиллагаа (БХБЯ-тай тохиролцсон)

(Төслийн хэрэгжилтийг сунгах талаар судалж байгаа бөгөөд Төслийн багтай зөвшилцөнө)

Удиртгал

1) ЖАЙКА-гаас баталсан удирдамжид заасан бүх шаардлагыг хангаж байгаа тул ҮХЦТ боловсруулах төслийн Эцсийн тайлангийн төсөл 2-ыг 2021 оны 2 дугаар сард холбогдох байгууллагуудад хүргүүлэхэд бэлэн болсон.

2) 2021 оны 6 дугаар сард холбогдох байгууллагуудаас төслийн Эцсийн тайлангийн төсөл 2-т ирүүлсэн саналд үндэслэн Эцсийн тайланг боловсруулах ажил үлдэж байна. Ирүүлсэн саналтай холбогдуулан Монголын тал болон ЖАЙКА-гийн төслийн баг хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд мөн хариу тайлбарыг хүргүүлсэн болно.

3) БХБЯ-ны боловсруулж буй ХАНСХЕТ, ҮХГ-ын боловсруулж буй БХҮБ-д ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг хэрхэн тусгах вэ гэдэг асуудал тулгарч байна.

4) ХАНСХЕТ болон БХҮБ-ыг боловсруулж, УИХ-д өргөн барихад дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл хэрэгжих хугацааг сунгахаар төлөвлөж байгаа бөгөөд төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэх үйл ажиллагааг тодорхойлсон.

(1) Төслийн хэрэгжилтийн хугацааг сунгах болон төслийн Эцсийн тайлангийн төсөл 3-ыг боловсруулж, хүргүүлэх

Төслийн Эцсийн тайлангийн төсөл 3-ыг холбогдох байгууллагуудад хүргүүлсний

дараа төслийн хэрэгжилтийн хугацааг 6 сараар сунгаж, ҮХЦТ боловруулах төсөл 2021 оны 12 дугаар сарыг дуустал үргэлжилнэ.

(2) ХАНСХЕТ-ын төслийг боловсруулах

2021 оны 6 дугаар сарыг дуустал төсөл хэрэгжих хугацаанд БХБЯ нь ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг тусгаж Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн төслийг боловсруулна.

(3) ЖАЙКА-гийн Төслийн багийн ажил үүрэг

ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд ЖАЙКА-гийн төслийн баг БХБЯ-нд ХАНСХЕТ-ийн төслийг эцэслэн боловсруулахад зөвлөгөө өгөх бөгөөд БХБЯ-тай хамтран ХАНСХЕТ-тэй холбоотой олон нийтийн санал хүсэлтэд хариу тайлбар өгөх, УИХ-ын чуулганаар хэлэлцэх үед асуултад хариулах зэргээр дэмжлэг үзүүлнэ. ЖАЙКА-гийн Төслийн баг нь ҮХЦТ болон ХАНСХЕТ-д тусгагдсан аливаа зөрүүтэй төлөвлөлт, саналыг БХБЯ-нд мэдэгдэх болно.

(4) Тоо мэдээлэл болон ЖАЙКА-гийн Төслийн багийн зөвлөгөө

БХБЯ нь ХАНСХЕТ-ийн төслийг боловсруулахтай холбогдуулан ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан төлөвлөлтийн тоо мэдээллийг авах хүсэлтэй байгааг ЖАЙКА хүлээн зөвшөөрсөн. ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-г боловсруулахад ашигласан бүх тоо мэдээлэл нь төслийн Эцсийн тайлангийн төсөл 2-т тусгагдсаныг танилцуулсан.

(5) Төсөл хэрэгжиж дууссаны дараа

Төслийн хэрэгжилтийг сунгасан нь онцгой тохиолдолд тооцогдох бөгөөд ЖАЙКА болон БХБЯ нь Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн төслийг эцэслэн боловсруулж, УИХ-д өргөн барих хүртэл хүчин чармайлт гарган ажиллана. Төслийн хэрэгжилтийн хугацааг цаашид дахин сунгахгүй бөгөөд төсөл хэрэгжиж дууссаны дараа БХБЯ нь ХАНСХЕТ-ийн төслийг эцэслэн боловсруулна.

Хавсралт В: ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийн хугацааг 2021 оны 7 дугаар сараас 12 дугаар сарыг дуустал сунгах хугацааны Үйл ажиллагааны төлөвлөгөө

## ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийн хугацааг 2021 оны 7 дугаар сараас 12 дугаар сарыг дуустал сунгах хугацааны Үйл ажиллагааны төлөвлөгөө

### 1. Удиртгал

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага нь Монгол Улсын Засгийн Газрын хүсэлтээр Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн хэрэгжилтийн хугацааг 2021 оныг дуустал сунгахаар шийдвэрлэсэн. Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны талаар ЖАЙКА болон ҮХГ, ЖАЙКА болон БХБЯ тус тус хэлэлцсэн бөгөөд 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр гарын үсэг зурж, 2021 оны 6 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн Хавсралтад тусгасан тохиролцоонд хүрэв.
Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд БХБЯ/БХТ-ийн боловсруулж буй Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл болон ҮХГ-ын боловсруулж

буй Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд дэвшүүлсэн санал, зөвлөмжийг хэрхэн тусгах талаар хэлэлцсэн. Энэхүү хугацаанд ЖАЙКА-гийн Төслийн баг нь БХБЯ/БХТ, ҮХГ-т ХАНСХЕТ болон БХҮБ-д Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд дэвшүүлсэн саналыг тусгахтай холбоотой хүсэлтэд санал, зөвлөмж өгөх бөгөөд олон нийтийн саналд хариу өгөх болон УИХ-аар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд улс төрийн болон бусад нөхцөл байдлын өөрчлөлтийн улмаас Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага тулгарсан тохиолдлоос бусдаар ЖАЙКА болон Монголын тал ҮХЦТ-д өөрчлөлт оруулахгүй байхаар тохиролцов.

## 2. Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэх үйл ажиллагаа

Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэх гол үйл ажиллагааг доор дурдав. Үүнд:

1) БХБЯ болон ҮХГ-т Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал боловсруулахад тус тус зөвлөмж өгөх,
2) ХАНСХЕТ болон БХҮБ-тай холбоотой олон нийтийн санал, УИХ-аар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
3) МХХТ-ийн инкубацийн талаарх семинар зохион байгуулах,
4) ҮХЦТ-г сурталчлах видео бүтээх, Монгол Улсад болон/буюу Японд хөрөнгө оруулалтын хурал, семинар зохион байгуулах,
5) ҮХЦТ-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
6) Төслийн төгсгөлийн тайлан боловсруулах.

## 3. Үйл ажиллагаа, аргачлал

### (1) Тогтмол уулзалт

ЖАЙКА-гийн Төслийн баг болон Монголын талын холбогдох байгууллагууд уулзалтыг тогтмол зохион байгуулж, ХАНСХЕТ, БХҮБ боловсруулж буй ажлын явц, тухайн баримт бичгийн агуулгатай холбоотой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. ЖАЙКА-гийн Төслийн баг нь "Алсын хараа 2050" баримт бичигт тусгасан Бүсчилсэн хөгжлийн агуулгыг Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөтэй нийцүүлэх үүднээс бүсийн хөгжлийн алсын хараа, хөгжлийн стратеги, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр бүхий Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг эдийн засгийн бүс тус бүрээр хэлэлцэхийг санал болгож байна.

Тухайлбал эдийн засгийн А бүсийн хөгжлийн алсын хараа, хөгжлийн стратеги, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг доор дурдсанаар боловсруулна. Үүнд:

1) ЖАЙКА-гийн Төслийн баг бүсийн хөгжлийн алсын хараа, хөгжлийн стратеги, хот, суурины хөгжил болон нийгэм, эдийн засгийн хөгжлийг хамарсан төсөл хөтөлбөр бүхий эдийн засгийн А Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийн талаар танилцуулга хийх,
2) ҮХЦТ-ий санал, шийдлийг Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгахтай холбоотой асуудлыг хэлэлцэх,
3) Эдийн засгийн А бүсийн талаарх хэлэлцүүлгийн үр дүнг нь БХБЯ/БХТ, ҮХГ нь ХАНСХЕТ болон БХҮБ-ын Бүсчилсэн хөгжлийн агуулгад тусгах,
4) "Алсын хараа 2050" баримт бичгийн хүрээнд БХБЯ/БХТ, ҮХГ-ын боловсруулсан эдийн засгийн А бүсийн хөгжлийн талаар хэлэлцүүлэг хийх.

Эдийн засгийн бүх бүсийг хамруулан дээр дурдсаны дагуу 6-7 уулзалт хийх боломжтой. Шаардлагатай бол зарим уулзалтыг баримт бичиг боловсруулж,

хүргүүлэх замаар орлуулж болох юм. Мөн ХАНСХЕТ, БХҮБ-ын хүрээнд орон зайн хөгжил, нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв, МХХТ-ийг нэвтрүүлэх зэрэг тодорхой сэдвүүдээр хэлэлцүүлэг хийх хурал, уулзалтыг зохион байгуулна. БХБЯ/БХТ, ҮХГ-тай хэлэлцэх өөр нэг сэдэв нь хяналт шинжилгээ, үнэлгээ юм. ЖАЙКА-гийн Төслийн баг нь Монголын талтай хамтран хөгжлийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн болон хийж байгаа туршлагын талаар тодруулж, "Алсын хараа 2050", ХАНСХЕТ, БХБ-ын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, үйл ажиллагааны талаар зөвлөмж өгнө.

**(2) МХХТ-ийн инкубацийн талаарх семинар**

ҮХЦТ боловсруулах төслийн хүрээнд бүх салбарт МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх, зарим салбарт МХХТ-ийн төслүүдийг хэрэгжүүлэх, мөн МХХТ-ийг хөгжүүлэх, нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санал болгосон. Хувийн хэвшлийн үйл ажиллагаанд МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой МХХТ-ийн инкубацийн талаарх семинарыг Төслийн баг ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтарч зохион байгуулна. МХХТ-ийн төслүүдэд хөрөнгө оруулах боломжтой хөрөнгө оруулагчдыг семинарт урин оролцуулж, бизнесийн саналуудыг хүлээж авна. Хэрэгжих боломжтой саналын бизнесийн төлөвлөгөөг боловсруулахад Төслийн багаас дэмжлэг үзүүлэх боломжтой.

ҮХЦТ боловсруулах төслийн хүрээнд МХХТ-ийн салбар болон академи хоорондын хамтын ажиллагааг дэмжих туршилтын төслийг хэрэгжүүлсэн бөгөөд хувийн хэвшил, их, дээд сургуулиуд, судалгааны институтууд, төрийн байгууллагууд цаашид үргэлжлүүлэн хамтран ажиллахаар санамж бичигт гарын үсэг зурсан. Туршилтын төслийн хүрээнд ашигласан хамтын ажиллагааны бүтцийг МХХТ-ийн инкубацийн талаарх семинар, үйл ажиллагааны бэлтгэлийг хангахад ашиглаж болно.

**(3) ҮХЦТ-г сурталчлан таниулах үйл ажиллагаа**

ҮХЦТ боловсруулах төслийн талаарх ойлголтыг өргөжүүлэх үүднээс сурталчлан таниулах видеог хийж байсан. ҮХЦТ-д санал болгосон төлөвлөлтийг олон нийтэд илүү таниулах, тодорхой салбаруудад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, ҮХЦТ-ийн хэрэгжилтийг сурталчлах зорилгоор видео контент хийнэ. Энэхүү видео контентийг ЖАЙКА-гийн Төслийн баг, БХБЯ, ҮХГ-тай хамтран Улаанбаатар эсвэл Токио хотод зохион байгуулах хөрөнгө оруулалтыг дэмжих сэдэвт семинарын үеэр ашиглана.

**(4) Эцсийн тайлан боловсруулах болон бусад үйл ажиллагаа**

Төслийн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор ҮХЦТ-г ХАНСХЕТ, БХБ-д тусгах зорилгоор шаардлагатай бусад үйл ажиллагааг хийж гүйцэтгэж болно. Төслийн баг нэмэлт ажлуудыг БХБЯ, БХТ, ҮХГ-тай хамтран төлөвлөж, гүйцэтгэнэ. Нэмэлт ажил нь Төслийн багаас ихээхэн оролцоо, хугацааг шаардах тохиолдолд Монголын тал нэмэлт ажлыг хийж гүйцэтгэх талаар ЖАЙКА-д хүсэлт тавина.

Төслийн баг төслийн Эцсийн тайланг боловсруулж, 2021 оны 12-р сарын сүүлээр Монголын талд хүргүүлнэ. ҮХЦТ-г эцсийн байдлаар боловсруулж хүргүүлэхээс гадна төслийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлуудыг тайлагнасан Нэмэлт тайланг Эцсийн тайланг дагалдуулан хүргүүлж болно.

## 4. Ажлын төлөвлөгөө

### (1) Ажлын хуваарь

Дээрх үйл ажиллагааг 2021 оны 7-р сараас 12-р сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ. Монгол болон Япон улс дахь COVID-19-ийн нөхцөл байдлаас шалтгаалж БХБЯ, БХТ, ҮХГ-тай хийх хурал, уулзалтуудыг цахимаар зохион байгуулна. Ингэхийн тулд Төслийн багийн монгол ажилтнууд болон төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд нягт хамтарч ажиллана.

Цар тахлын нөхцөл байдал сайжирсан тохиолдолд Төслийн багийн мэргэжилтнүүд Монгол Улсад богино хугацаанд томилогдож ажиллана. Мэргэжилтнүүдийн томилолтын хугацааг эцэслэн товлоогүй байгаа бөгөөд 9-р сард 15 хоногийн хугацаанд ажиллахаар урьдчилан төлөвлөөд байна. Япон мэргэжилтнүүд Монгол Улсад ажиллах хугацаанд БХБЯ, БХТ, ҮХГ-тай уулзалтуудыг зохион байгуулж, семинар зохион байгуулна. ҮХЦТ-г сурталчлан таниулах видеог 9-р сарын эхээр боловсруулж дуусгана. Зураг 1-д ажлын хуваарийг үзүүлэв.

**Зураг 1 Төслийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэх ажлын хуваарь**




### (2) Мэргэжилтнүүдийн ажиллах хуваарь

Дээрх үйл ажиллагааг хийж гүйцэтгэхийн тулд Зураг 2-т үзүүлсэн хуваарийн дагуу Төслийн багаас 4-5 гадаадын мэргэжилтэн томилогдон ажиллана. Төслийн багийн мэргэжилтнүүдийн томилолтын хугацааг 9-р сард 15 хоног байхаар урьдчилан төлөвлөөд байгаа ба төслийн удирдагчаас гадна 2-3 гадаадын мэргэжилтэн томилогдон ажиллана.

Төслийн баг Монгол Улс дахь COVID-19-ийн нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсад томилогдон ажиллах болон үйл ажиллагааны хуваарьтай холбоотой төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж болно.

**Зураг 2 Төслийг сунгасан хугацаанд томилогдож ажиллах Төслийн багийн мэргэжилтнүүдийн хуваарь**



Хавсралт C:

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ, ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР**

**ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА**

**ХООРОНД БАЙГУУЛСАН**

**“ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН**

**ТӨСЛИЙН ХАМТАРСАН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТАВДУГААР ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хот

____________________
Эрико Тамура
ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга

____________________
Ц.Нямдорж
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

____________________
Цүёоши Хашимото
ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч

____________________
С.Магнайсүрэн
Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга

____________________
Х.Батжаргал
Үндэсний хөгжлийн газрын дарга

“Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны (ТХЗХ) тавдугаар хурлыг 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга удирдаж, Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ), Үндэсний хөгжлийн газар (ҮХГ), холбогдох яамны бодлого төлөвлөлтийн газрын дарга, ахлах мэргэжилтэн болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын (ЖАЙКА) төлөөллүүдийн оролцоотойгоор зохион байгуулав.

ТХЗХ-ны хурал дээр ЖАЙКА-гийн Төслийн баг (ЖТБ) нь “Эцсийн тайлангийн төсөл 2”-той холбоотой холбогдох яамд, байгууллагууд, зөвлөх, мэргэжилтнүүдээс авсан саналуудыг тусгаж, шинэчлэн боловсруулсан Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө бүхий “Эцсийн тайлангийн төсөл 3”-ыг танилцуулсан. Хурлын үр дүнд талууд ҮХЦТ-нд тусгасан төлөвлөлт, саналуудыг оролцогч талуудад танилцуулж, хэлэлцүүлэх, БХБЯ, БХТ-ийн боловсруулж буй Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл (ХАНСХЕТ), ҮХГ-ын боловсруулж буй Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (БХҮБ)-д тусгах тал дээр санал нэгдэв.

1. Доорх асуудлуудыг хэлэлцэн, тохиролцов. Үүнд:
   (1) 2019 оны 1 дүгээр сараас ЖАЙКА-гийн Төслийн баг болон Монголын талын холбогдох байгууллагууд хамтран ажиллаж Эцсийн тайлангийн төсөл 3-т тусгагдсан Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний эцсийн хувилбарыг боловсруулсан. Тодруулбал Монголын талын холбогдох байгууллагуудаас Эцсийн тайлангийн төсөл 2-той холбоотойгоор хүлээж авсан бүх саналыг Эцсийн тайлангийн төсөл 3-т тусгасан.
   (2) Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА нь Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахад Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний төлөвлөлт, саналыг тусгаж дэмжлэг үзүүлэх зорилгоор Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн хугацааг 2021 оны 7 дугаар сараас 12 дугаар сарыг дуустал сунгахаар хэлэлцэж, тохиролцсон.
   (3) Монголын талын холбогдох байгууллагууд нь Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахдаа Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний төлөвлөлт, саналыг тусгаж ажиллах бөгөөд үүнтэй холбоотойгоор ЖАЙКА-гийн Төслийн баг санал, зөвлөмж өгнө.
   (4) Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд тусгасан төлөвлөлт, саналуудыг хэрэгжүүлэх зорилгоор Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, ҮХЦТ-г өргөн хүрээний оролцогч талуудад танилцуулж, хэлэлцүүлэх, Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд санал болгож буй хөгжлийн шинэ загварын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх талаар хоёр тал санал нэгдэв.
   (5) Хурлын үеэр 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатар хотод Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн семинар, Токио хотод хөрөнгө оруулалтыг дэмжих семинарыг тус тус зохион байгуулах талаар танилцуулав.
   (6) Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн хугацааг 2021 оны 12 дугаар сарыг дуустал сунгасан ч Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах ажил удаашралтай байна. ТХЗХ-ны гишүүд төсөл хэрэгжиж дуусcан ч Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА эдгээр бодлого,

төлөвлөлтийн баримт бичгүүдийн уялдааг хэрхэн хангах талаар цаашид хэлэлцэх шаардлагатай талаар саналаа илэрхийлэв.

(7) Эцсийн тайлангийн төсөл 3-т тусгагдсан Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг эцсийн хувилбар гэж үзэж байгаа бөгөөд ЖАЙКА-гийн Төслийн баг нь Монголын талын холбогдох байгууллагуудын нэмэлт саналуудыг хүлээн авч 2021 оны 12 дугаар сард хүргүүлэх Эцсийн тайланд тусгана.

2. Санал, зөвлөмж, асуулт, хариулт:

ТХЗХ-ны хурлын үеэр дэвшүүлсэн гол санал, зөвлөмжийг доор дурдав. ЖАЙКА-гийн Төслийн багийн хариултыг "➔" тэмдгээр тэмдэглэв.

(1) ҮХГ: Үндэсний хөгжлийн газар болон Төслийн баг бүх аймагт томилолтоор ажиллаж, одоогийн нөхцөл байдал, хөгжлийн нөөц бололцооны талаар судалсан. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан саналыг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр тусгахаар төлөвлөж байна.

(2) ЗГХЭГ: БХБЯ нь Сумын хөгжил төсөл, арга хэмжээг Засгийн Газраар батлуулсан. Тус баримт бичиг энэхүү төлөвлөгөөтэй хэрхэн уялдаж байна вэ? Мөн бусад яамдын боловсруулж, батлуулахаар зэхэж буй төлөвлөгөөнүүд энэхүү төлөвлөгөөтэй хэрхэн уялдаж байна вэ?
БХБЯ: 2021 оны 6 дугаар сард "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээг Засгийн газраар батлуулсан. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлтэй бодлогын хувьд уялдсан.
ЖТБ: Миний бие АХБ-ны "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр"-ийн багтай уулзаж, Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө болон аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөнүүд уялдаж байгаа талаар санал нэгдсэн.

(3) БОАЖЯ: Бүсийн хөгжлийн алсын хараанд ногоон эдийн засгийг хөгжүүлэх, үйлдвэрлэл, хэрэглээг ТХЗ-той нийцүүлэн тусгасан нь БОАЖЯ-ны бодлоготой уялдаж байна.

(4) ЗГХЭГ: "Алсын хараа 2050"-ын зорилтуудыг амбицтай зорилтууд байна гэсэн байна. "Алсын хараа 2050"-ын 73 шалгуур үзүүлэлт дээр тооцоолол хийж үзсэн үү? Зөрүү гарч байсан уу? Амбицтай гэж үзэж байгаа бол ямар хэмжээнд зөрүү гарч байсан бэ? КОВИД 19-ын нөхцөл байдлыг харгалзан тооцож үзсэн үү?
   ➔ Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө болон "Алсын хараа 2050" баримт бичигт тусгагдсан хүн амын хэтийн тооцоо нийцэж байна. Төслийн баг хүн ам, эдийн засгийн өсөлтийн хэтийн төлвийг хооронд нь уялдуулж тооцсон. Хөдөлмөрийн бүтээмжийг салбараар тооцсон тооцооллоос эдгээр үзүүлэлтүүд хэрхэн уялдаж байгааг харах боломжтой. Хөдөлмөрийн бүтээмжийг бүхий л салбарт ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг хангах шаардлага тулгарч байгаа тул амбицтай зорилт гэж үзэж байна. Төслийн баг КОВИД 19-ын нөхцөл байдлыг тооцож үзсэн.

(5) ЗГХЭГ: ТХЗ-той уялдсан Монгол Улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, онцлогт тохирсон ямар бодлогын саналуудыг хүргүүлж байна вэ?
   ➔ ТХЗ-ууд нь ТХҮБ 2030-ын суурь баримт бичиг юм. Төслийн Үндсэн тайлангийн Бүлэг 2-т "Алсын хараа 2050"-д агуулгаараа багтсан ТХҮБ 2030-ын зорилтуудын хэрэгжилтийн дэлгэрэнгүй үнэлгээг хийсэн.

(6) ЗГХЭГ: Хуульд заасан 7 чиглэлээр (хөгжлийн зорилтот хөтөлбөр) бодлогын зорилго, зорилтуудын саналууд юу байна вэ?
 ➔ Бид хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулж байна гэсэн ойлголттой байгаа бөгөөд үүний нэг болох Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд Төслийн баг нь ҮХГ-тай хамтран ажиллаж байна. Төслийн баг салбаруудын хөгжлийн төлөвлөлтөд ҮХЦТ-ний саналуудыг судалж, тусгана гэж найдаж байна. Ингэхдээ ТХЗ-уудын хоорондын уялдаа холбоог тодорхойлж, Монгол Улсын хөгжлийн цогц төлөвлөгөөнд аль зорилт нь илүү ач холбогдолтой болохыг тодорхой болгох боломжтой.

(7) ЗГХЭГ: Туршилтын төслүүдийн санал нь 2021-2025 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй аль хэр уялдаж байгаа вэ? Тооцож үзсэн үү?
 ➔ Төслийн баг ҮХЦТ-нд тусгасан зарим саналуудын хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор туршилтын төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлсэн. Цаг хугацаанаас хамааран 5 туршилтын төслийг хэрэгжүүлсэн. Туршилтын төслүүд нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөлд хамрагдахгүй. Анх туршилтын төслүүдийг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөлд тусгуулах төлөвлөгөөтэй байсан. Туршилтын төслүүдийг ерөнхийдөө хэрэгжүүлж дууссан.

(8) ЗГХЭГ: ЗГХЭГ-аас 4 дүгээр сард тайлангийн төсөлд саналаа хүргүүлсэн. Саналыг хэрхэн тусгасан бэ?
 ➔ Төслийн баг Эцсийн тайлангийн төсөл 2-той холбоотой саналыг холбогдох яамд, байгууллагууд, зөвлөх, мэргэжилтнүүдээс бичгээр авсан. Эдгээрээс цөөн тооны санал Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд хамаарахгүй санал байсан бөгөөд ЗГХЭГ-ын саналуудыг Эцсийн тайлангийн төсөл 3-т тусгаж оруулсан.

(9) БШУЯ: Бүсчилсэн хөгжлийн талаарх асуудлыг хэлэлцэхэд боловсролын салбартай холбоотойгоор их, дээд сургуулиудыг бүсүүдэд байгуулж, хөгжүүлэх асуудал хөндөгддөг. Өнгөрсөн 7 хоногт 3 аймаг руу их, дээд сургуулиудыг шилжүүлэх асуудлыг хэлэлцсэн. Аймаг, орон нутагт ажиллахад аймгуудын хөгжлийн загварт боловсролын салбарын хөгжлийг хэрхэн тусгах талаар ямар санал, дүгнэлт гарсан бэ?
 ➔ Орон нутагт их, дээд сургуулиудыг байгуулж, хөгжүүлэх төлөвлөлтийг санал болгоогүй. Харин одоо байгаа их, дээд сургуулиудыг хөгжүүлэх саналыг түлхүү тусгасан. Тухайлбал Ховд хотод дээд боловсрол, судалгаа шинжилгээний төвийг хөгжүүлэх, чацаргана боловсруулахтай холбоотой судалгаа хийх, Дорнодын их сургуулийг судалгаа, инкубацийн бааз болгон хөгжүүлэх, Алтай хотод боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын сургалтын төвийг хөгжүүлэх зэрэг саналуудыг тусгасан.

(10) БШУЯ: Нийслэлийн бүсийн хөгжлийн төлөвлөлт, саналууд Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлтэй хэр нийцэж байгаа вэ? Төслийн баг энэхүү төлөвлөгөөний төсөлд саналаа өгсөн үү?
 ➔ Төслийн баг Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулж байгаа талаар мэдээлэлтэй байсан бөгөөд Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний саналууд болон тус төлөвлөгөөний төсөлд ихээхэн зөрүүтэй асуудал байхгүй гэж үзэж байна.

(11) ЭХЯ: Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд бүс нутгийг холбосон цахилгаан дамжуулах сүлжээ, эх үүсвэрүүдийг холбож, орон нутгийг цахилгаанжуулах ажлыг эрчимжүүлэх төлөвлөлтүүд ногоон хөгжлийн зорилтууд руу түлхүү чиглэсэн байсан. Хоёр аймагт ногоон эрчим хүчийг хөгжүүлэхээр тусгасан. Гэхдээ үндэсний онцлогт тохирсон эрчим хүчний эх үүсвэрүүдийг барьж байгуулах, эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ бий болгох зорилтууд орхигдсон тал байна. Үүнийг дунд хугацааны зорилтот хөтөлбөрт түлхүү тусгах шаардлагатай байна.

- ➔ Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд эрчим хүч үйлдвэрлэх, эрчим хүчний сүлжээг өргөтгөхтэй холбоотойгоор нарийвчилсан төлөвлөлтүүд тусгагдаагүй бөгөөд Ховд аймагт УЦС-ын төслийг хэрэгжүүлэх болон импортын эрчим хүчний хамаарлыг бууруулах зорилгоор эрчим хүчний сүлжээг өргөтгөх төлөвлөлтүүдийг тусгасан. ЭХЯ-ны төлөвлөж, хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнээс гадна нүүрс ашигладаг том хэмжээний ДЦС ашиглалтад оруулах, нийт нутаг дэвсгэрийг хамарсан эрчим хүчний сүлжээг өргөтгөх төлөвлөлт төдийлөн байхгүй. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлж, эрчим хүчний сүлжээг сайжруулах санал, төлөвлөлтүүдийг онцолсон.

(12) ЭХЯ: Аймгийн төвүүдийн дулаан хангамжийг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх асуудал Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд дурдагдах төдий байсан. Түүнтэй хобоотой барилга байгууламжуудын чанарыг сайжруулах, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэхэд энэ асуудал чухал ач холбогдолтой юм.

- ➔ Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд дулаан хангамжтай холбоотой төлөвлөгөөг ерөнхийд нь тусгасан. Хөдөө, орон нутгийн дулаан хангамжийн төлөвлөгөө нь улсын түвшний хөгжлийн төлөвлөгөөний хувьд хэт нарийвчилсан төлөвлөгөө юм.

3. ЗГХЭГ-ын даргын үг, санал

Төслийн багт Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулсанд талархал илэрхийлье. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл хэрэгжиж эхэлсний дараа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсан. Мөн Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталсан. Эдгээр нь хууль эрх зүйн шинэ орчныг үүсгэж байна. 2022 онд шинээр Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулах саналыг Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг эцэслэхдээ энэхүү хоёр яам байгуулагдах төлөвлөгөөг тооцно гэж бодож байна. Цаашид хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой асуудал ЭЗХЯ дээр төвлөрнө. Өөрөөр хэлбэл Та бүгдийн хийсэн ажил энэ яамаар дамжиж, Засгийн газарт санал оруулж, шийдвэр гарч, хэрэгжинэ гэсэн үг.

Баруун бүсэд 3 аймгийг хамруулахаар тусгасан байна. Завхан аймгийг Хангайн бүсэд оруулж, Говь-Алтай, Баянхонгор аймгийг Говийн бүсэд оруулсан байна. Монголын хүн амын бүтэц, үндэстэн, ястантай холбогдолтой нарийн асуудлууд байдаг тул энэ бүсчлэлийг эргэн харна уу. 2003 онд БХҮБ-ыг боловсруулсан бөгөөд тэр үед энэ асуудлыг нухацтай авч хэлэлцэж байсныг дурдах нь зүйтэй.

Өнгөрсөн 30 жилд Монгол Улсад эрс шилжилтүүд гарсан. Энэ бүх хугацаанд Монголын ард түмнийг дэмжиж ирсэн Японы Засгийн газар, ЖАЙКА байгууллагад

талархаж, амжилт хүсч байна.

4. Төслийн үйл ажиллагааны хуваарь

(1) 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр ҮХЦТ боловсруулах төслийн семинарыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр Улаанбаатар хотод зохион байгуулна.
(2) ҮХЦТ-нд тусгасан төлөвлөлт, саналтай холбоотойгоор хувийн хэвшлийн үйл ажиллагаанд МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 11 дүгээр сард МХХТ-ийн инкубацийн талаарх семинарыг зохион байгуулна.
(3) ҮХЦТ-д үндэслэн хөрөнгө оруулалтыг дэмжих семинарыг 2021 оны 12 дугаар сард Токио хотод онлайнаар зохион байгуулна.

Төгсөв.

Хавсралт:

(1) Эцсийн тайлангийн төсөл 3-ын хураангуй
(2) Хуралд оролцогчдын нэрсийн жагсаалт
(3) 2021 оны 6 дугаар сард шинэчилсэн Төслийн Хэлэлцүүлгийн тэмдэглэл

# Бүлэг 2 ХАНСХЕТ, БХБ-ын төсөлд хүргүүлсэн санал, зөвлөмж

## 2.1 БХБЯ, БХТ, ҮХГ-тай хийсэн үйл ажиллагаа

Төслийн баг төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд (2021 оны 7-12 сар) БХБЯ, БХТ, ҮХГ-тай ХАНСХЕТ, БХҮБ-ыг боловсруулахад ҮХЦТ-г тусгах тал дээр хамтарч ажилласан. COVID-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас голчлон цахим уулзалтууд, имэйлээр дамжуулж холбогдож, хамтарч ажилласан бөгөөд Төслийн багийн Япон мэргэжилтнүүд 2021 оны 10-р сарын 10-29-ны хооронд Монгол Улсад томилогдон ажилласан. Хүснэгт 2.1.1-д төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааг, Хүснэгт 2.1.2-т Төслийн багийн Япон мэргэжилтнүүдийн Монгол Улсад дахь үйл ажиллагааг нэгтгэн үзүүллээ.

**Хүснэгт 2.1.1 Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд (2021 оны 7-12 сар) хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаа**

| Хугацаа | Үйл ажиллагаа | Тайлбар |
|---|---|---|
| 7-р сарын 7 | Үндэсний баяр наадмын дараа төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурлын өмнөх уулзалтыг зохион байгуулах тухай санал хүргүүлсэн. | Зохион байгуулагдаагүй. |
| 7-р сарын 14 | Төслийг хэрэгжилтийг сунгасан хугацааны Үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлсэн. | ҮХГ, БХТ-өөс санал хүсэлт хүлээн авсан. |
| 7-р сарын 27 | Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотойгоор БХТ-өөс ирүүлсэн санал, хүсэлтийн хариултыг хүргүүлсэн. | |
| 7-р сарын 29 | Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотойгоор ҮХГ-аас ирүүлсэн санал, хүсэлтийн хариултыг хүргүүлсэн. | |
| 8-р сарын 5 | Бүсүүдийн тоо мэдээлэл болон дүн шинжилгээг (нарийвчилсан, шинэчилсэн мэдээлэл) хүргүүлсэн. | |
| 8-р сарын 10 | Хамтарсан зохицуулах хорооны хурлын өмнөх уулзалтыг зохион байгуулах тухай санал хүргүүлсэн. | Хамтарсан зохицуулах хорооны хурлын өмнөх уулзалтыг 8-р сарын 27-нд зохион байгуулахаар тохиролцсон. |
| 8-р сарын 18 | Хамтарсан зохицуулах хорооны хурлын өмнөх уулзалтын хөтөлбөрийг боловсруулж, хүргүүлсэн. | |
| 8-р сарын 25 | Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотойгоор БХБЯ-наас ирүүлсэн санал, хүсэлтийн хариултыг хүргүүлсэн. | БХБЯ-ны саналыг 8-р сарын 24-нд ирүүлсэн. |
| 8-р сарын 27 | Хамтарсан зохицуулах хорооны хурлын өмнөх уулзалтыг зохион байгуулсан. | БХТ, ҮХГ-аас ХАНСХЕТ, БХҮБ-ыг боловсруулж буй ажлын явцыг танилцуулсан. |
| 9-р сарын 3 | ҮХГ-т ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан “Бүсүүдийн хөгжлийн | Хамтарсан зохицуулах хорооны хурлын өмнөх уулзалтаар |

| | | |
|---|---|---|
| | нэгдсэн хөтөлбөр"-ийг хүргүүлсэн. | хэлэлцсэн асуудлуудад хариулт хүргүүлсэн. |
| 9-р сарын 6 | БХТ-д "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхөд усны балансын шинжилгээг харгалзан үзэх нь" материалыг хүргүүлсэн. | Хамтарсан зохицуулах хорооны хурлын өмнөх уулзалтаар хэлэлцсэн асуудлуудад хариулт хүргүүлсэн. |
| 9-р сарын 13 | БХТ-өөс ирүүлсэн санал, хүсэлтийн хариултыг хүргүүлсэн. | |
| 9-р сарын 23 | Улаанбаатар хотод томилолтоор ажиллах төлөвлөгөөг боловсруулсан. | Төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан. |
| 9-р сарын 28 | АХБ-ны "Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөө" төслийн талаарх материалыг хүргүүлсэн. | АХБ-ны төслийн баг 8 аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөг ирүүлсэн. |
| 9-р сарын 28 | БХБЯ-ны ХБГХБХЗГ-ын даргатай ХАНСХЕТ-ийг боловсруулж буй ажлын явц болон томилолтоор ажиллах хугацаанд хийж гүйцэтгэх ажлын талаар онлайн уулзалт хийсэн. | |
| 10-р сарын 1 | Төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурал болон ҮХЦТ-ний семинарын хөтөлбөрийг боловсруулж, хүргүүлсэн. | |
| 10-р сарын 10~29 | Улаанбаатар хотод томилолтоор ажилласан. | Хүснэгт 2.1.2-оос дэлгэрэнгүй тайланг үзнэ үү. |
| 11-р сарын 29 | БХТ-д "Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн багтай хийсэн хэлэлцүүлэг"-ийн талаарх материалыг хүргүүлсэн. | |
| 12-р сарын 8 | БХБЯ/БХТ, ҮХГ-тай сүүлчийн зөвлөлдөх хурлыг зохион байгуулсан. | |

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Хүснэгт 2.1.2 Төслийн багийн Япон мэргэжилтнүүдийн Монгол Улсад дахь үйл ажиллагаа (2021 оны 10-р сарын 10~29)

| Огноо | Төслийн багийн үйл ажиллагаа |
|---|---|
| 10-р сарын 10 | Монгол Улсад ирсэн. |
| 11 | Ажлын төлөвлөгөө, хуваарийг баталгаажуулсан. |
| 12 | АХБ-ны төслийн багтай уулзах талаар холбогдсон. Төслийн видео контентын явцтай танилцсан. |
| 13 | Төслийн видеод санал өгсөн. Семинар зохион байгуулах газартай танилцсан. |
| 14 | Төслийн семинарын танилцуулгыг боловсруулсан. |
| 15 | Төслийн видеог хийхтэй холбоотойгоор цахим уулзалт хийсэн. |
| 16 | АХБ-ны төслийн багийн боловсруулсан хөгжлийн төлөвлөлтүүд, хотын зэрэглэлийн саналыг судалсан. |
| 17 | ТХЗХ-ны 5-р хурлын танилцуулгыг боловсруулсан.<br>Усны балансын шинжилгээг судалсан. |
| 18 | ҮХГ-ын Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Эрдэнэбаяр даргатай цахим уулзалт хийсэн.<br>АХБ-ны төслийн багийн боловсруулсан төлөвлөлт, саналуудад өгөх саналыг боловсруулсан. |
| 19 | Дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөртэй холбоотой хууль тогтоомжийг судалсан. ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрынхантай онлайн уулзалт хийсэн. |
| 20 | ҮХЦТ-г сурталчлах семинарын хөтөлбөрийг эцэслэсэн. ТХЗХ-ны 5-р |

| | |
|---|---|
| | хуралд танилцуулах илтгэлийг бэлтгэсэн. |
| 21 | МУ-д ажиллах ажлын хуваарийг шинэчилсэн. Монголын талын өндөр албан тушаалтнуудад зориулсан танилцуулга материал бэлтгэсэн. |
| 22 | ГХЯ-ны Ази, Номхон далайн орнуудын газрын захирал Э. Сарантогостой цахим уулзалт хийсэн.<br>ҮХЦТ-г сурталчлах семинарын хөтөлбөрийг эцэслэсэн. |
| 23 | ХАНСХХ, ҮХЦТ-ийн зарим зөрүүтэй асуудлуудын талаар АХБ-ны төслийн багтай мэдээлэл солилцсон. |
| 24 | |
| 25 | БХБЯ-ны ХБГХБХЗГ-ын дарга Ц.Баярбаттай уулзалт хийсэн.<br>АХБ-ны төслийн багийн ҮХЦТ-тэй холбоотой саналтай танилцсан. |
| 26 | АХБ-ны төслийн багтай зөвлөлдөх уулзалт хийсэн.<br>ТХЗХ-ны 5-р хурлыг зохион байгуулсан. |
| 27 | ҮХЦТ-г сурталчлах семинарыг зохион байгуулсан.<br>Бүсийн дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулах АХ-т ҮХЦТ-нд тусгагдсан бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийг танилцуулсан. |
| 28 | БХБ-ын дэд сайдтай уулзалт хийсэн. БХТ-тэй уулзалт хийсэн.<br>Японы Элчин сайдын яамд ажлын тайлан танилцуулсан. |
| 29 | Монгол Улсаас Япон Улс руу буцсан. |

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

## 2.2 БХБЯ, БХТ-д хүргүүлсэн, тэднээс ирүүлсэн бичгүүд болон нэмэлт мэдээлэл

Төсөл хэрэгжих хугацааг сунгахтай холбоотойгоор БХБЯ болон БХТ-өөс Төслийн багийн хийх ажлын саналыг ирүүлсэн. Тус бүлгийн Хавсралт А-д тэдний санал болон Төслийн багийн хүргүүлсэн хариуг хавсарган оруулсан.

ТХЗХ-ны өмнөх уулзалтын үеэр БХБЯ, БХТ-өөс 1) бүсчлэл, 2) төлөвлөлтийн шийдэл, 3) хотуудын чиг үүрэг, 4) засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлт, 5) гол замын сүлжээний төлөвлөлтийн талаар танилцуулсан. Хавсралт В-д үзүүлсэнчлэн Төслийн баг БХБЯ/БХТ-өөс танилцуулсан асуудлуудтай холбогдуулан саналыг боловсруулж, хүргүүлсэн.

Төслийн баг ТХЗХ-ны өмнөх уулзалтын үеэр ҮХЦТ-ийн хүрээнд хийгдсэн усны балансын шинжилгээг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх буюу сумдыг нэгтгэхтэй холбоотой ХАНСХЕТ-ийн төлөвлөлтөд харгалзан үзэх саналыг танилцуулсан. Хавсралт С-д үзүүлсэн “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхөд усны балансын шинжилгээг харгалзан үзэх нь” саналыг Төслийн баг боловсруулж, БХТ-д хүргүүлсэн.

ЖАЙКА-гаас дэмжлэг үзүүлж буй макро болон мезо түвшний хөгжлийн төлөвлөлт болон АХБ-наас дэмжлэг үзүүлж буй микро түвшний хөгжлийн төлөвлөлтийн уялдаа холбоог хангах зорилгоор ҮХЦТ болон АХБ-ны ХАНСХХ-ийг боловсруулах үйл ажиллагааг уялдуулах талаар талууд хэлэлцэж, тохиролцсон. Төслийн багууд 2019 оны 9-р сард уулзсанаас хойш COVID-19 цар тахал гарч энэ үйл ажиллагаа ихээхэн хязгаарлагдсан. ЖАЙКА-гийн Төслийн баг АХБ-ны төслийн багийн боловсруулсан Сэлэнгэ, Дархан, Булган, Орхон аймгуудын “Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөө”-ний (АХЧБТ) төслүүдийг 2020 оны 5-р сард, Хэнтий, Баянхонгор, Сүхбаатар, Архангай, Хөвсгөл аймгуудын АХЧБТ төслүүдийг 2021 оны 9-р сард авч танилцсан. Эдгээрийг судалж үзээд АХЧБТ-үүдийн төслийн талаарх санал, дүгнэлтийг боловсруулж БХБЯ, ҮХГ-т хүргүүлсэн (Хавсралт D-г харна уу).

Төслийн баг 10-р сард Монгол Улсад ажиллах үеэрээ АХБ-ны Төслийн багтай уулзаж, ҮХЦТ болон АХЧБТ төслүүд хэр уялдаж байгаа талаар хэлэлцсэн. Уулзалтын тэмдэглэлийг БХТ-д хүргүүлсэн.

## 2.3 ҮХГ-т хүргүүлсэн, тэднээс ирүүлсэн бичгүүд болон нэмэлт мэдээлэл

Төсөл хэрэгжих хугацааг сунгахтай холбоотойгоор ҮХГ-аас Төслийн багийн хийх ажлын саналыг ирүүлсэн. Үүний хариуд Төслийн баг тус бүлгийн Хавсралт E-д үзүүлсэн "Бүсүүдийн тоо мэдээлэл болон дүн шинжилгээ"-г боловсруулж, шинэчилсэн мэдээллийг бүсүүдээр гаргаж ҮХГ-т хүргүүлсэн.

БХБ-д ҮХЦТ-ийн саналуудыг тусгах үйл ажиллагааг дөхөм болгох үүднээс ҮХЦТ-өөс бүсийн хөгжлийн хөтөлбөртэй холбоотой хэсгүүдийг ялгаж ҮХГ-т хүргүүлсэн. Хавсралт F-т үзүүлсэнчлэн бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үе шат, хугацааг тодорхой болгон нарийвчлан боловсруулсан. Үүнийг 10 дугаар сарын 27-ны өдөр Бүсийн дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулах АХ-т танилцуулсан.

Төслийн баг ҮХГ-т АХБ-ны төслийн багийн боловсруулсан АХЧБТ-үүдийн төслийн талаарх санал, дүгнэлтийг хүргүүлж, БХБ-ыг боловсруулахдаа АХЧБТ-үүдэд тусгагдсан дэлгэрэнгүй мэдээлэл, дүн шинжилгээг ашиглахыг зөвлөсөн.

ҮХГ-аас ҮХЦТ-ний аль төлөвлөлт, хувилбарыг БХБ-д тусгах талаар ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газраас тодруулсны дагуу Төслийн баг "БХҮБ-ыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх ҮХЦТ" материалыг бэлдэж, ҮХГ-т хүргүүлсэн (Хавсралт G-г харна уу).

2021 оны 10-р сарын 27-ны өдөр ҮХЦТ-г сурталчлах семинарын дараа ҮХГ-ын зохион байгуулсан бүсийн дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулах АХ-ын уулзалтын үеэр Төслийн баг ҮХЦТ-нд тусгагдсан бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийг танилцуулсан.

## 2.4 Төслийн сүүлийн зөвлөлдөх хурал

2021 оны 12-р сарын 8-ны өдөр БХБЯ, БХТ, ҮХГ-тай төслийн сүүлийн зөвлөлдөх хурлыг цахимаар зохион байгууллаа. БХТ-өөс ХАНСХЕТ-ийг боловсруулах ажлын явц, тус баримт бичигт тусгагдсан томоохон хот, суурин газруудын хүн амын хэтийн тооцоо, хүн амын хэтийн тооцоонд үндэслэсэн төрийн үйлчилгээний хэрэгцээ, шаардлагын судалгаа, усны нөөц, зам, тээврийн сүлжээний бүтээн байгуулалттай уялдуулсан уул уурхайн салбарын хэтийн төлөв, аялал жуулчлалыг хөгжүүлэх кластер, хотын зэрэглэл, логистикийн төвүүд, авто замын сүлжээний төлөвлөлт, бүсчлэл болон сум дундын төвүүдийн талаар танилцуулсан. ҮХГ-тай хамтарч 90 гаруй сум дундын төвийг урьдчилсан байдлаар тогтоосон гэж мэдээлсэн.

ҮХГ-аас БХҮБ, бүсийн дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулах ажлын явцыг танилцуулж, холбогдох яамд болон зөвлөх, мэргэжилтнүүдийн төлөөллөөс бүрдсэн 2 ажлын хэсэг байгуулагдаж дээрх баримт бичгүүдийг ХАНСХЕТ, БХБ болон Улаанбаатар-2040 ерөнхий төлөвлөгөөний төсөлтэй уялдуулан боловсруулахаар ажиллаж байгаа талаар танилцуулсан. ХАНСХЕТ, БХБ-ыг эцэслэн боловсруулж, 2022 онд УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөж байгаа талаар ҮХГ, БХТ мэдээлсэн.

ЖАЙКА-гаас ҮХЦТ боловсруулах төсөл хэрэгжиж дууссаны дараа ХАНСХЕТ болон БХБ-ыг боловсруулах ажлын явцын талаар мэдээлэлтэй байх хүсэлтэй байгаагаа илэрхийлж, ингэхийн тулд тогтмол уулзалтууд хийж байхаар тохиролцсон. Хуралд оролцогчид ҮХЦТ-ийг ХАНСХЕТ, БХБ болон холбогдох хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулахад ашиглаж, түүнийг оролцогч талуудад өргөн хүрээнд хүргэж, танилцуулах хэрэгтэй талаар санал нэгдсэн.

Хавсралт А: БХБЯ, БХТ-өөс ирүүлсэн төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийж гүйцэтгэх ажлын саналын хариу

## 1. Төслийн багийн хариу:

### Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах зөвлөх багийн 2021 оны сүүлийн хагас жилд ажиллах ажлын санал

1.Бүсчилсэн хөгжлийн хуваарийг хэд хэдэн хувилбараар харьцуулан үнэлж, газар зүйн байршил, нийгэм-эдийн таталцалд тулгуурлан оновчтой тодорхойлох

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн Үндсэн тайлангийн 6.1.4 “Эдийн засгийн бүсчлэлийн хувилбарын харьцуулалт” бүлэгт эдийн засгийн бүсчлэлийн 3 хувилбараар харьцуулалт хийсэн. Эдийн засгийн бүсүүдийн газар зүйн болон нийгэм, эдийн засгийн онцлогийг Хүснэгт 6.1.1-д үзүүлсэн 21 аймгийг шалгуур үзүүлэлтээр харьцуулсан байдлаас тодруулан үзэх боломжтой. Түүнчлэн 6.2 “Эдийн засгийн бүсүүдийн онцлог” бүлэгт ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй эдийн засгийн бүсүүдийг тодорхойлоход эдгээр мэдээллийг хэрхэн ашиглаж болох талаар харуулсан. Эдийн засгийн бусад бүсүүдийн хувьд ижил байдлаар хийх боломжтой.

2.Бүсчилсэн хөгжлийн хуваарь болон бодлогыг бодитой, үр дүнтэйгээр ирэх 20 жилд хэрэгжүүлэхэд хууль эрхзүйн орчны болон институцийн түвшинд ямар бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх саналыг тодорхойлж, ямар үр дүнд хүрч болох талаар урьдчилан төсөөлөх

ҮХЦТ-ний хүрээнд Монгол Улсад хөгжлийн удирдлагыг аажмаар, үе шаттайгаар орон нутагт шилжүүлэхийг санал болгосон. Энэ нь “11.2.1 Бүсчилсэн хөгжлийн нөхцөл”-д тусгасан “(5) Монгол Улсын төвлөрлийг сааруулах бодлоготой нийцэж байна. “11.2.2 Санал болгож буй бүсчилсэн хөгжлийн институцийн арга хэмжээ” бүлгийн “(3) Санал болгож буй арга хэмжээ”-нд тусгаснаар институцийн арга хэмжээний хувьд Бүсийн хөгжлийн зөвлөл байгуулах нь зүйтэй. “11.2.1 Бүсчилсэн хөгжлийн нөхцөл”-ийн “(2) Бүсчилсэн хөгжилтэй холбоотой хууль тогтоомж, институцийн өөрчлөлт, шинэчлэл” хэсэгт дурдсанаар Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

Бүсчилсэн хөгжлийн талаарх бодлогын хэрэгжилт, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлэх шаардлагатай. “11.4.4 Алсын хараа 2050”, ХАНСХЕТ, БХБ, ҮХЦТ-ний хяналт-шинжилгээ, үнэлгээ” хэсэгт хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг санал болгосон. Тухайлбал "ҮХЦТ-ний хүрээнд бүсчилсэн хөгжлөөр дамжуулан орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг идэвхжүүлэх зорилготой тул орон нутгийн хүн амын харьцаа нь бүс нутгийн хөгжлийн үр дүнг хэмжих сайн үзүүлэлт юм." Тухайн бүсийн хүн амын тоо нь бүс нутгийн хөгжлийн үр дүнг үнэлэх энгийн боловч сайн үзүүлэлт бөгөөд бүс нутгийн хөгжлийн үр дүнг Улаанбаатараас бусад эдийн засгийн бүсүүдийн нийт хүн амыг хүн амын хэтийн төлвийн тооцоотой харьцуулж үнэлэх боломжтой.

3.Нийслэл Улаанбаатар хотын хүн амын өсөлтийн таамаглалын хувилбарыг газрын гадарга, хот байгуулалтын тохиромжтой байдлын үнэлгээ, дэд бүтэц, хүрээлэн буй орчин, зам тээврийн тогтвортой хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан бодитойгоор үнэлэн тодорхойлж, Улаанбаатар-2040 ерөнхий төлөвлөгөөний концепцитэй уялдуулан тогтвортой хөгжилд хүрч болох арга

замуудыг тодорхойлох

ҮХЦТ-ний хүрээнд Улаанбаатар хотын тэргүүлэх байр суурь цаашид хэвээр хадгалагдах үндсэн дээр нийслэлийн хүн амын хэтийн төлвийг тооцсон. Энэ нь ҮХЦТ-ний үндсэн санаа болох бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн урьдчилсан нөхцөл юм. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын хүн амын хэтийн төлвийг гадаад хүчин зүйлс, нөхцөл байдал, шаардлагад үндэслэн тооцсон. Улаанбаатар хотын хүн амын хэтийн төлвийг дотоод хүчин зүйлс, нөхцөл байдалд үндэслэн тооцвол огт өөр байна. Хүн амын хэтийн төлөвт үндэслэн хотын амьдрах орчныг сайжруулах зорилгоор газар ашиглалт, тээврийн систем болон бусад дэд бүтцийг төлөвлөх боломжтой (харин эсрэгээрээ бус).

Улаанбаатар хотын хүн амын хэтийн төлвийг гадаад хүчин зүйлс, нөхцөл байдалтай уялдуулан тооцсон (аймгуудын хөгжлийн түвшин, нөхцөл байдлаас хамааруулан). Улаанбаатар хотын орчин илүү сайжирснаар нийслэл хот руу чиглэх хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэх бөгөөд хотын орчныг доройтуулна.

4.Хот байгуулалтын инженерийн нэгдсэн дэд бүтцийн төсөл арга хэмжээнүүдийг хот, суурин газруудын зэрэглэл, хүн амын тоо, байгалийн бүстэй уялдуулан нийгэм-эдийн засгийн үр ашигтай байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах. Тухайлбал том, дунд, жижиг хотууд болон жижиг суурин газруудад хүн амын тоо, зэрэглэлийн дагуу нэгдсэн дэд бүтцийг болон бие даасан дэд бүтцүүдийг ач холбогдлын эрэмбээр, бодит хүчин чадалтайгаар Япон болон бусад улс орнуудын туршлагад тулгуурлан тодорхойлох.

ҮХЦТ-ний хүрээнд хотуудын зэрэглэл, чиг үүргийг тодорхойлсон. Жишээлбэл Хангайн бүсийн хотуудын чиг үүргийг доор тоймлон үзүүлэв. Хотуудын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгууламжийг ҮХЦТ-ний Үндсэн тайлангийн 3.5.4 “Хот байгуулалт” бүлгийн “(2) Хот байгуулалтын салбарын хөгжлийн стратеги” хэсэгт тусгаснаар тухайн хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусган төлөвлөх боломжтой.

| Зэрэглэл | Хот | Чиг үүрэг |
|---|---|---|
| Бүсийн хөгжлийн төв хот | Эрдэнэт-Булган | Эрдэнэт: Транзит худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээний төв, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв Медипас эмнэлэг.<br>Булган: Транзит худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээний төв. |
| Аймгийн төв | Дархан | МХХТ, хиймэл оюун ухаан, 5G-г ашиглан газар тариалангийн салбарт инноваци ашиглах, шинэ технологи нэвтрүүлэх төв |
| | Мөрөн | Аялал жуулчлалын зангилаа |
| | Улиастай | Баруун аймгуудын төрийн үйлчилгээний төв. |
| | Цэцэрлэг | Төвийн бүсийн МХХТ-ийн төв,<br>Өвлийн аялал жуулчлалын төв |
| Бусад суурин | Сүхбаатар | Хилийн худалдааны төв. |
| | Алтанбулаг | Худалдааны чөлөөт бүс |

Монгол Улсын цаг уурын өвөрмөц нөхцөл байдалд нийцсэн дэд бүтцийн бүтээн байгуулалтад тавигдах шаардлага болон дэд бүтцийн хөгжил нь санхүүгийн, институцийн болон бусад нөхцөл байдлаас хамаардаг зэргээс үүдэн Япон

болон бусад орны туршлага үр дүнтэй бус байж магадгүй юм. Энэ асуудлыг цаашид судлан үзнэ.

5.Хот байгуулалтын хөгжилд төр-хувийн хэвшлийн түншлэлийг хэрхэн оновчтой хэрэгжүүлэх талаар бусад улсын туршлага, сургамжид тулгуурлан Монголын нөхцлийг харгалзан зөвлөмж гаргах

Ихэнх улс орнуудад, тэр дундаа өндөр хөгжилтэй орнуудад хот байгуулалтын үйл ажиллагааг хувийн хэвшил голчлон хийдэг. Төсвийн байгууллага нь газар ашиглалтын бүсчлэл, барилгын норм, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, газрын татварын систем, нийтийн аж ахуйн үйлчилгээ зэрэгт хяналт тавьж, зохицуулалт хийдэг. Төсвийн байгууллагууд хот байгуулалтын томоохон төслүүдэд шууд оролцох нь ховор байдаг ба ихэнхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулж оролцдог. Төрийн байгууллагуудын үүрэг роль нь ихэвчлэн хувийн хэвшлийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох зэрэг байдаг.

Тухайлбал газар дахин зохион байгуулах үйл ажиллагаа нь дэд бүтэц, амьдрах орчинг сайжруулах хүсэлтэй иргэд, оршин суугчид, төрийн байгууллагуудын оролцоотой хот, суурин газрыг хөгжүүлэх үйл ажиллагаа бөгөөд үүнийг Улаанбаатар хотын гэр хороололд хэрэгжүүлж болно.

6.Шинэ Зуунмод Aerocity дагуул хотыг ирэх 20 жилд төр-хувийн хэвшлийн болоод гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын түншлэл тулгуурлан шинээр байгуулан өрсөлдөх чадвартай хотыг бие даан хөгжүүлэх талаар зөвлөмж гаргах

ҮХЦТ-нд Шинэ Зуунмод хотод нисэх онгоцны буудлын ажилчдын суурьшлын бүс, чөлөөт бүс, дотоодын болон импортын бараа бүтээгдэхүүний худалдааны төвийг барьж байгуулахаар төлөвлөсөн. Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоотойгоор, ТХХТ-ээр шинэ хотыг хөгжүүлэхэд чөлөөт бүс, худалдааны төвийг цогцоор нь барьж байгуулан, хөгжүүлэх нь чухал. Чөлөөт бүсийн хөгжил нь нэмүү өртөг шингэсэн эцсийн бараа бүтээгдэхүүний боловсруулалтад шаардлагатай технологи, загварыг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Орон нутгийн бүтээгдэхүүнийг чөлөөт бүсэд нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болгох боловсруулалтыг хийж, экспортод гаргаж эсвэл дотооддоо худалдааны төвд зарж, борлуулна. Шинээр нэвтрүүлсэн технологи, загварыг аймаг, орон нутаг дахь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ашиглана.

7.Аймгуудын хөгжлийн өрсөлдөх чадварт тулгуурлан ирэх 20 жилд тэргүүлэх чиглэл, болон хэрэгжүүлэх боломжтой төсөл арга хэмжээг ач холбогдлоор эрэмбэлэн тодорхойлж, хэрэгжүүлснээр гарч болох үр дүнг төсөөлөн тодорхойлох

6 бүсийн Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрт (БХНХ) нь ирэх 20 жилд бүсүүдэд хөгжүүлж, хэрэгжүүлэх эдийн засгийн тэргүүлэх чиглэл, төслүүдийг тодорхойлсон. Санал болгож буй эдийн засгийн үйл ажиллагаануудыг анхдагч бүтээгдэхүүн үйлдвэрлэл, анхан шатны боловсруулалт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, дотоод, гадаадын зах зээлд чиглэсэн маркетинг зэргээс бүрдсэн үйлдвэрлэлийн кластерын хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор, ҮХЦТ-нд санал болгосон ерөнхий процедурын дагуу үе шаттайгаар төлөвлөнө. Жишээлбэл мал аж ахуйн кластерыг доор үзүүлсэн гурван үе шаттайгаар хөгжүүлж болно. 1-р шатанд кластерыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, 2-р үе шатанд эхний үе шатны бүтээн байгуулалтын

ТЭЗҮ-ийг боловсруулна. Хүрэх үр дүн, зорилтуудыг ТЭЗҮ-д тусгана.




8.Монгол Улсын хотуудын өрсөлдөх чадварт тулгуурлан ирэх 20 жилд тэргүүлэх чиглэл, болон хэрэгжүүлэх боломжтой төсөл арга хэмжээг ач холбогдлоор эрэмбэлэн тодорхойлж, хэрэгжүүлснээр гарч болох үр дүнг төсөөлөн тодорхойлох

Монгол Улсын хотуудын өрсөлдөх чадвар нь хүн ам, эдийн засгийн бүтэц, байгалийн нөөц, баялаг, хүн, соёлын нөөц, дэд бүтэц, эрх зүйн байдал, бусад хот, бүс нутгуудад нэвтрэх боломж гэх мэт олон хүчин зүйлээс хамаарна. ҮХЦТ-нд санал болгосон бүсийн хуваарь нь бүс нутгийн өрсөлдөх чадварыг илэрхийлнэ. Хотуудын өрсөлдөх чадвар нь тухайн бүс дэх байрлалаас хамаарна. Тухайн хот нь хотын зэрэглэлийн аль зэрэглэлд багтаж байгаагаас шалтгаалж бүсэд ямар байрлал, байр суурьтай байх нь тодорхойлогдох ба энэ нь ҮХЦТ-нд тусгасан хотын чиг үүрэгтэй холбоотой байна. Том хотуудын чиг үүрэгт логистикийн төв, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах бааз, аялал жуулчлалын зангилаа хот байх зэрэг тэргүүлэх чиглэл, үйл ажиллагаа багтаж байна.

9.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, Япон болон бусад улсын туршлага, сургамжид тулгуурлан үе шаттайгаар өөрчлөх талаар зөвлөмж гаргах

Нутаг дэвсгэр, засаг захиргааны хамгийн том нэгжийн хувьд буюу бүсийн түвшинд хийх өөрчлөлтийг үе шаттайгаар хийдэггүй. Харин засаг захиргааны бага нэгжүүдийн хувьд хүн амын тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хот, суурин газруудыг нэгтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Япон Улсын туршлагын дагуу Монгол Улсад зарим сум, суурин газруудыг нэгтгэх төлөвлөлтийн хувилбарыг БХТ-ийн БНСТХ-ийн дарга Дааваням танилцуулсан. Аймгийн түвшинд хийх засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг тухайн аймгийн түүх, соёлын уламжлал, улбааг харгалзан нягт судалсны дүнд хийнэ. ҮХЦТ-нд санал болгосончлон эхний үе шатанд бүсийн хуваарийг засаг захиргааны нэгжээр тодорхойлохгүй байснаар эсэргүүцэл, маргаан бага дагуулна гэж үзэж байна. Бүсийн түвшинд төлөвлөлт хийж, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад шаардлагатай гэж үзвэл аймгийн түвшний засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг хийж болно.

10. Хот, суурин газруудын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах журмыг (хот байгуулалтын үнэлгээ, төлөвлөлт) шинэчлэх талаар

санал боловсруулах

ҮХЦТ-ний хот, суурин газрын төлөвлөлттэй холбоотой хэсэгт 1) хотыг дахин хөгжүүлэх, барилга байгууламжийн давхар, талбайн харьцаа, барилга байгууламжийн бүрхэцийн харьцаа болон барилгын бусад норм, дүрэм, журмыг боловсронгуй болгох, газрын татварын тогтолцоог бүрдүүлэх, 2) орон нутгийн гол хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, 3) орон сууцны хангамжийг төлөвлөн хэрэгжүүлэх дүрэм, журмыг боловсруулах, 4) засаг захиргааны нэгж бүрээр хөгжлийн төлөвлөгөөний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болон тавигдах шаардлагыг тодорхойлсон заавар боловсруулах зэрэг санал, зөвлөмжийг тусгасан. Түүнчлэн хот байгуулалтын салбарын хууль, эрх зүйн тогтолцоог шинэчлэх үйл ажиллагааны хүрээнд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэртэй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журмуудыг туршилтын төслийн түвшинд судалсан. Эдгээр санал, зөвлөмж, арга хэмжээг хандивлагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж болно.

БХТ-ийн ХАНБНСТХ-ийн дарга С.Даваанjam

2021.07.24

**2. Төслийн багийн хариу (2021.07.27):**

**ЖАЙКА байгууллагын Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах зөвлөх багийн 2021 оны сүүлийн хагас жилд ажиллах ажлын санал**

<u>Эдийн засгийн бүсчлэл</u>

1.“Эдийн засгийн бүсчлэлийн хувилбарын харьцуулалт”-ын талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, бүс тогтоох шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн Үндсэн тайлангийн 6.1.4 “Эдийн засгийн бүсчлэлийн хувилбарын харьцуулалт” бүлэгт эдийн засгийн бүсчлэлийн 3 хувилбараар харьцуулалт хийсэн. Эдийн засгийн бүсүүдийн газар зүйн болон нийгэм, эдийн засгийн онцлогийг Хүснэгт 6.1.1-д үзүүлсэн 21 аймгийг шалгуур үзүүлэлтээр харьцуулсан байдлаас тодруулан үзэх боломжтой. Түүнчлэн 6.2 “Эдийн засгийн бүсүүдийн онцлог” бүлэгт ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй эдийн засгийн бүсүүдийг тодорхойлоход эдгээр мэдээллийг хэрхэн ашиглаж болох талаар харуулсан. Эдийн засгийн бусад бүсүүдийн хувьд ижил байдлаар хийх боломжтой.

Олон нийтийн хэлэлцүүлэг гэдгээр чухам ямар хэлэлцүүлгийг хэлж байна вэ? 2021 оны 5-р сарын 14-ний өдөр зохион байгуулсан хурлын үеэр бүсчлэл ба бүсүүдийн алсын хараа, стратеги, хөтөлбөрийг боловсруулахтай холбоотойгоор дараах саналуудыг танилцуулсан. Үүнд:

- Шинэ бүсчлэлийг батлахаас өмнө бүх оролцогч талуудыг хамарсан өргөн хүрээний хэлэлцүүлгээр хэлэлцэх шаардлагатай бөгөөд үүнд хугацаа шаардлагатай.
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн дагуу бүсийн хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газар батална.
- Энэ төрлийн хөтөлбөрийг бүх бүсэд хамаарах/үйлчлэх стратегийн хүрээнд боловсруулна.
- Тиймээс ҮХЦТ-д хөгжлийн стратеги, хөтөлбөрүүдийг бүсчлэлийн хуваарийн

хүрээнд санал болгосон.

Хот байгуулалт болон бусад:

2.Хот байгуулалтын инженерийн нэгдсэн дэд бүтцийн төсөл арга хэмжээнүүдийг хот, тосгодын хүн амын тоо, байгалийн нөхцөлтэй уялдуулан нийгэм-эдийн засагт үр ашигтай байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах. Тухайлбал: том, дунд, бага хотууд болон тосгодын хүн амын тоо, байгалийн нөхцөл нөөцийн дагуу нэгдсэн дэд бүтцийг болон бие даасан дэд бүтцүүдийг ач холбогдлын эрэмбээр, бодит хүчин чадалтайгаар Япон болон бусад улс орнуудын туршлагад тулгуурлан тодорхойлох.

ҮХЦТ-ний хүрээнд хотуудын зэрэглэл, чиг үүргийг тодорхойлсон. Жишээлбэл Хангайн бүсийн хотуудын чиг үүргийг доор тоймлон үзүүлэв. Хотуудын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгууламжийг ҮХЦТ-ний Үндсэн тайлангийн 3.5.4 “Хот байгуулалт” бүлгийн “(2) Хот байгуулалтын салбарын хөгжлийн стратеги” хэсэгт тусгаснаар тухайн хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусган төлөвлөх боломжтой.

| Нэр | Хот | Чиг үүрэг |
|---|---|---|
| Бүсийн хөгжлийн төв хот | Эрдэнэт-Булган | Эрдэнэт: Транзит худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээний төв,<br>Бүсийн оношлогоо, эмчилгээний төв Медипас эмнэлэг.<br>Булган: Транзит худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээний төв. |
| Аймгийн төв | Дархан | МХХТ, хиймэл оюун ухаан, 5G-г ашиглан газар тариалангийн салбарт инноваци ашиглах, шинэ технологи нэвтрүүлэх төв |
| | Мөрөн | Аялал жуулчлалын зангилаа |
| | Улиастай | Баруун аймгуудын төрийн үйлчилгээний төв. |
| | Цэцэрлэг | Төвийн бүсийн МХХТ-ийн төв,<br>Өвлийн аялал жуулчлалын төв |
| Бусад суурин | Сүхбаатар | Хилийн худалдааны төв. |
| | Алтанбулаг | Худалдааны чөлөөт бүс |

Монгол Улсын цаг уурын өвөрмөц нөхцөл байдалд нийцсэн дэд бүтцийн бүтээн байгуулалтад тавигдах шаардлага болон дэд бүтцийн хөгжил нь санхүүгийн, институцийн болон бусад нөхцөл байдлаас хамаардаг зэргээс үүдэн Япон болон бусад орны туршлага үр дүнтэй бус байж магадгүй юм. Энэ асуудлыг цаашид судлан үзнэ.

2020 оны 12-р сарын 15-ны өдөр БХТ-ийн БНСТХ-ийн дарга Даваанямд хүргүүлсэн саналын хариуд Японд 5,001-ээс дээш хүн амтай хот, тосгонд “төвлөрсөн шугам сүлжээ”-гээр, 101-ээс 5,000 хүртэлх хүн амтай жижиг хот, тосгонд “бага оврын усны байгууламж”-аар дамжуулан усаар хангадаг талаар танилцуулж байсан. Бусад улс орнуудын энэ төрлийн туршлага, стандарт нь Монгол Улсын онцлогт тохирохгүй байх магадлалтай байдаг.

3.Хот байгуулалтын хөгжилд төр-хувийн хэвшлийн түншлэлийг хэрхэн оновчтой хэрэгжүүлэх талаар бусад улсын туршлага, сургамжид тулгуурлан Монголын нөхцөлийг харгалзан зөвлөмж гаргах;

Ихэнх улс орнуудад, тэр дундаа өндөр хөгжилтэй орнуудад хот байгуулалтын үйл

ажиллагааг хувийн хэвшил голчлон хийдэг. Төсвийн байгууллага нь газар ашиглалтын бүсчлэл, барилгын норм, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, газрын татварын систем, нийтийн аж ахуйн үйлчилгээ зэрэгт хяналт тавьж, зохицуулалт хийдэг. Төсвийн байгууллагууд хот байгуулалтын томоохон төслүүдэд шууд оролцох нь ховор байдаг ба ихэнхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулж оролцдог. Төрийн байгууллагуудын үүрэг роль нь ихэвчлэн хувийн хэвшлийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох зэрэг байдаг.

Тухайлбал газар дахин зохион байгуулах үйл ажиллагаа нь дэд бүтэц, амьдрах орчинг сайжруулах хүсэлтэй иргэд, оршин суугчид, төрийн байгууллагуудын оролцоотой хот, суурин газрыг хөгжүүлэх үйл ажиллагаа ба үүнийг Улаанбаатар хотын гэр хороололд хэрэгжүүлж болно.

4. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, Япон болон бусад улсын туршлагад тулгуурлан үе шаттайгаар өөрчлөх талаар зөвлөмж гаргах;

Нутаг дэвсгэр, засаг захиргааны хамгийн том нэгжийн хувьд буюу бүсийн түвшинд хийх өөрчлөлтийг үе шаттайгаар хийдэггүй. Харин засаг захиргааны бага нэгжүүдийн хувьд хүн амын тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хот, суурин газруудыг нэгтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Япон Улсын туршлагын дагуу Монгол Улсад зарим сум, суурин газруудыг нэгтгэх төлөвлөлтийн хувилбарыг БХТ-ийн БНСТХ-ийн дарга Даваанямд танилцуулж байсан. Аймгийн түвшинд хийх засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг тухайн аймгийн түүх, соёлын уламжлал, улбааг харгалзан нягт судалсны дүнд хийнэ. ҮХЦТ-нд санал болгосончлон эхний үе шатанд бүсийн хуваарийг засаг захиргааны нэгжээр тодорхойлохгүй байснаар эсэргүүцэл, маргаан бага дагуулна гэж үзэж байна. Бүсийн түвшинд төлөвлөлт хийж, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад шаардлагатай гэж үзвэл аймгийн түвшний засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг хийж болно.

5. Бүсчилсэн хөгжлийн болон үндэсний хэмжээний хөгжлийн төлөвлөгөө /"Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл", ҮХЦТ г.м/ боловсруулах аргачлал, норм дүрмийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах.

ҮХЦТ-ний хот, суурин газрын төлөвлөлттэй холбоотой хэсэгт 1) хотыг дахин хөгжүүлэх, барилга байгууламжийн давхар, талбайн харьцаа, барилга байгууламжийн бүрхэцийн харьцаа болон барилгын бусад норм, дүрэм, журмыг боловсронгуй болгох, газрын татварын тогтолцоог бүрдүүлэх, 2) орон нутгийн гол хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, 3) орон сууцны хангамжийг төлөвлөн хэрэгжүүлэх дүрэм, журмыг боловсруулах, 4) засаг захиргааны нэгж бүрээр хөгжлийн төлөвлөгөөний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болон тавигдах шаардлагыг тодорхойлсон заавар боловсруулах зэрэг санал, зөвлөмжийг тусгасан. Түүнчлэн хот байгуулалтын салбарын хууль, эрх зүйн тогтолцоог шинэчлэх үйл ажиллагааны хүрээнд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэртэй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журмуудыг туршилтын төслийн түвшинд судалсан. Эдгээр санал, зөвлөмж, арга хэмжээг хандивлагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж болно.

Бүсчилсэн хөгжлийн болон үндэсний хэмжээний хөгжлийн төлөвлөгөө боловсруулахтай холбоотойгоор ҮХЦТ-ний хүрээнд төлөвлөлтийн аргачлал, стандартыг санал болгосон ба үүнтэй холбоотойгоор ҮХЦТ-г Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл зэрэг баримт бичигт

тусгуулахаар Төслийн баг ажиллаж байна.

БХБЯ-ны ХБГХБХЗГазар
2021.08.24.

Хавсралт B: БХБЯ/БХТ-өөс дэвшүүлсэн асуудлуудтай холбогдуулан тайлбар хүргүүлэх нь

**БХБЯ/БХТ-өөс дэвшүүлсэн асуудлуудтай холбогдуулан тайлбар хүргүүлэх нь**

### 1. Эдийн засгийн бүсчлэлийн хувилбар

БХБЯ/БХТ-өөс ҮХГ болон ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй эдийн засгийн бүсчлэлийн хувилбар нь өнөөгийн байдал хэлбэрээр байгаа бөгөөд нарийвчлан тоон болон чанарын үнэлгээгээр баяжуулах шаардлагатай гэсэн санал ирүүлсэн. БХБЯ/БХТ-ийн саналын дагуу цаашид анхаарах асуудлууд: 1) эдийн засаг, худалдааг төрөлжүүлэх 2) гадаад худалдааны хамтын ажиллагаа, транзит тээврийн боломжууд 3) гадаад худалдаа, чөлөөт бүсүүдийн хөгжлийн бодит боломж чадавх зэрэг юм.

“Эдийн засаг, худалдааг төрөлжүүлэх” нь эдийн засгийн төрөлжилтийн үндэс суурь болох тухайн аймгийн эдийн засгийн бүтэц, хэмжээ болон экспортын шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай орон нутгийн нөөц баялгаас хамаарна. “Гадаад худалдааны хамтын ажиллагаа, транзит тээврийн боломжууд” нь хөрш зэргэлдээ улс орнуудтай хиллэж буй эсэх аймгийн байршил болон зам тээврийн дэд бүтцээс хамаарна. “Гадаад худалдаа, чөлөөт бүсүүдийн хөгжлийн бодит боломж” нь дээр дурдсан нөхцөлүүдээс хамаарна.

Тиймээс эдийн засгийн бүтэц, хэмжээний одоогийн нөхцөл байдал, газар, усны нөөц, ашигт малтмалын орд нөөц болон тухайн аймгийн онцлог, хөгжлийн боломжийг тодорхойлоход аймгийн байршил чухал ач холбогдолтой. Сайтар тусгах шаардлагатай бусад хүчин зүйлд тухайн аймгийн түүхтэй холбоотой нийгэм соёлын нөхцөл байдал орно. ҮХЦТ-ний хүрээнд аймгуудын ижил төстэй байдлын дүн шинжилгээг хийсэн бөгөөд эдгээр нөхцөл байдлын ихэнхийг одоогийн байдлын тоон мэдээлэлд үндэслэн 30 шалгуур үзүүлэлтээр илэрхийлж тусгасан болно. Түүнчлэн санхүү төсвийн нөхцөл байдлыг тодорхой хэмжээгээр тусгасан. Аймгуудын байршлын нөхцөл байдлыг нарийвчлан тусгаагүй хэдий ч аймгуудын ижил төстэй байдлын дүн шинжилгээний хүрээнд аймгууд өөр хоорондоо харилцан холбогдох зам, тээврийн гол дэд бүтцийг тодорхойлсон. Хөрш зэргэлдээ улс орнуудтай хиллэж буй байршлын нөхцөл байдал нь дүн шинжилгээнд тусгагдсан бөгөөд ОХУ, БНХАУ-тай хиллэж буй аймгуудыг үнэлгээнээс хамааруулан бүлэглэн нэг бүсэд хамруулсан.

ҮХЦТ-ний хүрээнд хийж гүйцэтгэсэн аймгуудын ижил төстэй байдлын дүн шинжилгээ нь одоогийн байдлын боломжит тоо баримт, мэдээлэлд үндэслэсэн дэлгэрэнгүй шинжилгээ бөгөөд үр дүнд эргэлзэх шаардлагагүй юм. Гэвч эдийн засгийн бүсчлэлийг шинээр тогтоох асуудал нь улс төртэй холбоотой тул олон оролцогч талуудыг хамруулан олон нийтийн хэлэлцүүлэг хийх шаардлагатай. Эдийн засгийн шинэ бүсчлэлийн хувилбарыг батлуулахад ихээхэн хугацаа шаардагдах боловч хэлэлцүүлэгт бүхий л оролцогч талууд оролцох шаардлагатай бөгөөд хэлэлцүүлгийг өрнүүлэхийн тулд ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан аймгуудын ижил төстэй байдлын дүн шинжилгээг нарийвчлан танилцуулах хэрэгтэй. Эдийн засгийн шинэ бүсчлэлийн хувилбарыг боловсруулахдаа

аймгуудын ижил төстэй байдлын дүн шинжилгээнд үндэслэх шаардлагатай.

## 2. Хот, суурины хөгжлийн төлөвлөгөө

ҮХЦТ нь үндэсний болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг юм. Дараагийн үе шатанд аймаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийг хийнэ. БХБЯ/БХТ-ийн санал "оновчтой төлөвлөлт, үр ашигтай шийдэл" нь Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсанаар үе шатаар төлөвлөгдөж, тусгагдана.

Орон нутгийн иргэд, олон нийт, хувийн компаниудын хэрэгцээ шаардлагад нийцсэн үр ашигтай шийдлийг санал болгохын тулд олон нийтийн оролцоотой төлөвлөлт, бүтээн байгуулалт хамгаас чухал юм. Нэг талаар орон нутгийн байгалийн нөөц баялаг зэрэг нөхцөл байдлыг хамгийн сайн мэддэг орон нутгийн иргэд, олон нийт, хувийн компаниудын хэрэгцээ шаардлага, хүсэл эрмэлзэлд нийцүүлэх үүднээс доороос дээш чиглэсэн механизмыг нэвтрүүлэх шаардлагатай. Нөгөө талаар төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд холбогдох яам, төрийн захиргааны байгууллагын удирдлага, зохион байгуулалтын дагуу нутгийн удирдлагын санаачилгаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөг тодотгож, хэрэгжилтийг сайжруулах эргэх холбооны механизмыг зүй зохистой бүрдүүлэх шаардлагатай.

ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөр (БХНХ) болон Бүсийн зөвлөлийг (БЗ) бүс нутаг тус бүрт байгуулснаар олон нийтийн оролцоотой төлөвлөлт, хэрэгжилтийг үр дүнтэй турших боломжтой. Холбогдох яам, төрийн захиргааны байгууллагын удирдлага, зохион байгуулалтын дагуу нутгийн удирдлагын санаачилгаар аймаг, хот, суурины хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад "аймаг" нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн гол нэгж байна. Орон нутгийн хөгжлийн эдгээр төлөвлөгөөг эхлээд салбарын асуудал хариуцсан байгууллагуудын боловсруулсан аймгийн түвшний салбарын хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулах шаардлагатай бөгөөд дараа нь ҮХЦТ-ний хүрээнд санал болгосон эдийн засгийн шинэ бүсүүдийн дагуу бүс нутгийн түвшинд хэлэлцэж, уялдуулан нэгтгэх хэрэгтэй.

## 3. Хотын хөгжлийн чиг үүргийг төрөлжүүлэх

ҮХЦТ-ний хүрээнд хотын зэрэглэлээр дээгүүр эрэмбэлэгдэх томоохон хотуудын чиг үүргийг тодорхойлсон. Хотуудын чиг үүргийг ихэвчлэн одоо хэрэгжүүлж буй чиг үүргийг нэмэгдүүлэх болон зарим нэг хотуудад шинээр хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлсон. Санал болгож буй хотуудын чиг үүрэг нь үндэсний болон бүс нутгийн хөгжлийн алсын хараа, хөгжлийн стратегитэй нийцэж байна. Холбогдох аймаг, хотын оролцогч талууд шинээр хэрэгжүүлэх чиг үүргийн талаар хэлэлцэх шаардлагатай бөгөөд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, олон нийтийн барилга байгууламжийг олон нийтийн оролцоотойгоор төлөвлөнө.

<u>Хангайн бүсийн томоохон хотуудын шинээр хэрэгжүүлэх чиг үүргийг жишээ болгон доор дурдав. </u>(ҮХЦТ-ний тайлангийн Аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ)

Орхон аймгийн Эрдэнэт хот:

"Орхон аймаг, Эрдэнэт хот нь хүн амын төвлөрөл, мэргэжилтэй боловсон хүчин, дэд бүтэц, ашигт малтмалын баялаг нөөц, бусад хотуудын болон экспортын зах зээлд нэвтрэх боломжоо ашиглан Монгол Улсын аж үйлдвэр, боловсруулах үйлдвэрийн бааз байж болно.~"Эрдэнэт хот нь транзит худалдааны чиг үүргийг хэрэгжүүлснээр Орхон аймаг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд том үүрэг

гүйцэтгэх хүний нөөц, бараа, мөнгө, мэдлэгийн уурхай болон хөгжих боломжтой.”

Булган аймгийн Булган:

“Булган аймаг нь Улаанбаатар-Эрдэнэт-Мөрөнгийн чиглэлийн гол авто зам дагуу байрладаг. Тус аймаг нь худалдаа, аялал жуулчлалын чухал транзит болон гол коридор зам дагуу байрлаж байгаа бөгөөд ОХУ-ын БНБУ-тай холбогдох боломжтой. ~”

Булган аймаг нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлт, үйлчилгээний бааз, хөдөө аж ахуйн технологийн төв бааз хэвээр байх болно.

Завхан аймгийн Улиастай:

“Аймгийн төв Улиастай хотын чиг үүргийг өргөжүүлж, Баруун бүсийг Улаанбаатар хоттой холбосон нийгмийн үйлчилгээ, засаг захиргааны төв болгон хөгжүүлэхийн тулд дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай. ~”

Тойрог коридор доторх бүс нутаг нь 21 дүгээр зуунд Монгол Улсын хөгжлийг тэргүүлэх, чанартай дэд бүтэц бүхий гол бүс нутаг болон хөгжих боломжтой. Ойрын ирээдүйд баруун талаас Улиастай хотыг Улаанбаатар хотоор дайруулан, зүүн талаас Өндөрхаан хоттой холбох өөр нэг гол харилцаа холбооны сүлжээ бий болох боломжтой (Тайлангийн 5.3.2-ын (4) Санал болгож буй орон зайн төлөвлөлт (Зураг 1)).

Архангай аймгийн Цэцэрлэг:

“Мэдээлэл, харилцаа холбооны технологийг зайнаас эмчлэх, зайнаас суралцах, эрчимжсэн болон бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдэд зориулсан цаг уурын урьдчилсан мэдээлэл өгөх, аялал жуулчлалын мэдээлэл зэргийг солилцоход нэг талаас малчид нөгөө талаас орон нутгийн засаг захиргаа ашиглаж болох юм. ~”

Цэцэрлэг хот нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн төв хэсэг, тойрог коридорын гол хэсэгт байрлаж байна. Цэцэрлэгээс Улаанбаатар хот хүртэл зам харилцаа сайтай ба Хангайн уулсад түшиглэж цанаар гулгалтыг хөгжүүлж, өвлийн аялал жуулчлалын бааз болох боломжтой.

## 4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх талаар

БХБЯ, БХТ-өөс жижиг сум, суурин газрыг нэгтгэхтэй холбоотойгоор Төслийн баг 2020 оны 12-р сард БХТ-ийн хүсэлтийн хариу болгож бэлтгэн хүргүүлсэн мэдээлэлд санал өгч, нэмэлт тодруулга авахыг хүссэн байна.

Японы тосгоны засаг захиргааны статус нь жижиг хот, сууриngийн статустай ижил байдаг. Тосгон нь бие даасан засаг захиргаа биш бөгөөд бие даасан чиг үүрэг нь хязгаарлагдмал байдаг. Энэ төрлийн засаг захиргааны нэгж нь хил хязгаар, орон нутгийн хурлын байгууллага, гишүүдийн тоо, зарим олон нийтийн байгууламж (захиргааны байгууллагын тогтмол үйл ажиллагаа г.м.) зэрэгтэй холбоотойгоор зохих хууль, тогтоомжийн хүрээнд захирамж, дүрэм, журмаа гаргаж, хэрэгжүүлдэг. Хуульд зааснаар хүн ам нь 5000, зарим тохиолдолд 8000-аас давсан тохиолдолд тосгон нь хот, суурин газрын статустай болж болно. Түүнчлэн хүн ам нь 30 мянга, зарим тохиолдолд 50 мянгаас давсан тохиолдолд хотын статустай болж болдог.

Японд тосгодыг нэгтгэх журмыг хуульд заасан байдаг. Япон Улсад нэгтгэхээр төлөвлөж байгаа хот, тосгодын зөвлөлийг байгуулж, судалгаа, төлөвлөгөөг боловсруулж, хэлэлцсэний үндсэн дээр нэгтгэх эсэх тухай эцсийн шийдвэрийг иргэдийн санал хураалтаар гаргадаг. Хот, тосгодын оршин суугчдын саналуудыг

төлөвлөгөөнд хэрхэн тусгаснаас хамаарч хот, тосгодыг амжилттай нэгтгэдэг. Энэхүү үйл явцад нийгэм, эдийн засгийн хөшүүрэг нөлөөлөхгүй.

## 5. Зам, тээврийн босоо тэнхлэг, гол коридор

ҮХЦТ-нд аймгууд хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх, тойрог коридор дайран өнгөрч буй аймгуудын хөрш улс орнууд руу нэвтрэх боломжийг сайжруулах зорилгоор тойрог коридорыг хөгжүүлэх саналыг тусгасан. Тойрог коридор нь ихэнх аймгийн төвүүдийг холбож, хамгийн бүтээмж өндөртэй газар нутгуудаар дайран өнгөрч байгаа бөгөөд умард, өмнөдийг холбосон хэд хэдэн коридорыг байгуулахаас илүү ашигтай шийдэл гэж үзэж байна. Энэхүү бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх юм. Аймаг хоорондын зам нь тойрог коридороос салбарлаж, бусад аймгуудыг холбоно. Зураг 2-т ҮХЦТ-нд санал болгож буй хот, суурингуудын чиг үүрэг, зам, харилцаа холбоог харууллаа.

ҮХЦТ-нд босоо тэнхлэгийн 4 замаас Сүхбаатар-Дархан-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн замыг үе шаттайгаар сайжруулах саналыг тусгасан. Эрээнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн замыг Зураг 2-т үзүүлснээр санал болгосон. Арцсуурь-Шивээхүрэн чиглэлийн замыг тойрог коридорын баруун хэсэгтэй холбож, сайжруулж болох ч Алтай, Шивээхүрэнгийн хоорондох замыг урт хугацаанд л сайжруулах магадлалтай гэж үзэж байна. Цагааннуур-Ховд-Булган чиглэлийн замаас Цагааннуур, Ховд хоорондын замыг эхэлж сайжруулах нь зүйтэй.

Зам тээврийн тэнхлэгүүдийн хувьд ҮХЦТ-ний 5.3.2 (3) хэсэгт хөндлөн гол тэнхлэгийн авто замын хөгжлийн нөөц, чадавхыг тойрог коридорын хойд ба өмнөд хэсгүүдтэй нарийвчлан харьцуулж, судалсан. ҮХЦТ-нд санал болгосон тойрог коридорын хойд хэсэг (тойрог коридор 4b) нь тухайн газар нутагт суурьшиж буй хүн ам зэргээс шалтгаалж чухал ач холбогдолтой коридорт тооцогдоно. Мөн тойрог коридорын хойд хэсэг нь ОХУ-тай хиллэдэг Хангайн бүсийн Сэлэнгэ, Булган, Хөвсгөл гурван аймгийг холбож байгаа ба ОХУ-д түшиглэж худалдаа, аялал жуулчлалын хөгжүүлэх ач холбогдолтой.

БХТ-ийн санал болгосон тойрог коридорын хойд хэсэг нь (Зураг 5.3.6 дээр ногооноор тодруулсан төвийн чиглэл) тухайн газар нутагт суурьшиж буй хүн амыг харгалзан үзвэл бусад 3 чиглэлээс ач холбогдол бага юм. Гэсэн хэдий ч Улаанбаатар, Улиастай, Ховдыг холбох талаас нь авч үзвэл ач холбогдолтой ба тойрог коридорыг барьж байгуулсны дараа тойруу замын (bypass) үүрэг гүйцэтгэнэ (Зураг 1). Түүнчлэн энэхүү тойруу зам нь Улиастай хотын хэсэгт дээр дурдсанчлан тойрог коридор доторх бүс нутгийн хөгжлийг дэмжих харилцаа холбооны сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлнэ. Тиймээс Монгол Улсын зам тээврийн сүлжээний чухал хэсэг болох нөөц чадавх бүхий тойрог коридорыг байгуулах саналыг ҮХЦТ-нд санал болгосон.




**Зураг 1. Санал болгож буй Монгол Улсын орон зайн төлөвлөлт, 2040 оноор**




**Зураг 2. ҮХЦТ-нд санал болгож буй хот, суурингуудын чиг үүрэг, зам харилцаа**

<u>Хавсралт С: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхөд усны балансын шинжилгээг харгалзан үзэх нь</u>

## Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхөд усны балансын шинжилгээг харгалзан үзэх нь

ҮХЦТ-ний хүрээнд усны балансын нарийвчилсан шинжилгээг гол мөрний сав, дэд сав газраар болон аймаг, сумдаар хийж гүйцэтгэсэн. Усны балансын нарийвчилсан шинжилгээний үр дүнг ҮХЦТ-ний Байгаль орчин, нийгэм, усны салбарын тайлангийн 3 дугаар бүлэгт харин хураангуйг Үндсэн тайлангийн 5.5.2 хэсэгт тус тус тусгасан болно.

Нийт 15 аймгийн 20 сум гадаргын усны хомсдолд өртөх бөгөөд зарим суманд усны хомсдолын хувь 60-аас дээш байх төлөвтэй байна. Нийт 10 аймгийн 13

сум газрын доорх усны хомсдолд орж болзошгүй байна.

Тиймээс эдгээр сумдад усны шинэ эх үүсвэрийг барьж байгуулахдаа хөрш зэргэлдээ сумдын хамт цогцоор авч үзэх шаардлагатайг зөвлөж байна.

ХАНСХЕТ-ыг ҮХЦТ-тэй уялдуулан боловсруулж байгаа бөгөөд БХБЯ/БХТ нь зарим сумдыг нэгтгэх зэрэг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх талаар судалж байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхөд усны балансын шинжилгээг харгалзан үзэх үүднээс ҮХЦТ-ний тусгасан холбогдох үр дүнг нэгтгэн оруулав. ҮХЦТ-ний зорилтот он болох 2040 онд усны хомсдолд орж болзошгүй сумдыг Хүснэгт 1-д үзүүлэв. ҮХЦТ-ний хүрээнд тусгай арга хэмжээ авахыг санал болгосон Улаанбаатар хотын дүүргүүдийг эс тооцвол нийт 24 сум гадаргын буюу газрын доорх усны эсвэл аль алины хомсдолд орж болзошгүй байна. ХАНСХЕТ-ийн хүрээнд зарим сумдыг аймгийн төвтэй нэгтэхийг санал болгосон (Хүнэгт 2).

**Хүснэгт 1. Усны хомсдолд орж болзошгүй сумд, 2040 оноор**

| | | Усны баланс (хур тунадас багатай жил) 2040 (сая $м^3$/жил) | | |
|---|---|---|---|---|
| Сум/Дүүрэг | Аймаг/Нийслэл | Гадаргын ус | Газрын доорх ус | Нийт |
| Баянгол | Улаанбаатар | -5.03 | -34.67 | -39.70 |
| Баянзүрх | Улаанбаатар | 51.54 | -25.42 | 26.12 |
| Сонгинохайрхан | Улаанбаатар | -2.22 | 1.79 | -0.43 |
| Сүхбаатар | Улаанбаатар | 4.16 | -19.62 | -15.46 |
| Хан-Уул | Улаанбаатар | 14.71 | -17.29 | -2.57 |
| Чингэлтэй | Улаанбаатар | -0.93 | -24.13 | -25.06 |
| Хэрлэн | Дорнод | -9.25 | 112.62 | 103.37 |
| Дашбалбар | Дорнод | -0.25 | 609.91 | 609.66 |
| Хэрлэн | Хэнтий | -8.06 | 54.63 | 46.57 |
| Зуунмод | Төв | -3.06 | -39.21 | -42.27 |
| Сүхбаатар | Сэлэнгэ | -70.53 | 8.15 | -62.38 |
| Баянгол | Сэлэнгэ | -2.46 | 105.98 | 103.51 |
| Зүүнбүрэн | Сэлэнгэ | -1.19 | 253.47 | 252.28 |
| Сайхан | Сэлэнгэ | -19.46 | 50.52 | 31.06 |
| Шаамар | Сэлэнгэ | -8.46 | 141.35 | 132.88 |
| Замын-Үүд | Дорноговь | 0.55 | -19.90 | -19.35 |
| Сайншанд | Дорноговь | 0.04 | -3.03 | -2.99 |
| Дархан | Дархан -Уул | -33.56 | 0.19 | -33.37 |
| Шарын гол | Дархан -Уул | -2.88 | 8.11 | 5.23 |
| Даланзадгад | Өмнөговь | -4.05 | -8.17 | -12.23 |
| Баян-Өндөр | Орхон | -3.24 | 1.94 | -1.31 |
| Арвайхээр | Өвөрхангай | -7.62 | -7.21 | -14.84 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Булган | Булган | -6.86 | -4.44 | -11.30 |
| Баянхонгор | Баянхонгор | -4.55 | -8.46 | -13.01 |
| Эрдэнэбулган | Архангай | -19.94 | -0.88 | -20.82 |
| Мөрөн | Хөвсгөл | -2.22 | -13.08 | -15.30 |
| Рашаант | Хөвсгөл | 287.58 | -1.10 | 286.48 |
| Улиастай | Завхан | -4.06 | -1.34 | -5.40 |
| Өлгий | Баян-Өлгий | -1.58 | -1.61 | -3.19 |
| Жаргалант | Ховд | -2.89 | -4.39 | -7.27 |

**Хүснэгт 2. Аймгийн төвтэй нэгтгэх боломжтой сумд (БХТ-ийн төлөвлөлт)**

| Аймаг | Сум | Аймгийн төвөөс алслагдсан зай (км) | Аймгийн төв |
|---|---|---|---|
| Баян-Өлгий | Бугат | 4 | Өлгий |
| Дорнод | Баянтүмэн | 10 | Хэрлэн (Чойбалсан) |
| Төв | Сэргэлэн | 15 | Зуунмод |
| Баянхонгор | Өлзийт | 17 | Баянхонгор |
| Булган | Орхон | 22 | Булган |
| Сэлэнгэ | Шаамар | 22 | Сүхбаатар |
| Хэнтий | Баянхутаг | 22 | Хэрлэн (Өндөрхаан) |
| Дархан-Уул | Хонгор | 23 | Дархан |
| Баянхонгор | Баян-Овоо | 24 | Баянхонгор |
| Өмнөговь | Ханхонгор | 25 | Даланзадгад |
| Ховд | Буянт | 25 | Жаргалан (Ховд) |
| Говьсүмбэр | Баянтал | 26 | Чойр |
| Хэнтий | Мөрөн | 27 | Хэрлэн (Өндөрхаан) |
| Архангай | Ихтамир | 27 | Эрдэнэбулган (Цэцэрлэг) |
| Баян-Өлгий | Сагсай | 28 | Өлгий |
| Баянхонгор | Эрдэнэцогт | 28 | Баянхонгор |
| Архангай | Цэнхэр | 29 | Эрдэнэбулган (Цэцэрлэг) |
| Увс | Тариалан | 30 | Улаангом |
| Орхон | Жаргалант | 31 | Эрдэнэт |
| Завхан | Алдархаан | 32 | Улиастай |
| Ховд | Ховд | 32 | Жаргалан (Ховд) |
| Увс | Түргэн | 34 | Улаангом |
| Өвөрхангай | Тарагт | 35 | Арвайхээр |
| Архангай | Булган | 35 | Эрдэнэбулган (Цэцэрлэг) |

| | | | |
|---|---|---|---|
| Ховд | Мянгат | 36 | Жаргалан (Ховд) |
| Баян-Өлгий | Алтанцөгц | 41 | Өлгий |
| Говь-Алтай | Тайшир | 43 | Алтай |

Сумдыг оновчтой байдлаар нэгтгэх талаар санал дэвшүүлэхийн тулд ҮХЦТ-ний усны балансын шинжилгээний үр дүн болон БХТ-ийн саналын хувилбарыг Хүснэгт 3-т нэгтгэлээ. Хүснэгт 3-аас харахад 2040 он гэхэд 14 аймгийн төв усны хомсдолд өртөх магадлалтай байгаа бөгөөд ус хангамжийн системийг өргөжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай юм. Түүнчлэн ус хангамжийг нэмэгдүүлснээр хөрш зэргэлдээ сумдыг ч мөн усаар хангах боломжтой болно.

Аймгийн төвтэй нэгтгэх боломжтой гэж үзсэн сумдаас 2040 онд зөвхөн Сэлэнгэ аймгийн Шаамар сум усны хомсдолд өртөх магадлалтай байна. Тус сумыг аймгийн төвтэй нэгтгэх ажлыг зохион байгуулсны дараа ус хангамжийн системийг өргөжүүлэх ажлыг хийх нь зүйтэй юм. БХТ-ийн санал, төлөвлөлтөөр Ховд аймгийн Буянт, Мянгат, Увс аймгийн Түргэн, Архангай аймгийн Цэнхэр, Өвөрхангай аймгийн Тарагт зэрэг сумдыг аймгийн төвүүдтэй нэгтгэхээр санал болгосон бөгөөд эдгээр сумдыг аймгийн төвийн ус хангамжийн системээс усаар хангаж болох юм. Ялангуяа 2040 онд усны хомсдолд өртөх магадлалтай Ховд аймгийн Буянт, Мянгат, Архангай аймгийн Цэнхэр, Өвөрхангай аймгийн Тарагт сумд нь тус тусын аймгийн төвүүдийн ус хангамжийн системийг өргөжүүлэх үйл ажиллагаанд хамрагдаж болох юм.

Баян-Өлгий аймгийн Бугат, Сагсай, Алтанцөгц, Ховд аймгийн Ховд сум, Архангай аймгийн Ихтамир, Булган, Орхон аймгийн Жаргалант, Завхан аймгийн Алдархаан, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Эрдэнэцогт, Өмнөговь аймгийн Ханхонгор, Дорнод аймгийн Баянтүмэн, Хэнтий аймгийн Мөрөн, Төв аймгийн Сэргэлэн сумд нь 2040 онд усны хомсдолд өртөхгүй ч аймгийн төвийнхөө ус хангамжийн системийг өргөжүүлэх төсөл, үйл ажиллагаанд хамрагдаж болох юм. Сумдын хүн ам, усны хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр тухайн сумыг нэгтгэх үйл ажиллагааг үе шаттайгаар хийж болно.

2040 онд усны хомсдолд өртөх магадлалтай, аймгийн төвийн ус хангамжийн системд нэгдэх боломжгүй буюу алслагдсан байрлалтай 7 сум байна. Эдгээр нь Сэлэнгэ аймгийн Баянгол, Зүүнбүрэн, Сайхан, Дархан-Уул аймгийн Шарын гол, Дорноговь аймгийн Замын-Үүд, Хөвсгөл аймгийн Рашаант юм. Баянгол, Сайхан сум хоорондоо ойр байрлалтай тул нэг ус хангамжийн системийг ашиглаж болох юм. Баянгол сум нь Төв аймгийн Сүмбэр сумтай ойр тул БХТ эдгээр сумдыг нэгтгэх саналыг боловсруулсан. Зүүнбүрэн сум нь Сэлэнгэ аймгийн төвөөс 49 км зайд байрлалтай. Дээрх дөрвөн сум нь Орхон голын цутгал голуудаас ус авдаг тул ус хангамжийн системийг өргөтгөх ажлыг нэгдсэн байдлаар төлөвлөж, хийх шаардлагатай. Үлдсэн сумдын хувьд усны эх үүсвэрийг бие даасан байдлаар шийдвэрлэнэ.

**Хүснэгт 3. Усны балансыг харгалзан нэгтгэх боломжтой сумд**

| Аймаг | Аймгийн төв | Аймгийн төвтэй нэгтгэх боломжтой сумд | Аймгийн төвөөс алслагдсан зай (км) | 2040 онд усны хомсдолд өртөх магадлалтай сумд |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| Баян-Өлгий | Өлгий | Бугат | 4 | |
| | | Сагсай | 28 | |
| | | Алтанцөгц | 41 | |
| Ховд | Жаргалан (Ховд) | Буянт | 25 | |
| | | Ховд | 32 | |
| | | Мянгат | 36 | |
| Увс | Улаангом | Тариалан | 30 | |
| | | Түргэн | 34 | |
| Булган | Булган | Орхон | 22 | |
| Сэлэнгэ | Сүхбаатар | Шаамар | 22 | Баянгол Зүүнбүрэн Сайхан |
| Дархан-Уул | Дархан | Хонгор | 23 | Шарын гол |
| Архангай | Эрдэнэбулган (Цэцэрлэг) | Ихтамир | 27 | |
| | | Цэнхэр | 29 | |
| | | Булган | 35 | |
| Орхон | Баян-Өндөр (Эрдэнэт) | Жаргалант | 31 | |
| Завхан | Улиастай | Алдархаан | 32 | |
| Өвөрхангай | Арвайхээр | Тарагт | 35 | |
| Баянхонгор | Баянхонгор | Баян-Овоо | 24 | |
| | | Эрдэнэцогт | 28 | |
| Говь-Алтай | Алтай | Тайшир | 43 | |
| Говьсүмбэр | Чойр | Баянтал | 26 | |
| Өмнөговь | Даланзадгад | Ханхонгор | 25 | |
| Дорнод | Хэрлэн (Чойбалсан) | Баянтүмэн | 10 | Дашбалбар |
| Хэнтий | Хэрлэн (Өндөрхаан) | Мөрөн | 27 | |
| Төв | Зуунмод | Сэргэлэн | 15 | |
| Дорноговь | Сайншанд | | | Замын-Үүд |
| Хөвсгөл | Мөрөн | | | Рашаант |

Тайлбар: 2040 онд усны хомсдолд өртөх магадлалтай сумдыг улаанаар; БХТ-ийн төлөвлөлтөөр аймгийн төвтэй нэгтгэх боломжтой сумдыг ногооноор тэмдэглэв.

## Хавсралт D: Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөө (АХЧБТ) төслүүдтэй холбоотой санал, дүгнэлт

**Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөө (АХЧБТ) төслүүдтэй холбоотой санал, дүгнэлт**

(2021 оны 9 дүгээр сарын 22; ЖТБ - Ц.Хашимото)

АХБ-ны Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөний (АХЧБТ) төслийг доор

дурдсан зарим аймгуудын Дунд хугацааны тайланд үндэслэн судлав. Үүнд:

Дунд хугацааны тайлан 2020 оны 4 дүгээр сар:

- Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөний (АХЧБТ) төсөл:
  1) Сэлэнгэ, Дархан-Уул аймаг,
  2) Булган, Орхон аймаг

Хэнтий (2021 оны 5 дугаар сар), Баянхонгор (2021 оны 3 дугаар сар), Сүхбаатар (2021 оны 4 дүгэр сар), Архангай (2020 оны 10 дугаар сар), Хөвсгөл (2021 оны 6 дугаар сар) аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөний (АХЧБТ) төсөл.

## 1. Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөний (АХЧБТ) төслийн тойм

АХБ-ны төслийн багийн ахлагчаас Сэлэнгэ, Дархан-Уул, Булган болон Орхон аймгийн АХЧБТ-ний тайланг 2020 оны 5 дугаар сарын 30-нд, бусад аймгийн АХЧБТ-ний тайланг 2021 оны 9 дүгээр сарын 6-нд тус тус хүлээн авсан. Аймгуудын хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөг өөр өөр хугацаанд боловсруулсан хэдий ч хамрах хүрээ, бүтэц, дүн шинжилгээний хувьд хоорондоо нийцэж байна.

Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөнд дор дурдсан нийтлэг зүйлийг тусгасан. Үүнд:

1) Усны нөөц, уур амьсгалын нөхцөл, байгаль орчны тулгамдаж буй асуудлууд, газрын нөөц, газар ашиглалтын сэдэвчилсэн зургийг Монгол Улс болон аймгуудаар боловсруулсан бөгөөд аймгуудын байр суурийг харьцуулсан судалгаа хийсэн;
2) БДНБ болон эдийн засгийн салбаруудын шинжилгээ, эдийн засгийн бүтэц, эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, аймгуудын байр суурийг харьцуулсан;
3) Сумын түвшний газар тариалангийн үйлдвэрлэл, мал аж ахуй эрхлэлт, уул уурхай, аж үйлдвэр, худалдаа, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн үйл ажиллагаа болон боловсрол, сургалт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ зэрэг нийгмийн үйлчилгээ, ажиллах хүч, хүн ам зүй, хүн амын шилжих хөдөлгөөн, хот, суурины дэд бүтэц, нийтийн аж ахуй, санхүү, институцийн дэлгэрэнгүй тоо баримт, мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийсэн;
4) Төслийн хүрээнд боловсруулсан аргачлалын дагуу бүх сумын хэв шинжийг хүн амын тоо, хүн ам зүйн болон эдийн засгийн динамик, дэд бүтцийн хангамж, эдийн засгийн чиг үүргийг харгалзан тодорхойлсон; Сумын тогтвортой байдлыг усны нөөц, бэлчээрийн төлөв байдал, эдийн засгийн үүрэг болон хүн амын байршил, эдийн засаг, нийгмийн үйлчилгээний хувьд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд сумын эзлэх байр суурийг үндэслэн үнэлсэн;
5) Гадаад, дотоод байдлын шинжилгээ (SWOT) хийсэн;
6) Аймгийн хөгжлийн үндсэн асуудлуудыг тодорхойлсон.

Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөнд эдийн засгийг хөгжүүлэх гол нутаг дэвсгэр, ирээдүйтэй бүсэд эдийн засгийн тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар тусгасан бөгөөд эдийн засгийн ирээдүйтэй үйл ажиллагааны байршлыг эрэмбэлэн тодорхойлж, эдгээр байршлуудын хоорондын холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зөвлөсөн. Мөн томоохон хот, суурины чиг

үүргийг бэхжүүлж, эдийн засгийн тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүсийг эрэмбэлэн хөгжүүлэх талаар зөвлөсөн. Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөнд төрийн холбогдох байгууллагуудтай уялдуулан хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих зорилгоор "Төслийн санхүүжилтийн аргачлалыг" санал болгосон.

Тус төслийн хүрээнд аймгийн хөгжлийн хөтөлбөр, салбарын хөгжлийн төлөвлөгөө зэрэг бүхий л төлөвлөлтийн баримт бичиг, бодлого, стратегийг нарийвчлан судалсан. Түүнчлэн Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөнд зарим аймагт хандивлагчдын саяхан хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй гол төслүүдийг авч үзсэн.

## 2. Ерөнхий дүгнэлт

АХЧБТ-ний талаар дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

1) Тус төсөлд салбар салбарын үндэсний экспертүүд ажиллаж байгаа тул сумын түвшний нарийвчилсан мэдээлэл, дүн шинжилгээг өргөн хүрээнд хийж чадсан байна.

2) Эдгээр нарийвчилсан мэдээлэл нь ҮХЦТ-нд тусгасан макро түвшний болон аймгийн түвшний бараг бүх өгөгдөл, мэдээллийг сумын түвшний мэдээлэл болгон задалж болохоор байна. ҮХГ-т БХҮБ-ыг боловсруулахад шаардлагатай байгаа нарийвчилсан мэдээллийг 21 аймгийн АХЧБТ-нөөс авч болно гэж үзэж байна.

3) АХЧБТ дэх SWOT шинжилгээ, бүс нутгийн төрөлжилтийн коэффициент (LQ) зэрэг дүн шинжилгээ нь тухайн аймгийн улсын нийгэм, эдийн засагт эзлэх байр суурийг тодруулахад ач холбогдолтой юм.

4) Аймгийн түвшинд хүн ам, эдийн засгийн хэтийн төлвийн тооцоо хийгдээгүй байна.

5) АХЧБТ-нд хөгжлийн зарим чиглэлийг тусгасан ч, тодорхой төсөл, хөтөлбөрүүд, институцийн арга хэмжээний саналыг тусгаагүй байгаа тул хараахан төлөвлөлтийн баримт бичиг болоогүй байна гэж үзэж байна.

6) Төлөвлөгөөнд тусгагдсан SWOT шинжилгээ нь хөгжлийн алсын хараag тодорхойлох, хөгжлийн хувилбарыг боловсруулах, сумын түвшний нарийвчилсан өгөгдөл, түүний дотор сумын типологийн судалгаанд үндэслэсэн бүс нутгийн төрөлжилтийн коэффициентийн дүн шинжилгээ болон харьцуулсан дүн шинжилгээ нь аймаг бүрийн хөгжлийн зорилт, стратегийг салбараар тодорхойлоход ашиглагдана. АХЧБТ-ийг тодорхой төсөл, хөтөлбөрүүд, институцийн арга хэмжээний саналын хамт боловсруулахад эдгээр судалгаа, дүн шинжилгээ нь чухал ач холбогдолтой юм.

Бидэнд ирүүлсэн АХЧБТ-ийн төслүүд нь ҮХЦТ-тэй дараах байдлаар нийцэж байна.

(1) Аймгуудын онцлог, хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлсон байдлаараа ҮХЦТ болон АХЧБТ нь хоорондоо ерөнхийдөө нийцэж байгаа бөгөөд ихээхэн ялгаа байхгүй байна.

(2) ҮХЦТ болон АХЧБТ-ын хоорондох онцлох зөрүүтэй санал, төлөвлөлт нь АХЧБТ-нд сумын түвшний нөхцөл байдлыг илүү нарийвчлан тодорхойлж, микро түвшний буюу сум тус бүрийн хөгжлийн нөөц боломжийг тусгасан байна.

## 3. АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд болон ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүдийн саналын харьцуулалт

АХЧБТ-нд төсөл, хөтөлбөрүүдийн саналыг тодорхой тусгаагүй боловч аймгуудын одоогийн нөхцөл байдал, хөгжлийн потенциал, чиглэл зэрэгт хийсэн дүн шинжилгээнд үндэслэсэн төсөл, хөтөлбөрүүдийн санаа, саналыг дурдсан байна. Эдгээрийг Хүснэгт 1-7-д ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүдийн саналтай харьцуулж харууллаа.

**Хүснэгт 1. Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд болон ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүдийн саналын харьцуулалт**

| | **Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд** | **ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд** |
|---|---|---|
| 1 | Үр тариа, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх Сэлэнгэ мөрний сав газрын захиргаа байгуулах | ҮХЦТ-нд тусгасан санал: Сэлэнгэ аймагт I4.1 Тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төсөл, I5.1 Усжуулалтын төсөл, I3.1 Ухаалаг хөдөө аж ахуйн хандлагыг дэмжих төслийн хамт хагас эрчимжсэн МАА, тэжээлийн үйлдвэрлэлийг хослуулсан нэгдсэн фермерийн аж ахуйг хөгжүүлнэ. |
| 2 | Дархан хотод их, дээд сургууль байгуулах хөтөлбөр:<br>Дархан хотыг газар тариалан, мал аж ахуйд төвлөрсөн шинжлэх ухааны технологийн парк бүхий их сургуулийн хот болгож хөгжүүлнэ. | ҮХЦТ-ний Дархан хотод МХХТ, хиймэл оюун ухаан, 5G-г ашиглан газар тариалангийн салбарт инноваци ашиглах, шинэ технологи нэвтрүүлэх төв байгуулах саналтай нийцэж байна. |
| 3 | Дархан хот дахь ашиглагдахаа больсон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай газрыг дахин ашиглалтад оруулах хөтөлбөр:<br>үйлдвэрлэлийн бүсийг нөхөн сэргээх үйл ажиллагаа, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл хөгжүүлэх сан г.м. | ҮХЦТ-нд тусгасан барилга байгууламжууд, газрын эрхтэй холбоотой үнэлгээ хийх, сонгогдсон байгууламжуудыг сэргээн засварлах, Дарханы аж үйлдвэрийн паркийг дахин байгуулах саналтай нийцэж байна. |
| 4 | Техникийн туслалцаа, оролцогч талуудын түншлэл зэргээр дамжуулж ЖДҮ эрхлэгчдэд тоног төхөөрөмж түрээслүүлэх | ҮХЦТ-нд тусгасан ЖДҮ-ийг дэмжих институцийн арга хэмжээний саналтай нийцэж байна. |
| 5 | Сүхбаатарт олон үйлдэлт системд суурилсан логистикийн төв (үйлдвэрлэлийн бүс бүхий хуурай боомт) байгуулах эсвэл Алтанбулаг чөлөөт бүсэд логистикийн төв байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлэх | ҮХЦТ-нд дэд бүтэц, институцийн үйл ажиллагааг сайжруулах замаар Алтанбулаг чөлөөт бүсийн үйл ажиллагааг идэвхжүүлэх саналыг санал болгосон. |
| 6 | Сүхбаатар, Мандал, Сайхан сумдыг хоёрдогч хот болгон хөгжүүлэх хөтөлбөр (боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн санхүүжилт, анхан шатны боловсруулалт, хөдөө аж ахуйн технологийн парк зэргийг хөгжүүлэх) | Хоёрдогч хотын чиг үүрэг нь ҮХЦТ-нд санал болгосон хотын зэрэглэлийн саналтай нийцэж байна. |

| | | |
|---|---|---|
| 7 | МАА-н салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр: бэлчээрийн менежмент, хагас эрчимжсэн болон эрчимжсэн МАА эрхлэлт, мал эмнэлгийн үйлчилгээ, сургалт, санхүүжилт, зохион байгуулалтыг бэхжүүлэх үйл ажиллагаа, боловсруулалт г.м. | ҮХЦТ-нд тусгасан МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл (II2.2), хяналт бүхий бэлчээрийн бүсийг байгуулах, бэлчээрийн менежментийг сайжруулах үйл ажиллагаатай нийцэж байна. |
| 8 | Ойг нөхөн сэргээх хөтөлбөр: зах зээлийн судалгаа, дэд бүтэц, санхүүжилт, зохион байгуулалт г.м. | ҮХЦТ-нд тусгасан ойн сан, усны сан бүхий газар, эмзэг экосистемийг хадгалан, хамгаалах байгаль орчны стратегитэй нийцэж байна. |
| 9 | Сэлэнгэ мөрөн, Орхон голын дагуу ХАА-н бизнесийг хөгжүүлнэ. | ҮХЦТ-нд тусгасан саналтай нийцэж байна. Сэлэнгэ, Булган аймагт инновацид суурилсан ХАА-н салбарыг хөгжүүлэх төсөл (I3.1), хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэх төслийн (I3.3) хамт хагас эрчимжсэн МАА, тэжээлийн үйлдвэрлэлийг хослуулсан нэгдсэн фермерийн аж ахуйг хөгжүүлнэ. |

### Хүснэгт 2. Булган, Орхон аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд болон ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүдийн саналын харьцуулалт

| | **Булган, Орхон аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд** | **ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд** |
|---|---|---|
| 1 | Үр тариа, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх Сэлэнгэ мөрний сав газрын захиргаа байгуулах | ҮХЦТ-нд тусгасан санал: Булган аймагт I4.1 Тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төсөл, I5.1 Усжуулалтын төсөл, I3.1 Ухаалаг хөдөө аж ахуйн хандлагыг дэмжих төслийн хамт хагас эрчимжсэн МАА, тэжээлийн үйлдвэрлэлийг хослуулсан нэгдсэн фермерийн аж ахуйг хөгжүүлнэ. |
| 2 | МАА-н салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр: худаг, малын хашаа хороо, тэжээлийн агуулах, мал эмнэлгийн үйлчилгээ, гарал үүслийн систем, санхүүжилт, институцийн зохион байгуулалтыг сайжруулах, хөгжүүлэх г.м. | I2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөлтэй холбоотой төслийн санал. |
| 3 | Бэлчээрийн менежментийг сайжруулж, малын тоог хянаж, бэлчээрийг нөхөн сэргээх үйл ажиллагаа | ҮХЦТ-нд тусгасан хяналт бүхий бэлчээрийн бүсийг байгуулах, бэлчээрийн менежментийг сайжруулах саналтай нийцэж байна. |
| 4 | Эрдэнэт хотын эдийн засгийг төрөлжүүлэх үйл ажиллагаа (аж үйлдвэрийн бүс, логистикийн төвийг ТХХТ-ээр дамжуулан хөгжүүлэх г.м.) | ҮХЦТ-нд тусгасан Эрдэнэт хотод арьс шир, хүнс болон бусад хөнгөн үйлдвэрийг төрөлжүүлэн, хөгжүүлэх саналтай нийцэж байна. |
| 5 | Булган, Дашинчилэн, Хутаг-Өндөр сумдыг хоёрдогч хот болгон хөгжүүлэх хөтөлбөр | ҮХЦТ-нд хамаарахгүй. |

| | | |
|---|---|---|
| 6 | Ойг нөхөн сэргээх хөтөлбөр | ҮХЦТ-нд тусгасан ойн сан, усны сан бүхий газар, эмзэг экосистемийг хадгалан, хамгаалах байгаль орчны стратегитэй нийцэж байна. |
| 7 | “Орхон говь” төслийг хэрэгжүүлэх | Тус төслийг ҮХЦТ-нд тусгасан → Орхон гол дээр урсацын тохируулга хийж, говийн бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл (III12) |
| 8 | Эгийн голын усан цахилгаан станц төсөл | IV9 Сэлэнгэ мөрний усан цахилгаан станцын далан байгуулах төсөлтэй холбоотой төслийн санал. |
| 9 | Сэлэнгэ мөрний дагуу ХАА-н бизнесийг хөгжүүлэх | ҮХЦТ-нд тусгасан Сэлэнгэ, Булган аймагт инновацид суурилсан ХАА-н салбарыг хөгжүүлэх төсөл (I3.1), хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэх төслийн (I3.3) хамт хагас эрчимжсэн МАА, тэжээлийн үйлдвэрлэлийг хослуулсан нэгдсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх саналтай нийцэж байна. |

**Хүснэгт 3. Хөвсгөл аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд болон ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүдийн саналын харьцуулалт**

| | Хөвсгөл аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд | ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд |
|---|---|---|
| 1 | Хөвсгөлийн умард-өмнөд чиглэлийн тэнхлэгийг хөгжүүлэх | III3 Аймгуудын тусгай зориулалтын авто замыг барьж байгуулах төсөлтэй (Мөрөн~Шинэ-Идэр~Жаргалант~Цэцүүх чиглэлийн авто зам) холбоотой төслийн санал. |
| 2 | Архангай аймагтай хамтарч аялал жуулчлалыг хөгжүүлэх (Сангийн далай нуур - Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолборт газар) | ҮХЦТ-нд тусгасан Хөвсгөл аймагт байгалийн аялал жуулчлал, эрүүл мэндийн аялал жуулчлал, соёлын аялал жуулчлал болон бусад төрлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх саналтай нийцэж байна. |
| 3 | Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газар, түүний орчны бүсийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл (АХБ хэрэгжүүлж буй) | ҮХЦТ-нд тусгасан Хөвсгөлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэх саналтай нийцэж байна. |
| 4 | Тогтвортой, эдийн засгийн хүртээмжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх | ҮХЦТ-нд тусгасан Хөвсгөлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэх саналтай нийцэж байна. |
| 5 | Өрсөлдөх чадвартай, тогтвортой мал аж ахуйн салбар, хүнс үйлдвэрлэлийг дэмжих | I2.2 Мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах төсөл, I4.1 Тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төслийн саналтай нийцэж байна. |
| 6 | Хот, суурин газрын тогтолцоог хөгжүүлэх: Хатгал сумыг аялал жуулчлалын болон сум дундын төв, Ханх, Цагааннуурыг аялал жуулчлалын хоёрдогч чиглэл, Тариаланг газар тариалан | ҮХЦТ-нд хамаарахгүй. |

| | | |
|---|---|---|
| | эрхлэлтийн төв болгож тус тус хөгжүүлэх | |
| 7 | Тариалан – хэвтээ тэнхлэгийн зам холбоог бэхжүүлэх | III3 Аймгуудын тусгай зориулалтын авто замыг барьж байгуулах төсөлтэй холбоотой төслийн санал. |
| 8 | Усан цахилгаан станцыг хөгжүүлж усны нөөцийн нэгдсэн менежмент хийх, ус нөөцлөх, хадгалах, бусад бүс нутаг руу ус дамжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх | ҮХЦТ-нд тусгасан ойн нөөцийг үнэлэх, ой модон бус бүтээгдэхүүний түүхий эдийн нөөцийг тогтоож, урт болон дунд хугацааны ойн нөөцийг зохистой ашиглах мастер төлөвлөгөөг боловсруулах саналтэй нэгтгэж болно гэж үзэж байна. |

**Хүснэгт 4. Архангай аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд болон ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүдийн саналын харьцуулалт**

| | Архангай аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд | ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд |
|---|---|---|
| 1 | Эрдэнэмандал сумыг боловсруулах үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэр бүхий сум дундын төв болгон хөгжүүлэх, Тариат сумыг баруун бүс нутаг дахь сум дундын төв болгон хөгжүүлэх, Төвшрүүлэх суманд малын тэжээл тариалалт, газар тариалан эрхлэлтийг хөгжүүлэх | ҮХЦТ-нд хамаарахгүй. |
| 2 | Цэцэрлэг хот дахь ашиглагдахаа байсан үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай газрыг дахин ашиглах | ҮХЦТ-нд тусгагдаагүй. |
| 3 | Зүүн өмнөд хэсгийн сумдад тэжээлийн үйлдвэрлэл, газар тариалан эрхлэлтийг дэмжих | I4.1 Тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төсөл, I5 Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх төслийн саналыг илүү нарийвчилсан байдлаар тусгасан байна. |
| 4 | Цэцэрлэг хотын дэд бүтцийг сайжруулах | III11 Бүсийн болон орон нутгийн хотуудыг хөгжүүлэх төсөлтэй холбоотой төслийн санал. |
| 5 | Мах боловсруулах үйлдвэр, сарлагийн хөөврөн бүтээгдэхүүнд түшиглэн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх | I2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөлтэй холбоотой төслийн санал. |
| 6 | Малын гарал үүслийг мөшгөх тогтолцоог нэвтрүүлэх | ҮХЦТ-нд тусгасан I4.2 Мал аж ахуйн салбарт МХТ-ийн хяналтын болон дэмжлэг үзүүлэх системийг нэвтрүүлэх төсөлтэй холбоотой төслийн санал. |
| 7 | Тэрхийн цагаан нууранд 1 МВ-ын хүчин чадалтай хөвдөг нарны цахилгаан станцыг барих (хэрэгжиж байгаа) | Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, ашиглахтай холбоотой ҮХЦТ-нд тусгасан саналтай нийцэж байна. |

| | | |
|---|---|---|
| 8 | “Экосистемийн үйлчилгээний төлбөр” институцийн арга хэмжээг хэрэгжүүлэх | ҮХЦТ-нд тусгасан нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн иргэдийн оролцоотойгоор орон нутагт байгаль орчны хяналтын тогтолцоог бий болгох байгаль орчны стратегитэй нийцэж байна. |
| 9 | Хөвсгөл аймагтай хамтарч аялал жуулчлалыг хөгжүүлэх (Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолборт газар) | ҮХЦТ-нд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд Тэрхийн цагаан нуурыг түшиглэх саналыг тусгасан. |
| 10 | Тогтвортой, эдийн засгийн хүртээмжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх (Хөгнө хааны байгалийн цогцолборт газар, Хархорин, Орхоны хөндий г.м.) | ҮХЦТ-нд тусгасан Хархорин, Орхоны хөндий, Цэцэрлэгийг холбосон аялал жуулчлалын гурвалжинг хөгжүүлэх саналтай нийцэж байна. |
| 11 | Өрсөлдөх чадвартай, тогтвортой мал аж ахуйн салбар, хүнс үйлдвэрлэлийг дэмжих | I2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл, I4.1 Тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төсөлтэй нийцэж байна. |

## Хүснэгт 5. Баянхонгор аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд болон ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүдийн саналын харьцуулалт

| | **Баянхонгор аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд** | **ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд** |
|---|---|---|
| 1 | Бизнес инкубатор төвийн үйл ажиллагаа | ҮХЦТ-нд тусгасан ЖДҮ-ийг дэмжих институцийн арга хэмжээний саналтай нийцэж байна. |
| 2 | Баянхонгор, Баян-Өвөр, Өлзийт, Эрдэнэцогт сумын ус хангамжийн системийн өргөтгөл | IV7.1 Хот, суурины ус хангамжийг сайжруулах төсөл болон IV7.2 Хөдөө, орон нутгийн ус хангамжийг сайжруулах төслийн саналыг илүү нарийвчилсан байдлаар тусгасан байна. |
| 3 | Баянхонгор, Өлзийт сумын хатуу хог хаягдлын цэгийг сайжруулах | ҮХЦТ-нд тусгагдаагүй. |
| 4 | Шаргалжуутын халуун рашаан зэргийг танилцуулсан аялал жуулчлалын сурталчилгаа хийх | ҮХЦТ-нд тусгасан III11 Бүсийн болон орон нутгийн хотуудыг хөгжүүлэх төсөл-Баянхонгор хотыг эрүүл мэндийн аялал жуулчлал болон эрүүл мэндийн шинжлэх ухааны төв болгох төслийн саналыг илүү нарийвчилсан байдлаар тусгасан байна. |
| 5 | Богд, Баянлиг, Эрдэнэцогт сумыг аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх | ҮХЦТ-нд тусгагдаагүй. |
| 6 | Тогтвортой МАА болон ноолуурын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх | ҮХЦТ-нд тусгасан II2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төслийн саналтай нийцэж байна. |
| 7 | Сум дундын хөгжлийн хөтөлбөр: Богд, Баянцагаан болон Бууцагаан сумын төвүүдийг сум дундын төв болгон хөгжүүлэх | ҮХЦТ-нд хамаарахгүй. |
| 8 | Шинэжинст сумыг ноолуурын тогтвортой хөгжлийн загвар сум болгох | II1.1 Малчдыг дэмжих бааз байгуулах төслийн санал |

| | | |
|---|---|---|
| 9 | Өмнөд хилийн орчим амьдардаг малчдад явуулын үйлчилгээ үзүүлэх (гэр цэцэрлэг, эрүүл мэндийн цахим үйлчилгээ) | II1.1 Малчдыг дэмжих бааз байгуулах төслийн санал |
| 10 | МАА-н салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр: худаг, малын хашаа хороо, тэжээлийн агуулах, мал эмнэлгийн үйлчилгээ, гарал үүслийн систем, санхүүжилт, институцийн зохион байгуулалтыг сайжруулах, хөгжүүлэх г.м. | ҮХЦТ-нд тусгасан II2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төслийн саналтай нийцэж байна. |
| 11 | Малын тоо толгой, газрын доройтлыг хянах бэлчээрийн менежмент | ҮХЦТ-нд тусгасан бэлчээр ашиглалтын хяналт бүхий бүсийг байгуулах, бэлчээрийн менежментийг сайжруулах үйл ажиллагаатай нийцэж байна. |
| 12 | Усалгаатай тэжээлийн үйлдвэрлэл | ҮХЦТ-нд тусгасан I5.1Усжуулалтын төслийн саналыг илүү нарийвчилсан байдлаар тусгасан байна |
| 13 | Хангайн нурууны ойн менежмент | ҮХЦТ-нд тусгасан ойн сан, усны сан бүхий газар, эмзэг экосистемийг хадгалан, хамгаалах байгаль орчны стратегитэй нийцэж байна. |
| 14 | Хүнсний ногоо, эмийн ургамал, гүргэм зэрэг өндөр үр ашигтай ургацыг бага хэмжээгээр тариалах | ҮХЦТ-нд тусгасан Үр тарианы үйлдвэрлэлийг төрөлжүүлэх төслийн саналтай нийцэж байна. |
| 15 | Баянхонгор~Богд, Баянхонгор~Баянцагаан, Баянхонгор~Эрдэнэцогт чиглэлийн авто замыг сайжруулах хөтөлбөр | III3 Аймгуудын тусгай зориулалтын авто зам барьж байгуулах төсөл болон III1Авто замын тойрог сүлжээ барьж байгуулах төслийн саналтай нийцэж байна. |

## Хүснэгт 6. Хэнтий аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд болон ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүдийн саналын харьцуулалт

| | **Хэнтий аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд** | **ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд** |
|---|---|---|
| 1 | Өрсөлдөх чадвартай, тогтвортой МАА болон хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх | I2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл I4.1 Тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төслийн саналтай нийцэж байна. |
| 2 | Хэрлэн голын сав газар, Онон голын сав газар дагуу усжуулалттай газар тариаланг хөгжүүлэх | I5.1 Усжуулалтын төслийн саналыг илүү нарийвчилсан байдлаар тусгасан байна. |
| 3 | Биндэр, Дадал, Өмнөдэлгэр, Батширээт сумдад тогтвортой бөгөөд эдийн засгийн хүртээмжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх | ҮХЦТ-нд тусгасан Дадал сумыг эко туризмын төв болгох, Биндэр сумыг аялал жуулчлал болон агро чиглэлийн үйлчилгээний төв, Жаргалтхаан ~ Өмнөдэлгэрийн авто замыг сайжруулах төслийн саналтай нийцэж байна. |
| 4 | Өндөрхаан хотыг Зүүн бүсийн логистик төв болгон хөгжүүлэх | III11Бүсийн болон орон нутгийн хотуудыг хөгжүүлэх төслийн санал |
| 5 | Бор-Өндөр~Өндөрхааны авто замын тэнхлэгийг сайжруулах | III3 Аймгуудын тусгай зориулалтын авто зам барьж байгуулах төслийн санал |

| | | |
|---|---|---|
| 6 | Дадал сум-эко аялал жуулчлал, Өмнөдэлгэр сум-газар тариалан ойн аж ахуй, Баян-Адарга сум, Өндөрхаан хот орчимд- сүүний ферм, Баян-Овоо, Мөрөн, Норовлин сум-газар тариалан хөгжүүлэх | ҮХЦТ-нд тусгасан Дадал сумыг эко туризмын төв болгох саналтай нийцэж байна. Мөн I5 Газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх хөтөлбөрүүд болон I6 Үхрийн аж ахуйн хосолсон төслийн саналыг илүү нарийвчилсан байдлаар тусгасан байна. |
| 7 | Бор-Өндөр сумыг Хэнтий аймгийн өмнөд хэсгийн сум дундын төв, Биндэр сумыг аймгийн хойд хэсгийн сум дундын төв болгох, Бэрх тосгоныг МАА-н салбарын дунд түвшний үйлчилгээ, байгууламж бүхий суурингаар хөгжүүлэх | ҮХЦТ-нд хамаарахгүй. |
| 8 | Бор-Өндөр ~ Даланжаргалан чиглэлийн авто замыг сайжруулах ажил (барилгын ажил явагдаж байгаа) | III2 Аймаг хоорондын авто замыг барих, сайжруулах төслийн санал |
| 9 | Өндөрхаан~Бэрх~Дадал чиглэлийн авто зам (барилгын ажил явагдаж байгаа) | III3 Аймгуудын тусгай зориулалтын – аялал жуулчлалын авто зам барьж байгуулах төслийн санал |
| 10 | Аймгийн урд хэсгийн Галшар, Дархан сумдад ноолуурын үйлдвэрлэл, адуу үржлийн өрсөлдөх давуу талуудыг хөхүүлэн дэмжих | I2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төслийн санал |
| 11 | Баруун хойд ташуу чиглэлд Цэнхэрмандал сумаас Дадал хүртэл ойн аж ахуйг хөгжүүлэх | ҮХЦТ-нд тусгасан Хэнтий аймагт модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх саналтай нийцэж байна. |
| 12 | Төвийн бүс болон аймгийн өмнөд хэсгийг холбосон Биндэр, Батноров, Өмнөдэлгэр, Галшар, Баян-Овоо, Өндөрхаан зэрэг сумдад эрчимжсэн МАА-г хөгжүүлэх | I4 МАА, газар тариалангийн салбар хосолсон төслийн санал |

## Хүснэгт 7. Сүхбаатар аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд болон ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүдийн саналын харьцуулалт

| | **Сүхбаатар аймгийн АХЧБТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд** | **ҮХЦТ-нд тусгасан төсөл, хөтөлбөрүүд** |
|---|---|---|
| 1 | МАА-н салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр: худаг, малын хашаа хороо, тэжээлийн агуулах, мал эмнэлгийн үйлчилгээ, гарал үүслийн систем, санхүүжилт, институцийн зохион байгуулалтыг сайжруулах, хөгжүүлэх г.м. | II2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төслийн санал |
| 2 | Малын тоо толгой, газрын доройтлыг хянах бэлчээрийн менежмент | ҮХЦТ-нд тусгасан бэлчээр ашиглалтын хяналт бүхий бүсийг байгуулах, бэлчээрийн менежментийг сайжруулах үйл ажиллагаатай нийцэж байна. |

| | | |
|---|---|---|
| 3 | Орон нутгийн өндөр ашиг шимт малын үүлдэр угсааг хамгаалах: Баяндэлгэр сумын ноолуурын чиглэлийн улаан ямаа, махны чиглэлийн Үзэмчин хонь, улаан үхэр | ҮХЦТ-нд тусгасан Сүхбаатар аймагт МАА-г хөгжүүлэхийн тулд уламжлалт болон өндөр ашиг шимт малын удмын санг бий болгох саналтай нийцэж байна. |
| 4 | МАА-г хөгжүүлэхэд малын гоц халдварт өвчингүй бүс болон гарал үүслийн хяналтын систем бий болгох | ҮХЦТ-нд тусгасан Малын гоц халдварт өвчингүй, эрүүл бүс байгуулах үйл ажиллагааны саналтай нийцэж байна. |
| 5 | Хэрлэн гол дагуу Түмэнцогтын усжуулалтын системийг байгуулах | I5.1Усжуулалтын төслийн саналыг илүү нарийвчилсан байдлаар тусгасан байна. Мөн ҮХЦТ-нд тусгасан Хэрлэн голын усжуулалтын системийг барьж байгуулах төслийн саналтай нийцэж байна. |
| 6 | Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах | ҮХЦТ-нд тусгасан I3.2 Хүлэмжийн аж ахуйг дэмжих төслийн саналтай нийцэж байна. |
| 7 | Орон нутгийн хотуудын хөтөлбөр: Эрдэнцагаан, Онгон, Түмэнцогт | ҮХЦТ-нд хамаарахгүй. |
| 8 | Авто зам сайжруулах хөтөлбөр: Баруун-Урт~Бичигт, Эрдэнэцагаан~Дарьганга, Баруун-Урт~Чойбалсан, Баруун-Урт~Онгон чиглэлийн авто замууд | III3 Аймгуудын тусгай зориулалтын авто зам барьж байгуулах төсөл болон III2 Аймаг хоорондын авто замыг барих, сайжруулах төслийн саналтай нийцэж байна. |
| 9 | Бичигт боомтоор нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх барилга байгууламжийг өргөжүүлэх | ҮХЦТ-нд тусгасан БНХАУ болон ОХУ-тай хийх хилийн худалдааг үе шаттайгаар өргөжүүлэх саналтай нийцэж байна. |
| 10 | Дарьганга-Эрдэнэцагааныг холбосон аялал жуулчлалын хөтөлбөр: байгалийн цогцолбор газрууд, Шилийн богдын галт уул, Дарьганга болон Эрдэнэцагааны Үзэмчин ястны ахуй байдалтай танилцах аялал | ҮХЦТ-нд тусгасан Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд Эрдэнэцагаан, Дарьгангыг холбосон аялал жуулчлал, худалдааг үе шаттайгаар өргөжүүлэх төслийн саналтай нийцэж байна. |
| 11 | Сүхбаатарын аж үйлдвэрлэлийн паркийг дахин сэргээх | ҮХЦТ-нд тусгасан Хөнгөн үйлдвэрлэлийг салбарыг өргөжүүлэх саналтай нийцэж байна. |
| 12 | Баруун-Урт сумын ус хангамжийн шугам сүлжээг өргөтгөх, усны чанар сайжруулах | IV7.1 Хот, суурины ус хангамжийг сайжруулах төслийн санал болон ҮХЦТ-нд тусгасан Баруун-Урт сумын ус хангамжийг сайжруулах саналтай нийцэж байна. |
| 13 | Баруун-Урт суманд МАА-н суурь баазыг байгуулах | ҮХЦТ-нд тусгасан Баруун-Урт суманд МАА-г дэмжих төв байгуулах саналтай нийцэж байна. |

<u>Хавсралт E: Бусүүдийн тоо мэдээлэл болон дүн шинжилгээ</u>

## Хавсралт E: Бүсүүдийн тоо мэдээлэл болон дүн шинжилгээ

### 1. Бүсүүдийн тоо мэдээлэл болон дүн шинжилгээ

## 1) Эдийн засгийн 6 бүсийн харьцуулалт

### (1) Хүн ам

**Хүснэгт 1. Эдийн засгийн 6 бүсийн үндсэн үзүүлэлтүүд**

| Region | Land area (km2) | Population 2019 | Population 2017 | Population 2015 | Population 2010 | Population density 2019 (/km2) | Population growth rate 2010-15 (% p.a.) | Population growth rate 2015-17 (% p.a.) | Population growth rate 2010-17 (% p.a.) | Population growth rate 2015-19 (% p.a.) | Urbanization rate 2019 (%) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Western Region | 191,400 | 281,500 | 271,700 | 264,500 | 238,200 | 1.24 | 2.12 | 1.35 | 1.90 | 1.57 | 36.5 |
| *Khangai Region* | 332,400 | 689,700 | 677,300 | 658,100 | 602,300 | 1.81 | 1.79 | 1.45 | 1.69 | 1.18 | 47.0 |
| *Altai Region* | 320,300 | 263,100 | 259,200 | 252,500 | 231,100 | 0.72 | 1.34 | 1.32 | 1.65 | 1.03 | 31.9 |
| *Southern Region* | 355,100 | 205,200 | 196,600 | 187,900 | 172,500 | 0.49 | 1.72 | 2.29 | 1.89 | 2.23 | 46.2 |
| *Eastern Region* | 286,200 | 223,300 | 216,200 | 208,100 | 186,900 | 0.65 | 2.17 | 1.93 | 2.10 | 1.78 | 41.5 |
| *Capital Region* | 78,700 | 1,634,100 | 1,557,000 | 1,486,700 | 1,329,800 | 16.90 | 2.26 | 2.34 | 2.28 | 2.39 | 95.3 |
| **Mongolia** | **1,564,100** | **2,939,500** | **2,824,800** | **2,714,900** | **2,444,300** | **1.56** | **2.12** | **2.00** | **2.09** | **2.01** | **67.2** |

Нийслэлийн бүсийн эдийн засгийн төвлөрөл болон Өмнөд бүсийн уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжлөөс үүдэн 2010-2015 оноос 2015-2019 онд тус бүсүүдийн хүн ам хурдацтай өссөн. Харин Хангайн бүсийн хүн амын өсөлт ихээхэн удаашралтай байсан бөгөөд мөн Баруун, Зүүн бүсийн хүн амын өсөлт удаашралтай байв. Энэхүү удаашрал нь Хангайн бүсийн эдийн засгийн бүтэцтэй холбоотой бөгөөд Баруун болон Зүүн бүсийн эдийн засгийн хөгжил төдийлөн сайн бус байна. Эдийн засгийн зогсинго байдлаас хамааран энэ хугацаанд Алтайн бүсийн хүн амын өсөлт тогтмол бага байсаар ирсэн.

Нийслэлийн бүсэд хүн амын нягтрал хамгийн өндөр буюу 1 км2 талбайд 16.9 хүн ногдож байгаа бол Хангайн бүсэд 1 км2 талбайд 1.81 хүн, Баруун бүсэд 1 км2 талбайд 1.24 хүн тус тус ногдож байна. Эдийн засгийн бусад бүсүүдэд 1 км2 талбайд 1.0-ээс бага хүн ногдож байна. Хотжилтын түвшин Нийслэлийн бүсэд хамгийн өндөр буюу 95.3%, Хангайн бүсэд 47.0%, Өмнөд бүсэд 46.2%, Баруун бүсэд 41.5% байна. Орон нутгийн эдийн засгийн байдлаас хамааран Баруун болон Алтайн бүсийн хотжилтын түвшин доогуур байна.

### (2) Эдийн засаг

**Хүснэгт 2. Эдийн засгийн үзүүлэлтээр 6 бүсийг харьцуулсан байдал (1/2)**

| Эдийн засгийн бүс | БДНБ-д ХАА салбарын эзлэх хувь (2019) | БДНБ-д Аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь (2019) | БДНБ-д Үйлчилгээ-ний салбарын эзлэх хувь (2019) | БДНБ-д аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувь | БДНБ (2019) | 1 хүнд ногдох БДНБ (2019) | 1 хүнд ногдох хөрөнгийн зардал | Аймгийн 1 хүнд ногдох орлого |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | % | % | % | % | ₮10⁶ | ₮10³ | ₮10⁶ | ₮10³ |
| Баруун бүс | *38.8* | *25.1* | *36.1* | *61.2* | *1,355,608* | *4,81* | 221 | 814 |
| *Хангайн бүс* | 26.6 | 49.7 | 23.8 | 73.5 | 5,475,615 | 7,939 | 238 | 789 |
| *Алтайн бүс* | 50.6 | 18.9 | 30.4 | 49.3 | 1,436,090 | *5,458* | | 844 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| *Өмнөд бүс* | 29.8 | 31.5 | 38.7 | 70.2 | 1,787,629 | 8,712 | 1,634 | 1,460 |
| *Зүүн бүс* | 34.6 | 45.0 | 20.5 | 65.5 | 27,784,284 | 8,694 | 178 | 823 |
| *Нийс-лэлийн бүс* | 1.7 | 41.5 | 56.9 | 98.4 | 25,842,826 | 15,815 | | 896 |
| **Мон-гол Улс** | **10.6** | **39.4** | **50.0** | **89.4** | **37,839,225** | **12,873** | 1,103 | 1,001 |

Нийслэлийн бүсийн нэг хүнд ногдох БДНБ хамгийн өндөр буюу 2019 оны байдлаар 15.8 сая төгрөг байсан бол энэхүү үзүүлэлт Өмнөд бүсэд 8.71 сая төгрөг, Зүүн бүсэд 8.69 сая төгрөг байв. Хэдийгээр нэг хүнд ногдох БДНБ-ий хэмжээ ижил байгаа боловч эдгээр бүсүүд болон Хангайн бүсийн эдийн засгийн бүтэц эрс өөр байна. Хангайн бүсийн нэг хүнд ногдох БДНБ 7.94 сая төгрөг бөгөөд эдийн засгийн төрөлжилт илүү байна. Хангайн бүсийн БДНБ-д аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувь Өмнөд болон Зүүн бүстэй харьцуулахад их байна. Алтайн бүсийн нэг хүнд ногдох БДНБ 5.46 сая төгрөг бөгөөд БДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь давамгайлсан Баруун бүсийн нэг хүнд ногдох БДНБ 4.82 сая төгрөг байсан байна.

Өмнөд бүсэд уул уурхайн үйлдвэрлэл зонхилж байгаатай холбоотойгоор нэг хүнд ногдох хөрөнгийн зардал болон аймгийн нэг хүнд ногдох орлого хамгийн өндөр байна. Нийслэлийн бүс тухайн 2 үзүүлэлтээр улсад 2 дугаар байранд орж байна. Баруун бүсийн нэг хүнд ногдох хөрөнгийн зардал хамгийн бага байсан бөгөөд удаах байранд Зүүн болон Алтайн бүс орж байна. Аймгийн нэг хүнд ногдох орлого бусад 4 бүсийн хувьд ижил төстэй байна.

Эдийн засгийн 6 бүсийн мал аж ахуй эрхлэлт байгаль газар зүйн нөхцөл байдал, мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах зах зээлд дөт байдал зэргээс хамааран харилцан адилгүй байна. Өмнөд бүс малтай нэг өрхөд ногдох малын тоогоор улсад эхний байранд ордог бол удаах байранд Баруун болон Алтайн бүс тус тус орж байгаа нь тухайн бүсүүдэд мал аж ахуй эрхлэлт давамгайлж буйг харуулж байна. 100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тооны хувьд Хангайн бүс эхний байранд орж байгаа бол удаах байранд Нийслэлийн болон Алтайн бүс тус тус орж байгаа нь эрчимжсэн мал аж ахуй эрхлэлттэй холбоотой юм. Баруун бүс малтай нэг өрхөд ногдох малын тоогоор хамгийн сүүлийн байр, 100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор Өмнөд бүсийн өмнө сүүлээсээ 2–рт орж байгаа нь уламжлалт мал аж ахуй эрхлэлт давамгайлсантай холбоотой байж болно.

Алтайн бүсэд нийт ажиллагсадад малчдын эзлэх хувь хамгийн өндөр байгаа бол түүний дараа Зүүн болон Баруун бүс тус тус орж байна. Энэхүү үзүүлэлт Нийслэлийн бүсэд хамгийн доогуур байгаа бол удаах байранд мал маллагааны дэвшилтэт арга технологийг нэвтрүүлж буй Өмнөд болон Хангайн бүс тус тус орж байна.

Өмнөд, Алтайн болон Хангайн бүсэд ажилгүйдлийн түвшин бага байна. Зүүн бүсэд хөдөлмөрийн бүтээмж хамгийн өндөр байгаа бол удаах байранд Нийслэлийн болон Хангайн бүс орж байна. Дээрх 2 үзүүлэлтийн хувьд Баруун бүс хамгийн доогуур байр эзэлж байна. Зүүн бүсэд хөдөлмөрийн бүтээмж өндөр байгаа хэдий ч ажилгүйдлийн түвшин их байна. Эсрэгээрээ Өмнөд бүсэд ажилгүйдлийн түвшин хамгийн бага байгаа хэдий ч хөдөлмөрийн бүтээмж бага

байна. Энэхүү ялгаатай байдал нь Өмнөд бүсэд БДНБ-д үйлчилгээний салбарын эзлэх хувь их байгаагаар тайлбарлаж болох юм. Мөн ядуурлын түвшин Өмнөд бүсэд хамгийн бага байгаа бөгөөд удаах байранд Нийслэлийн болон Хангайн бүс тус тус орж байна.

**Хүснэгт 3. Эдийн засгийн үзүүлэлтээр 6 бүсийг харьцуулсан байдал (2/2)**

| Эдийн засгийн бүс | Малтай нэг өрхөд ногдох малын тоо (2019) | 100 га бэлчээр-ийн талбайд ногдох хонин толгойд шилжүүл-сэн малын тоо (2019) | Нийт ажиллаг-садад малчдын эзлэх хувь (2019) | Ажилгүйд-лийн түвшин (2019) | Хөдөлмөр-ийн бүтээмж (2019) |
|---|---|---|---|---|---|
| | | | % | % | ₮10³ |
| Баруун бүс | 340 | 468 | 36.1 | *13.8* | 9,686 |
| *Хангайн бүс* | 386 | 1,129 | 35.0 | *9.4* | 16,984 |
| *Алтайн бүс* | 389 | 777 | 49.2 | *7.7* | 9,802 |
| *Өмнөд бүс* | 544 | 353 | 33.6 | *5.3* | 15,210 |
| *Зүүн бүс* | 534 | 529 | 39.7 | *12.0* | 20,624 |
| *Нийслэлийн бүс* | 366 | 1,006 | 4.8 | *10.6* | 17,570 |
| **Монгол Улс** | 414 | 643 | 24.9 | **10.0** | 15,825 |

**(3) Нийгмийн хөгжлийн үзүүлэлт**

Эдийн засгийн 6 бүс нь нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн хувьд төдийлөн ялгаагүй байна. Баруун бүсийн Баян-Өлгий аймгийг (66.9%) эс тооцвол хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт ерөнхийдөө 80-аас дээш хувьтай байна. Сурагч-багшийн харьцаа Баян-Өлгий аймагт 21, Говь-Алтай аймагт 22, Орхон аймагт 36 байгаа бөгөөд бусад аймгуудад 25~32 хооронд хэлбэлзэлж байна. Аймгуудын хувьд нялхсын эндэгдлийн түвшин ихээхэн ялгаатай байгаа бөгөөд ерөнхийдөө Баруун болон Алтайн бүс, бусад бүсийн зарим нэг цөөн аймгуудад өндөр байна. Эмнэлгийн ажилтнуудын хүрэлцээ эдийн засгийн хөгжлийн түвшинг илтгэхгүй бөгөөд тус үзүүлэлт нь Хангай, Зүүн болон Баруун бүсүүдэд доогуур байна. Нийслэлийн бүсэд 10,000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо хамгийн өндөр байгаа бол удаах байранд Баруун бүс орж байна. Харин уг үзүүлэлт Баруун бүсэд хамгийн бага байна.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 1,000 хүнд ногдох суралцагчийн тоо ажил, хөдөлмөр эрхлэлтийн боломжийг илтгэх бөгөөд энэхүү үзүүлэлт Өмнөд бүсэд хамгийн өндөр байгаа бөгөөд удаах байранд Нийслэлийн, Зүүн болон Хангайн бүс тус тус орж байна. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш нарын тоо Хангайн бүсэд хамгийн өндөр, удаах байранд Өмнөд болон Зүүн бүс орж байна. Харин энэхүү үзүүлэлт Алтайн болон Нийслэлийн бүсэд хамгийн доогуур байна.

**Хүснэгт 4. Нийгмийн хөгжлийн үзүүлэлтээр 6 бүсийг харьцуулсан байдал**

| Эдийн засгийн бүс | Хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт (2018) | Бага боловсролын сурагч-багшийн харьцаа (2018) | Нялхсын эндэгдлийн түвшин (2019) | 1 их эмчид ногдох хүний тоо (2019) | 10,000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо | Ядуурлын түвшин (2018) | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 1,000 хүнд ногдох суралцагчийн тоо (2019/2020) | 1,000 хүнд ногдох Мэргэжлийн сургалт,үйлдвэрлэлийн төвийн багшийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | % | | /1,000 төрөлт | | | % | | |
| Баруун бүс | 66.9~86.4 | 21~29 | 14~21 | *400* | *63* | *31.2* | 9.4 | 1.27 |
| *Хангайн бүс* | 78.4~92.3 | 25~36 | 8~18 | *413* | *105* | *30.7* | 10.0 | 1.57 |
| *Алтайн бүс* | 87.3~91.0 | 22~29 | 13~15 | *388* | *111* | *35* | 9.9 | 1.19 |
| *Өмнөд бүс* | 78.0~89.3 | 25~32 | 7~21 | *293* | 118 | *21.6* | 13.9 | 1.51 |
| *Зүүн бүс* | 87.0~90.4 | 27~31 | 7~16 | *412* | *166* | *37* | *10* | 1.36 |
| *Нийслэлийн бүс* | | | 13~15 | *215* | *166* | *26* | 12.5 | 1.25 |
| **Монгол Улс** | | | 13 | **271** | 154 | **28.4** | 12.9 | 1.50 |

## (4) Газрын сан, усны нөөц

Бүсүүдийн хөгжлийн потенциал нь газар зүйн, байр зүйн, цаг уурын болон бусад байгалийн нөхцөлүүдээс шалтгаалж өөр өөр байна. Тухайлбал Хангайн бүсэд 70,809 км2 ойн сан байгаа нь Монгол Улсын нийт ойн сангийн 70 гаруй хувийг бүрдүүлж байна. Хангайн бүс, Алтайн бүс, Баруун бүсэд зудын гамшигт өртөж болзошгүй бүс нутгууд голчлон ногдож байна. Өмнөд бүс, Алтайн бүс, Баруун бүсэд их, дунд зэргийн хуурайшилттай бүс нутгууд байна.

Малын тэжээл тариалахад хамгийн тохиромжтой газар нутагтай бүсэд Зүүн бүс, Баруун бүс, Хангайн бүс багтаж байна. Тосны ургамал тариалахад тохиромжтой бүсэд Өмнөд бүс багтаж байгаа бөгөөд энэ төрлийн тариалан эрхлэхэд тохиромжтой газар нутгийн 73% нь энэ бүсэд ноогдож байна. Жимс, жимсгэнэ тариалахад тохиромжтой бүсэд Зүүн, Өмнөд, Баруун, Алтайн бүс багтаж байна. Нийслэлийн бүсийн газар нутгийн 30 орчим хувьд эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой бол Баруун бүсийн газар нутгийн 24 орчим хувь нь бэлчээр ашиглалтын хяналт бүхий газрын ангилалд багтаж байна.

**Хүснэгт 5. Газрын үзүүлэлтүүд (6 бүсийн харьцуулалт)**

| Region/aimag | Forest area (%) | Sown area (ha) | Controlled grazing (%) | Intensive livestock (%) | High dzud risk area (km2) | High & moderately dry (%) | Highly suitable for fodder (km2) | Moderately suitable for oil seed (km2) | High & moderately suitable for fruit (km2) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Western Region | *6,002* | *15,254* | *23.7* | *5.1* | *32,930* | 15~68 | 74,950 | 3,896 | 145,281 |
| *Khangai Region* | 70,809 | *103,914* | *0.0* | 6.7 | *85,545* | 0~40 | 64,449 | 1,227 | 97,743 |
| *Altai Region* | *17,028* | *12,609* | *0.0* | *2.5* | *49,262* | 61~88 | 24,472 | 17,900 | 142,398 |
| *Southern Region* | 9,809 | *438* | *0.4* | *8.5* | *62* | 61~75 | 30,385 | 191,401 | 155,407 |
| *Eastern Region* | 13,048 | *71,608* | 0.0 | 2.8 | 0 | 100 | 178,047 | 48,231 | 272,252 |
| *Capital Region* | 6,472 | 109,664 | 0.0 | 29.8 | 29 | 19~74 | 20,793 | 380 | 30,978 |
| **Mongolia** | **100,409** | **192,039** | 8.3 | 6.5 | 118,555 | 0~39 | 329,395 | 261,808 | 717,098 |

Бүсүүдийн усны нөөц, хүртээмж харилцан адилгүй байна. Хангайн бүс нь хамгийн их нөөцтэй буюу нэгж талбайд ноогдох усны нөөц 145,000 м3/км2 байна. Баруун бүс нь усны нөөцөөрөө 2-т орж байгаа ч Хангайн бүсийнхээс ихээхэн зөрүүтэй буюу 49 м3/км2, дараа нь Нийслэлийн бүс 43 м3/км2 нөөцтэй байна. Нэг хүнд ноогдох усны нөөц нь Нийслэлийн бүсэд 2.1 м3/км2 байгаа бол бусад бүсэд 19-44 м3/км2 хооронд хэлбэлзэж байна.

**Хүснэгт 6. Усны нөөц (6 бүсийн харьцуулалт)**

| Бүс | Нэгж талбайд ногдох усны нөөц (1,000 м3/км2) | | | Хүн амд ногдох усны нөөц (1,000 км2) | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Гадаргын усны нөөц | Газрын доорх усны нөөц | Нийт | Гадаргын усны нөөц | Газрын доорх усны нөөц | Нийт |
| Баруун бүс | 25.87 | 23.56 | 49.44 | 17.59 | 16.02 | 33.62 |
| Хангайн бүс | 54.44 | 90.75 | 145.19 | 16.47 | 27.46 | 43.93 |
| Алтайн бүс | 8.75 | 16.66 | 25.41 | 10.66 | 20.28 | 30.94 |
| Өмнөд бүс | 1.89 | 8.94 | 10.82 | 3.27 | 15.46 | 18.73 |
| Зүүн бүс | 4.20 | 29.65 | 33.85 | 5.38 | 38.00 | 43.38 |
| Нийслэлийн бүс | 13.86 | 29.16 | 43.02 | 0.67 | 1.40 | 2.07 |
| **Монгол Улс** | 15.33 | 29.67 | 45.00 | 6.70 | 12.96 | 19.66 |

## 2. бүсийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийн харьцуулалт

Нийслэлийн бүс нь эдийн засгийн бүтэц, орлогын өндөр түвшингээс шалтгаалж эдийн засгийн үзүүлэлтүүд, хөдөлмөрийн бүтээмж, ядуурлын түвшингээр дээгүүр байр эзэлж байна. Нөгөөтээгүүр энэ бүс хэт их төвлөрлийн улмаас хүн амд ноогдох МСҮТ-ийн багшийн тоо, хүн амд ноогдох халдварт өвчний тоо зэрэг үзүүлэлтээр доогуур байр эзэлж байна. Зүүн бүс дэх уул уурхайн үйл ажиллагааны дүнд энэ бүс хөдөлмөрийн бүтээмжийн үзүүлэлтээр хамгийн өндөр байр эзэлсэн бол мал аж ахуйн үзүүлэлтүүдээр мөн өндөр байр эзэлж байна.

Өмнөд бүс нь ашигт малтмал олборлох том төслүүд, уул уурхайн үйл ажиллагааны үр дүнд аймгийн нэг хүнд ногдох орлого болон нэг хүнд ногдох капиталын зардлын үзүүлэлтээр хамгийн өндөр байр эзэлж байна. Ядуурлын түвшин, хүн амд ноогдох МСҮТ-д суралцагчдын тоо, МСҮТ-ийн багшийн тоо зэрэг нийгмийн үзүүлэлтүүдээр мөн хамгийн өндөр байр эзэлж байгаа бөгөөд зарим үзүүлэлт нь чадварлаг, мэргэжлийн ажиллах хүчний ажил эрхлэх боломж нэмэгдэж байгааг илтгэж байна. Өмнөд бүс дэх мал аж ахуй эрхлэлтийн үзүүлэлт нь өргөн уудам газар нутагт бэлчээрийн МАА эрхэлж байгаатай нь холбоотой.

Алтайн бүс нь нийт ажиллагсдын тоонд малчдын эзлэх хувь хамгийн их байдаг мал аж ахуйн бүс юм. Тус бүсийн эдийн засгийн үзүүлэлтүүд дундаж бөгөөд ур чадвараа дээшлүүлэх нөхцөл, боломж хязгаарлагдмал ч харьцангуй өндөр орлого, капиталын зардалтай, ажилгүйдлийн түвшин доогуур үзүүлэлттэй байна. Хангайн бүс нь бусад бүстэй харьцуулахад эдийн засгийн үйл ажиллагаа нь илүү өргөн хүрээний буюу хувийн хэвшлийн идэвхтэй үйл ажиллагаатай хэдий ч гүйцэтгэл нь дунд зэрэг тул эдийн засгийн үзүүлэлтээр дээгүүр байр эзэлдэггүй. Хангайн бүсэд уламжлалт мал аж ахуй эрхлэхээс гадна эрчимжсэн МАА эрхэлдэг. Нэг хүнд ногдох БДНБ-ээрээ Нийслэлийн бүсийн дараа буюу хоёрт ордог.

Баруун бүс нь нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдээрээ доогуур байр эзэлж байна. Тус бүс нь нийт ажиллагсдын тоонд малчдын эзлэх хувиар 3-т ордог ба малчин өрхөд ногдох малын тоо, 100 га бэлчээрийн талбайд ногдох малын тоогоороо доогуур байр эзэлдэг. Түүнчлэн ажилгүйдлийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжийн үзүүлэлт өндөр биш байна. Эдгээр тааруу үзүүлэлтүүд нь сүүлийн жилүүдэд хүн амын өсөлт төдийлөн нэмэгдэхгүй байх шалтгаан болж байна.

**Хүснэгт 7. 6 бүсийн харьцуулалт, нийгэм-эдийн засгийн үзүүлэлтээр (1/2)**

| | Баруун бүс | Хан-гай бүс | Алтайн бүс | Өмнөд бүс | Зүүн бүс | Нийслэл-ийн бүс |
|---|---|---|---|---|---|---|
| **ЭЗ-ийн үзүүлэлтүүд** | | | | | | |
| Хүн амын өсөлт (2015-2019) | 4 | 5 | 6 | 2 | 3 | 1 |
| Нэг хүнд ногдох БДНБ | 5 | 2 | 6 | 3 | 4 | 1 |
| Аймгийн нэг хүнд ноогдох орлого | 5 | 6 | 3 | 1 | 4 | 2 |
| Нэг хүнд ногдох капиталын зардал | 6 | 3 | 4 | 1 | 5 | 2 |
| **Нийгмийн үзүүлэлтүүд** | | | | | | |
| Ажилгүйдлийн түвшин | 6 | 3 | 2 | 1 | 5 | 4 |
| Хөдөлмөрийн бүтээмж | 6 | 3 | 5 | 4 | 1 | 2 |
| Ядуурлын түвшин | 4 | 3 | 5 | 1 | 6 | 2 |
| Хүн амд ноогдох МСҮТ-д суралцагчдын тоо | 6 | 3 | 5 | 1 | 4 | 2 |
| Хүн амд ноогдох МСҮТ-ийн багшийн тоо | 4 | 1 | 5 | 2 | 3 | 5 |
| Нэг их эмчид ногдох хүний тоо | 4 | 6 | 3 | 2 | 5 | 1 |
| Хүн амд ногдох халдварт өвчний тоо | 1 | 2 | 3 | 4 | 5 | 5 |
| **МАА-тай холбоотой үзүүлэлтүүд** | | | | | | |
| Малчин өрхөд ногдох малын тоо | 6 | 4 | 3 | 1 | 2 | 5 |
| 100 га бэлчээрийн талбайд ногдох малын тоо | 5 | 1 | 3 | 6 | 4 | 2 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт ажиллагсдын тоонд малчдын эзлэх хувь | 3 | 4 | 1 | 5 | 2 | 6 |

Баруун бүс нь харьцангуй газрын сан, усны нөөц ихтэй тул малын тэжээл, жимс жимсгэнэ тариалахад тохиромжтой ч эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломж хязгаарлагдмал байх магадлалтай. Баруун бүс нь усны нөөцөөрөө 2-т ордог. Хангайн бүс нь Монгол Улсын газар тариалангийн гол бүс боловч малын тэжээлээс бусад тариалалтаар дээгүүр байрт ороогүйг хүснэгтээс харж болно. Тус бүсэд эрчимжсэн буюу хагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэх нөөц боломжтой. Хангайн бүс нь нэгж талбайд ногдох усны нөөц, 1 хүнд ногдох усны нөөц ихтэй бүсэд тооцогддог.

Алтайн бүсэд малын тэжээл, тосны ургамал, жимс тариалах нөөц боломжтой ч, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх нөөц хязгаарлагдмал. Алтайн бүс нь нэгж талбайд ногдох усны нөөцөөрөө 5-д, хүн амд ноогдох усны нөөцөөрөө 4-т орж байна. Өмнөд бүс нь газар тариалан эрхлэхэд харьцангуй тохиромжтой бүсэд тооцогдож байгаа ч усны нөөц, хүртээмжээр хувьд доогуур байр эзэлж байна.

Зүүн бүсийн газар нь малын тэжээл, тосны ургамал, жимс жимсгэнэ тариалах, эрчимжсэн буюу хагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд харьцангуй тохиромжтойд тооцогдож байна. Харин усны нөөц, хүртээмжээр доогуур эрэмбэлэгдэж байна. Нийслэлийн бүс нь газар тариалан эрхлэлтийн тохиромжтой байдлаар харьцуулахад хамгийн доогуур байр эзэлж байгаа ч эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой байдлаар хамгийн тохиромжтойд тооцогдож байна. Түүнчлэн энэ бүс нь нэгж талбайд ноогдох усны нөөцөөрөө 3-т, хүн амд ногдох усны нөөцөөрөө хамгийн доогуур эрэмбэлэгдэж байна.

**Хүснэгт 8. 6 бүсийн харьцуулалт, нийгэм-эдийн засгийн үзүүлэлтээр (2/2)**

| Газрын тохиромжтой байдал | Баруун бүс | Хангай бүс | Алтай бүс | Өмнөд бүс | Зүүн бүс | Нийслэл-ийн бүс |
|---|---|---|---|---|---|---|
| Малын тэжээл тариалалтад тохиромжтой байдал | 2 | 3 | 5 | 4 | 1 | 6 |
| Тосны ургамал тариалалтад тохиромжтой байдал | 4 | 5 | 3 | 1 | 2 | 6 |
| Жимс жимсгэнэ тариалалтад тохиромжтой байдал | 3 | 5 | 4 | 2 | 1 | 6 |
| Эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой байдал | 4 | 3 | 6 | 2 | 5 | 1 |
| Нэгж талбайд ногдох усны нөөц | 2 | 1 | 5 | 6 | 4 | 3 |
| 1 хүнд ногдох усны нөөц | 3 | 1 | 4 | 5 | 2 | 6 |

# 3. Нэмэлт дата, мэдээлэл

| Region/aimag | Land area (km2) | Population 2019 | Population 2017 | Population 2015 | Population 2010 | Population density 2019 (/km2) | Population growth rate 2010-15 (% p.a.) | Population growth rate 2015-17 (% p.a.) | Population growth rate 2010-17 (% p.a.) | Population growth rate 2015-19 (% p.a.) | Urbanization rate 2019 (%) | Agriculture GRDP 2019 (%) | Industry GRDP 2019 (%) | Services GRDP 2019 (%) | GRDP share of industry & services (%) | GRDP 2019 (MNT106) | Per capita GRDP 2019 (MNT103) | Forest (ha) | Sown area (ha) | Controlled grazing (%) | Intensive livestock (%) | High dzud risk area (km2) | High & moderately dry (%) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Western Region | 191,400 | 281,500 | 271,700 | 264,500 | 238,200 | 1.24 | 2.12 | 1.35 | 1.90 | 1.57 | 36.5 | *38.8* | *25.1* | *36.1* | *61.2* | *1,355,608* | *4,816* | *6,002* | *15,254* | *23.7* | *5.1* | *32,930* | |
| Bayan-Ulgii | 45,700 | 108,600 | 102,600 | 100,200 | 88,200 | 1.93 | 2.58 | 1.19 | 2.18 | 2.03 | 37.5 | 42.2 | 15.3 | 42.5 | 57.8 | 425,584 | 3,919 | 226 | 1,222 | 9.0 | 29.6 | 4,806 | 15 |
| Uvs | 69,600 | 83,200 | 82,700 | 80,800 | 73,200 | 1.05 | 2.00 | 1.17 | 1.76 | 0.73 | 37.0 | 46.2 | 15.8 | 38.1 | 53.9 | 396,436 | 4,765 | 1,102 | 11,775 | 0.1 | 0.0 | 13,492 | 68 |
| Khovd | 76,100 | 89,700 | 86,400 | 83,500 | 76,800 | 1.01 | 1.69 | 1.72 | 1.70 | 1.81 | 34.9 | 30.5 | 29.6 | 38.4 | 68.0 | 533,589 | 5,949 | 4,674 | 2,257 | 0.4 | 10.7 | 14,632 | 58 |
| *Khangai Region* | 332,400 | 689,700 | 677,300 | 658,100 | 602,300 | 1.81 | 1.79 | 1.45 | 1.69 | 1.18 | 47.0 | 26.6 | 49.7 | 23.8 | 73.5 | 5,475,615 | 7,939 | 70,809 | *103,914* | *0.0* | 6.7 | *85,545* | |
| Arkhangai | 55,300 | 95,000 | 95,100 | 92,100 | 84,600 | 1.53 | 1.71 | 1.62 | 1.69 | 0.78 | 21.9 | 64.2 | 15.1 | 20.7 | 35.8 | 605,914 | 6,378 | 10,826 | 11,509 | 0.0 | 0.0 | 13,477 | 6 |
| Bulgan | 48,700 | 62,100 | 61,300 | 60,000 | 53,700 | 1.10 | 2.24 | 1.08 | 1.91 | 0.86 | 25.3 | 57.7 | 17.1 | 25.2 | 42.3 | 369,841 | 5,956 | 19,050 | 48,559 | 0.1 | 16.9 | 6 | 9 |
| Darkhan-Uul | 3,300 | 107,000 | 104,100 | 100,900 | 94,900 | 28.76 | 1.23 | 1.57 | 1.33 | 1.48 | 79.8 | 9.3 | 41.5 | 49.2 | 90.7 | 524,207 | 4,899 | 720 | 22,528 | 0.0 | 2.4 | 1 | 0 |
| Orkhon | 800 | 107,600 | 104,000 | 100,700 | 90,900 | 113.63 | 2.07 | 1.63 | 1.94 | 1.67 | 96.3 | 0.9 | 87.5 | 11.7 | 99.2 | 2,103,313 | 19,548 | 159 | 2,603 | 0.0 | 0.2 | 0 | 0 |
| Khuvsgul | 100,600 | 135,100 | 131,600 | 128,200 | 114,900 | 1.14 | 2.21 | 1.32 | 1.96 | 1.32 | 32.9 | 52.8 | 18.8 | 28.4 | 47.2 | 707,041 | 5,233 | 40,054 | 18,714 | 0.0 | 6.1 | 19,908 | 0 |
| Selenge | 41,200 | 110,100 | 109,600 | 106,300 | 97,900 | 2.38 | 1.66 | 1.54 | 1.63 | 0.88 | 34.5 | 27.5 | 42.2 | 30.3 | 72.5 | 739,908 | 6,720 | 15,339 | 208,968 | 0.0 | 3.9 | 106 | 0 |
| Zavkhan | 82,500 | 72,800 | 71,600 | 69,900 | 65,400 | 0.79 | 1.34 | 1.21 | 1.30 | 1.02 | 22.4 | 49.0 | 14.8 | 36.2 | 51.0 | 425,393 | 5,843 | 4,906 | 1,863 | 0.0 | 0.0 | 52,047 | 40 |
| *Altai Region* | 320,300 | 263,100 | 259,200 | 252,500 | 231,100 | 0.72 | 1.34 | 1.32 | 1.65 | 1.03 | 31.9 | 50.6 | 18.9 | 30.4 | 49.3 | 1,436,090 | *5,458* | *17,028* | *12,609* | *0.0* | *2.5* | *49,262* | |
| Bayankhongor | 116,000 | 88,700 | 86,600 | 83,900 | 76,200 | 0.66 | 1.94 | 1.60 | 1.84 | 1.40 | 36.1 | 51.2 | 16.3 | 32.5 | 48.8 | 453,977 | 5,118 | 3,307 | 754 | 0.0 | 16.6 | 22,802 | 75 |
| Gove-Altai | 141,400 | 57,700 | 57,500 | 56,200 | 53,500 | 0.38 | 0.99 | 1.15 | 1.04 | 0.66 | 32.5 | 52.0 | 17.5 | 30.5 | 48.0 | 333,345 | 5,777 | 12,213 | 1,320 | 0.2 | 0.0 | 20,479 | 88 |
| Uvurkhangai | 62,900 | 116,700 | 115,100 | 112,400 | 101,400 | 1.61 | 2.08 | 1.19 | 1.83 | 0.94 | 28.4 | 49.6 | 21.4 | 29.0 | 50.4 | 648,767 | 5,559 | 1,508 | 10,536 | 0.1 | 0.0 | 5,981 | 61 |
| *Southern Region* | 355,100 | 205,200 | 196,600 | 187,900 | 172,500 | 0.49 | 1.72 | 2.29 | 1.89 | 2.23 | 46.2 | 29.8 | 31.5 | 38.7 | 70.2 | 1,787,629 | 8,712 | 9,809 | *438* | *0.4* | *8.5* | *62* | |
| Goveisumber | 5,500 | 17,900 | 17,400 | 16,500 | 13,300 | 2.42 | 4.41 | 2.69 | 3.91 | 2.06 | 59.8 | 22.5 | 26.7 | 50.8 | 77.5 | 112,643 | 6,293 | 0 | 39 | 0.0 | 11.6 | 0 | 100 |
| Dornogovi | 109,500 | 71,000 | 68,100 | 65,300 | 58,900 | 0.54 | 2.08 | 2.12 | 2.10 | 2.11 | 64.0 | 29.6 | 16.7 | 53.6 | 70.3 | 460,604 | 6,487 | 1,585 | 122 | 65.7 | 2.8 | 0 | 100 |
| Dundgovi | 74,700 | 47,100 | 45,800 | 44,400 | 38,700 | 0.52 | 2.79 | 1.56 | 2.44 | 1.49 | 26.6 | 59.4 | 16.7 | 23.9 | 40.6 | 372,606 | 7,911 | 687 | 92 | 0.0 | 7.0 | 0 | 100 |
| Umnugovi | 165,400 | 69,200 | 65,300 | 61,700 | 61,600 | 0.37 | 0.03 | 2.88 | 0.84 | 2.91 | 37.7 | 17.8 | 46.8 | 35.4 | 82.2 | 841,776 | 12,164 | 7,537 | 185 | 31.7 | 5.9 | 62 | 100 |
| *Eastern Region* | 286,200 | 223,300 | 216,200 | 208,100 | 186,900 | 0.65 | 2.17 | 1.93 | 2.10 | 1.78 | 41.5 | 34.6 | 45.0 | 20.5 | 65.5 | 27,784,284 | 8,694 | 13,048 | *71,608* | 0.0 | 2.8 | 0 | |
| Dornod | 123,600 | 82,100 | 79,400 | 76,500 | 69,600 | 0.56 | 1.91 | 1.88 | 1.90 | 1.78 | 56.4 | 21.4 | 60.6 | 18.0 | 78.6 | 951,635 | 11,591 | 1,746 | 34,246 | 0.0 | 5.6 | 0 | 33 |
| Sukhbaatar | 82,300 | 63,200 | 61,100 | 59,000 | 51,400 | 0.62 | 2.80 | 1.76 | 2.50 | 1.73 | 29.5 | 39.0 | 42.2 | 18.8 | 61.0 | 514,237 | 8,137 | 1 | 9,219 | 0.0 | 0.0 | 0 | 74 |
| Khenti | 80,300 | 78,000 | 75,700 | 72,600 | 65,900 | 0.82 | 1.96 | 2.11 | 2.00 | 1.81 | 35.6 | 56.1 | 16.7 | 27.2 | 43.9 | 475,586 | 6,097 | 11,301 | 28,143 | 0.0 | 1.9 | 0 | 19 |
| *Capital Region* | 78,700 | 1,634,100 | 1,557,000 | 1,486,700 | 1,329,800 | 16.90 | 2.26 | 2.34 | 2.28 | 2.39 | 95.3 | 1.7 | 41.5 | 56.9 | 98.4 | 25,842,826 | 15,815 | 6,472 | 109,664 | 0.0 | 29.8 | 29 | |
| Ulaanbaatar | 4,700 | 1,539,800 | 1,463,000 | 1,396,300 | 1,244,400 | 264.77 | 2.33 | 2.36 | 2.34 | 2.48 | 100.0 | *0.3* | *42.0* | *57.7* | *99.7* | *25,217,038* | 16,377 | 741 | *825* | 0.0 | 62.3 | 18 | 0 |
| Tuv | 74,000 | 94,300 | 94,000 | 90,400 | 85,400 | 1.15 | 1.14 | 1.97 | 1.38 | 1.06 | 18.0 | 57.4 | 18.5 | 24.1 | 42.6 | 625,788 | 6,636 | 5,731 | 108,839 | 0.0 | 27.8 | 11 | 39 |
| **Mongolia** | **1,564,100** | **2,939,500** | **2,824,800** | **2,714,900** | **2,444,300** | **1.56** | 2.12 | 2.00 | 2.09 | 2.01 | 67.2 | **10.6** | **39.4** | **50.0** | **89.4** | **37,839,225** | 12,873 | **100,409** | **192,039** | 8.3 | 6.5 | 167,828 | 57 |

| Region/aimag | Sensitivity to mining | Highly suitable for fodder | Moderately suitable for oil seed | High & moderately suitable for fruit | Livestock population per herder household 2019 | Livestock population per 100ha pasture land 2019 | Share of herders in total employment 2019 | Unemployment rate (2019) | Labor productivity (2019) | Enrollment in kindergarten 2018 | Pupill-to-teacher ratio at primary education 2018 | Infant mortality rate 2019 | No. of people per physician 2019 | Infectious diseases per 10,000 people | Poverty incidence 2018 | Vocational students per 1,000 population 2019/20 | Vocational teachers per 1,000 population | Capital expenditure per capita | Aimag revenue per capita |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | (%) | (km2) | (km2) | (km2) | | | (%) | (%) | (MNT103) | (%) | | (/1,000birth) | | | (%) | | | (MNT106) | (MNT103) |
| *Western Region* | 60.8 | 74,950 | 3,896 | 145,281 | 340 | 468 | 36.1 | *13.8* | 9,686 | 66.9~86.4 | 21~29 | 14~21 | *400* | *63* | *31.2* | 9.4 | 1.27 | 97 | 814 |
| Bayan-Ulgii | 79.9 | 789 | 0 | 1,675 | 248 | 248 | 28.2 | 24.2 | 7,559 | 66.9 | 21 | 21 | 436 | 37 | 24.3 | 6.7 | 0.97 | 87 | 716 |
| Uvs | 71.5 | 7,636 | 1,954 | 27,105 | 358 | 768 | 48.9 | 6.6 | 11,767 | 86.4 | 25 | 14 | 423 | 75 | 29.6 | 11.0 | 1.49 | 122 | 967 |
| Khovd | 39.6 | 2,865 | 715 | 20,433 | 411 | 602 | 35.3 | 11.3 | 10,666 | 80.0 | 29 | 18 | 334 | 84 | 40.9 | 11.2 | 1.44 | 86 | 790 |
| *Khangai Region* | 72.2 | 64,449 | 1,227 | 97,743 | 386 | 1,129 | 35.0 | *9.4* | 16,984 | 78.4~92.3 | 25~36 | 8~18 | *413* | *105* | *30.7* | 10.0 | 1.57 | 384 | 789 |
| Arkhangai | 89.1 | 8,667 | 28 | 12,464 | 366 | 1,650 | 58.5 | 4.8 | 9,812 | 81.5 | 28 | 15 | 464 | 56 | 38.2 | 15.2 | 1.38 | 115 | 723 |
| Bulgan | 100.0 | 16,387 | 192 | 21,751 | 398 | 1,466 | 51.0 | 5.7 | 11,342 | 78.4 | 25 | 18 | 459 | 87 | 36.8 | 9.1 | 1.63 | 337 | 965 |
| Darkhan-Uul | 100.0 | 1,750 | 22 | 2,016 | 243 | 1,972 | 5.5 | 18.7 | 13,833 | 85.8 | 33 | 8 | 366 | 143 | 32.8 | 19.1 | 2.41 | 381 | 623 |
| Orkhon | 100.0 | 369 | 0 | 509 | 133 | 3,256 | 3.7 | 11.7 | 52,573 | 92.3 | 36 | 8 | 278 | 85 | 25.1 | 8.5 | 1.52 | 335 | 1,012 |
| Khuvsgul | 57.7 | 10,409 | 112 | 15,371 | 341 | 1,377 | 51.4 | 12.4 | 10,341 | 81.0 | 30 | 18 | 490 | 169 | 25.3 | 3.4 | 0.55 | 141 | 710 |
| Selenge | 99.6 | 12,605 | 55 | 14,896 | 318 | 1,045 | 16.9 | 4.7 | 14,828 | 80.5 | 29 | 10 | 437 | 66 | 34.0 | 6.2 | 1.40 | 769 | 706 |
| Zavkhan | 47.0 | 14,262 | 818 | 30,736 | 392 | 556 | 49.0 | 5.0 | 10,870 | 89.7 | 27 | 16 | 399 | 98 | 25.7 | 11.0 | 2.73 | 725 | 911 |
| *Altai Region* | 27.4 | 24,472 | 17,900 | 142,398 | 389 | 777 | 49.2 | *7.7* | 9,802 | 87.3~91.0 | 22~29 | 13~15 | *388* | *111* | *35* | 9.9 | 1.19 | 258 | 844 |
| Bayankhongor | 25.3 | 7,939 | 7,303 | 41,501 | 357 | 1,312 | 52.5 | 7.3 | 10,065 | 90.9 | 29 | 13 | 414 | 182 | 29.6 | 12.7 | 1.21 | 311 | 864 |
| Gove-Altai | 18.3 | 7,077 | 3,657 | 77,815 | 494 | 418 | 45.7 | 10.7 | 11,574 | 91.0 | 22 | 15 | 313 | 71 | 45.1 | 6.2 | 1.28 | 172 | 1,034 |
| Uvurkhangai | 51.5 | 9,456 | 6,940 | 23,082 | 335 | 989 | 48.5 | 6.3 | 8,754 | 87.3 | 28 | 15 | 406 | 77 | 34.1 | 9.7 | 1.13 | 260 | 735 |
| *Southern Region* | 8.4 | 30,385 | 191,401 | 155,407 | 544 | 353 | 33.6 | *5.3* | 15,210 | 78.0~89.3 | 25~32 | 7~21 | *293* | 118 | *21.6* | 13.9 | 1.51 | 3,434 | 1,460 |
| Goveisumber | 100.0 | 3,010 | 411 | 4,615 | 608 | 956 | 16.6 | 10.0 | 13,894 | 89.3 | 30 | 12 | 264 | 93 | 51.9 | 37.9 | 4.64 | 219 | 923 |
| Dornogovi | 7.2 | 10,884 | 69,430 | 38,451 | 507 | 264 | 23.6 | 3.9 | 11,772 | 78.5 | 32 | 7 | 280 | 158 | 23.4 | 12.6 | 1.11 | 1,396 | 967 |
| Dundgovi | 12.7 | 16,414 | 43,648 | 50,532 | 534 | 573 | 52.5 | 4.9 | 13,714 | 78.9 | 25 | 7 | 305 | 86 | 21.7 | 13.1 | 1.51 | 172 | 952 |
| Umnugovi | 4.2 | 77 | 77,912 | 61,809 | 437 | 262 | 32.6 | 6.0 | 20,114 | 78.0 | 32 | 21 | 306 | 107 | 11.8 | 9.4 | 1.11 | 8,577 | 2,448 |
| *Eastern Region* | 45.1 | 178,047 | 48,231 | 272,252 | 534 | 529 | 39.7 | *12.0* | 20,624 | 87.0~90.4 | 27~31 | 7~16 | *412* | *166* | *37* | *10.3* | 1.36 | 178 | 823 |
| Dornod | 34.8 | 90,116 | 36,698 | 111,756 | 467 | 304 | 26.4 | 20.9 | 29,929 | 87.0 | 31 | 7 | 410 | 268 | 42.5 | 14.5 | 1.66 | 146 | 779 |
| Sukhbaatar | 23.6 | 43,763 | 10,485 | 75,470 | 478 | 498 | 54.1 | 7.6 | 17,641 | 90.4 | 31 | 10 | 430 | 153 | 30.2 | 5.9 | 0.81 | 130 | 854 |
| Khenti | 82.9 | 44,168 | 1,048 | 54,048 | 584 | 961 | 40.3 | 7.1 | 13,785 | 86.8 | 27 | 16 | 400 | 68 | 38.0 | 9.6 | 1.49 | 249 | 845 |
| *Capital Region* | 89.7 | 20,793 | 380 | 30,978 | 366 | 1,006 | 4.8 | *10.6* | 17,570 | | | 13~15 | *215* | *166* | *26* | 12.5 | 1.25 | 1,052 | 896 |
| Ulaanbaatar | 100.0 | 1,184 | 16 | 1,422 | 162 | 2,070 | 0.9 | *11.0* | | | | 13 | 201 | 172 | *25.9* | 12.3 | 1.17 | 1,098 | 897 |
| Tuv | 89.0 | 19,609 | 364 | 29,556 | 387 | 962 | 37.1 | 4.1 | 11,956 | 86.8 | 27 | 15 | 437 | 76 | 20.5 | 15.9 | 2.52 | 309 | 879 |
| **Mongolia** | 43.0 | 329,395 | 261,808 | 717,098 | 414 | 643 | 24.9 | **10.0** | 15,825 | | | 13 | **271** | 154 | **28.4** | 12.9 | 1.50 | 1,103 | 1,001 |

Хавсралт F: "Алсын хараа-2050 баримт бичгийн бүрдэл болж батлагдаагүй эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн төлөвлөгөө"

## "Алсын хараа-2050 баримт бичгийн бүрдэл болж батлагдаагүй эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн төлөвлөгөө"

Дараах Хүснэгтүүдэд ҮХЦТ-нд санал болгосон 6 бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрт тусгасан үе шатуудаар хэрэгжүүлэх төслүүдийг бүсийн хөгжлийн загварын хувилбар байдлаар үзүүллээ. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Хэрэгжүүлэх төслийн жагсаалтад тусгасан төслүүдийг "ногоон" өнгөөр, ҮХЦТ-ний хүрээнд санал болгосон Хэрэгжүүлэх төслийн жагсаалтад тусгагдаагүй төслүүдийг "улаан" өнгөөр тэмдэглэв. Түүнчлэн бүс бүрийн бүсийн хөгжлийн загварын хувилбарын I, II, III үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоймыг ҮХЦТ-ний саналуудтай нийцтэй байдлаар боловсруулж нэгтгэлээ.

### Зүүн бүсийн хөгжлийн загварын хувилбар (Алсын хараа: Хөдөө аж ахуй-худалдаа-аялал жуулчлалыг хөгжүүлсэн хилийн бүс болох)

| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны тойм | | Анхан шатны бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл, хил дамнасан худалдаа, аялал жуулчлалыг хөгжүүлэх, өргөжүүлэхэд бэлтгэх | Анхан шатны бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэх, БНХАУ, ОХУ-тай хилийн худалдааг өргөжүүлэх, өв соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх | Анхан шатны бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг сайжруулах, худалдааг өргөжүүлэх, хилийн аялал жуулчлалыг хөгжүүлэх байдлаар аялал жуулчлалыг төрөлжүүлэх |
| Хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт | Мал аж ахуйг хөгжүүлэх, малын гаралтай түүхий эдийг боловсруулах кластер байгуулах | - Тодорхой байршлуудад мал аж ахуй эрхлэлтийг дэмжих | - Дээд зэрэглэлийн бүтээгдэхүүний зах зээлд зориулан малын гаралтай түүхий эдийг боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх<br>- Малын гоц халдварт өвчингүй эрүүл бүсийг тодорхойлох | - Мал аж ахуй эрхлэлт, малын гаралтай түүхий эд боловсруулалтыг нэмэгдүүлэх<br>- Малын гоц халдварт өвчингүй эрүүл бүсийг өргөжүүлэх |
| | Газар тариалан | - Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалалтыг өргөжүүлэх | - Импортыг орлох хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалалтыг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх | - Хүнсний ногоо, жимс, жимсгэний усалгаатай тариалалтыг өргөжүүлэх |
| Аж үйлдвэр, худалдаа | Хилийн худалдаа | - БНХАУ, ОХУ-тай хилийн худалдааг үе шаттайгаар өргөжүүлэх | - БНХАУ, ОХУ-тай хилийн худалдааг үе шаттайгаар өргөжүүлэх | - БНХАУ, ОХУ-тай хилийн худалдааг улам өргөжүүлэх |
| Аялал жуулчлал | | - Хэнтий аймагт өв соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх;<br>- Бичигт боомт дээр худалдааны чөлөөт бүс байгуулж, худалдаа хийх | - Өв соёлын аялал жуулчлалыг Сүхбаатар аймгийн аялал жуулчлалтай холбон хөгжүүлэх<br>- Эрдэнэцагаан, Дарьгангыг | - Ганга нуурын байгалийн цогцолбор газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | боломжийг ашиглан хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх | холбосон хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх | |
| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
| Авто зам | Хил нэвтрэх авто зам | - Хил нэвтрэх замуудын талаар цогц судалгаа хийж, эрэмбэлэх | - Хавирга, Эрээнцав, Бичигтийн чиглэлээр БНХАУ руу хил нэвтрэх авто замыг сайжруулах | - Ульхан чиглэлээр ОХУ руу хил нэвтрэх авто замыг сайжруулах |
| | Аялал жуулчлалын чиглэлийн авто зам | | - Жаргалтхаан~ Өмнөдэлгэр чиглэлийн авто замыг сайжруулах | - Норовлин~Дадал чиглэлийн авто замыг сайжруулах |
| | Уул уурхайн зориулалттай авто зам | | - Говьсүмбэр~Хэнтий (Дархан) чиглэлийн авто замыг сайжруулах | |
| | Гол болон туслах зам | | - Чойбалсан~Өндөрхаан чиглэлийн авто замыг сайжруулах | - Чойбалсан~Баруун-Урт чиглэлийн авто замыг сайжруулах |
| Бусад дэд бүтэц | Дорнод аймгийн нисэх онгоцны буудлыг ОУ-ын нисэх онгоцны буудал болгож өргөжүүлэх | - Дорнод аймгийн нисэх онгоцны буудлыг ОУ-ын нисэх онгоцны буудал болгож өргөжүүлэх төлөвлөгөө, 1-р үе шатны хэрэгжилт | - Дорнод аймгийн нисэх онгоцны буудлыг ОУ-ын нисэх онгоцны буудал болгож дуусгах | - Дорнод аймгийн ОУ-ын нисэх онгоцны буудлын үйл ажиллагаа, байгууламжийг сайжруулах |
| | Хот, суурины дэд бүтэц | - Баруун-Урт хотод ус хангамжийн шугам сүлжээг өргөтгөж, усны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | - Өндөрхаан хотын ус хангамж, ариутгах татуурга зэрэг дэд бүтцийг сайжруулах | - Чойбалсан хотын ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан, харилцаа холбоо, хот доторх авто зам зэрэг дэд бүтцийг сайжруулах |
| Хот, суурин хөгжүүлэх үйл ажиллагаа | | - Хот, суурины хөгжлийн төлөвлөгөө боловсруулах | - Чойбалсан: Олон улсын логистик, бизнесийн төв<br>- Баруун-Урт: мал аж ахуйн хөгжлийг дэмжих төв | - Өндөрхаан аялал жуулчлалын бүсэд нэвтрэх орц |
| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
| Институцийн арга хэмжээ | Хариуцлагатай уул уурхай | - Хариуцлагатай уул уурхайн зарчмыг тодорхойлж, баримтлах | - Хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс нутгийн удирдлагыг бэхжүүлэх | - Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд нутгийн иргэдийн оролцоог хангах |
| | Мал аж ахуй эрхлэлт | - Малын тэжээл, ус хангамжид тохируулан отор нүүдэл хийх | - Малын гоц халдварт өвчингүй эрүүл бүсийг тодорхойлох | - Малын гоц халдварт өвчингүй эрүүл бүсийг өргөжүүлэх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | замаар уламжлалт мал аж ахуй эрхлэлтийг дэмжих | | |
| | Аялал жуулчлал | | - Зүүн бүсийн аялал жуулчлалын нэгдсэн брэндийг хөгжүүлэх, маркетинг хийх | |
| | Бусад | - Хилийн худалдаанд хялбаршуулсан журам, татвар,тарифын хөнгөлөлтийг нэвтрүүлэх<br>- Худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээ болон эдийн засгийн бусад шинэ үйл ажиллагаатай холбогдуулан орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжих | - Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг үргэлжлүүлэн дэмжих<br>- Бизнесийн хөгжлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх | - Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг үргэлжлүүлэн дэмжих |

## Өмнөд бүсийн хөгжлийн загварын хувилбар (Алсын хараа: Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлсэн, олон нийтийн хөгжлийн загвар бүс болох)

| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны тойм | | Орон нутагт эдийн засгийн шинэ үйл ажиллагааг дэмжих зорилгоор хариуцлагатай уул уурхайг хэрэгжүүлэхэд бэлтгэх | Уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалыг нэгдсэн байдлаар хөгжүүлэх эдийн засгийн бүтэц рүү шилжих | МХХТ, дэвшилтэт технологид түшиглэсэн нийгэм, эдийн засгийн нэгдсэн системийг байгуулах |
| Хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт | Мал аж ахуйг хөгжүүлэх, малын гаралтай түүхий эдийг боловсруулах | - Сонгогдсон байршлуудад эрчимжсэн эсвэл хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх;<br>- Ус хангамжийн системийн өргөтгөлийн ажлыг эхлүүлэх. | - Сонгогдсон байршлуудад ус хангамжийг нэмэгдүүлэх;<br>- Гадаадын зах зээлд нийлүүлэхийн тулд малын гаралтай анхан шатны бүтээгдэхүүнийг боловсруулах. | - Мал аж ахуй эрхлэлтийг дэмжих зорилгоор ус хангамжийн системийг өргөтгөх. |
| | Газар тариалангийн үйлдвэрлэл, боловсруулалт | - Тосны ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх<br>- Орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах үүднээс эмийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх. | - Орон нутгийн ЖДҮ тосны ургамал, эмийн ургамлыг боловсруулах. | - Тосны ургамал, эмийн ургамал үйлдвэрлэл, боловсруулалтыг нэмэгдүүлэх. |
| Аж үйлдвэр, худалдаа | Чөлөөт бүс | - Говьсүмбэрт МХХТ-д суурилсан үйлдвэрийн бүсийг байгуулах ТЭЗҮ-г хийх. | - Говьсүмбэрт МХХТ-д суурилсан үйлдвэрийн бүсийг байгуулах ажлыг эхлүүлэх. | - Говьсүмбэрт МХХТ-д суурилсан үйлдвэрийн бүсийг үргэлжлүүлэн байгуулах. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Аялал жуулчлал | Аялал жуулчлалын гурвалжин | - Сайншанд хот, нутгийн өмнөд хэсгийн хагас цөл, Замын-Үүдийг холбосон аялал жуулчлалын гурвалжинг төлөвлөх. | - Аялал жуулчлалын байгууламжууд, хүний гараар бүтсэн үзмэрүүдийг барьж байгуулах. | - Аялал жуулчлалыг төрөлжүүлэх. |
| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
| Авто зам | Тойрог коридор | | - Мандалговь~Говь-Угтаал~Чойр чиглэлийн замыг сайжруулах | - Мандалговь ~Эрдэнэдалай~Арвайхээр чиглэлийн замыг сайжруулах |
| | Бусад зам | - Тавантолгой- Гашуунсухайт чиглэлийн замыг сайжруулах ажлыг эхлүүлэх | - Тавантолгой- Гашуунсухайт чиглэлийн замыг үргэлжлүүлэн сайжруулах | |
| Бусад дэд бүтэц | Төмөр зам | - Тавантолгой~Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төслийг үргэлжлүүлэх; | - Тавантолгой~Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж дуусгах;<br>- Бусад чиглэлийн төмөр замын төслүүдийг төлөвлөх. | - Бусад тэргүүлэх чиглэлүүдэд төмөр зам барих; |
| | Бусад | - Чойр хотын ус хангамжийн системийг өргөтгөх; | - Нүүдлийн мал аж ахуй эрхлэхэд ус хангамжийг нэмэгдүүлэх; | |
| Хот, суурин хөгжүүлэх үйл ажиллагаа | Аялал жуулчлалын гурвалжин | - Замын-Үүдийн хилийн худалдаа, аялал жуулчлалын төвийг хөгжүүлэх; | - Сайншанд хотын логистик, аялал жуулчлалын төвийг хөгжүүлэх; | - Говийн байгаль орчны технологийн төвийг хөгжүүлэх; |
| | Бусад | - Чойр хотод автомашины засвар үйлчилгээний төв байгуулах; | - Чойр хотод цэвэр эрчим хүчний технологийн төв байгуулах;<br>- Мандалговь хотод логистикийн төв байгуулах; | - Сайншанд хотод байгаль орчны боловсролын төвийг байгуулах. |
| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
| Институцийн арга хэмжээ | Хариуцлагатай уул уурхай | - Хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа, зарчмуудыг нэвтрүүлэх | - Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бий болгохтой холбоотойгоор орон нутгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх | - Хяналт, үнэлгээнд иргэдийн оролцоог хангах |
| | Хэрэгжүүлэх зохицуулалтуудыг хэрэгжүүлэх | - Институцийн зохицуулалтуудыг хэрэгжүүлж цэвэр эрчим хүчний төвийг байгуулах ажлыг эхлүүлэх | - Аялал жуулчлалын гурвалжин хэлхээг хөгжүүлэх чиглэлээр аймаг хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх; | |
| | ЖДҮ эрхлэгчдийг дэмжих | - Худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээ, эдийн засгийн бусад үйл ажиллагаг | - Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх;<br>- Бизнесийг хөгжүүлэх цогц | - Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | дэмжих орон нутгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх | хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | |
| | Бусад | - Хилийн худалдааны үйл ажиллагааны дүрэм, журмыг хялбаршуулах, татвар, тарифын хөнгөлөлт үзүүлэх<br>- Байгаль орчны боловсролыг сурталчлах | - Хагас эрчимжсэн МАА эрхлэгчдэд зориулж ус, тэжээл ашиглалтын заавар, удирдамжийг боловсруулах<br>- УУ-н үйл ажиллагааны орлогоор Орон нутгийн хөгжлийн санг байгуулах | - Говийн бараа бүтээгдэхүүний нийтлэг брэндийг хөгжүүлэх. |

## Алтайн бүсийн хөгжлийн загварын хувилбар (Алсын хараа: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлсэн, эрчим хүчний нөөц бүхий бүс болох)

| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны тойм | | Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластер байгуулах, газар тариалангийн үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, аялал жуулчлалын сүлжээ, сэргээгдэх эрчим хүчний төв, Хархорин соёлын өвийн төв байгуулах бүтээн байгуулалтад төлөвлөгөөний хүрээнд бэлтгэх | Өндөр үр ашигтай эдийн засгийн үйл ажиллагаа, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх үйл ажиллагаа, хэд хэдэн хот, суурин газрын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлж эхлүүлэх | Өндөр бүтээмжтэй мал аж ахуйн бүс, боловсруулах үйлдвэрлэлийн хот, суурин газрын сүлжээ, сэргээгдэх эрчим хүчний төвийг байгуулах, нийгэм, соёлын чиг үүргийг хэрэгжүүлэх |
| Хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт | Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластер | Кластер байгуулах төлөвлөгөө боловсруулах, 1-р үе шатыг хэрэгжүүлэх | Мах боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, мах, махан бүтээгдэхүүн экспортлох | Бусад бүс рүү экспортлох зорилгоор нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх |
| | Газар тариалангийн үйлдвэрлэл, боловсруулалт | - Жимс жимсгэнэ, тосны ургамал, эмийн ургамал зэрэг газар тариалангийн үйлдвэрлэлийг төрөлжүүлэх | - Орон нутгийн ЖДҮ жимс жимсгэнэ, эмийн ургамлыг боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх | - Газар тариалангийн үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэлд хэмнэлттэй усжуулалтыг ашиглах |
| Аялал жуулчлал | | - Орхоны хөндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх стратегийн төлөвлөгөө боловсруулах | - Хархорин, Орхоны хөндийн соёлын өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэх | - Халуун рашаан, эмийн ургамлын баялаг нөөцөд түшиглэн эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх |
| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
| Авто зам | Тойрог коридор | | - Алтай~Улиастай чиглэлийн авто замыг сайжруулах | - Алтай, Баянхонгор, Арвайхээрийг холбосон авто замыг сайжруулах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Аялал жуулчлалын чиглэлийн авто зам | - Арвайхээр~Хужирт чиглэлийн авто зам | - Хархорин~Шанхын хийд~ Төвхөн хийд чиглэлийн авто зам | - Хужирт~Улаанцутгалан ~Шаргалжуут~Баянхонгор чиглэлийн авто зам |
| | Хил нэвтрэх авто зам | | - Алтай~Бургастай чиглэлийн авто зам | - Арвайхээр~Шивээхүрэн чиглэлийн авто зам |
| Бусад дэд бүтэц | Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, судалгааны төв байгуулах | - Сэргээгдэх эрчим хүчийг үе шаттайгаар хөгжүүлэх дэлгэрэнгүй судалгаа хийх | - Нар, салхины эрчим хүчийг ашиглах туршилтын төсөл хэрэгжүүлэх<br>- Газрын гүний дулааны эрчим хүч ашиглах хайгуул хийх | - Нар, салхины эрчим хүчийг өргөнөөр ашиглах<br>- Газрын гүний дулааны эрчим хүчийг төрөл бүрийн зорилгоор ашиглах |
| | Завхан гол дээр далан барьж байгуулах | - Усан цахилгаан станц, усжуулалтын системийн ТЭЗҮ-ийг боловсруулах | - Бүтээн байгуулалт хийх | - Бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх |
| Хот, суурин хөгжүүлэх үйл ажиллагаа | Хархорин соёлын өвийн төв | - Хархорин хотыг соёлын өвийн төв болгон үе шаттайгаар хөгжүүлэх дэлгэрэнгүй судалгаа хийх | - Хархорин хотыг соёлын өвийн төв болгон хөгжүүлэх бүтээн байгуулалт | - Соёлын өвийн төв болгон хөгжүүлэхтэй холбогдуулан чиг үүргийг төрөлжүүлэх, байгууламжийг барьж байгуулах |
| | Бусад | - Алтай хотод Боловсрол, эрүүл мэндийн ажилтнуудын сургалтын төв байгуулах | - Алтай: Байгалийн, өв соёлын, эрүүл мэндийн аялал жуулчлалын төв;<br>- Арвайхээр: Логистикийн төв | - Баянхонгор: Эрүүл мэндийн аялал жуулчлал, анагаахын шинжлэх ухааны төв |
| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
| Институцийн арга хэмжээ | Бэлчээрийн менежмент | - Бэлчээр ашиглалтын хяналтыг бий болгох | - Бэлчээрийн менежментийг сайжруулах | - Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд нутгийн иргэдийн оролцоог хангах |
| | Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластер | - Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо байгуулах/бэхжүүлэх | - Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэхэд шаардлагатай технологийг нутагшуулах, малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластерын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах | |
| | Бусад | - Худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээ болон эдийн засгийн бусад шинэ үйл ажиллагаатай хөгжүүлж, дэмжих үүднээс орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжих | Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг үргэлжлүүлэн дэмжих<br>Бизнесийн хөгжлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх | - Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг үргэлжлүүлэн дэмжих |

## Баруун бүсийн хөгжлийн загварын хувилбар (Алсын хараа: Ногоон хөгжлийн загвар бүс болох)

| | | **I үе шат (2021~2025)** | **II үе шат (2026~30)** | **III үе шат (2031~40)** |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны тойм | | МАА-н үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх төлөвлөлт хийх, аялал жуулчлалын сүлжээ, Цагаан нуурын чөлөөт бүс, Ховд хотын ОУ-н нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг идэвхжүүлэх бэлтгэл ажлууд | Боловсруулах үйлдвэрлэлийн кластер, чөлөөт бүсүүд, аялал жуулчлалын сүлжээ, хот, суурин газрын үйлдвэрлэл, худалдаа, дээд боловсрол, судалгаа шинжилгээг хөгжүүлэх ажлыг идэвхжүүлэх | Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг ахисан шатанд хүргэх, аялал жуулчлалын нэгдсэн сүлжээ бий болгох, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах дээд боловсрол, судалгаа шинжилгээг хөгжүүлэх |
| ХАА, боловсруулах үйлдвэрлэл | МАА-н үйлдвэрлэлийн кластер | Хөгжлийг үе шаттайгаар төлөвлөх, 1-р үе шатыг хэрэгжүүлэх | Боловсруулах үйлдвэр байгуулах, мах, махан бүтээгдэхүүн экспортлох | Экспортод гаргах зорилгоор нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх |
| | Чацаргана жимсний үйлдвэрлэлийн кластер | Хөгжлийг үе шаттайгаар төлөвлөх, 1-р үе шатыг хэрэгжүүлэх | Боловсруулах үйлдвэр байгуулах, мах, махан бүтээгдэхүүн экспортлох | Европ руу экспортод гаргах зорилгоор нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх |
| Үйлдвэр, худалдаа | Чөлөөт бүсийг хөгжүүлэх | Цагааннуурын чөлөөт бүсэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | Бусад чөлөөт бүсүүдийг бусад төрлийн үйлдвэрлэлээр хөгжүүлэх | Сонгогдсон чөлөөт бүсүүдийг өргөжүүлэн хөгжүүлэх |
| Аялал жуулчлал | Аялал жуулчлалыг цогц байдлаар хөгжүүлэх | Аялал жуулчлалын нэгдсэн сүлжээг төлөвлөх | Аялал жуулчлалын бие даасан байршлуудыг хөгжүүлэх | Аялал жуулчлалын байршлуудыг үргэлжлүүлэн хөгжүүлэх |
| | | **I үе шат (2021~2025)** | **II үе шат (2026~30)** | **III үе шат (2031~40)** |
| Авто зам | | - Ховд~Улаангом чиглэлийн авто замыг сайжруулах<br>-Өлгий~Ташант чиглэлийн авто замыг сайжруулах | -Өлгий~Улаангом чиглэлийн авто замыг сайжруулах | -Даяннуур~Өлгий чиглэлийн авто замыг сайжруулах |
| Бусад дэд бүтэц | Ховд хотын нисэх онгоцны буудлыг ОУ-ын нисэх онгоцны буудал болгож өргөжүүлэх | - Ховд хотын нисэх онгоцны буудлыг ОУ-ын нисэх онгоцны буудал болгож өргөжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, 1-р үе шатыг хэрэгжүүлэх | - Ховд хотын нисэх онгоцны буудлыг ОУ-ын нисэх онгоцны буудал болгон өргөжүүлж дуусгах | - Ховд хотын ОУ-ын нисэх онгоцны буудлын байгууламж, үйл ажиллагааг сайжруулах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Бусад | - Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барьж дуусгах;<br>- Ховд аймгаас Баян-Өлгий, Увс аймаг хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугам татах төслийг хэрэгжүүлэх. | - Ховд голын усан цахилгаан станцын бүтээн байгуулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх | - Ховд голын усан цахилгаан станцын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх |
| Хот, суурин хөгжүүлэх үйл ажиллагаа | | - Ховд аймагт дээд боловсрол, судалгааны төв байгуулах төслийг төлөвлөх & 1-р үе шатыг хэрэгжүүлэх | - Ховд аймагт дээд боловсрол, судалгааны төвийг байгуулах;<br>-Өлгийн байгаль, соёлын аялал жуулчлалын төвийг хөгжүүлэх;<br>- Улаангом хотод худалдааны төвийг хөгжүүлэх. | - Хот, суурингийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хөгжүүлэх |
| | | **I үе шат (2021~2025)** | **II үе шат (2026~30)** | **III үе шат (2031~40)**0) |
| Институцийн арга хэмжээ | Хариуцлагатай уул уурхай | - Хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа, зарчмуудыг нэвтрүүлэх | - Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бий болгохтой холбоотойгоор орон нутгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх | - Хяналт, үнэлгээнд иргэдийн оролцоог хангах тогтолцоог бий болгох |
| | Бэлчээрийн менежмент | - Хяналт бүхий бэлчээрийн газрыг ашиглуулж эхлэх | - Бэлчээрийн менежментийг сайжруулах | - Хяналт, үнэлгээнд иргэдийн оролцоог хангах тогтолцоог бий болгох |
| | Үйлдвэрлэлийн кластер | - Чацаргана жимсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, МАА-н үйлдвэрлэлийн кластерын үйлдвэрлэгчдийн холбоог бэхжүүлэх | - МАА-н болон чацаргана жимсний үйлдвэрлэлийн кластерын бүтээгдэхүүний хөгжүүлэлт, маркетингд технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх | - Үйлдвэрлэгчдийн холбоог бэхжүүлэх, бусад үйлдвэрлэлийн кластерыг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх |
| | Бусад | - Хилийн худалдааны үйл ажиллагааны дүрэм, журмыг хялбаршуулах, татвар, тарифын хөнгөлөлт үзүүлэх<br>- Худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээ, эдийн засгийн бусад үйл ажиллагааг дэмжих орон нутгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх | - Буянт, Булган, Ховд, Цэнхэрийн голуудыг хамруулан усны нөөцийн менежментийн цогц төлөвлөгөө боловсруулах<br>- Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх | -Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх |

**Хангайн бүсийн хөгжлийн загварын хувилбар (Алсын хараа: Нийгэм, эдийн засгийн цогц хөгжлийг хангасан бүс болох)**

| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны тойм | | МХХТ болон дэвшилтэт технологийг ашигласан МАА, тэжээлийн үйлдвэрлэлийг хослуулсан өндөр ашиг шимтэй фермерийн аж ахуйг хөгжүүлэх | Өндөр ашиг шимтэй фермерийн аж ахуйг үргэлжлүүлэн хөгжүүлэх, ОХУ-тай хийх худалдаа, аялал жуулчлалын үйл ажиллагааг төрөлжүүлэх, олон талт чиг үүрэг бүхий хот, суурин хөгжүүлэх | Нийгэм, эдийн засгийн олон талт үйл ажиллагааг дэмжсэн болон бусад бүсүүдийг МХХТ-ийн сүлжээнд холбох үүрэгтэй технологийн төвийг байгуулах |
| ХАА, боловсруулах үйлдвэрлэл | МАА-г хөгжүүлэх, боловсруулах үйлдвэрлэл | - Хагас эрчимжсэн мал аж ахуй, тэжээлийн үйлдвэрлэлийг хослуулсан нэгдсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх<br>- МХХТ-ийг нэвтрүүлсэн МАА-н үйлдвэрлэлийн кластер байгуулах | - Нэгдсэн фермерийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх<br>- МАА-г кластераар хөгжүүлсэнээр үнэ цэнэтэй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх | - Экспортод гаргах зорилгоор үнэ цэнэ бүхий малын гаралтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх |
| | Үр тариа тариалалт болон боловсруулах үйлдвэрлэл | - Ухаалаг, механикжсан газар тариаланг түгээн дэлгэрүүлэх<br>- Усны хэмнэлттэй усжуулалтын системийг төлөвлөх | - Ухаалаг, механикжсан газар тариаланг эрчимтэйгээр хөгжүүлэх<br>- Усны хэмнэлттэй усжуулалтын системийг хэрэгжүүлэх | - Усны хэмнэлттэй усжуулалтын системийг үргэлжлүүлэн хөгжүүлэх |
| Үйлдвэрлэл, худалдаа | Чөлөөт бүсийг хөгжүүлэх | Алтанбулагийн чөлөөт бүсийг эрчимтэй хөгжүүлэх | Бусад чөлөөт бүсүүдийг хөгжүүлэх | Сонгогдсон чөлөөт бүсүүдийг өргөжүүлэн хөгжүүлэх |
| Аялал жуулчлал | Хөвсгөл аймгийг аялал жуулчлал төрөлжүүлэн хөгжүүлэх | Хөвсгөл аймгийн аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлэх үе шаттай төлөвлөлт | Аялал жуулчлалын бие даасан байршлуудыг хөгжүүлэх, ирээдүйг харсан идэвхтэй маркетинг хийх. | Аялал жуулчлалын бие даасан байршлуудыг үргэлжлүүлэн хөгжүүлэх, гадаад жуулчдад зориулсан аялалын бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх |
| | | **I үе шат (2021~2025)** | **II үе шат (2026~30)** | **III үе шат (2031~40)** |
| Авто зам | Аялал жуулчлалын маршрутын дагуух авто зам | - Арвайхээр~ Хархорин авто чиглэлийн зам | - Хатгал~Ханх чиглэлийн авто зам<br>- Булган~Хишиг-Өндөр~ Гурванбулаг чиглэлийн авто зам<br>- Бат-Өлзийт~Цэцэрлэг чиглэлийн авто зам | - Мөрөн~Шинэ-Идэр~ Жаргалант~Цэцүүх чиглэлийн авто зам |
| | Хил орчмын | | - Хутаг-Өндөр~Тэшиг~ Бага-Илэнх | - Номлог~Тэс~Арцсуурь чиглэлийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | авто зам | | чиглэлийн авто зам | авто зам |
| | Тойрог коридор | - Дархан~Эрдэнэт чиглэлийн авто замын хэсгийг сайжруулах; | - Мөрөн~Бүрэнтогтох~Цагаан-Уул чиглэлийн авто замын хэсгийг сайжруулах; | - Авто замыг бүхэлд нь сайжруулах |
| Бусад дэд бүтэц | МХХТ-ийн хөгжил | - Дархан, Цэцэрлэг хотын МХХТ-ийн сүлжээг хөгжүүлэх төлөвлөлт хийх | - Дархан, Цэцэрлэг хотын МХХТ-ийн сүлжээг хөгжүүлэх | - Дархан, Цэцэрлэг хотын МХХТ-ийн сүлжээг сайжруулах |
| Хот, суурин хөгжүүлэх үйл ажиллагаа | | - Хөвсгөл: аялал жуулчлалын төв;<br>- Сүхбаатар: хилийн худалдааны суурь бааз болгон хөгжүүлэх;<br>- Улиастай: төрийн үйлчилгээний төв болгон хөгжүүлэх | - Дархан: Газар тариалангийн дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн төв болгон хөгжүүлэх;<br>- Эрдэнэт-Булган: Транзит худалдаа болон аялал жуулчлалын үйлчилгээний төв болгон хөгжүүлэх;<br>- Цэцэрлэг хотыг МХХТ-ийн төв, өвлийн аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх | - Хотуудын чиг үүргийг бэхжүүлэх;<br>- Эрдэнэт-Булганыг зэрэгцүүлэн хөгжүүлэх (twin city) |
| | | **I үе шат (2021~2025)** | **II үе шат (2026~30)** | **III үе шат (2031~40)** |
| Институцийн арга хэмжээ | Хариуцлагатай уул уурхай | - Хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа, зарчмуудыг нэвтрүүлэх | - Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бий болгохтой холбоотойгоор орон нутгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх | - Хяналт, үнэлгээнд иргэдийн оролцоог хангах тогтолцоог бий болгох |
| | Ойн менежмент | - Ойн нөөцийн нэгдсэн тооллогыг хийх | - Ойн менежментийг сайжруулах, ойн бус нөөцийг ашиглах | - Ойн нөөцийг үргэлжлүүлэн ашиглах, удирдах |
| | Засаг захиргаа | - Дархан хотыг бие даасан хот болгон хөгжүүлэх | - Орон нутгийн бие даасан байдлыг дэмжих, төрийн захиргааны чиг үүрэг, эрх мэдлийг үе шаттайгаар шилжүүлэх | - Төвлөрсөн бус бүсийн хөгжлийн загварыг бий болгох |
| | Бусад | - Худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээ, эдийн засгийн бусад үйл ажиллагааг дэмжих орон нутгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх | - Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх<br>- Фермерүүдэд зориулсан ган гачгийн урьдчилсан мэдээ, дохиоллын системийг бий болгох | - Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх |

**Нийслэлийн бүсийн хөгжлийн загварын хувилбар (Алсын хараа: Дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл,**

**логистикийн баазыг хөгжүүлсэн бүс болох)**

| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны тойм | | COVID-19-н дараах нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүрээнд орон зайн болон эдийн засгийн бүтцийн эхний шатны өөрчлөлтийг хийх | Нэмүү өртөг шингэсэн эдийн засгийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор судалгаа, хөгжүүлэлттэй холбоотой чиг үүргийг бэхжүүлэхийн зэрэгцээ дагуул хотуудын амьдрах орчны чанарыг сайжруулах | Улаанбаатар хотод төвтэй хүчирхэг эдийн засаг, тогтвортой нийгмийг цогцлоож, ногоон байгууламж, тохижилт сайтай дэлхийн түвшний хотыг хөгжүүлэх |
| ХАА, боловсруулах үйлдвэрлэл | МАА-н үйлдвэрлэл | - Эрчимжсэн МАА-г малын тэжээлийн үйлдвэрлэлтэй хамтатган хөгжүүлэх; | - Генийн сан бүхий өндөр бүтээмжтэй мал аж ахуй эрхлэлтийн судалгаа, хөгжүүлэлт хийх; | - Өндөр чанартай мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортод гаргаж дэлхийд таниулах; |
| Үйлдвэр, худалдаа | | - Улаанбаатар хотод төвлөрсөн төрийн зарим байгууллагыг Төв аймаг дахь дагуул хотууд руу нүүлгэн шилжүүлэх; | - Бусад аймгуудаас нийлүүлж буй бүтээгдэхүүнийг экспортод гаргахын тулд брэндинг, шошго, баглаа боодлыг сайжруулж, нэмүү өртөг шингээх; | - Өндөр чанартай бүтээгдэхүүнийг экспортод гаргаж дэлхийд таниулах; |
| Аялал жуулчлал | | - Аялал жуулчлалын салбарын COVID-19-ийн дараах төлөвлөлтүүдийг хийх, Улаанбаатар хот нь аялал жуулчлалын гол гарц, бааз болох тул виртуал аялал жуулчлал зэргийг нэвтрүүлэх, хөгжүүлэх; | - Хүний гараар бүтсэн үзмэрүүд бүхий аялал жуулчлалын өндөр чанартай байгууламжуудыг барьж байгуулах; | - Амралт, зугаалгын дэвшилтэт байгууламжуудыг барьж байгуулах. |
| | | I үе шат (2021~2025) | II үе шат (2026~30) | III үе шат (2031~40) |
| Авто зам | Умард, өмнөд чиглэлийн эдийн засгийн коридор | - Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн замыг үргэлжлүүлэн сайжруулах. | - Улаанбаатар-Чойр хоорондын замыг сайжруулах. | - Нэмэлт эгнээ хийж өргөтгөн сайжруулах. |
| | Улаанбаатар хотын авто зам | - Хотын хөгжлийн шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу тэргүүлэх чиглэлийн ажлуудыг тодорхойлох; | - Гол замыг үе шаттайгаар сайжруулах; | - Авто замыг явган хүний замын хамт сайжруулах ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлэх. |
| | Логистикийн төвүүдийг холбосон зам | - Логистикийн төвүүдийг холбосон замыг үе шаттайгаар сайжруулах төлөвлөлтийг хийх | - Логистикийн төвүүдийг холбосон замыг үе шаттайгаар сайжруулах; | - Борнуур~ Лүн~Баян-Өнжүүл~Баян~Багануурыг холбосон авто замын ажлыг дуусгах |
| Бусад дэд бүтэц | Төмөр зам | | - Богд хаан төмөр замыг барьж байгуулах; | - Умард, өмнөд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Ус хангамж | - Улаанбаатар хот болон түүний дагуул хотуудын ус хангамжийн системийг өргөтгөх ажлыг төлөвлөх; | - Улаанбаатар хотын ус хангамжийн системийг өргөтгөх үйл ажиллагааг эхлүүлэх; | - Улаанбаатар хотын ус хангамжийн системийг өргөтгөх үйл ажиллагааг үргэлжлүүлэх. |
| Хот, суурин хөгжүүлэх үйл ажиллагаа | Улаанбаатар хотын хот байгуулалт | | - Улаанбаатар хотын МХХТ-ийн баазыг сайжруулах. | - Улаанбаатар хотыг жишиг ногоон хот болгож хөгжүүлэх. |
| | Шинэ хотуудыг байгуулах үйл ажиллагаа | - Нарийвчилсан төлөвлөлтийг хийж, эхний ээлжийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх | - Хот байгуулалтын үйл ажиллагааг бүрэн хэмжээнд хэрэгжүүлэх; | - Өргөжүүлэх |
| | | **I үе шат (2021~2025)** | **II үе шат (2026~30)** | **III үе шат (2031~40)** |
| Институцийн арга хэмжээ | Шинэ хотуудыг байгуулах үйл ажиллагаа | - Нисэх онгоцны буудалд түшиглэсэн худалдааны чөлөөт бүсийг байгуулах;<br>- Дагуул хотуудын ус хангамжтай холбоотойгоор ус ашиглах зөвшөөрлийг шийдвэрлэх; | - Улс төрийн болон захиргааны чиг үүргийн төвлөрлийг багасгах хууль, эрх зүйн болон захиргааны зохицуулалтуудыг хэрэгжүүлэх;<br>- Нийслэлийн бүсийн захиргааны байгууллагуудыг байгуулах. | - Нийслэлийн бүсийн захиргааны байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх. |
| | Бусад | - Технологи хөгжүүлэх, нутагшуулах институцийн чадавхыг бэхжүүлэх. | - Төв аймагт логистикийн тойрог байгуулах үйл ажиллагааны зохицуулалтуудыг хийх | |

Хавсралт G: БХҮБ-ыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх ҮХЦТ

**БХҮБ-ыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх ҮХЦТ**

## 1. Макро түвшний хөгжлийн хувилбарууд ба санал болгож буй хөгжлийн хувилбар

Хөгжлийн хувилбаруудын тодорхойлолт

ҮХЦТ-нд тусгасан макро түвшний хөгжлийн хувилбаруудыг Хүснэгт 1-д тодорхойлов.

**Хүснэгт 1. ҮХЦТ-нд тусгасан макро түвшний хөгжлийн хувилбарууд**

| Хувилбар | Тодорхойлолт | Тайлбар |
|---|---|---|
| A. Уул уурхайд түшиглэсэн хөгжил | Эдийн засаг болон экспортын өсөлтийг дэмжих уул уурхайн салбарт үргэлжлүүлэн түшиглэх бөгөөд уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт нэн бага байна. | Энэхүү хөгжлийн хувилбараар уул уурхайн салбарт үргэлжлүүлэн түшиглэх ба хөдөө аж ахуйн салбарын өсөлт тогтвортой түвшинд (3%) байна. |
| B. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өндөр хөгжил | Уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл нь хөгжлийн гол хөдөлгөгч хүч болно. | Уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг одоогийнхоос илүү түвшинд боловсруулан, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өндөр өсөлтийг хангана. Үүний зэрэгцээ уул уурхайн салбар тодорхой түвшинд өссөөр байна. |
| C. Транзит тээврийн чиг баримжаатай хөгжил | Үйлчилгээний салбарын өндөр өсөлтийг хангах Монгол Улсын транзит тээвэр нь хөгжлийн өөр нэг хөдөлгөгч хүч болно. | БНХАУ, ОХУ-ын хооронд хийх транзит тээвэрт илүү ач холбогдол өгнө. Боловсруулах үйлдвэрлэлийн салбар нь эдийн засгийн өсөлтөөс хамааран өссөөр байна. |
| D. Өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжил | Уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл болон транзит тээвэр нь эдийн засгийн өндөр өсөлтийг хангана. | Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах зорилгоор аж үйлдвэрийг хөгжүүлэх Хувилбар B болон транзит тээврийн чиг баримжаатай хөгжлийн Хувилбар C-г хослуулан хөгжинө. |

Хүснэгт 2-т ҮХЦТ-нд тусгасан хөгжлийн хувилбаруудыг сонгогдсон үзүүлэлтүүдээр үнэлэв.

**Хүснэгт 2. Макро түвшний хөгжлийн хувилбаруудын үнэлгээ, сонгогдсон**

**үзүүлэлтүүдээр**

| Үзүүлэлт | A: Уул уурхайд түшиглэсэн хөгжил | B: Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өндөр хөгжил | C: Транзит тээврийн чиг баримжаатай хөгжил | D: Өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжил |
|---|---|---|---|---|
| Хүн ам, 2030 оноор, мянган хүн | 3,740 | | | |
| Эдийн засгийн өсөлт, ж.д % | 6.7 | | | 7.1 |
| Нэг хүнд ногдох ДНБ, 2030 оноор, мянган төгрөг | 17,933 | | | 18,848 |
| Хөдөлмөр эрхлэлт, мянган хүн | 1,562 | 1,559 | 1,556 | 1,555 |
| Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өсөлт | 7.0 | 9.4 | 7.6 | 9.4 |
| Үйлчилгээний салбарын өсөлт | 7.5 | 7.5 | 8.0 | 8.3 |
| Хотжилт ба хүн амын тархалт, байршил | - Нийслэлийн тэргүүлэх байр суурь нэмэгдэж, Улаанбаатар хотын хүн амын төвлөрөл үргэлжилнэ.<br>- Иргэдийн гадаад улсад ажиллаж, амьдрах явдал үргэлжилнэ.<br>- Хөдөө, орон нутгийн хүн ам буурна. | - Боловсруулах үйлдвэрлэл болон холбогдох үйлчилгээ бүхий орон нутгийн хотууд хөгжинө.<br>- Нийслэлийн тэргүүлэх байр суурь хэвээр хадгалагдана<br>- Иргэдийн гадаад улсад ажиллаж, амьдрах явдал зогсоно. | - Гол тэнхлэгийн дагуу үйлчилгээний үүрэг функц бүхий орон нутгийн хотууд хөгжинө.<br>- Үйлчилгээний чиг баримжаатайгаар Улаанбаатар хотын тэргүүлэх байр суурь бага зэрэг нэмэгдэнэ.<br>- Иргэдийн гадаад улсад ажиллаж, амьдрах явдал зогсоно. | - Иргэдийн гадаад улс орноос шилжин ирэх хөдөлгөөн ихэснэ.<br>-Улаанбаатар болон орон нутгийн хотууд хөгжинө.<br>- Улаанбаатар хот нь өндөр зэрэглэлийн үйлчилгээ бүхий дэлхийн хот болон хөгжинө.<br>- Бүс нутаг хоорондын тэнцвэрт байдал сайжирна. |
| Нийгмийн нөлөөлөл | - Хөдөө, орон нутагт ажлын байр хязгаар-лагдмал байгаагаас үүдэлтэй хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал ихэснэ.<br>- Иргэд гадаад улсад ажиллаж, амьдрах болсны улмаас нийгмийн болон гэр бүлийн харилцаа муудна. | - Орон нутгийн хотуудад ажлын байр нэмэгдсэнээр хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа багасна.<br>- Орон нутгийн хотууд болон хөдөө орон нутагт бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэл болон хөдөө аж ахуй, мал аж ахуй эрхлэлт нэмэгдсэнээр нийгмийн болон гэр бүлийн харилцаа сайжирна. | - Ихэвчлэн гол тэнхлэгийн дагуу хүн ам төвлөрч буйгаас үүдэлтэй хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал үргэлжилнэ.<br>- Орон нутагт хотжилт, үйлчилгээний чиг баримжаатай хөгжлөөс үүдсэн нийгмийн асуудлууд тулгарна. | - Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал багасна.<br>- Хөдөө орон нутагт анхан шатны бүтээгдэхүүний боловсруулалттай холбоотойгоор<br>- ажлын байр нэмэгдэж, нийгмийн болон гэр бүлийн харилцаа сайжирна.<br>- Гадаад улс орноос шилжин ирэгсэдтэй холбоотойгоор нийгмийн зөрчилдөөн үүсч болзошгүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Байгаль орчны нөлөөлөл | - Уул уурхайн үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой-гоор байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлнэ.<br>- Улаанбаатар хотын хэт төвлөрлөөс үүдэн хотын байгаль орчин доройтно. | - Орон нутгийн хотуудад байгаль орчны асуудлууд үүснэ.<br>- Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудлууд багасна. | - Улаанбаатар хотын байгаль орчин доройтож болзошгүй.<br>- Орон нутгийн хотуудад байгаль орчны асуудлууд үүснэ.<br>- Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудлууд багасна. | - Улаанбаатар хотын байгаль орчин доройтож болзошгүй.<br>- Орон нутгийн хотуудад байгаль орчны асуудлууд үүснэ. |
| Хөгжлийн менежмент | - Нийгэм, байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх менежментийг сайжруулна.<br>- Хязгаарлагд-мал капиталын хуримтлалаас үүдсэн хөгжлийн менежментийн хүндрэл үүснэ. | - -Бүтээгдэхүүн хөгжүүлэх боловсруулах үйлдвэрийг технологи, зах зээлээр дэмжинэ.<br>- Орон нутгийн байгаль орчны асуудлуудыг орон нутгийн захиргаа шийдвэрлэх шаардлагатай. | - Улаанбаатар болон орон нутгийн хотуудад дэд бүтцийг сайжруулах шаардлагатай.<br>- Улаанбаатар хотын үйлчилгээний өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд менежментийг сайжруулна.<br>- Орон нутгийн засаг захиргаа орон нутгийн хотуудын дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай. | - Улаанбаатар хотыг дэлхийн хот болгох зорилгоор менежментийг сайжруулна.<br>- Боловсруулах үйлдвэрийг технологи, зах зээлээр дэмжинэ.<br>- Орон нутгийн засаг захиргаа орон нутгийн хотуудын дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай. |

Эх сурвалж: Төслийн тайлангийн Хүснэгт 4.3.5

<u>Санал болгож буй хөгжлийн хувилбар</u>

Төслийн тайлангийн 4.3 дугаар хэсэгт дурдсан хөгжлийн дөрвөн хувилбар нь хүн ам, ажиллах хүчний хувьд ойролцоо байх боловч технологийн хөгжлийн үр нөлөө нь харилцан адилгүй байна. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өндөр хөгжлийг илэрхийлэх B хувилбар болон өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжлийг илэрхийлэх D хувилбарын хувьд хөдөлмөрийн бүтээмжийг хамгийн ихээр нэмэгдүүлэхэд технологийн хөгжил ихээр шаардагдана. Хөгжлийн хувилбар B, C болон D-г хэрэгжүүлэхэд үйлчилгээний салбарын технологийн хөгжлийг дэмжих шаардлагатай. Технологийг хөгжүүлснээр аж үйлдвэрийн салбар өсч, үйлчилгээний салбарын өсөлтийг нэмэгдүүлнэ. Тиймээс өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжил нь нэг хүнд ногдох ДНБ болон хамгийн их өсөлтийг хангана. Өөрөөр хэлбэл энэ нь хамгийн сайн хувилбар юм. Төслийн тайлангийн Хүснэгт 4.3.5-д дүгнэсэнчлэн энэ хувилбар нь эдийн засгийн аж үйлдвэр, үйлчилгээний салбарыг төрөлжүүлэх бөгөөд байгаль орчинд ээлтэй хувилбар юм.

## 2. Бүсчилсэн хөгжлийн хувилбарууд

<u>Макро түвшний хөгжлийн хувилбар ба бүсүүд</u>

Бүсүүдийн онцлогоос хамаарч тухайн бүсэд хэрэгжүүлэх макро түвшний хөгжлийн хувилбар нь өөр байна. A, B, C макро түвшний хөгжлийн хувилбаруудыг бүсүүдэд хэрэгжүүлэх тохиромжтой байдлыг үнэлж Хүснэгт 3-т үзүүлэв. Түүнчлэн

ХАА-н салбарын хөгжлийн ач холбогдолтой байдал бүс бүрт харилцан адилгүй байна.

**Хүснэгт 3. Макро түвшний хөгжлийн хувилбаруудын бүсүүдэд хэрэгжүүлэх тохиромжтой байдал ба ХАА-н салбарын хөгжлийн ач холбогдол, бүсээр**

| Бүс | Макро түвшний хөгжлийн хувилбаруудын бүсүүдэд хэрэгжүүлэх тохиромжтой байдал* | | | ХАА-н салбарын хөгжлийн ач холбогдол** | |
|---|---|---|---|---|---|
| | A: Уул уурхайд түшиглэсэн хөгжил | B: Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өндөр хөгжил | C: Транзит тээврийн чиг баримжаатай хөгжил | Газар тариалан | МАА |
| Баруун бүс | △ | ○ | ◎ | △ | ○ |
| Хангайн бүс | ○ | ◎ | ◎ | ○ | ○ |
| Алтайн бүс | △ | ○ | ○ | ○ | ◎ |
| Өмнөд бүс | ◎ | ○ | △ | △ | △ |
| Зүүн бүс | ○ | ○ | ◎ | ○ | ◎ |
| Нийслэлийн бүс | △ | ◎ | ◎ | △ | ○ |

Тайлбар: *◎ тохиромжтой, ○ тодорхой түвшинд тохиромжтой, △ тохиромжгүй
**◎ чухал ач холбогдолтой, ○ ач холбогдолтой, △ ач холбогдолгүй

Санал болгож буй хөгжлийн хувилбар ба бүсүүд

Макро түвшний хөгжлийн хувилбаруудын бүсүүдэд хэрэгжүүлэх тохиромжтой байдал, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн ач холбогдлыг бүс нутгаар үнэлж, бүс бүрт санал болгох хувилбарыг ҮХЦТ-ний 6.3 Хөгжлийн алсын хараа, стратеги хэсэгт тусгасан. Баруун бүсийн хөгжлийн алсын харааг жишээ болгон доор харууллаа.

| **Баруун бүсийн хөгжлийн алсын хараа** |
|---|
| Баруун бүс нь ОХУ, БНХАУ-тай ойр дөт, хиллэн оршдогийн хувьд худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээ эрхлэх **ногоон хөгжлийн загвар бүс** болон хөгжинө. Байгаль, соёлын баялаг нөөц, бэлчээрийг хамгаалах, нутгийн захиргааны байгууллага болон иргэдийн идэвхтэй оролцооны үр дүнд байгалийн гамшигт үзэгдлийн сөрөг нөлөөг бууруулна. |

### 3. Үе шат бүхий хөгжлийн хувилбар

Макро түвшний хөгжлийн хувилбар

ҮХЦТ-ний 8.1 Хөгжлийн загварын хувилбарууд хэсэгт улсын хэмжээнд хэрэгжүүлэх макро түвшний хөгжлийн хувилбаруудыг дэлгэрэнгүй танилцуулсан.

Бүсчилсэн хөгжлийн хувилбарууд

ҮХЦТ-нд үндэслэн бүсийн хөгжлийн хувилбарын powerpoint танилцуулгыг боловсруулж, 2021 оны 9-р сарын 3-ны өдөр ҮХГ-т хүргүүлсэн. Хүснэгт 4-т Баруун бүсийн хөгжлийн хувилбарыг жишээ болгон үзүүллээ.

**Хүснэгт 4. Баруун бүсийн үе шат бүхий хөгжлийн хувилбар**

| | | 1-р үе шат (2021~25) | 2-р үе шат (2026~30) | 3-р үе шат (2031~40) |
|---|---|---|---|---|
| ХАА, боловсруулах үйлдвэрлэл | МАА-н үйлдвэрлэлийн кластер | Үе шаттай хөгжлийг төлөвлөх, 1-р үе шатыг хэрэгжүүлэх | Боловсруулах үйлдвэр байгуулах, мах, махан бүтээгдэхүүн экспортлох | Экспортод гаргах зорилгоор нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх |
| | Чацаргана жимсний үйлдвэрлэлийн кластер | Үе шаттай хөгжлийг төлөвлөх, 1-р үе шатыг хэрэгжүүлэх | Боловсруулах үйлдвэр байгуулах | Европ руу экспортлох зорилгоор нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх |
| Үйлдвэр, худалдаа | Чөлөөт бүсийг хөгжүүлэх | Цагааннуурын чөлөөт бүсэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | Бусад чөлөөт бүсүүдийг бусад төрлийн үйлдвэрлэлээр хөгжүүлэх | Сонгогдсон чөлөөт бүсүүдийг өргөжүүлэн хөгжүүлэх |
| Аялал жуулчлал | Аялал жуулчлалыг цогц байдлаар хөгжүүлэх | Аялал жуулчлалын нэгдсэн сүлжээг төлөвлөх | Аялал жуулчлалын бие даасан байршлуудыг хөгжүүлэх | Аялал жуулчлалын байршлуудыг үргэлжлүүлэн хөгжүүлэх |
| Авто зам | | - Ховд-Улаангом чиглэлийн авто замыг сайжруулах<br>-Өлгий-Ташанта чиглэлийн авто замыг сайжруулах | - Өлгий-Улаангом чиглэлийн авто замыг сайжруулах | Даяннуур-Өлгий чиглэлийн авто замыг сайжруулах |
| Бусад дэд бүтэц | Ховд хотын нисэх онгоцны буудлыг ОУ-ын нисэх онгоцны буудал болгож өргөжүүлэх | - Ховд хотын нисэх онгоцны буудлыг ОУ-ын нисэх онгоцны буудал болгож өргөжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, 1-р үе шатыг хэрэгжүүлэх | - Ховд хотын нисэх онгоцны буудлыг ОУ-ын нисэх онгоцны буудал болгон өргөжүүлж дуусгах | - Ховд хотын ОУ-ын нисэх онгоцны буудлын байгууламж, үйл ажиллагааг сайжруулах |
| | Бусад | Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барьж дуусгах;<br>- Ховд аймгаас Баян-Өлгий, Увс аймаг хүртэлх цахилгаан дамжуулах | - Ховд голын усан цахилгаан станцын бүтээн байгуулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх | - Ховд голын усан цахилгаан станцын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | агаарын шугам татах төслийг хэрэгжүүлэх. | | |
| Хот, суурин хөгжүүлэх үйл ажиллагаа | | - Ховд аймагт дээд боловсрол, судалгааны төв байгуулах төслийг төлөвлөх, 1-р үе шатыг хэрэгжүүлэх | - Ховд аймагт дээд боловсрол, судалгааны төвийг байгуулах;<br>-Өлгийн байгаль, соёлын аялал жуулчлалын төвийг хөгжүүлэх;<br>- Улаангом хотод худалдааны төвийг хөгжүүлэх. | - Хот, суурингийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хөгжүүлэх |
| Институцийн арга хэмжээ | Хариуцлагатай уул уурхай | - Хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа, зарчмуудыг нэвтрүүлэх | - Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бий болгохтой холбоотойгоор орон нутгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх | - Хяналт, үнэлгээнд иргэдийн оролцоог хангах |
| | Бэлчээрийн менежмент | - Хяналт бүхий бэлчээрийн газрыг ашиглуулж эхлэх | - Бэлчээрийн менежментийг сайжруулах | - Хяналт, үнэлгээнд иргэдийн оролцоог хангах |
| | Үйлдвэрлэлийн кластер | - Чацаргана жимсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, МАА-н үйлдвэрлэлийн кластерын үйлдвэрлэгчдийн холбоог бэхжүүлэх | - МАА-н болон чацаргана жимсний үйлдвэрлэлийн кластерын бүтээгдэхүүний хөгжүүлэлт, маркетингд технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх | - Үйлдвэрлэгчдийн холбоог бэхжүүлэх, бусад үйлдвэрлэлийн кластерыг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх |
| | Бусад | - ОХУ, БНХАУ-ын хилийн худалдааны үйл | - Буянт, Булган, Ховд, Цэнхэрийн | - Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ажиллагааны дүрэм, журмыг хялбаршуулах, татвар, тарифын хөнгөлөлт үзүүлэх<br>- Худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээ, эдийн засгийн бусад үйл ажиллагааг дэмжих орон нутгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх. | голуудыг хамруулан усны нөөцийн менежментийн цогц төлөвлөгөө боловсруулах<br>- Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх. | |

Эдийн засгийн бүсийн хөгжлийн алсын хараа, стратеги

ҮХЦТ-ний 6.3-т тусгасан бүсүүдийн хөгжлийн алсын хараа, стратеги хэсэгт хөгжлийн стратеги, арга хэмжээг бүсээр танилцуулсан бөгөөд үүнийг бүсийн хөгжлийн хувилбарт тооцож болно. Баруун бүсийн хөгжлийн стратеги, арга хэмжээг доорх хэсэгт жишээ болгож үзүүллээ.

Эдийн засаг

Баруун бүсийн хөгжил сул, нэг хүнд ногдох БДНБ-ий хэмжээ бага, хөдөлмөрийн бүтээмж муу, ажилгүйдлийн түвшин өндөр байна. Ойн сан, тариалалтын талбай харьцангуй багатай, зудын эрсдэл өндөртэй. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэж, Баруун бүс нь худалдаа, аялал жуулчлалын холбоотой үйлчилгээ, хагас эрчимжсэн мал аж ахуй, чацарганы үйлдвэрлэлийн кластер, хариуцлагатай уул уурхай, барилгын материалын үйлдвэрлэл, өргөн хэрэглээний бараа, барилгын материалыг хэрэглэгчид хүргэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Орон нутгийн засаг захиргаа, иргэдийн хяналтан дор хариуцлагатай уул уурхайн зарчмын дагуу уул уурхайн хязгаарлагдмал үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрнө. Худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээг сайжруулна. Үүнд:

(a) Боршоо, Даян, Улаанбайшинтын боомтуудыг хөгжүүлж ОХУ, БНХАУ-тай хийх гадаад худалдааг дэмжих,
(b) Өлгий хотын ойролцоо орших Цагааннуурын чөлөөт бүсийн үйл ажиллагааг идэвхжүүлэх,
(c) Байгаль, соёлын аялал жуулчлалын нэгдсэн сүлжээ бий болгох,
(d) Мал аж ахуйг хөгжүүлэх биологийн олон янз байдал, чацаргана боловсруулалт, олон угсаатны соёл, аялал жуулчлалын үйлчилгээний чиглэлээр дээд боловсрол олгох, судалгаа шинжилгээ хийх.

Баруун бүсийн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. Үүнд:

(a) Увс аймагт хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, нэгдсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх зорилгоор тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
(b) Увс аймагт бэлчээрийн мал аж ахуй, нүүдлийн амьдралын хэв маягийг хадгалан, мал аж ахуйн салбарын бүтээмжийг дээшлүүлэн, худалдааны төвүүдээр малын гаралтай бүтээгдэхүүн борлуулж, ашиг орлого олох, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх,
(c) Улаангом, Ховд хотуудыг холбосон гол зам дагуу Увс, Ховд аймагт үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх эхний алхам болох чацарганы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
(d) Гол коридор дагуу чацаргана боловсруулах үйлдвэр байгуулах.

Аялал жуулчлалын нэгдсэн сүлжээг хөгжүүлнэ. Үүнд:

(a) Баян-Өлгий, Ховд аймгийн байгалийн аялал жуулчлалыг Алтайн нуруу, Увс нуурын сав газрыг хамруулан хөгжүүлэх, Баян-Өлгий, Ховд аймгийн олон ястны өв соёлд үндэслэсэн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх,
(b) Ховд хотыг бусад улс орон, бүс нутгаас шууд нислэгээр зорчих Баруун бүсийн аялал жуулчлалын зангилаа болгон хөгжүүлэх.

Дэд бүтэц

Хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд дэд бүтцийг сайжруулах шаардлагатай. Үүнд:

(a) Ховд гол дээр 90 Мвт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцыг ашиглалтад оруулсанаар ОХУ, БНХАУ-аас эрчим хүч импортлохгүйгээр Баруун бүсийн эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангах,
(b) Баян-Өлгий, Увс чиглэлийн цахилгаан дамжуулах шугам барих,

(c) Аялал жуулчлалын нэгдсэн сүлжээ байгуулах, хагас эрчимжсэн мал аж ахуйн фермүүдэд тэжээл нийлүүлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн борлуулах, барилгын материал, бараа бүтээгдэхүүн хэрэглэгчид хүргэх зорилгоор Улаангом, Ховд, Өлгий хотуудыг холбосон авто замыг сайжруулах,
(d) БНХАУ-ын Даяннуураас Өлгийгөөр дайрсан ОХУ-ын Ташант хүртэлх А15 авто замыг сайжруулах.
(e) Ховд хотын нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгон хөгжүүлэх.

Хотын чиг үүрэг

Баруун бүсийн 3 аймгийн төвийн үндсэн чиг үүргийг доор нэгтгэн үзүүлэв. Хотын зэрэглэлийн дүн шинжилгээнд үндэслэн эдгээр 3 аймгийн төвөөс Ховд хотыг бүсийн тулгуур төв хотоор тодорхойлов.

| Аймгийн төв | Үндсэн чиг үүрэг |
|---|---|
| Баян-Өлгий аймгийн Өлгий хот | Боловсруулах, үйлчилгээний үйл ажиллагаа бүхий Цагааннуурын чөлөөт бүс,<br>Байгаль, соёлын аялал жуулчлалын төв. |
| Увс аймгийн Улаангом хот | ОХУ-тай хийх худалдаа, арилжааны төв,<br>Барилгын материал, бараа бүтээгдэхүүн түгээх төв. |
| Ховд аймгийн Ховд хот | Хөдөө аж ахуйг хөгжүүлэх биологийн олон янз байдал, чацаргана боловсруулалт чиглэлээр дээд боловсрол олгох, судалгаа шинжилгээ хийх,<br>Баруун аймгийн аялал жуулчлалын зангилаа,<br>Барилгын материал, хангалтын төв. |

Институцийн арга хэмжээ

Эдийн засгийн шинэ үйл ажиллагааг дэмжих зорилгоор дор дурдсан институцийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

(a) Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх хууль тогтоомж боловсруулах, нутгийн захиргааны байгууллагын зүгээс чанд мөрдүүлэх,
(b) Бэлчээрийн талхагдалаас урьдчилан сэргийлэх зорилгоор бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх,
(c) Дүрэм, журмыг хялбаршуулах, ОХУ, БНХАУ-ын хилийн худалдааны татвар, тарифын хөнгөлөлт үзүүлэх,
(d) Буянт, Булган, Ховд, Цэнхэрийн голуудыг хамруулан усны нөөцийн менежментийн цогц төлөвлөгөө боловсруулах,
(e) Үйлдвэрлэгчдийн холбоог байгуулах/бэхжүүлэх, чацарганы бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх, бүтээгдэхүүн борлуулах, технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
(f) Худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээ, барилгын материалын үйлдвэрлэл, эдийн засгийн бусад үйл ажиллагааг дэмжих орон нутгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх.

# Бүлэг 3 Хяналт-шинжилгээ, үнэлгээ

## 3.1 Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт

### 3.1.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

Аливаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хянаж, үнэлж, үр нөлөөг нь тооцож, шаардлагатай бол зорилтот түвшинд нь хүргэхийн тулд шинэчлэн өөрчилж, шинээр батлагдах бодлого, төлөвлөлтүүдэд үр дүнг нь тусгадаг жишиг байдаг. Түүнчлэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад тодорхойлдог үзэл баримтлал, алсын хараа, удирдамжид ч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, өөрчлөлт оруулж болдог. Иймд хяналт-шинжилгээ, үнэлгээ нь хөгжлийн менежментийн чухал хэсэгт тооцогддог.

Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ хэрэгжилтийн хяналт, гүйцэтгэлийн хяналтаас бүрддэг. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналтын хүрээнд хэрэгжүүлэх хугацаа, төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн явц, хуваарь, гүйцэтгэл зэргийг хянадаг. Түүнчлэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж буй ажилтнууд болон хэрэгжүүлэхэд ашиглаж буй байгууламжуудын үйл ажиллагааг үнэлэх зорилгоор үйл ажиллагаа, менежментийн хяналт-шинжилгээг хийж болно. Гүйцэтгэлийн хяналт нь төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө эсвэл хөгжлийн төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн бодлого, багц төсөл, хөтөлбөрийн ерөнхий үр нөлөөг хянадаг.

Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд үндэсний зөвлөхүүд Төслийн багийн удирдлага дор Монгол Улсын ТХҮБ 2030 болон бусад урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг судалсан. Одоо хэрэгжиж байгаа хяналт-шинжилгээ, үнэлгээний хууль, дүрэм, журам, үйл ажиллагааг судалж, ХАНСХЕТ, БХБ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх санал, зөвлөмжийг боловсрууллаа. Мөн Японы үндэсний цогц төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний жишээг танилцуулав.

### 3.1.2 Хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, хариуцлагын хуваарилалт

2015 оны 11 дүгээр сарын 26-нд батлагдаж, 2020 оны 5 дугаар сарын 20-нд нэмэлт өөрчлөлт оруулсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Монгол Улсад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар тусгасан. Хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг үндэсний, бүс нутгийн, орон нутгийн түвшинд хангахад оршино. Энэ хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлогыг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Хуульд УИХ, Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, Төв банк болон Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн бүрэн эрх, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаарх чиг үүргийг тусгасан. Хүснэгт 3.1.1-д хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчийн эрх, үүргийг нэгтгэн үзүүлэв.

**Хүснэгт 3.1.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчийн эрх, үүрэг (хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх)**

| Нэр | Чиг үүрэг |
|---|---|
| УИХ | - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон энэ хуульд заасан баримт бичигт нийцүүлэн батлах;<br>-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах, түүнчлэн холбогдох судалгаа, шинжилгээ, явцын болон эцсийн үнэлгээг үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Засгийн газарт чиглэл өгөх. |
| Засгийн газар | -Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг улсын түвшинд удирдан зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах үйл ажиллагааг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулах;<br>-Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хянан үзэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх журмыг батлах;<br>-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг энэ хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;<br>-Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам, тайлангийн үлгэрчилсэн загвар батлах;<br>-Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;<br>-Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн аливаа асуудлаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тодорхой үүрэг, чиглэл өгөх. |
| Төрийн захиргааны төв байгууллага | -Энэ хуульд заасан баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд оролцох;<br>-Энэ хуульд заасан баримт бичигт тусгах саналаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, батлах, төлөвлөхөд шаардлагатай өөрийн эрхлэх асуудлын хүрээний тоо баримт, судалгаа, мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд шуурхай гарган хүргүүлэх;<br>-Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хууль тогтоомжид заасан хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, дүгнэлтийг Засгийн газар болон үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх. |
| ҮХГ | -Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах;<br>-Макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх |

| | |
|---|---|
| | асуудлаар зөвшөөрөл өгөх;<br>-Мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, ангилах, бүртгэл хөтлөх, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, хянан үзэх, мэдээллийг эргэлтэд оруулах болон мэдээллийн сантай холбоотой бусад ажлыг эрхлэн гүйцэтгэх;<br>-Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай мэдээлэл, судалгаа, тодорхой салбарын хөгжлийн асуудлаар санал, дүгнэлт, төлөвлөгөөний төслийг төрийн бүх шатны байгууллага болон холбогдох бусад байгууллагаас гаргуулан авах. |
| ҮСХ | -Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд шаардагдах албан ёсны статистикийн мэдээллийг тухай бүрд нь боловсруулж үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;<br>-Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай шалгуур үзүүлэлт, түүний эх үүсвэр, тооцох аргачлалыг тодорхойлох, бий болгоход шаардлагатай арга зүй, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах. |
| Төрийн аудитын байгууллага | -Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт Төрийн аудитын тухай хуульд заасан аудит хийж Улсын Их Хуралд танилцуулах; |
| Аймаг, нийслэлийн Засаг дарга | -Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;<br>-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулахад холбогдох саналаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;<br>-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Засгийн газар болон үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус хүргүүлэх. |

### 3.1.3 ТХҮБ 2030-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дагаж мөрдөх хууль, дүрэм, журам

УИХ-аар 2020 оны 5 дугаар сард “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдсан бөгөөд ТХҮБ 2030 баримт бичгийн үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд нь агуулгаараа тус бодлогод тусгагдсан тул ТХҮБ 2030-ыг хүчингүйд тооцсон. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог судлах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбоотой асуудлуудыг тодруулах зорилгоор ТХҮБ 2030 баримт бичгийн хэрэгжилтэд хэрхэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн

талаар судалсан.

### (1) ТХҮБ 2030-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дагаж мөрдөх хууль, дүрэм, журам

2015 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулга уулзалтаар 2030 он хүртэл хэрэгжүүлэх Тогтвортой хөгжлийн зорилгуудыг нийт 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлттэйгээр баталсан. ТХЗ-уудын хүрээнд 2016 оны 2 дугаар сард Монгол Улсын Их Хурал 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталсан. Тус тогтоолд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын бүтэц, тогтолцоог бий болгох”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн байдалд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж байх”, “Тогтоолын биелэлтэд Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо хяналт тавьж ажиллах” заалтууд тусгагдсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 20.2, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолд заасны дагуу Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баталсан (2020 онд тус журмыг шинэчлэн баталсан). Тус журмын Хавсралт 1-д бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа, тайлангийн төрөл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, тайлан хүргүүлэх хугацаа, тайлан хүлээн авах байгууллага, давтамж, тайлагнах байгууллага, хугацаа зэргийг тодорхой заасан.

Хавсралт 1-ээс харахад төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2018 оны 9-р сарын 1-нд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заасан. Түүнчлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2018 оны 10-р сарын 1-нд хүргүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайланг хянаж, Засгийн газарт 11-р сард, УИХ-д 12-р сард танилцуулахаар заасан байна.

Яамдын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрууд журамд заасны дагуу Монгол Улсын ТХҮБ 2030-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд боловсруулж, 2018 оны 9-р сарын 1-нд хүргүүлсэн. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2018 оны 10-р сарын 1-нд хүргүүлсэн. Тайланг хугацаанд нь хүргүүлсэн эсэх тодорхойгүй байна. Эдгээр байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хариуцсан ахлах мэргэжилтэн 7-14 хоногийн хугацаанд холбогдох агентлаг, байгууллагаас ирүүлсэн тайланг хүлээн авч нэгтгэсэн.

### (2) ТХҮБ 2030-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгжилт

ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Э. Бат-Идэрийн хэлснээр ТХҮБ 2030-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг журамд заасан хугацаанд Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-

ын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлсэн ч, УИХ-д танилцуулаагүй байна.

2018 оны 2-р сарын 7-нд УИХ-ын гишүүд С.Бямбацогт, Н.Амарзаяа, Б.Баттөмөр, Д.Оюунхорол, Д.Эрдэнэбат нар Монгол Улсын ТХҮБ 2030-ын хэрэгжилтийн явцын талаар асуулгыг Ерөнхий сайдад хүргүүлсэн. 2018 оны 3-р сарын 30-нд ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар асуулгын хариу бичгийг хүргүүлсэн байна. 2019 оны 5-р сарын 24-нд УИХ-ын хаврын чуулганы үеэр Ерөнхий сайд У.Хүрэлсүх дээрх асуулгад хүргүүлсэн хариугаа танилцуулсан (эх сурвалж: http://parliament.mn/files/35568).

Уг асуулгад хөгжлийн бодлогын баримт бичиг нь аль ч нам төрийн эрх барьж байсан төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах ба хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтуудыг тодорхой тусгасан байх шаардлагатайг дурдсан байна. Тухайлбал тогтвортой хөгжлийн зорилтод тусгагдсан Монгол Улсын хөгжлийн үндсэн зорилт болох эдийн засгийг төрөлжүүлж, олон тулгууртай болгох зорилтын хэрэгжилтийн талаар, ТХҮБ-ыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын бүтэц, тогтолцоо бий болсон эсэх талаар, тогтвортой хөгжлийн зорилтууд, түүний хэрэгжилтийн явцад хэрхэн хяналт тавих талаар асуултуудыг асуусан байв.

Түүнчлэн асуулгад тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр жил бүрийн улс, орон нутгийн төсөвт хүрэлцээтэй тусч байгаа эсэх талаар, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлж байгаа, хэлэлцэн батлуулсан салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөр, зорилтууд нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай хэрхэн уялдаж байгаа талаар, 2020 он гэхэд Тогтвортой хөгжлийн зорилтын 1-р үе шатанд тавигдсан зорилтуудыг бүрэн хэрэгжүүлж чадах эсэх талаар асуултуудад тодорхой хариултуудыг хүссэн байна.

**(3) ТХҮБ 2030-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт**

Төслийг сунгасан хугацаанд ТХҮБ 2030-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотойгоор судалгаа хийж, дараах зүйлсийг тодруулсан ба үүнээс урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий дүр зургийг харж болох юм.

1) Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох дүрэм, журмын дагуу Монгол Улсын ТХҮБ 2030 баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2018 оны 11 дүгээр сард Засгийн газарт, 2018 оны 12 дугаар сард УИХ-д хүргүүлсэн боловч УИХ-ын чуулганаар хэлэлцэх асуудалд ороогүй.
2) ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас боловсруулж гаргасан Монгол Улсын ТХҮБ 2030-ын 2017-2018 он болон 2019 оны эхний хагаст хийсэн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хэзээ УИХ-д хүргүүлсэн нь тодорхойгүй байна.
3) Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орох бүрт хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, хэлтсүүдийн хүний нөөц өөрчлөгддөг, хүний нөөцийн чадавх сул байдаг, шаардлагатай сургалтууд дутмаг байдаг зэрэг асуудлууд байна.
4) ТХҮБ 2030-ын зорилтот түвшин, зорилтод хүрэх арга хэмжээтэй харьцуулахад

хяналт-шинжилгээ, үнэлгээ, гүйцэтгэлийн түвшинг үнэлэхэд шаардлагатай зарим үзүүлэлтүүд тодорхой бус байдаг бөгөөд шаардлагатай мэдээллийг гаргаж авч чадахгүй учир үнэлгээ хийхэд хүндрэл учирдаг.

5) Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, аймаг, нийслэлийн Засаг дарга нар өөрийн хариуцсан асуудлын хүрээнд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг боловсруулж, батална. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгжилт хангалтгүй байх тохиолдолд аргачлалыг сайжруулж, боловсронгуй болгоно.

### 3.1.4 Бусад бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

#### (1) Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан. Тус тогтоолоор үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулж байх, мөн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг тус тус тогтоосон.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Тус тогтоолд Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байхаар, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, үнэлгээ хийж, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхаар тус тус тогтоосон.

ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь дараах чиг үүрэгтэй байна (https://cabinet.gov.mn/sector/). Үүнд:

1) Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн Хэрэг эрхлэх газарт холбогдох заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг тайлагнах;

2) Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төслийн үр ашгийг дээшлүүлэх талаар зөвлөмж өгөх, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх;

3) Энэ чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргах, мэргэжил, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх, үр дүнг нэгтгэх;
4) Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг нэгтгэн үнэлж дүгнэх;
5) Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх;
6) "Иргэд, олон нийттэй харилцах-1111" төвийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлын хэрэгжилт, үр дүнг хууль тогтоомжийн дагуу нэгтгэн дүгнэх, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг нэгтгэж, 2020 оны 3-р сарын 27-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2020 оны 4-р сарын 2-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийт 5 бодлого, 387 зорилт, 1287 арга хэмжээ тусгагдсан.

### (2) Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт

Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийг дүгнэж, зорилтуудад хүрэх үйл ажиллагаа, арга хэмжээг бүх шатанд эрчимжүүлэх тодорхой чиг үүргийг холбогдох газруудад өгсөн. Түүнчлэн УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо болон УИХ дахь МАН-ын бүлгийн хуралдаанаас Засгийн газарт холбогдох үүрэг, чиглэлүүдийг өгсөн.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг холбогдох журмын дагуу 2019 оны эцсийн байдлаар дүгнэхэд Эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого, Нийгмийн бодлого, Засаглалын бодлогын хэрэгжилт 80 гаруй хувьтай, Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого, Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилт 68~78%-тай байв. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого, нийгмийн бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн зам, барилга, уул уурхай, эрчим хүчний салбарын зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байсан буюу зорилтот түвшиндээ хүрээгүй.

Ерөнхийдөө Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг чанарын үнэлгээгээр бодлогын зорилтоор, хэрэгжүүлэгч байгууллагаар хууль тогтоомжид заасан журмын дагуу хийж байна. Зам, барилга, уул уурхай, эрчим хүчний салбарын хэмжиж болохуйц үр дүнг тоон үнэлгээгээр үнэлдэг бөгөөд зорилтот түвшинд хүрэхгүй байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт цаашид анхаарах гол асуудлуудыг дараах байдлаар тоймлосон байна. Үүнд:

1) Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах;
2) Валютын ханшийн өсөлт, бууралтыг хязгаарлах;

3) 2021-2024 онд төлөгдөх 2.9 тэрбум ам.долларын өрийг төлөх хуримтлал бий болгох;
4) Авлигатай тэмцэх, тодорхой үр дүнд хүрэх;
5) ФАТФ-ын саарал жагсаалтаас гарах* болон
6) Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж 30 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Тайлбар*: 2021.10.21-ний байдлаар Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтад байхгүй байна.

### (3) БХБЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

БХБЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, яамны чиг үүрэгтэй холбогдон гарсан шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах үндсэн үүрэг хүлээдэг. Үүний хүрээнд 1) салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах, 2) яамны хариуцсан ажлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, шийдвэрийн биелэлтэд хяналт шалгалт, хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах, 3) төсвийн тухай хуульд заасны дагуу дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, бусад хэрэглэгчид, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, иргэд байна. (https://mcud.gov.mn/p/178)

БХБЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтууд, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жилийн болон жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн. Энэхүү ажил нь дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, цаашид анхаарах асуудлуудын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлагуудыг холбогдох мэдээллээр хангахад чиглэгдсэн.

2019 оны тайлангийн хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт 59 зорилтын хүрээнд 150 арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнээс БХБЯ-ны бие даан хэрэгжүүлэх 99, хамтарч хэрэгжүүлэх 51 төлөвлөгөө, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. 2019 оны эцсийн байдлаар БХБЯ-ны чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт 94.5 хувьтай байв.

БХБЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (ХШҮДАГ) 2016-2020 онд газрын дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдээс бүрдсэн 6 хүнтэйгээр ажилласан. Тус газар нь БХБЯ-ны газар, агентлагуудаас ирүүлсэн тайлан мэдээнд 7-14 хоногийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. БХБЯ-ны бусад газар, хэлтэс, харьяа байгууллагуудын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан мэргэжилтнүүд харьяа нэгж,

байгууллагынхаа тайланг нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлдэг. ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн дээрх журамд заасан аргачлалын дагуу хэрэгжилтийн тайланд 7-14 хоногт үнэлгээ хийж, газрын дарга үнэлгээг хянана.

Үүний дараа хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгтгэсэн тайланг БХБЯ-ны Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлдэг ба хурлын шийдвэрээс хамаарч холбогдох материалуудыг ЗГХЭГ-т жилд хоёр удаа (тухайн жилийн 7-р сарын 1-нд болон дараа жилийнх нь 1-р сарын 10-нд) хүргүүлдэг. ХШҮДАГ-ын дарга хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох санал, зөвлөмжийг www.unelgee.gov.mn цахим хуудсанд байршуулж байгаа эсэхэд хяналт тавьдаг. Түүнчлэн газрын дарга нь Сайдын зөвлөлийн хурлын шийдвэр, холбогдох хавсралтыг тайланд хавсаргасан эсэхийг нарийвчлан шалгана.

2020 оны эхний хагас жилийн байдлаар (2020.06.26) Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан БХБЯ-ны хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт 94.8% байсан. 2020 оны 8-р сард УИХ-ын 24 дүгээр тогтоолоор Засгийн газрын үйл ажиллагааны шинэ хөтөлбөр буюу Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан.

### (4) Монгол Улсын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны талаарх ерөнхий дүгнэлт

Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийсэн судалгааны дүнд Монгол Улсын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоотой холбоотойгоор дараах асуудлуудыг онцолж байна. Үүнд:

1) Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орох бүрт хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, хэлтсүүдийн хүний нөөц өөрчлөгддөг, хүний нөөцийн чадавх сул байдаг, шаардлагатай сургалтууд дутмаг байдаг зэрэг асуудлууд байна.
2) Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтот түвшин, зорилтод хүрэх арга хэмжээтэй харьцуулахад хяналт-шинжилгээ, үнэлгээ, гүйцэтгэлийн түвшинг үнэлэхэд шаардлагатай зарим үзүүлэлтүүд тодорхой бус байдаг ба бодит үр дүн гараагүй зорилтуудад үнэлгээ хийхэд хүндрэл учирдаг.
3) “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон. Гэвч хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал хангалтгүй байгаа ба аргачлалыг боловсронгуй болгох шаардлагатай байна.
4) ЗГХЭГ олон нийтэд зориулсан хяналт-шинжилгээ, үнэлгээний нээлттэй, цахим мэдээллийн санг (http://unelgee.gov.mn/) ажиллуулдаг болович мэдээллийн санд тайлангууд бүрэн тавигдаагүй байна. Мөн яамдын цахим хуудас дээр тайлангууд дутуу тавигдсан байна.
5) Холбогдох мэргэжилтнүүд тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгтгэхэд дараах асуудлууд тулгарч байгааг онцолсон. Үүнд:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хугацаанд нь хүргүүлдэггүй.
- Суурь түвшин тодорхойгүй, хүрэх үр дүн, зорилтот түвшин, шалгууруудыг тодорхой заагаагүй.
- Тайлан нь хэт дэлгэрэнгүй, ойлгомжгүй, ташаа мэдээлэл агуулсан эсвэл хэт том хэмжээтэй байх зэрэг асуудлууд байдаг.
- Тайлан хүргүүлэх хугацаа, шалгуурыг чанд мөрддөггүй.
- Тайлан хүргүүлэх хугацаатай давхцдаг тул газар, хэлтсүүд хоцорч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг, холбогдох газар, агентлагаас тодруулга хийдэггүй, дутуу тайлагнадаг, холбогдох материалыг тайланд хавсаргадаггүй, үг, үсгийн алдаатай байдаг зэрэг асуудлууд гардаг. Тиймээс ЗГХЭГ-т тайлан хүргэх хугацаанд илүү цагаар ажиллах шаардлагатай болдог.
- Байгууллагууд өөр өөр байдлаар тайлагнадаг тул үр дүнг ижил үзүүлэлтээр үнэлэхэд заримдаа хүндрэлтэй байдаг. Тухайлбал аливаа нэг арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төсөл боловсруулах, хэлэлцэх, хүргүүлэх, батлуулах зэрэг үе шатуудад өөр өөрөөр төлөвлөсөн байдаг. Бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт нь бусад баримт бичгийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах үйл ажиллагаатай уялддаггүй буюу төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн ч тухайн төлөвлөлтийн зохицуулалтыг хангах хууль, эрхзүйн баримт бичгийг батлуулаагүй байдаг г.м. Тиймээс ЗГХЭГ-т хэрэгжиж дуусаагүй гэж тайлагнах тохиолдлууд гардаг.

6) Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагааг цаашид боловсронгуй болгох үүднээс холбогдох албан тушаалтнаас эдгээр асуудлуудыг хөндсөн. Төлөвлөгөөг боловсруулах явцад суурь түвшин, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт, төсвийг эхнээс нь тодорхой заaж өгвөл буруу тооцоо хийх, дутуу тайлагнах, хэтрүүлэн төсөвлөх, дутуу үнэлэх зэрэг алдаа мадаг гарахгүй.

Ажигласнаар тоон үнэлгээ нь тодорхой бус шалгуур үзүүлэлт, бодит үр дүн гараагүй зэргээс шалтгаалж хязгаарлагдмал байдлаар үнэлдэг (2). Журамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаарх ерөнхий үйл ажиллагааг тусгасан бөгөөд тус журамд үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон нь хангалтгүй байна (3). ЗГХЭГ олон нийтэд зориулсан хяналт-шинжилгээ, үнэлгээний нээлттэй, цахим мэдээллийн санг ажиллуулдаг боловч тайланг бүрэн байршуулаагүй, мэдээлэл ил тод бус байна (4). Зарим тохиолдолд үнэлгээний суурь түвшин болон шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус байна (5). Байгууллагууд бодлогын зарим арга хэмжээг төрөл бүрийн үе шаттайгаар, өөр өөрөөр тайлагнадаг нь чанарын үнэлгээ хийхэд хүндрэл учруулдаг.

Хөгжлийн бодлого, төлөвлөгөө, төслүүдийг хэрэгжүүлэхэд уялдаа холбоо бүхий төлөвлөлт-програмчлал-төсвийн системийг (PPBS) нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээг ижил логикийг баримтлан хийж гүйцэтгэхийг зөвлөж байна. Өөрөөр хэлбэл суурь түвшинг тогтоож, програмчлалын бүрэлдэхүүн хэсэг болох суурь түвшинтэй уялдуулан шалгуур үзүүлэлтээр хэрэгжүүлэх зорилтыг тогдорхойлж, зорилтот түвшинд хүрч байгаа эсэхийг шалгуур үзүүлэлтийн дагуу хянаж, үнэлдэг байх ёстой.

### 3.1.5 Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн нь үнэлгээний суурь үзүүлэлтүүдийг тогтоох, үр дүнг тоон байдлаар үнэлэхэд шаардлагатай мэдээлэл байгаа эсэхээс хамаардаг. Үндэсний статистикийн хороо (ҮСХ) хөгжлийн зорилтын гүйцэтгэлийг нийгэм, эдийн засгийн болон бусад индексүүдээр нэгтгэн гаргадаг. ҮСХ нь гүйцэтгэлийн хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэж, статистикийн мэдээллийн нэгдсэн санд байршуулж, олон нийтийг хялбар олж авах боломжтой, цогц, нарийвчлал бүхий, сүүлийн үеийн мэдээллээр хангадаг.

НҮБ-ын ТХЗ-уудын хүрээнд жендэр, орлогын хуваарилалт, аймаг, сумд, үндэс угсаа, нийгмийн бүлэг болон бусад холбогдох микро түвшний мэдээллийг цуглуулах шаардлагатай болсон. Үүний дагуу ҮСХ микро түвшний мэдээллийг цуглуулж, нэгтгэх ажлыг эхлүүлсэн. АХБ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон бусад хандивлагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр асуулгын хуудсыг илүү нарийвчлалтай болгож, нэмэлт индекс, микро өгөгдлийг ашиглаж, хөдөлмөрийн эрхлэлтийн улирлын судалгаа, өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, таван жил тутамд явуулдаг нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа зэрэг тогтмол хийгддэг судалгаануудыг сайжруулсан.

ҮСХ 2020 онд “Статистикийн салбарыг хөгжүүлэх, статистикийн үйл ажиллагаанд стандарт нэвтрүүлэх зорилгоор үндэсний 4 дүгээр дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулах” гол зорилгыг тавьж, зорилгод хүрэхийн тулд дараах зургаан зорилтыг тодорхойлсон.

1) Статистикийн ерөнхий үйл ажиллагаанд стандарт нэвтрүүлэх, албан ёсны статистикийн мэдээлэл боловсруулалтыг сайжруулах;
2) Статистикийн үзүүлэлтүүд, аргачлалыг олон улсын ангилал, арга зүй, стандартын дагуу боловсронгуй болгож, баг, хороо, сумын түвшинд статистикийн мэдээллийг боловсруулж, олон нийтэд хүртээмжтэй байдлаар байршуулах;
3) 2020 оны хүн ам, орон сууцны тооллого болон бусад тооллого, судалгааны дүнг боловсруулж, олон нийтэд хүртээмжтэй байдлаар байршуулах;
4) ТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тооцох арга, аргачлалыг боловсронгуй болгох, мета өгөгдлийн системийн мэдээллийг сайжруулах;
5) Хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх, статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон улсын статистикийн салбарын шинэчлэл, сайн туршлагаас суралцах;
6) Албан болон үйл ажиллагааны статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах, статистикийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор гүйцэтгэлд хяналт тавих.

НҮБ-ын байгууллагуудын боловсруулсан аргачлал, судалгааг ашиглан ТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай микро өгөгдлүүдийг цуглуулах, боловсруулах ажлууд хийгдсэн. Тухайлбал Монгол Улс ТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх 244 шалгуур үзүүлэлтээс 132 үзүүлэлтийг тооцож байгаагаас ҮСХ-ноос 88 үзүүлэлтийг тооцож ТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх хяналтын самбарыг баяжуулсан. 2019 онд цуглуулж, нэгтгэсэн мэдээллээс харахад 19 үзүүлэлт нь ногоон хөгжилтэй холбоотой үзүүлэлт байв.

Монгол Улс НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын төсөл хэрэгжүүлэгч долоон

орны нэгээр сонгогдож, ҮСХ “Монгол Улсын ТХЗ-д жендэрийн статистикийг бий болгох, ашиглах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Түүвэр судалгааны загварыг оновчтой болгох, шинжлэх ухааны үндэслэлтэй болгох, үүнийг үе шаттайгаар, системтэйгээр нэвтрүүлэх ажлын хүрээнд хөдөө аж ахуйн салбарын арга зүй, статистикийн талаарх гарын авлагыг бэлтгэх зорилгоор НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хөдөө аж ахуйн статистикийн мастер төлөвлөгөөг орчуулсан. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага хөрөнгө, капиталын үйлчилгээний статистик мэдээг нэгтгэхэд ашигладаг “Хөрөнгийг хэмжих нь” гарын авлагад үндэслэн шинэ гарын авлагыг боловсруулсан.

## 3.2 Япон Улсын үндэсний хөгжлийн төлөвлөгөөнүүд

### (1) Үндэсний хөгжлийн 5 цогц төлөвлөгөө

Япон Улсад бодлогын баримт бичгүүдийн үнэлгээг 2001 онд хуульчилж, Бодлогын үнэлгээний тухай хуулийг баталсан. Үүнээс өмнө үндэсний бодлогын баримт бичгийн үнэлгээг олон нийтэд системтэйгээр нээлттэй байлгах үйл ажиллагаа байгаагүй. Тиймээс 1962-1997 оны хооронд хэрэгжүүлсэн үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй. Харин 1969-1977 оны хооронд хэрэгжүүлсэн Үндэсний хөгжлийн хоёрдугаар цогц төлөвлөгөөний эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт, байгаль орчныг хамгаалах төлөвлөлт, мега хотуудад тулгамдсан асуудлуудыг бууруулах арга хэмжээ зэрэг 8 бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтэд үнэлгээ хийгдсэн байдаг. Үүний үр дүнд нефтийн хямрал, бохирдлын асуудлуудтай холбоотойгоор хоёрдугаар төлөвлөгөөнд тусгагдсан байсан томоохон аж үйлдвэрийн бүсүүдийг хөгжүүлэх төлөвлөлтийг эргэн харж, зармынх нь хэрэгжилтийг түр зогсоосон байна.

1977-1987 оны хооронд хэрэгжүүлсэн Үндэсний хөгжлийн гуравдугаар цогц төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд нийгэм-эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт, аж үйлдвэрийн хөгжлийн төлөвлөлт, амьдрах орчныг сайжруулах төлөвлөлт болон бусад төлөвлөлтүүдийг боловсруулах 5 техникийн хороог байгуулсан. Эдгээр хороод гуравдугаар төлөвлөгөөг боловсруулахдаа хоёрдугаар төлөвлөгөөний үнэлгээг харгалзаж үзсэн.

1998-2008 оны хооронд хэрэгжүүлсэн тавдугаар үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг “XXI зууны улсын газрын сангийн их дизайн” гэж нэрлэж байсан ба Бодлогын үнэлгээний тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш батлагдсан тул төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих цахим хуудсыг нээж, хяналт-шинжилгээний үр дүнг байршуулж эхэлсэн. Тавдугаар төлөвлөгөөнд тусгагдсан дөрвөн стратегид Үндэсний газрын зөвлөлөөс онцолсон таван чиглэлээр хяналт-шинжилгээ хийсэн. Хяналт-шинжилгээ хийх 14 чиглэлийн хүрээнд 166 үнэлгээний шалгуурыг тогтоосон. Цахим мэдээллийн санд голчлон тавдугаар төлөвлөгөөний төлөвлөлтийн үе шатны мэдээлэл байгаа ба түүнээс хойш цөөн тооны үзүүлэлтийн мэдээллийг шинэчилсэн бөгөөд хамгийн сүүлд мэдээллийг 2006 онд шинэчилсэн байна.

### (2) Үндэсний газрын 2 төлөвлөгөө

Үндэсний хөгжлийн тавдугаар цогц төлөвлөгөө батлагдсаны дараа 2008 онд Засгийн газар Үндэсний газрын нэгдүгээр төлөвлөгөөг баталсан бөгөөд 2009-2014 оны хооронд Газар, дэд бүтэц, тээврийн яам, Үндэсний газрын бодлогын газар тус төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн. Стратегийн таван

зорилгын хүрээнд 15 төлөөлөх шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээг 2008 оноос хойш хийсэн. Иргэд, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон бусад этгээдийн талаарх статистик мэдээ, ойлголтын судалгааг төлөөлөх шалгуур үзүүлэлтийн суурь тоо мэдээ болгож ашигласан. Стратегийн таван зорилгын хэрэгжилтэд чанарын үзүүлэлтээр хяналт-шинжилгээ хийсэн. 2014 онд ойлголтын судалгааг 11000 иргэн, 800 нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл, 363 ашгийн бус байгууллага, 94 эксперт, 256 хувийн хэвшлийг хамруулж цахимаар хийсэн.

2015 онд Засгийн газар Үндэсний газрын төлөвлөгөөг хоёрдугаар баталсан бөгөөд Үндэсний газрын зөвлөлийн дэргэд Төлөвлөлт, хяналтын хороо байгуулагдсан. Түүнчлэн төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжих ажлын хэсэг байгуулагдаж “Эргэлтийг дэмжсэн газрын сан” концепцэд тулгуурласан үндэсний газрын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцэж байсан.[1] Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын яам, Үндэсний газрын бодлого, цогц төлөвлөлтийн газар, газар нь хэрэг эрхлэх газрын үүргийг гүйцэтгэдэг. Төлөвлөлт, хяналтын хороо нь их, дээд сургууль, төрийн байгууллага болон санхүүгийн байгууллагуудын мэргэшсэн, чадварлаг гишүүдээс бүрдэнэ. Тус хороо 2018-2019 онд таван удаа хуралдсан байна. Эдгээр хурлуудын дүнд албан ёсоор хяналт-шинжилгээний үзүүлэлтийг тогтоогоогүй ч “Эргэлтийг дэмжсэн газрын сан” үзэл баримтлалд нийцүүлэн хүн ам, түүний тархалтын талаар олон асуудлыг хэлэлцсэн.

Бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ нь бүс нутгийн хүн ам, бүсийн эдийн засаг, газар ашиглалт гэх мэт нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүдэд хийх хяналт-шинжилгээ, тодорхой бодлого, төсөл, хөтөлбөрүүдэд хийх хяналт-шинжилгээнээс бүрддэг. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө батлагдсаны дараа хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үндэсний газрын төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ хийхдээ эхний төрлийн хяналт-шинжилгээг хийдэг. Япон улсад тусдаа нэг төслийн явцын тайланд хяналт-шинжилгээ хийхдээ сүүлийн төрлийн хяналт-шинжилгээг хийдэг ба үүнд системчилсэн бодлогын үнэлгээ байдаггүй. Энэ нь төлөвлөлт хариуцсан газар, байгууллагын чиг үүрэгт туссан байдагтай холбоотой байж болох юм.

### (3) Японы үндэсний газрын бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог шинэчлэх санал болон шалгуур үзүүлэлтүүд

“Эргэлтийг дэмжсэн газрын сан” концепцэд үндэслэсэн үндэсний газрын бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэх саналыг Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын яамны (ГДБТАЖЯ) Үндэсний орон зайн төлөвлөлт, бүсийн бодлогын газраас гаргасан. Зураг 3.2.1-д санал болгож буй шинэчлэх бүтцийг үзүүлэв. Хүснэгт 3.2.1-д Япон улсын газар зохион байгуулалтад ашиглагддаг индексүүдийн жишээг үзүүллээ.

[1] ps://www.mlit.go.jp/policy/shingikai/s104_monitoring01_past.html




Эх сурвалж: "Үндэсний орон зайн стратеги" (шинэчилсэн), ГДБТАЖЯ-ны Үндэсний орон зайн төлөвлөлт, бүсийн бодлогын газрын дарга М.Кимура, 2018 оны 8 дугаар сар

**Зураг 3.2.1 Бүсчилсэн хөгжлийн хяналтын тогтолцоог Үндэсний хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд шинэчилсэн дүр зураг**

**Хүснэгт 3.2.1 "Эргэлтийг дэмжсэн газрын сан" концепцэд тулгуурласан Япон улсын үндэсний хөгжлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний индексүүд**

| Концепц | Хяналт-шинжилгээний индекс | Мэдээлэл авсан байгууллага | Одоогийн тоо/үзүүлэлт |
|---|---|---|---|
| Нэгдсэн чиг үүрэг бүхий жижиг өртөөнүүдийг байгуулах | Шинээр байгуулагдсан жижиг өртөөний тоо | ЗГХЭГ | 1,260 (2016 оны 10-р сар) |
| Төлөвлөлтийг оновчтой хийж цомхон хотуудыг байгуулах | Газар ашиглалтын оновчтой төлөвлөгөө боловсруулсан хотын тоо | ГДБТАЖЯ | 124 (2017 оны 5-р сар) |
| Өсөлттэй эдийн засаг, идэвхтэй амьдрах орчинтой бүс нутгийг бүсийн төвөөр хөгжүүлэх | Шинээр байгуулагдсан бүсийн төвүүдийн тоо | ДХХХЯ | 23 (2017 оны 3-р сар) |
| Өрсөлдөх чадвартай тээвэр-экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэх | Хөдөө аж ахуйн, далайн болон хүнсний бүтээгдэхүүний экспорт | СЯ | 745.1 тэрбум япон иен (2015) |
| Бизнес эрхлэгчдэд түшиглэж бүс нутагт чиглэсэн инновацийг дэмжих | Орон нутгийн нөөцөд түшиглэн хэрэгжүүлсэн төслийн тоо | ЖДҮ | 1,677 (2016 оны 12-р сар) |
| Хоёр газар оршин суудаг буюу ажиллаж, амьдардаг газар тусдаа хэв маягийг сурталчлах | U-turn шилжих хөдөлгөөнийг дэмжих төвийн хэрэглэгчдийн дунд залуучуудын эзлэх хувь | U-turn шилжих хөдөлгөөнийг дэмжих төв | 45.9% (2016) |

| | | | |
|---|---|---|---|
| Токио хотыг дэлхийн жишиг хот болгон хөгжүүлэх | Дэлхийн хүчирхэг хотын жагсаалт/индекс | Моригийн дурсгалын сан | 3-т (2016) |
| Ухаалаг, эрүүл мэндийн (wellness) орон сууц, хотыг барьж байгуулах | Бүс халамжийн төвүүдийг байгуулсан Хот сэргэн босголтын агентлагийн үл хөдлөх хөрөнгийн тоо | Хот сэргэн босголтын агентлаг | 47 (2016 оны 1-р сар) |

Эх сурвалж: "Үндэсний орон зайн стратеги" (шинэчилсэн), ГДБТАЖЯ-ны Үндэсний орон зайн төлөвлөлт, бүсийн бодлогын газрын дарга М.Кимүра, 2018 оны 8 дугаар сар.

## 3.3 Санал, зөвлөмж

### (1) Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо

2020 оны 5-р сард шинэчлэн найруулсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааг хуульчлан заасан байдаг. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний процедур, аргачлалыг тухайн бодлого, төлөвлөлтийг баталж буй тогтоолд заасан байдаг.

Төслийн хэрэгжилтийг сунгасан хугацаанд хийсэн судалгаагаар одоогийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотойгоор дараах асуудлуудыг онцолж байна. Үүнд:

1) Үйл ажиллагаа, арга зүйг боловсронгуй болгож, сайжруулах;
2) Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хүний нөөцийг сайжруулах зорилгоор сургалтуудыг зохион байгуулах шаардлагатай;
3) Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд ихээр солигддог нь үйл ажиллагаанд нөлөөлдөг;
4) Бодит үр дүн гараагүй тохиолдолд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэхэд хүндрэлтэй байдаг;
5) Цахим мэдээллийн санд хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг олон нийтэд нээлттэй байршуулдаг ч тайлангууд бүрэн тавигддаггүй;
6) Бодит үнэлгээ хийхэд шаардлагатай үнэлгээний суурь түвшин, зорилтот түвшин, үнэлгээний шалгуурууд зарим тохиолдолд тодорхой байдаггүй ба зорилтот түвшинд хүрсэн эсэхийг байгууллагууд өөр өөр аргачлалаар хэмждэг;
7) Бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт нь бусад баримт бичгийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах үйл ажиллагаатай уялддаггүй буюу төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн ч тухайн төлөвлөлтийн зохицуулалтыг хангах хууль, эрхзүйн баримт бичгийг батлуулаагүй байдаг г.м.

Хуульд заасанчлан хяналт-шинжилгээ, үнэлгээний журам, түүнийг хариуцах байгууллага, хамрах хүрээг холбогдох байгууллагууд чандлан мөрдөж, шат шатанд тайлангуудыг боловсруулсны дараа үе шаттайгаар нэгтгэн боловсруулдаг. Эцэст нь маш том хэмжээтэй тайланг ЗГХЭГ, УИХ-д хүргүүлдэг. Энэ процедур хэт нарийн байсны дунд хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан нь мөн хэт нарийн, дэлгэрэнгүй болдог байж болох юм. Цаашид тайлангуудыг илүү хураангуй, цомхон болгож, олон нийтэд нээлттэйгээр байршуулдаг жишиг тогтоох нь чухал.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

(a) Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуурыг тодорхойлох;
(b) Шалгуурын суурь түвшинг тодорхойлох;
(c) Гүйцэтгэлийн үнэлгээний мэдээллийн санг бий болгох, шинэчлэх;
(d) Мэдээллийн санг ашиглан үр нөлөөг шалгуураар хэмжих.

ҮСХ хэд хэдэн байгууллагатай хамтран холбогдох мэдээллийг цуглуулж, суурь өгөгдөл, мэдээллийг боловсруулж, шинэчилж, хадгалдаг. Дараах хэсэгт дурдсанчлан ҮСХ шаардлагатай тохиолдолд нэмэлт шалгуур үзүүлэлтүүдийг нэмж, ТХЗ-ын гүйцэтгэлийн үнэлгээнд шаардлагатай микро түвшний мэдээллийг цуглуулах ажлыг хийж байна. Энэ нь хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой техникийн ажил ба ҮСХ хийж, хэрэгжүүлдэг. Аливаа хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход үнэлэлт, дүгнэлт шаардлагатай ба үүнийг сайн тодорхойлж чадсанаар хийх ажлын хэмжээ болон үйл ажиллагааны зардлыг бууруулахын сацуу хэт том хэмжээний тайлан бэлтгэн гаргах шаардлагагүй болдог.

### (2) Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санг хөгжүүлэх

<u>Хэрэгжилт болон гүйцэтгэлд хяналт тавихад шаардлагатай тоо мэдээлэл</u>

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ нь хэрэгжилтийн болон гүйцэтгэлийн хяналт-шинжилгээнээс бүрддэг. Монгол Улсын хяналт-шинжилгээ, үнэлгээнд ихэвчлэн хэрэгжилтийн хяналт-шинжилгээг хийдэг. Хэрэгжилтийн хяналт-шинжилгээний хүрээнд тухайн бодлого, төлөвлөлтөд тусгагдсан зорилт, арга хэмжээ хэрэгжсэн эсэх харгалзаж үздэг ба бодлого, төлөвлөлтийн үр нөлөөг тооцдоггүй. Тухайлбал Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийт 5 бодлого, 387 зорилт, 1287 арга хэмжээг тусгасан байдаг. Дээрх аргачлалаар аливаа арга хэмжээг хэрэгжсэн эсэхийг үнэлж, дүгнэж болох ч хэрэгжилт хэр зэрэг байсан болон үр нөлөө нь ямар байсан талаарх дүгнэлт дутмаг байдаг.

Аливаа бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд гүйцэтгэлийн үнэлгээний практикийг бэхжүүлэх нь чухал. Ингэхийн тулд үнэлгээний шалгуурыг тогтоож, суурь түвшинг тодорхой болгох шаардлагатай. Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг үнэлэхэд ашиглах макро түвшний шалгуур үзүүлэлтүүд, хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд ашиглах микро түвшний шалгуур үзүүлэлтүүд багтана. Тухайлбал НҮБ-ын ТХЗ-уудын хэрэгжилтийг үнэлэхэд жендэр, орлогын хуваарилалт, аймаг, сумд, үндэс угсаа, нийгмийн бүлэг болон бусад холбогдох микро түвшний мэдээллийг цуглуулах шаардлагатай. ҮСХ микро түвшний мэдээллийг цуглуулж, нэгтгэн мэдээллийн санг баяжуулах, уламжлалт бус мэдээллийн эх үүсвэр болох их өгөгдөл, Google-д суурилсан өгөгдөл, Facebook болон бусад эх үүсвэрийг ашиглан илүү нарийвчилсан, тодорхой өгөгдлийг цуглуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

<u>Микро өгөгдлийг цуглуулах арга, шаардлага</u>

ТХЗ-уудыг хэрэгжүүлэх зорилгоор илүү цогц, өргөн хүрээний мэдээлэл цуглуулахад хувь хүмүүс, хувийн хэвшил болон орон нутгийн захиргааны байгууллагуудын идэвх оролцоо зайлшгүй шаардлагатай. Энэ ажилд олон талын

оролцоог хангаж чадаагүй тохиолдолд ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай микро өгөгдлийг цуглуулах, нэгтгэх үйл ажиллагаа нь маш өндөр зардалтай болно. ОНМП-ыг байгуулах зорилгоор ухаалаг гар утас, үүлэн системийг ашиглан вэбэд суурилсан хөдөлгөөнт хяналт, үнэлгээний системийг бий болгох хэрэгтэй. Энэхүү системд хувь хүмүүс, ААНБ-ууд сайн дураараа мэдээлэл оруулах боломжтой байх ба орон нутгийн захиргааны байгууллагын мэдээлэл боловсруулалтад Засгийн газраас дэмжлэг үзүүлнэ.

Жишээлбэл малчидтай холбоотой мэдээлэл буюу малын бүлэглэлт, малын тоо толгой, бүтэц, малчин өрхийн нутаг сэлгэлт, байршил, ус, тэжээлийн хүрэлцээтэй байдал болон бусад мэдээллийг бодит цаг хугацаанд авснаар орон нутгийн захиргааны байгууллага тэдэнд тулгарч буй асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэхэд ач холбогдолтой. Мөн малчид орон нутгийн захиргааны байгууллагаас өгдөг орон нутгийн цаг уур, малын гаралтай бүтээгдэхүүний эрэлт, үнийн мэдээлэл, малын өвчлөлийн эсрэг авч буй арга хэмжээ, тэжээлийн хангамжийн талаар мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой болно. Ингэснээр малчдын аж байдлыг дэмжиж, ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад хувь нэмэр оруулах болно.

Энэхүү хоёр талт харилцаа холбооны үйл ажиллагааг дэмжихийн тулд нэг талаас хувь хүн, компаниуд, нөгөө талаас захиргааны байгууллагаас сайн дурын оролцооны урамшууллыг олгох хэрэгтэй. Иргэд, тухайлбал малчид өөрсдийн хэрэгцээ, шаардлага болон орон нутагт хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд (аялал жуулчлалын г.м.) шаардлагатай нөөц, боломжийн талаар мэдээллийг өгөх боломжтой ба хувийн хэвшил орон нутгийн нөөц, нутгийн удирдлагын дэмжлэгийг харгалзан хөрөнгө оруулалт хийж болно. Мөн орон нутгийн удирдлага нь хамгийн бага зардлаар нийгэм, эдийн засгийн микро өгөгдлийг цуглуулах боломжтой болно.

Орон нутгийнханы оролцоо, дэмжлэгтэйгээр мэдээлэл цуглуулж, үүсгэдэг тул гаднаас мэдээлэл цуглуулах үйлчилгээ авахаас ихээхэн ялгаатай байдаг. Түүнчлэн энэ нь нэг талаар иргэд, олон нийтийн чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагаа болно. Нөгөө талаар орон нутгийн захиргааны байгууллагууд нутгийн иргэд, олон нийттэй харилцахдаа илүү цогц мэдээлэл, МХХТ-ийн хэрэгслүүдийг ашиглах чадавхаа дээшлүүлнэ. Үр дүнд нь орон нутгийн захиргаа, иргэд хамтарч илүү оновчтой төсөл, хөтөлбөрүүд, институцийн арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

<u>Иргэдийн оролцоотойгоор микро өгөгдлийг цуглуулах</u>

Иргэд, хувийн хэвшил нь орон нутгийн захиргааны байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, микро өгөгдлийн цуглуулах, нэгтгэх дээр дурдсан системийг бүрдүүлэх нөхцөл Монгол Улсад хангагдсан байна. Үүнд:

1) Монгол Улсын 21 аймгийн төв, ихэнх сумд өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбогдсон бөгөөд МХХТ-ийн үндсэн дэд бүтэц сайн хөгжсөн;

2) Алслагдсан хөдөө орон нутгаас бусад бүх аймаг, сум 4G интернетэд холбогдсон;

3) Интернэт хэрэглэгчдийн тоо 2018 он гэхэд бараг 4 саяд хүрч, 5 сая орчим гар утас хэрэглэж байна.

Тус системийг бүрдүүлэхэд орон нутгийн засаг захиргааны чадавхын асуудал чухал юм. Тухайлбал орон нутагт эрх мэдэл шилжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн засаг захиргааны чадавхыг Засгийн газрын дэмжлэгтэйгээр бэхжүүлэх нь зүйтэй. Олон нийтийн оролцоотойгоор микро өгөгдлийн цуглуулах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд Засгийн газар болон орон нутгийн захиргааны байгууллагуудын ажлын уялдаа холбоо хамгийн чухал юм.

### (3) “Алсын хараа-2050”, ХАНСХЕТ, БХҮБ, ҮХЦТ-ний хяналт-шинжилгээ, үнэлгээ

ҮХЦТ-г тусгаж боловсруулсан ХАНСХЕТ, БХҮБ-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг 2015 оны 11 дүгээр сарын 26-нд батлагдаж, 2020 оны 5-р сард шинэчлэн найруулсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулинд заасны дагуу хийнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуур үзүүлэлтүүд нь “Алсын хараа-2050”, ХАНСХЕТ, БХҮБ баримт бичгүүдийн хувьд хоорондоо нийцсэн байх шаардлагатай бөгөөд БХҮБ нь “Алсын хараа-2050” баримт бичгийн агуулгын багагүй хэсгийг бүрдүүлнэ.

“Алсын хараа-2050” баримт бичигт үндэсний үнэт зүйл, онцлог, хүний болон нийгмийн хөгжил, амьдралын чанар, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, энх тайван, аюулгүй байдал, бүсчилсэн хөгжил болон Улаанбаатар хот болон түүний дагуул хотуудын хөгжлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний олон шалгуур үзүүлэлт багтсан. Тус баримт бичигт нийт 50 зорилтыг тодорхойлж, зорилтуудын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг 2030, 2040, 2050 оноор гаргасан. Шалгуур үзүүлэлт бүрээр мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах, үнэлэх арга, давтамж, хариуцсан байгууллагуудыг тодорхойлсон. Шалгуур үзүүлэлтүүд нь ихэвчлэн макро түвшний шалгуур үзүүлэлт байдаг ч ихэнх үзүүлэлтүүдийг хүйсээр болон аймгаар цуглуулах шаардлагатай. “Алсын хараа-2050” баримт бичигт тусгасан бүх шалгуур үзүүлэлтүүдийг ХАНСХЕТ, БХҮБ-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ашиглах шаардлагагүй.

ҮХЦТ-нд тусгагдсан одоогийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ нь хяналт-шинжилгээ, үнэлгээний зарим үзүүлэлтэд суурь мэдээлэл болох боломжтой. “Алсын хараа 2050” баримт бичигт ДНБ, нэг хүнд ногдох ДНБ болон уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан. Тиймээс хяналт-шинжилгээ нь эдгээр болон бусад шалгуур үзүүлэлтүүд дээр хийгдэнэ. “Алсын хараа 2050”-д тусгасан ДНБ-ий өсөлтийн түвшин 2030 он хүртэлх хугацаанд өндөр, 2030-2040 онд ҮХЦТ-нд тооцоолсноос бага байгаа ба 2030, 2040 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь ҮХЦТ-нд тооцоолсноос нэлээд өндөр байна.

“Алсын хараа 2050”, ҮХЦТ-ийн 2030, 2040 оны хүн амын хэтийн тооцоо нийцэж байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” баримт бичигт 2050 онд орон нутгийн хүн ам нь нийт хүн амын 50 хувьтай тэнцэнэ

гэж тооцоолол хийсэн. ҮХЦТ-нд бүсчилсэн хөгжлөөр дамжуулж орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах төлөвлөлтүүдийг тусгасан ба орон нутгийн хүн амын нийт хүн амд эзлэх хувь нь бүсчилсэн хөгжлийн үр дүнг илтгэнэ.

“Алсын хараа-2050”-д бүсчилсэн хөгжлийн индексүүдээр 1) шинээр байгуулагдсан хүнс, хөнгөн үйлдвэрийн тоо, 2) шинээр байгуулагдсан ХААҮТП-ийн тоо, 3) олон улсын зэрэглэлтэй нисэх буудлын тоог авч үзсэн. Эдгээр индексүүд нь бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг үнэлэхэд төдийлөн оновчтой индексүүд биш юм. Харин шинээр байгуулагдсан хөнгөн үйлдвэрүүдийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, эдгээр үйлдвэрүүдийн бий болгосон ажлын байрууд, ХААҮТП-ууд дээр байгуулагдсан ААН-үүдийн тоо зэрэг индексүүдийг ашиглаж харьцангуй оновчтой үнэлгээг гаргах боломжтой. ҮХЦТ-нд Зүүн бүсэд Чойбалсан хот, Баруун бүсэд Ховд хот дахь одоо байгаа нисэх буудлуудыг олон улсын нисэх онгоцны буудал болгож хөгжүүлэх тэргүүлэх зорилт, саналыг тусгасан. Эдгээр нисэх онгоцны буудлуудын тогтмол нислэгийн тоо, зорчигчдын тоог бүсчилсэн хөгжлийг үнэлэх үзүүлэлтээр ашиглаж болно.

“Алсын хараа-2050”-д тусгагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай нийгмийн бусад үзүүлэлтүүдэд ядуурлын түвшин, ажилгүйдлийн түвшин, хөдөө орон нутгийн ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, хатуу хог хаягдлын менежмент зэрэг багтана. Эдгээр болон бусад үзүүлэлтүүдэд шаардлагатай жендэрийн, орлогын хуваарилалтын болон бусад холбогдох микро түвшний мэдээллийг ҮХЦТ-нд санал болгосон ОНМП-ыг ашигласан шинэ аргачлалын дагуу үе шаттайгаар цуглуулж, нэгтгэх ба эдгээр нь ТХЗ-ын гүйцэтгэлийн үнэлгээнд мөн шаардлагатай мэдээлэл юм.

ХАНСХЕТ-ийн хүрээнд эдийн засгийн бүсчлэл, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн шинэчлэл, хүн амын хэтийн төлөв, байршил, хотын зэрэглэл, зам, тээврийн сүлжээг төлөвлөж, усны нөөц, зам, тээврийн дэд бүтцийн хамт уул уурхайн салбарын хөгжил болон аялал жуулчлалын кластерын хөгжил зэрэг салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлно. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн шинэчлэл, хотын зэрэглэл, хот, суурины статус зэрэг санал, төлөвлөгөөг хэлэлцэх, шийдвэрлэх зорилгоор ЗГХЭГ-ын даргын тушаалаар Байгууллага хоорондын зөвлөлийг байгуулж болох юм. Тухайн зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг УИХ-д өргөн мэдүүлж, батлуулна.

ХАНСХЕТ болон БХҮБ баримт бичигт тусгагдсан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хэрэгтэй. ҮХЦТ-ний хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон гол төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, ҮХЦТ-нд тусгасан нийгэм, эдийн засгийн хөгжилд ямар нөлөө үзүүлж буйг тодорхойлох шаардлагатай. 2022 онд байгуулагдсан Эдийн засаг, хөгжлийн яам нь БХҮБ, Бүсийн хөгжлийн хөтөлбөр, “Алсын хараа-2050” баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хариуцан ажиллана.

# Бүлэг 4 Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг тусгах

## 4.1 “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, ХАНСХЕТ, БХҮБ

### (1) “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг дэмжих ҮХЦТ

Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА-гийн төлөөлөл тохиролцож, гарын үсэг зурсан Хэлэлцүүлгийн тэмдэглэлд тодорхой тусгаснаар Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний төлөвлөлт, саналыг БХБЯ/БХТ-ийн боловсруулж буй ХАНСХЕТ болон ҮХГ-ын боловсруулж буй БХҮБ-д тусгана. Тиймээс Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг ЖАЙКА-гийн Төслийн баг болон БХБЯ, БХТ, ҮХГ хамтран боловсруулсан. ХАНСХЕТ болон БХҮБ-ыг боловсруулах ажлын явц удааширсан хэдий ч ЖАЙКА-гийн Төслийн баг Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний төлөвлөлт, саналыг ХАНСХЕТ болон БХҮБ-д тусгуулах талаар БХБЯ, БХТ, ҮХГ-тай 2 дугаар сараас 5 дугаар сарын хооронд болон төслийн хэрэгжилтийг сунгасан 7 дугаар сараас 12 дугаар сарын хооронд цуврал уулзалтуудыг зохион байгуулсан. УИХ-аар 2020 оны 5 дугаар сард батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл болон Бүсчилсэн хөгжлйн үзэл баримтлалыг нийцүүлэн боловсруулна.

ЖАЙКА-гийн Төслийн баг Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний төлөвлөлт, санал нь хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар судалсан. Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд тусгасан хөгжлийн алсын хараа, хөгжлийн хувилбарууд, нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв, макро түвшний хөгжлийн зорилтууд, үндсэн стратегийг төлөвлөлтийн үе шатаар харьцуулан Хүснэгт 4.1.1-ээс 4.1.6-д нэгтгэн үзүүлэв.

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд тусгасан хөгжлийн алсын харааг Хүснэгт 4.1.1-д харьцуулж үзүүлсэн бөгөөд ҮХЦТ-д тусгасан хөгжлийн алсын харааг товчилж оруулсан бол “Алсын хараа 2050”-д тусгасан хөгжлийн алсын харааг бүрэн эхээр нь оруулсан. Хүснэгт 4.1.1-ээс харахад ҮХЦТ боловсруулах төслийн хүрээнд санал болгож буй хөгжлийн алсын хараа нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан хөгжлийн алсын хараатай нийцэж байгаа бөгөөд аль аль нь Монгол Улсын онцлог, заяагдмал нөөц баялагт түшиглэж эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилготой.

**Хүснэгт 4.1.1 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй хөгжлийн алсын хараа**

| ҮХЦТ | Алсын хараа 2050 |
|---|---|
| Шинэ мэдлэг, боловсролоор өөрийгөө | Монгол Улс 2050 он гэхэд хэл, хил, |

| | |
|---|---|
| тасралтгүй хөгжүүлдэг хүний нөөцтэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн, байгалийн болон соёлын баялаг нөөцийг ухаалгаар, зүй зохистой ашиглаж эдийн засаг, экспортыг төрөлжүүлэн, уян хатан нийгэм, эдийн засгийг хөгжүүлнэ. | соёлоо тогтвортой хадгалсан, нийгмийн болон эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэгч орон болно. |

“Алсын хараа 2050” болон ҮХЦТ боловсруулах төслийн хүрээнд хөгжлийн хувилбаруудыг боловсруулж, тэдгээрээс хамгийн оновчтой хувилбарыг санал болгосон (Хүснэгт 4.1.2). “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг бодвол ҮХЦТ боловсруулах хүрээнд илүү олон хөгжлийн хувилбаруудыг боловсруулсан.

**Хүснэгт 4.1.2 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан хөгжлийн хувилбарууд, оновчтой хувилбар**

| | Хувилбар | Тайлбар | Оновчтой хувилбар |
|---|---|---|---|
| Алсын хараа 2050 | Сүүлийн үеийн чиг хандлагын дагуух хөгжил | Сүүлийн үеийн чиг хандлагын дагуух эдийн засгийн хөгжил | Мега төслүүдэд түшиглэсэн ногоон эдийн засаг бүхий хөгжил |
| | Ногоон эдийн засаг | Малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэх | |
| | Мега төслүүдэд түшиглэсэн хөгжил | Эрчим хүч, уул уурхай, зам тээврийн салбарыг хөгжүүлэх мега төслүүдэд түшиглэсэн эдийн засгийн өндөр өсөлт | |
| ҮХЦТ | Уул уурхайд түшиглэсэн хөгжил | Эдийн засаг болон экспортын өсөлтийг дэмжих уул уурхайн салбарт үргэлжлүүлэн түшиглэх бөгөөд уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт нэн бага байна. | Өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжил |
| | Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өндөр хөгжил | Уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл нь хөгжлийн гол хөдөлгөгч хүч болно. | |
| | Транзит тээврийн чиг баримжаатай хөгжил | Үйлчилгээний салбарын өндөр өсөлтийг хангах Монгол Улсын транзит тээвэр нь хөгжлийн өөр нэг хөдөлгөгч хүч болно. | |
| | Өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжил | Уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл болон транзит тээвэр нь эдийн засгийн өндөр өсөлтийг хангана. | |

Хүснэгт 4.1.3-т тухайн 2 баримт бичигт тусгасан ДНБ болон хүн амын хэтийн төлвийн тооцоог харьцуулан үзүүлэв. Хүснэгтээс харахад “Алсын хараа 2050” болон ҮХЦТ боловсруулах төслийн хүрээнд тооцсон 2040 он хүртэлх хүн амын хэтийн төлвийн тооцоо бараг ижил байна. “Алсын хараа 2050”-д тусгасан эдийн

засгийн өсөлтийн төсөөлөл амбицтай тооцоо юм. Мега төслүүдийг хэрэгжүүлж эдийн засгийн өндөр өсөлтйг хангах нь Монгол Улсын эдийн засгийг гадаад орчны нөлөөнд хэт өртөмтгий болгоно.

**Хүснэгт 4.1.3 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд тооцсон ДНБ, хүн амын хэтийн төлөв**

| | ҮХЦТ | Алсын хараа 2050 |
|---|---|---|
| Хүн ам 2030 | 3,968,000 | 3,868,000 |
| Хүн ам 2040 | 4,638,000 | 4,500,000 |
| Хүн ам 2050 | тооцоогүй | 5,400,000 |
| ДНБ 2030 | 70,249 их наяд төгрөг (25.1 тэрбум ам.доллар) | 32.1 тэрбум ам.доллар |
| Нэг хүнд ногдох ДНБ 2030 | 17,704,000 төгрөг (6,323 ам.доллар) | 8,299 ам.доллар |
| ДНБ 2040 | 134,364 их наяд төгрөг (48.0 тэрбум ам.доллар) | 54.0 тэрбум ам.доллар |
| Нэг хүнд ногдох ДНБ 2040 | 28,970,000 төгрөг (10,346 ам.доллар) | 12,000 ам.доллар |
| ДНБ 2050 | тооцоогүй | 78.0 тэрбум ам.доллар |
| Нэг хүнд ногдох ДНБ 2050 | тооцоогүй | 15,000 ам.доллар |

ҮХЦТ боловсруулах төслийн хүрээнд эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчны хөгжлийн зорилт бүхий макро түвшний хөгжлийн зорилтуудыг тодорхойлсон. Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт макро түвшний хөгжлийн зорилтуудыг тодорхой заагаагүй хэдий ч хөгжлийн алсын харааг дэмжих зорилтуудыг тусгасан. Тэдгээрийг Хүснэгт 4.1.4-т нэгтгэн үзүүлэв. “Алсын хараа 2050”-д тусгасан макро түвшний хөгжлийн зорилтууд нь илүү өргөн цар хүрээтэй, үзэл баримтлалын түвшинд боловсруулагдсан бөгөөд ҮХЦТ-ний төслийн хүрээнд боловсруулсан макро түвшний хөгжлийн зорилтуудтай нийцэж байна.

**Хүснэгт 4.1.4 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан макро түвшний хөгжлийн зорилтууд**

| ҮХЦТ | Алсын хараа 2050 |
|---|---|
| 1) Хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн бүтэц, экспортыг төрөлжүүлэх; (**<u>эдийн засгийн хөгжлийн зорилт</u>**);<br>2) Ядуурал, хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгахын тулд хөдөө, орон нутаг, төв суурин газруудад өгөөжтэй, тогтвортой ажил эрхлэх боломжийг бүрдүүлэх;<br>(н**ийгмийн хөгжлийн зорилт**);<br>3) Улаанбаатар хотын хүн ам, эдийн | Алсын хараag дэмжих макро түвшний зорилтууд:<br><u>“Оюун санаа”</u><br>1) Хуулийн засаглалын доор хүн төвтэй, ардчилсан нийгмийг цогцлоох;<br>2) Байгаль орчинд ээлтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх;<br>3) Өндөр боловсролтой, эрүүл дундаж давхаргыг нэмэгдүүлэх;<br>“Хурд”<br>1) Дэвшилтэт эдийн засгийг төрөлжүүлэн, хөгжүүлэх; |

| | |
|---|---|
| засгийн үйл ажиллагааны хэт их төвлөрлийн сөрөг үр дагаврыг арилгах замаар хотын байгаль орчны асуудлыг багасгах.<br>(**байгаль орчны хөгжлийн зорилт**). | 2) МХХТ-д суурилсан хөгжлийг дэмжих;<br>“Мөн чанар”<br>1) Ирээдүйдээ итгэлтэй, чинээлэг дундаж давхаргыг өргөжүүлэх;<br>2) Үндэстний язгуур шинжийг хадгалах;<br>3) Өрсөлдөх чадвартай Монгол иргэнийг төлөвшүүлэх. |

ҮХЦТ-ний төслийн хүрээнд эдийн засаг, орон зай, институци, үйлдвэрийн кластер байгуулах гэсэн 4 бүрэлдэхүүн бүхий бүсчилсэн хөгжлийн үндсэн стратегийг тодоройлсон. “Алсын хараа 2050”-д хөгжлийн стратегийг тодорхой заагаагүй болович урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм 9 зорилгыг тодорхойлсон. Тэдгээрийг Хүснэгт 4.1.5-д нэгтгэн үзүүлэв.

**Хүснэгт 4.1.5 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан хөгжлийн стратеги**

| ҮХЦТ | Алсын хараа 2050 |
|---|---|
| <u>Эдийн засаг</u><br>1) Үр ашигтай анхдагч бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд байгалийн баялгийг үр дүнтэй, ухаалгаар ашиглах ;<br>2) Экспортын анхдагч бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгох;<br><u>Орон зай</u><br>1) ОХУ, БНХАУ-тай хиллэн оршдог газар зүйн байршлын давуу талыг ашиглаж, дэлхийн зах зээлд холбогдох;<br>2) Усны нөөцийг хөгжүүлэх, усны нөөцийн менежментийг боловсронгуй болгох замаар ногоон хөгжлийг хангах;<br><u>Институци</u><br>1) Төвлөрлийг сааруулж орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх;<br><u>Үйлдвэрийн кластер байгуулах</u><br>1) Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг нэгтгэн анхан шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд түшиглэсэн үйлдвэрлэлийн босоо кластеруудыг хөгжүүлэх. | Урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм <u>“9 зорилго”</u> нь стратегийн хөгжлийн чиглэлийг илэрхийлж байна.<br>1) Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн гүн ухамсар дархлаатай улс үндэстэн болно.<br>2) Монгол Улсын Хүний хөгжлийн индексийг 0.9-д хүргэж, аз жаргалын индексээр дэлхийн эхний 10 орны тоонд багтана.<br>3) Сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэнэ.<br>4) ДНБ 6.1 дахин нэмэгдэж нэг хүнд оногдох ДНБ 3.6 дахин өсөж, 15,000 ам.долларт хүрч, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын босгыг давна.<br>5) Тогтвортой засаглал тогтож, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.<br>6) Ногоон хөгжлийг эрхэмлэн байгаль орчны тогтвортой байдлыг хангана.<br>7) Үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад дотоод таатай орчин бүрдэнэ.<br>8) Бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай улс доторх бүсүүдийг хөгжүүлнэ.<br>9) Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй хот болгон хөгжүүлнэ. |

“Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан үе шаттайгаар хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчны хөгжлийн зорилт бүхий хөгжлийн хувилбаруудыг Хүснэгт 4.6-д үзүүлэв. “Алсын хараа 2050” нь макро түвшний эдийн засгийн хөгжилд чиглэсэн бол ҮХЦТ нь салбарын хөгжилд чиглэсэн бөгөөд хоёуланг нь хослуулснаар эдийн засгийн хөгжлийн цогц хувилбарыг хэрэгжүүлэх боломжтой. Мөн “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг нэгтгэснээр нийгмийн хөгжлийн хувилбарыг хэрэгжүүлэх боломжтой. Байгаль орчны хувьд “Алсын хараа 2050” нь илүү бодлогын баримт бичиг бол ҮХЦТ нь 1,2-р үе шатуудад бодит, тодорхой, боломжит хувилбарыг хэрэгжүүлэхээр санал болгосон. “Алсын хараа 2050”-д тусгагдсан 3-р үе шатны үйл ажиллагааг Засгийн газрын түвшинд хэрэгжүүлэх бол ҮХЦТ-нд тусгагдсан үйл ажиллагааг орон нутгийн түвшинд хэрэгжүүлнэ.

**Хүснэгт 4.1.6 “Алсын хараа 2050” болон ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан хөгжлийн хувилбарууд**

(1) Эдийн засаг

| | ҮХЦТ | Алсын хараа 2050 |
|---|---|---|
| Үе шат 1 ~2025 | - Уул уурхайн салбар эдийн засгийн гол салбар хэвээр байна.<br>- Хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлж, эдийн засгийн шинэ үйл ажиллагаануудад хөрөнгө оруулалт хийнэ.<br>- МАА, газар тариалангийн бүтээгдэхүүнийг боловсруулна. (үйлдвэрлэлийн кластеруудыг хөгжүүлж эхэлнэ)<br>- Бүх салбарт дижитал шилжилтийг нэмэгдүүлнэ. | - Макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр өр төлбөрийг шийдвэрлэж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ.<br>- Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.<br>- Уян хатан, дижитал технологид суурилсан санхүүгийн тогтолцоог хөгжүүлнэ.<br>- Хөрш орнуудыг дамнасан эдийн засгийн коридорыг хөгжүүлж, БНХАУ, ОХУ- тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, эдийн засгийн гадаад харилцааг нэмэгдүүлнэ.<br>- Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацид тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.<br>- Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ. |
| Үе шат 2 2025~2030 | - Хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа өргөжнө.<br>- Экспортод гаргах ашигт малтмалуудын боловсруулалтыг нэмэгдүүлнэ.<br>- Чөлөөт бүсүүдийг хөгжүүлэх үйл ажиллагаа эрчимжинэ.<br>- Аж үйлдвэрийн кластерыг хөгжүүлэх үйл ажиллагаа үргэлжилнэ.<br>- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлж, салбарыг хөгжүүлнэ. | |

| | | |
|---|---|---|
| Үе шат 3 2030~2040 | - Дэлхийн зах зээлд танигдах экспортын бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.<br>- Төмөр, зэсэд суурилсан эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.<br>- Аж үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлж, экспортын бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлнэ.<br>- ОХУ болон БНХАУ-ын хил дагуух худалдааны чөлөөт бүс, эдийн засгийн онцгой бүсийг үйлчилгээний салбарт түлхүү түшиглэн бүрэн хөгжүүлнэ.<br>- Орон нутгийн онцлог шинж чанар бүхий бүтээгдэхүүнд түшиглэн аялал жуулчлал, эрүүл мэндийн салбарын цогцолбор байгуулна.<br>- ОХУ, БНХАУ болон бусад улс орнуудтай эдийн засгийн идэвхтэй харилцааг хөгжүүлнэ. | - Үндэсний хуримтлал бүхий макро эдийн засгийн орчинг бүрдүүлнэ.<br>- Хүнд, хөнгөн болон эрчим хүч, барилгын материалын үйлдвэрлэлийн хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж эхэлнэ.<br>- Зүүн хойд Азийн органик хүнс, эрчим хүчний идэвхтэй тоглогч болно.<br>- Чөлөөтэй, дэлхийн хөрөнгийн зах зээлд оролцох түвшний санхүүгийн тогтолцоог хөгжүүлнэ.<br>- Гадаад харилцааны тэнцвэртэй хөгжлийн түвшинг хангана.<br>- ОУ-ын чанар, стандартыг нэвтрүүлж, цахим худалдааг хөгжүүлж бүс нутгийн нэмүү өртгийн сүлжээнд холбогдоно.<br>- Мега төсөл хөтөлбөрүүд болон гадаадын санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар эдийн засгийг дэмжинэ. |
| 2040~2050 | Тодорхойлоогүй | - Инфляцын нам түвшин бүхий макро эдийн засгийн орчинг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгох<br>- Эдийн засгийн тэргүүлэх салбаруудын дэлхийн зах зээл дэх байр суурийг бэхжүүлэх<br>- Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилан дэлхийн түвшинд хөгжүүлэх<br>- Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцад идэвхтэй оролцож, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар, худалдааг нэмэгдүүлэх |

| | | |
|---|---|---|
| | | - Технологийн дэвшил, ур чадвартай хүний нөөц, цахим худалдаанд тулгуурлан дэлхийд өрсөлдөх чадвартай, инновацид суурилсан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх<br>- Эдийн засгийн төрөлжилт, инноваци, шинэ технологи, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг төлөвшүүлэх |

(2) Нийгмийн хөгжил

| | ҮХЦТ | Алсын хараа 2050 |
|---|---|---|
| Үе шат 1 ~2025 | - Сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөрийн хүрээнд үндэсний үнэт зүйлс, байгаль орчны боловсрол олгоно.<br>- Мэргэжлийн боловсрол, сургалт болон дээд боловсролын тогтолцоог цогцоор нь шинэчлэх ажлыг эхлүүлнэ.<br>- Анхан шатны болон урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түлхүү үзүүлдэг тогтолцоонд шилжинэ.<br>- Нийгмийн халамжийн үйлчилгээг илүү зорилтот бүтэцтэй болгож, шинэчилнэ. | - Тэгш, хүртээмжтэй боловсролын тогтолцооны шинэчлэлийг хийнэ.<br>- Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийг хийнэ.<br>- Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ.<br>- Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ. |
| Үе шат 2 2025~2030 | - Үндэсний үнэт зүйлсийн талаар боловсрол олгох сургуулийн өмнөх болон бага боловсролын тогтолцоог сайжруулна.<br>- Эрүүл мэндийн анхан шатны болон урьдчилан сэргийлэх тусламжийг хөгжүүлэх замаар эрүүл ажиллах хүчээр хангана.<br>- Нийгмийн халамжийн үйлчилгээг үргэлжлүүлэн сайжруулна. | |
| Үе шат 3 2030~2040 | - Орон нутагт ажлын байр нэмэгдсэнээр гэр бүлийн харилцаа, хамт олны эв нэгдлийг хангана.<br>- Бүх хүнд хүртээмжтэй, чанартай нийгмийн цогц үйлчилгээг үзүүлнэ.<br>- Ядуурлыг бүрэн устгана. | - Чанартай боловсрол олгох, насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.<br>- Амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэнийг төлөвшүүлнэ.<br>- Эрсдэлээс сэргийлсэн нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулна. |

| | | |
|---|---|---|
| 2040~2050 | - Тодорхойлоогүй | - Насан туршдаа суралцахуйг дэмжсэн нээлттэй боловсролын тогтолцоог бэхжүүлэх<br>- Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих<br>- Амьдралын чанарыг сайжруулахуйц нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх |

(3) Байгаль орчин

| | ҮХЦТ | Алсын хараа 2050 |
|---|---|---|
| Үе шат 1 ~2025 | - Уул уурхайгаас хамааралтай байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө үргэлжлэх боловч хариуцлагатай уул уурхайн талаарх иргэдийн мэдлэг ойлголт сайжирна.<br>- Улаанбаатар хотын дагуул хотуудыг хөгжүүлснээр хэт төвлөрлөөс үүдэлтэй асуудлуудыг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.<br>- Нутгийн удирдлагын байгууллагуудын байгаль орчны хяналтын чадавх бэхжсэнээр орон нутгийн иргэдийн оролцоог хангасан хяналтыг нэмэгдүүлнэ. | - Монгол орны унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, даацыг тогтоож, эдийн засгийн үр өгөөжийг үнэлнэ.<br>- Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлнэ.<br>- Доройтсон орчныг нөхөн сэргээж, нөөцийн хомсдолыг бууруулна.<br>- Усны нөөцийн шаталсан үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэн үнэлэмжийг нэмэгдүүлж, усны нөөцийг хамгаалж, хуримтлуулна.<br>- Үндэсний ногоон санхүүгийн тогтолцоог бий болгон хөгжүүлж, байгальд ээлтэй, үр ашигтай цэвэр технологи, хэмнэлттэй хэрэглээг дэмжинэ. |
| Үе шат 2 2025~2030 | - Хариуцлагатай уул уурхайг эрчимтэй хөгжүүлснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө буурна.<br>- Улаанбаатар хотын дагуул хотууд хөгжихийн хэрээр хотын байгаль орчны доройтол багасна.<br>- Орон нутгийн хотуудад байгаль орчны шинэ асуудлууд тулгамдах магадлалтай.<br>- Нутгийн удирдлагын байгууллагуудын байгаль орчны хяналтыг иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх замаар бэхжүүлнэ. | |
| Үе шат 3 2030~2040 | - Бүс нутгийн эдийн засгийн хөгжлөөс хамааран нутгийн удирдлагын байгууллагуудын санхүүгийн, удирдлагын чадавх дээшилнэ.<br>- Орон нутгийн хотуудад байгаль орчинд тулгамдаж буй шинэ асуудлуудыг шийдвэрлэх орон нутгийн нэгдэл бий болно. | - Экосистемийн үйлчилгээг тэтгэж үр өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.<br>- Техник, технологийн ололт, инновацийг байгаль хамгаалалд ашиглаж, нөөцийн хомсдол, орчны доройтлоос сэргийлнэ. |

| | | |
|---|---|---|
| | - Улаанбаатар хотын дагуул хотууд хөгжиж, нийслэл хотын нөөц бололцоог ашиглаж ногоон байгууламж, амарч зугаалах орчин бүхий чанартай амьдрах орчинг бүрдүүлнэ. | - Усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлж, усны хуримтлалыг нэмэгдүүлж, хүртээмж, хангамжийг сайжруулна.<br>- Ухаалаг хэрэглээ, бүтээмжтэй үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уур амьсгалын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. |
| 2030~2050 | - Тодорхойлоогүй | - Үнэлэмж, нөөц, нөхөн сэргэх чадавх, даацад суурилсан байгалийн нөөцийн ашиглалт, хамгааллын бодлого баримталж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах<br>- Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, зохистой ашиглах, шавхагддаг нөөцийг зөвхөн улсын хөгжлийн түвшинг шат ахиулахад хязгаартай ашиглах<br>- Байгалийн болон зориудаар арвижуулсан нөөцийг хяналттай, зохистой ашиглаж хэвших ү<br>- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг тасралтгүй бэхжүүлж, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төгөлдөржүүлэх |

### (2) ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг ХАНСХЕТ, БХҮБ-д тусгах

ҮХЦТ-ний хүрээнд сум дундын төв болон 4 түвшний хотуудын зэрэглэлийг санал болгосон. ҮХЦТ-ний хүрээнд тодорхойлсон хотуудын зэрэглэл нь ХАНСХЕТ-ийн хүрээнд тодорхойлсон хотуудын зэрэглэлтэй нийцэж байна (Хүснэгт 4.1.7). Улсын нийслэлийн доор 7 хотыг улсын зэрэглэлтэй хотоор тодорхойлсон нь бүсийн хөгжлийн төв хот эсвэл орон нутгийн хөгжлийн төв хот байгаа бөгөөд хотын зэрэглэлээр дээгүүр эрэмбэлэгдэж байна. Улсын зэрэглэлтэй 10 хотоос Хархорин, Арвайхээр, Улиастай хотыг орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хотуудаар тодорхойлж, доогуур эрэмбэлсэн. Орон нутгийн зэрэглэлтэй 19 хотоос Сайншанд, Баянхонгор хотыг бүсийн хөгжлийн төв хотоор тодорхойлсон бөгөөд үлдсэн 17 хотыг орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот эсвэл орон нутгийн хөгжлийн төв хотуудаар тодорхойлсон буюу хотын зэрэглэлээр доогуур эрэмбэлсэн байна.

**Хүснэгт 4.1.7 ХАНСХЕТ ба ҮХЦТ-нд тусгасан хотын зэрэглэл**

| ҮХЦТ-нд тусгасан хотын зэрэглэл | Хот | ХАНСХЕТ-д тусгасан хотын зэрэглэл |
|---|---|---|
| Улсын нийслэл | Улаанбаатар | Улсын нийслэл; улсын зэрэглэлтэй хот |

| | | |
|---|---|---|
| Бүсийн хөгжлийн төв хот | Эрдэнэт | Улсын зэрэглэлтэй хот |
| | Булган | Орон нутгийн зэрэглэлтэй хот; ҮХЦТ-нд Эрдэнэт хоттой хамт төлөвлөсөн. |
| | Дархан | Улсын зэрэглэлтэй хот |
| | Чойбалсан | Улсын зэрэглэлтэй хот |
| | Сайншанд | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Ховд | Улсын зэрэглэлтэй хот |
| | Баянхонгор | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| Орон нутгийн хөгжлийн төв хот | Багануур | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Чойр | Улсын зэрэглэлтэй хот |
| | Замын-Үүд | Улсын зэрэглэлтэй хот |
| | Мөрөн | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Даланзадгад | Улсын зэрэглэлтэй хот |
| | Сүхбаатар | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Өндөрхаан | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Мандалговь | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот | Арвайхээр | Улсын зэрэглэлтэй хот |
| | Улиастай | Улсын зэрэглэлтэй хот |
| | Алтай | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Цэцэрлэг | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Баруун-Урт | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Хархорин | Улсын зэрэглэлтэй хот |
| | Улаангом | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Өлгий | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Зүүнхараа | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Бор-Өндөр | ҮХЦТ-нд улсын нийслэлд нэгтгэсэн |
| | Зуунмод | ҮХЦТ-нд улсын нийслэлд нэгтгэсэн |
| | Ханбогд | Орон нутгийн зэрэглэлтэй хот |
| | Цогтцэций | Орон нутгийн зэрэглэлтэй хот |

ҮХЦТ-ний хүрээнд орон зайн төлөвлөлтийг оновчтой болгох зорилгоор Алтай, Хангай, Өмнөд, Төв болон Зүүн бүсийн гол хотуудыг хооронд нь үр дүнтэй холбох шинэ тойрог коридорыг байгуулахаар санал болгосон. Энэхүү тойрог коридорыг ХАНСХЕТ-ийн төлөвлөлтөд тусгана гэдэгт итгэлтэй байна.

ҮХЦТ-ний хүрээнд 21 аймгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр бүсчлэн хөгжүүлэх зорилгоор эдийн засгийн шинэ бүсчлэлийг санал болгосон. Энэхүү бүсчлэл нь ҮХГ-ын боловсруулж буй БХБ-д тусгасан эдийн засгийн бүсчлэлтэй ижил байна. ҮХЦТ-ний хүрээнд эдийн засгийн шинэ бүсчлэлийн дагуу бүс тус бүрээр Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг боловсруулсан. Эдгээр хөтөлбөрийг БХБ-д тусгана гэдэгт найдаж байна.

## 4.2 Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулах

ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдэд худалдааны чөлөөт бүсийг хөгжүүлэх, боловсролын салбарын шинэчлэл, Орхон гол дээр урсацын тохируулга хийж, говийн бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх, Туул голд усан

цогцолбор байгуулах зэрэг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээг оруулсан. Бусад төсөл, хөтөлбөрийг шинээр боловсруулж санал болгосон бөгөөд тэдгээрийг албан ёсны бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгана хэмээн найдаж байна. Шинээр санал болгож буй төсөл, хөтөлбөрүүд нь ерөнхий концепцийн түвшинд боловсруулагдсан тул тэдгээр баримт бичигт тусгагдсан эсэхийг нягтлахад хүндрэлтэй бөгөөд санал болгож буй төсөл, хөтөлбөрийн зарим бүрэлдэхүүн хэсгийг өөр бусад төсөл хөтөлбөртэй нэгтгэн хэрэгжүүлж болох юм. ҮХЦТ болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээний уялдаа холбоог харахын тулд замын төслүүдийг авч үзлээ. Хүснэгт 4.2.1-д ҮХЦТ болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан авто замын төслүүдийг харьцуулан үзүүлэв.

**Хүснэгт 4.2.1 ҮХЦТ болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан авто замын төслүүд**

| **ҮХЦТ** | | **Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө** | | | |
|---|---|---|---|---|---|
| Төсөл | Үе шат | Төсөл | Урт (км) | Хэрэгжүүлэх хугацаа | Өртөг (сая төгрөг) |
| **Баруун бүс** | | | | | |
| Өлгий ~ Ташинт чиглэлийн авто зам | Үе шат 1 | Цагааннуур ~ Улаанбайшинт чиглэлийн авто зам | 25.8 | 2021-22 | 34,600 |
| | | Өлгий хотын бвто зам, гүүр | 18.8 | | |
| Даяннуур~Өлгий чиглэлийн авто зам | Үе шат 3 | Өлгий ~ Улаанхус ~ Алтай Таван богд чиглэлийн авто зам | 118 | 2023-24 | 22,951 |
| Ховд~ Улаангом чиглэлийн авто зам | Үе шат 1 | Ховд ~ Улаангом чиглэлийн авто зам | 163 | 2022-24 | 155,135 |
| **Хангайн бүс** | | | | | |
| Булган ~ Хишиг-Өндөр ~ Гурванбулаг чиглэлийн авто зам | Үе шат 2 | Булган ~ Хишиг-Өндөр ~ Гурванбулаг чиглэлийн авто зам | 99.7 | 2020-24 | 88,000 |
| Номлог ~ Тэс ~ Арцсуурь чиглэлийн авто зам | Үе шат 3 | Цэцэрлэг сум/Овоотын уурхай ~ Арцсуурь чиглэлийн авто зам | | 2022 | 1,295 (ТЭЗҮ) |
| УБ ~ Дархан ~ Эрдэнэт чиглэлийн авто замын шинэчлэл | Үе шат 1 | УБ ~ Дархан чиглэлийн авто замын шинэчлэл | 204.2 | 2020-24 | 339,030 |
| **Алтайн бүс** | | | | | |
| Алтай~ Баянхонгор ~ Арвайхээр чиглэлийн авто | Үе шат 3 (сайжруу-лах) | Баянхонгор ~ Алтай чиглэлийн авто замын шинэчлэл | 126.7 | 2020-22 | 92% гүйцэтгэлтэй |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| зам | | | | | |
| Арвайхээр ~ Хужирт чиглэлийн авто зам | Үе шат 1 | Арвайхээр ~ Хужирт чиглэлийн авто зам | 56 | 2022-23 | 53,200 |
| Шаргалжуут ~ Баянхонгор чиглэлийн авто зам | Үе шат 3 | Баянхонгор ~ Шаргалжуут чиглэлийн авто зам | 54.2 | 2023-24 | 30,900 |
| Хужирт ~ Улаанцутгалан чиглэлийн авто зам | Үе шат 3 | Хужирт ~ Улаанцутгалан чиглэлийн авто зам | 90.1 | 2022-24 | 94,000 |
| **Өмнөд бүс** | | | | | |
| Мандалговь ~ Эрдэнэдалай ~ Арвайхээр чиглэлийн авто зам | Үе шат 3 | Арвайхээр ~ Мандалговь ~ Чойр чиглэлийн авто зам | 474.2 | 2022-24 | 1,600 (ТЭЗҮ) |
| Мандалговь ~ Говь-Угтаал ~ Чойр чиглэлийн авто зам | Үе шат 2 | | | | |
| Тавантолгой ~ Гашуунсухайт чиглэлийн авто зам | Үе шат 1~2 | Тавантолгой ~ Гашуунсухайт чиглэлийн авто зам | 250 | 2020-24 | Концесс |
| **Зүүн бүс** | | | | | |
| Чойбалсэн ~ Хавирга чиглэлийн авто зам | Үе шат 2 | Чойбалсэн ~ Хавирга чиглэлийн авто зам | 124.5 | 2022-24 | 123,000 |
| Жаргалтхаан~ Өмнөдэлгэр чиглэлийн авто зам гэр чиглэлийн авто зам | Үе шат 2 | Жаргалтхаан~ Өмнөдэлгэр ~ Рашаан хад ~ Биндэр ~ Дадал чиглэлийн авто зам | 290 | 2022-24 | 200,000 |
| Норовлин~Дадал чиглэлийн авто зам | Үе шат 3 | Өндөрхаан ~ Норовлин~Дадал чиглэлийн авто зам | 255 | 2020-24 | 196,880 |
| Говь-Сүмбэр ~ Дархан сум чиглэлийн авто зам | Үе шат 2 | Говь-Сүмбэр ~ Бор-Өндөр чиглэлийн авто зам | 50 | 2020-22 | 29,800 |
| **Нийслэлийн бүс** | | | | | |
| Улаанбаатар хотын хөгжлийн шинэ ерөнхий төлөвлөгөөний дагуу авто замын | Үе шат 1~3 | Тасралтгүй шинэчлэн сайжруулах | | 2022-25 | 323,376 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| шинэчлэл | | | | | |

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан авто замын төслүүд нь ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй 1-р үе шатанд хэрэгжүүлэх авто замын төслүүдтэй нийцэж байна. ҮХЦТ-ний хүрээнд 1-р үе шатанд хэрэгжүүлэхээр санал болгож буй авто замын бүх төслүүд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан байна. Түүнчлэн ҮХЦТ-ний хүрээнд 2-р үе шатанд хэрэгжүүлэхээр санал болгож буй 12 төсөл бүгд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд эдгээрээс 5 төслийг 3-р үе шатанд хэрэгжүүлнэ. ҮХЦТ-ний хүрээнд 3-р үе шатанд хэрэгжүүлэхээр санал болгож буй авто замуудаас Даяннуур~ Өлгий чиглэлийн аялал жуулчлалын авто зам болон Шаргалжуут ~ Баянхонгор чиглэлийн авто замыг Хужирт ~ Улаанцутгалан чиглэлийн авто замаас түрүүлэн эхний ээлжинд тус тус хэрэгжүүлэх боломжтой. Одоо байгаа Алтай~ Баянхонгор ~ Арвайхээр чиглэлийн авто зам болон Мандалговь ~ Эрдэнэдалай ~ Арвайхээр чиглэлийн авто замыг үе шаттайгаар шинэчлэн сайжруулах ба зарим хэсгийг нэн даруй сайжруулах боломжтой. ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй авто замын нийт 30 төслөөс 17 төсөл нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан байна. Эдгээр авто замын төслүүдийг үе шаттайгаар, хэсэгчлэн хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан авто замын зарим төслүүдийн хэрэгжилт удаашралтай байна.

## 4.3 Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт ба ҮХЦТ-нд тусгасан гол төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа

Дээр дурдсан шалтгааны улмаас ҮХЦТ-нд тусгасан гол төсөл, хөтөлбөрүүд болон Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт хоорондын уялдаа холбоог тодорхойлоход хүндрэлтэй байна. Хүснэгт 4.3.1-д гол төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой одоогийн нөхцөл байдал болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн холбогдох заалтуудыг нэгтгэн үзүүллээ. Хүснэгтэд гол төсөл, хөтөлбөрүүдийг 1) бүрэн нийцэж байгаа, 2) тодорхой хүрээнд нийцэж байгаа эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөтөлбөрт тусгагдсан, 3) агуулгын хувьд нийцэж байгаа гэж ангилав. Хүснэгтээс харахад 29 гол төсөл, хөтөлбөрөөс 26 нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан эсвэл Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Бусад төслүүдийг ч мөн хугацаа алдалгүй хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

**Хүснэгт 4.3.1 Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт ба ҮХЦТ-нд тусгасан гол төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа**

| No. | Төсөл, хөтөлбөр | Тусгагдсан байдал* | Тайлбар |
|---|---|---|---|
| I1.1 | Хилийн Чөлөөт худалдааны бүс болон Эдийн засгийн тусгай бүсүүдийг дэмжих төсөл | ○ | Алсын хараа 2050-д Замын-Үүд чөлөөт бүс, шинэ нисэх онгоцны буудал, Алтанбулаг, Цагааннуур чөлөөт бүсийн бүтээн байгуулалт |

| | | | |
|---|---|---|---|
| | | | тусгагдсан; түүнчлэн ТХХТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтад багтсан. |
| I2.1 | Чацарганы үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл | △ | "Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр (2018-2021)"-т тусгагдсан. |
| I2.2 | МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл | △ | Технологийн шинэчлэл бүхий МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах цогцолбор нь Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан. |
| I3.2 | Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл | △ | Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан. (хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах) |
| I3.3 | Хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэх төсөл | ○ | ҮХГ Булган, Хөвсгөл, Хархоринд хөгжүүлэх агро-технологийн паркийг тодорхойлсон. |
| I4.2 | Мал аж ахуйн салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх төсөл | △ | I2.2, II1.1 дугаартай төслүүдийн хүрээнд хэрэгжинэ. |
| I5.3 | Чацарганы тариалалтын төсөл | △ | “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрт тусгагдсан. |
| I7.2 | Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох систем нэвтрүүлэх төсөл | △ | НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэмжлэгтэй ХХААХҮЯ, ХХМТГ-ын цахим хөдөө аж ахуйн хөтөлбөрт тусгагдсан. |
| I9.1 | Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих төсөл | △ | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн замын төсөл Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. |
| I10.2 | “Өртөө” авто зам дагуух үйлчилгээний цогцолбор байгуулах төсөл | ◎ | Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, БОАЖЯ-ны дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан. |
| II1.1 | Малчдыг дэмжих бааз байгуулах төсөл | ○ | Төрөөс малчдын талаар баримтлах бодлогод тусгагдсан. |
| II2.1 | Нутгийн удирдлага болон малчдын харилцаа холбоог бэхжүүлэх төсөл | ○ | ҮХГ төслийн судалгааг хийсэн. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ. |
| II3 | Залуучууд, насанд хүрэгчдийн ур чадварыг сайжруулах, ажлын байр бий болгох төсөл | ○ | ХНХЯ Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийг 2021-2024 хооронд хэрэгжүүлнэ. |
| II4 | Залуу эмэгтэйчүүдийн ажил, мэргэжил дээшлүүлэх, дэмжих хөтөлбөр | | Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын орчин аажмаар бүрдэж байна. |
| II6 | Боловсролын салбарын өргөн хүрээтэй шинэчлэлийн төсөл | ○ | Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан БШУЯ-ны сунгагдсан хөтөлбөр |
| II7.1 | Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг сайжруулах төсөл | ○ | ЭМЯ-ны одоо хэрэгжиж байгаа хөтөлбөр |
| II9.1 | Бүлгийн динамикийн төв | | Явц байхгүй |

| | | | |
|---|---|---|---|
| | байгуулах төсөл | | |
| III1 | Авто замын тойрог сүлжээ барьж байгуулах төсөл | ○ | Баянхонгор-Алтай чиглэлийн замыг сайжруулах, Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн зам тавих төслүүд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. |
| III2 | Аймаг хоорондын авто замуудыг барих, сайжруулах төсөл | ○ | Ховд-Улаангом чиглэлийн авто замын бүтээн байгуулалт Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Мөрөн-Улиастай, Улиастай-Алтай чиглэлийн авто замын бүтээн байгуулалт хийгдэж байна. (ЗТХЯ) |
| III4 | Улаанбаатар хотыг тойрон гарах төмөр замын шугам (Богд Хаан шугам) сүлжээг барьж байгуулах төсөл | ◎ | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа 2050-д тусгагдсан. |
| III5 | Хойд-өмнөд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл | ○ | Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод тусгагдсан. |
| III9 | Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудалд түшиглэсэн дагуул хот байгуулах төсөл | ◎ | БХБЯ-ны дэмжлэгтэйгээр хувийн хэвшил хэрэгжүүлсэн; улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан. |
| IV2.2 | Хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах төсөл | ◎ | ЗТХЯ-ны дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан. |
| IV2.4 | Эко-парк байгуулах төсөл | | ЗТХЯ -ны дэмжлэгтэйгээр хувийн хэвшил хэрэгжүүлсэн; улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан. |
| IV3.1 | Гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах төсөл | ◎ | Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулинд тусгагдсан; хэрэгжүүлэх удирдамж, заавар шаардлагатай. |
| IV3.2 | Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл | ○ | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа 2050-д тусгагдсан. Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан. |
| IV6 | Туул голд усан цогцолбор байгуулах төсөл | △ | Нийслэлийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх мега төслүүдийн жагсаалтад тусгагдсан;<br>Улаанбаатар хотын ус хангамжийн системийг өргөтгөх зорилготой газрын доорх усны төслийг хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор зогсоосон. |
| IV7.1 | Хот, суурины ус хангамжийг сайжруулах төсөл | ○ | БХБЯ-ны дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан. |
| IV8.4 | Сумын төвд бага оврын цэвэрлэх байгууламж барих төсөл | ○ | 2021 оны 6-р сард “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг баталсан. |
| IV9 | Сэлэнгэ мөрний усан | ○ | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн |

| | | | |
|---|---|---|---|
| | цахилгаан станцын далан байгуулах төсөл | | баримт бичгүүдэд Эгийн голын усан цахилгаан станцыг хөгжүүлэх төсөл тусгагдсан. |
| Тайлбар: ◎ бүрэн нийцэж байгаа; ○ тодорхой хүрээнд нийцэж байгаа эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөтөлбөрт тусгагдсан; △ агуулгын хувьд нийцэж байгаа | | | |

## 4.4 Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.3.2-р зүйлд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тушаалаар Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг болон Ажлын хэсэгт мэргэжлийн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий дэд Ажлын хэсгүүдийг байгуулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргаар ахлуулсан Ажлын хэсгийн доор 7 дэд Ажлын хэсэг байгуулагдаж, хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулна. Үүнд: Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр (БШУЯ-аар ахлуулсан); нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр (ХНХЯ); эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр (СЯ); байгаль орчны зорилтот хөтөлбөр (БОАЖЯ); засаглалын зорилтот хөтөлбөр (Удирдлагын академи); бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр (ЗГХЭГ); үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр (ҮХГ). Түүнчлэн 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн БХБ-ын сайд, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч, ҮХГ-ын даргын хамтарсан тушаал, захирамжаар Монгол Улсын хэмжээнд хийгдэж байгаа Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг хот байгуулалтын баримт бичгүүдийг боловсруулах ажлуудын хоорондын уялдааг хангах, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.

Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг ЗГХЭГ-ын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга ахалж, Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар БХБЯ, ҮХГ ажиллаж байгаа бөгөөд холбогдох яам, байгууллага, МХАҮТ, болон хувийн компаниудын төлөөлөл, эрдэмтэн, судлаачид бүхий 25 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. ЖАЙКА-гийн Төслийн баг нь ҮХЦТ-ний хүрээнд шинээр санал болгож буй 6 бүс тус бүрээр боловсруулсан Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийн талаар Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан. ҮХЦТ нь холбогдох хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж, ашиглагдах баримт бичиг юм.

# Бүлэг 5 АХБ-ны Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах төсөлтэй хамтран ажиллах, уялдаа холбоог хангах нь

## 5.1 Уялдаа холбоог хангах үйл ажиллагаа

### (1) Удиртгал

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) болон Азийн хөгжлийн банк (АХБ) нь Монгол Улсын Засгийн газартай хот төлөвлөлт, хот байгуулалтын салбарын хөгжлийг дэмжих чиглэлээр урт хугацаанд хамтран ажиллаж байна. ЖАЙКА болон АХБ нь БХБЯ-нд макро түвшний (үндэсний), мезо түвшний (бүсийн/дэд-бүсийн) болон орон нутгийн түвшний (аймаг/сум) төлөвлөлтийг агуулсан орон зайн хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх хамтарсан хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрт 2015-2016 онд хэрэгжүүлсэн АХБ-ны “Монгол Улсын хот байгуулалтын үндэсний үнэлгээ” төсөл, ЖАЙКА-гийн 2015-2016 онд хэрэгжүүлсэн "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа"-ны төсөл болон холбогдох судалгаа зэрэг техникийн хамтын ажиллагааны төслүүд хамаарна.

АХБ, ЖАЙКА 2 талын тохиролцсон үйл ажиллагааны ерөнхий зохицуулалтыг доор үзүүлэв. Үүнд:

1) АХБ нь дэд бүсийн хөгжлийн төлөвлөгөө болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, орон зайн төлөвлөгөөг боловсруулна;
2) ЖАЙКА нь үндэсний болон бүсийн түвшний төлөвлөгөө (нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө, нутаг дэвсгэр, орон зайн төлөвлөгөө) боловсруулна;
3) АХБ, ЖАЙКА нь БХБЯ-тай нягт хамтран ажиллаж, ХАНСХЕТ-ийг боловсруулах ажлын хүрээнд холбогдох төслийн үр дүнг нутаг дэвсгэр, хүн амын хөгжлийн нэгдсэн бодлого, стратегид нэгтгэн ажиллана;
4) АХБ нь веб дээр суурилсан зураглалын портал, е-атлас болон хууль тогтоомжийг боловсруулах ажлыг голлон хариуцна;
5) ЖАЙКА нь газар зүйн мэдээлийн системийн асуудлыг голлон хариуцна;
6) Энэ хоёр байгууллагын аль аль нь институцийн болон чадавхийг бэхжүүлэх ажлыг өөрсдийн үйл ажиллагаанд хамруулна.

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн үйл ажиллагаа эхэлсний дараа АХБ нь орон нутгийн нийгэм, эдийн засаг, орон зайн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, институцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар Монгол Улсад хүртээмжтэй, ногоон, өрсөлдөх чадвартай бөгөөд хотын тогтвортой хөгжлийг хангах стратегийн чиглэлүүдийг тодорхойлох зорилгоор Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр санаачилсан.

ЖАЙКА-гийн техникийн хамтын ажиллагааны Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл болон АХБ-ны техникийн туслалцааны Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах төсөл нь хамтран ажиллаж, төслийн үр дүнг уялдуулна.

### (2) Анхны уулзалтууд

2019 оны 6 дугаар сард ЖАЙКА-гийн Токио дахь Төв байгууллагын Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийг хариуцаж буй ажилтнууд Монгол Улсад ажиллах үеэр Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр (ХАНСХХ) боловсруулах АХБ-ны төслийн багийн гишүүн Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах ЖАЙКА-гийн Төслийн багтай холбож өгөхийг хүссэн. 7 дугаар сарын 12-нд АХБ-ны Төслийн багийн ахлагчийг ҮХЦТ боловсруулах Төслийн багийн ахлагчтай холбогдохыг зөвлөсний дагуу тэд 7 дугаар сарын 13-нд холбогдсон. Үүний дараа цахим уулзалт хийсэн. Тус 2 баг салбаруудын мэдээллийг харилцан солилцох талаар хэлэлцэв. ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-ний Явцын тайлан болон төслийн хүрээнд цуглуулсан мэдээ, мэдээллийг өгсөн.

8 дугаар сарын 21-нд тус 2 төслийн багийн ахлагчид Улаанбаатар хотноо анх удаа уулзсан. 8-р сарын 22-ны өдөр Үндэсний хөгжлийг цогц төлөвлөгөө боловсруулах болон Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах төслийн багууд анхны зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, хот байгуулалтын үе шатны баримт бичиг боловсруулах, төслүүдийн ажлын уялдаа холбоог хангах, мэдээлэл цуглуулах, солилцох, үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар санал солилцов.

8-р сарын 22-ны өдөр БХБЯ, ЖАЙКА-гийн Төслийн баг болон АХБ-ны төслийн багийн хамтарсан гурван талт уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын үеэр АХБ-ны төслийн баг Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөлтийн аргачлал, цар хүрээ, ажлын уялдаа холбоо зэргийн талаар танилцуулсан бол ЖАЙКА-гийн Төслийн баг Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн ажлын явцын талаар танилцуулсан. Тус 2 төслийн ажлын уялдаа холбоог хангах протокол боловсруулахаар тохиролцов.

Тус 2 төслийн мэргэжилтнүүд цахимаар холбогдож, цаг уурын болон усны нөөцийн холбогдолтой мэдээллийг хуваалцсан. 8 дугаар сарын 28-нд 2 төслийн баг хуралдаж, зарим асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд ЖАЙКА-гийн Төслийн баг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар батлагдсан төслийн Хамтарсан зохицуулах хороо, хорооны гишүүдийн талаар мэдээлэл өгөв. 8 дугаар сарын 30-ны өдөр гурван талт уулзалтыг дахин зохион байгуулж, хамтран ажиллах тухай протокол болон төслийн үр дүнгүүдийг нэгтгэх боломжийн талаар хэлэлцсэн.

### (3) Хамтын ажиллагааны протокол

АХБ-ны төслийн багийн ахлагч хамтын ажиллагааны протоколын төслийг боловсруулж, БХБЯ, ЖАЙКА, АХБ болон ЖАЙКА-гийн Төслийн багт хүргүүлсэн. ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч "Монгол Улсын Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулахад АХБ-ны төсөл болон ЖАЙКА-гийн төсөл хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг дурдаж, протоколд тусгах чухал асуудлын талаар тодруулав.

ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч АХБ-ны төслийн багийн ахлагчтай и-мэйлээр харилцсаны үндсэн дээр хамтын ажиллагааны протоколыг өөрчилж,

боловсруулав. 9 дүгээр сарын 20-ны өдөр АХБ-ны төслийн багийн ахлагчид Хамтын ажиллагааны протоколыг и-мэйлээр илгээсэн бөгөөд 9 дүгээр сарын 23-нд протоколыг хүлээн зөвшөөрснөө мэдэгдсэн. 9 дүгээр сарын 24-нд уг протоколыг ЖАЙКА болон АХБ-нд хүргүүлсэн.

Хавсралт А-д үзүүлсний дагуу Хамтын ажиллагааны протоколыг ЖАЙКА болон АХБ нягталсны дараа эцэслэн боловсруулсан. 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан зөвлөлдөх хурлын үеэр 2 төслийн баг протоколыг албан ёсоор баталгаажуулсан. Хавсралт В-д хурлын тэмдэглэлийг үзүүлэв.

### (4) COVID-19 цар тахлын үеийн хамтын ажиллагаа

11 дүгээр сарын 25-нд зохион байгуулагдсан зөвлөлдөх уулзалтын үеэр ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр (ХАНСХХ) боловсруулах АХБ-ны Төслийн багт Монгол Улсад томилолтоор ажиллах хуваариа танилцуулсан бөгөөд дараагийн зөвлөлдөх уулзалтыг Монгол Улсад ажиллах хугацаандаа буюу 1-3 сарын хооронд зохион байгуулахаар төлөвлөж байсан. COVID-19 цар тахлын улмаас 3 дугаар сарын эхээс 2 төслийн багийн гадаадын зөвлөхүүдийн Монгол Улсад ажиллах томилолтыг түр зогсоосон бөгөөд зөвлөлдөх уулзалт зохион байгуулагдаагүй.

2019 оны 12 дугаар сард АХБ-ны Төслийн баг Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон аймагт томилолтоор ажилласан бөгөөд ЖАЙКА-гийн Төслийн баг нь эдгээр болон бусад аймгуудын төлөвлөлттэй холбоотой материалуудыг АХБ-ны Төслийн багт хүлээлгэж өгсөн. Мөн ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан Аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ, ЖАЙКА-гийн Төслийн багийн тухайн аймгуудад зохион байгуулсан уулзалтын үеэр асуусан асуултууд, уулзалтад оролцогчдын хариулт, оролцогчдын нэрсийн жагсаалт зэргийг өгсөн. 12 дугаар сард холбогдох байгууллагуудад хүргүүлсэн ҮХЦТ-ний Дунд хугацааны тайланг АХБ-ны Төслийн багт хүлээлгэж өгсөн. АХБ-ны Төслийн багаас 12 дугаар сарын 5-нд цахим уулзалт хийх хүсэлт ирүүлсэн боловч ЖАЙКА-гийн Төслийн баг Япон улсад Монгол Улсын хамтран ажиллагч байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдийн сургалтыг зохион байгуулж байсан.

2020 оны 1 дүгээр сарын 22-нд ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-ний Дунд хугацааны тайланг танилцуулах, ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй төлөвлөлт, саналын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор Оролцогч талуудын нэгдсэн хурлыг (ОТНХ) зохион байгуулсан. Хуралд судлаачид, аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нар, яам, агентлаг, НЗТДГ болон хувийн хэвшлийн төлөөлөл, хэвлэл мэдээлэл зэрэг 150 гаруй оролцогчид оролцсон. БХБЯ-ны зүгээс тус хуралд хандивлагчдыг уриагүй тул АХБ-ны Төслийн баг оролцоогүй.

COVID-19 цар тахлын улмаас 3 дугаар сарын 5-нд усны нөөцийн менежмент, хөгжлийн асуудал хариуцсан Япон зөвлөх Монгол Улс дахь томилолтоо дуусгавар болгосноор Төслийн багийн гадаадын зөвлөхүүдийн Монгол Улсад ажиллах томилолтыг түр зогсоосон. ЖАЙКА-гийн Төслийн баг нь ҮХЦТ болон ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй гол төсөл, хөтөлбөрийн танилцуулгыг нарийвчлан боловсруулахын зэрэгцээ нэмэлтээр туршилтын төслүүдийг боловсруулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. ЖАЙКА-гийн Төслийн баг болон АХБ-ны Төслийн баг түр хугацаанд харилцаагүй.

2020 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах АХБ-ны Төслийн багийн ахлагч АХЧБТ-ний нутаг

дэвсгэрийн зохион байгуулалтын дүн шинжилгээний аргачлал бүхий Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Орхон аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөний (АХЧБТ) Дунд хугацааны тайлан, веб дээр суурилсан зураглалын портал болон чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн явцын тайланг ирүүлсэн. ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-ний Эцсийн тайлангийн төсөл 1-ийг боловсруулсны дараа Монголын талын холбогдох байгууллагуудад хүргүүлэн санал авж, тэдгээрийг тусгаж 6 дугаар сарын 30-нд эцэслэн боловсруулсан. ҮХЦТ-ний Эцсийн тайлангийн төсөл 1-ийг АХБ-ны Төслийн багт хүргүүлсэн. Үүний дараа тус 2 баг хоорондоо харилцаагүй.

2020 оны 6 дугаар сард болсон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дараа ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-г сайжруулан боловсруулж, туршилтын төслүүдийг хэрэгжүүлсэн. ЖАЙКА-гийн Төслийн баг Монголын талын хамтран ажиллагч байгууллагуудтай цахимаар холбогдож, ажилласан бөгөөд 8 дугаар сарын 17-нд Залуучуудын төлөөллийг оролцуулсан Оролцогч талуудын нэгдсэн хурлыг, 9 дүгээр сарын 7-нд онлайн хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. Гэвч тус арга хэмжээнд АХБ-ны Төслийн багийг урьж оролцуулаагүй. ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-ний Эцсийн тайлангийн төсөл 2-ыг боловсруулж 12 дугаар сарын 15-нд Монголын талын холбогдох байгууллагуудад хүргүүлэн санал авж, тусган эцэслэн боловсруулж 2021 оны 2 дугаар сарын 28-нд дахин хүргүүлсэн.

ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-ний Эцсийн тайлангийн төсөл 2-т ирүүлсэн Монголын талын холбогдох байгууллагуудын саналыг тусгаж ҮХЦТ-ний Эцсийн тайлангийн төсөл 3-ыг боловсруулж, 2021 оны 6 дугаар сарын 29-нд хүргүүлсэн. ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг тусгаж ХАНСХЕТ болон БХҮБ-ыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийн хугацааг 2021 оны 6 дугаар сараас 12 дугаар сарыг дуустал сунгасан. 8 дугаар сарын 27-ны өдрийн төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтарсан ээлжит зөвлөлдөх уулзалтын үеэр Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах АХБ-ны Төслийн баг 9 дүгээр сарын дундуур семинар зохион байгуулах гэж байгаа тухай олж мэдсэн бөгөөд ЖАЙКА-гийн Төслийн баг тус семинарт оролцох хүсэлтээ илэрхийлж, сүүлийн үед боловсруулсан аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөний тайлангуудыг ирүүлэхийг хүссэн.

## 5.2 Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөө

АХБ-ны Төслийн багийн ахлагч сүүлийн үед боловсруулсан аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөний тайлангуудыг имэйлээр ирүүлсэн. ЖАЙКА-гийн Төслийн баг тайлангуудтай танилцаж, “Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөө”-ний талаар материал боловсруулж, БХБЯ болон БХТ-д хүргүүлсэн (Бүлэг 2-ыг үзнэ үү). Тус материалыг 9 дүгээр сарын 30-нд АХБ-ны Төслийн багийн ахлагчид хүргүүлсэн. Бүлэг 2-ын Хавсралт D-д материалыг хавсаргалаа.

Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөг сайн боловруулсан бөгөөд 9 аймгийн хувьд тодорхойлсон хөгжлийн чиг баримжаа нь ҮХЦТ-ний төлөвлөлт, саналтай ерөнхийдөө нийцэж байна. ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч Аймгуудын хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөг Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөтэй уялдуулахын тулд холбогдох материалд үндэслэж хэлэлцүүлэг хийхийг санал болгов.

# 5.3 Тодорхой асуудлуудыг шийдвэрлэх

АХБ-ны болон ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагчид Улаанбаатар хотод томилолтоор ажиллах хугацаандаа зөвлөлдөх уулзалт зохион байгуулахаар тохиролцов. ЖАЙКА-гийн Төслийн багийн гишүүд 10 дугаар сарын 10-наас 29-ны хооронд Улаанбаатар хотод томилолтоор ажилласан бөгөөд 10 дугаар сарын 25-нд зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан (Бүлэг 2-ыг үзнэ үү).

Төслийн багийн ахлагчид Улаанбаатар хотод томилолтоор ажиллах хугацаандаа и-мэйлээр харилцсан. 10 дугаар сарын 16-нд АХБ-ны Төслийн багийн ахлагч "Хотын зэрэглэл", "Үндэсний болон бүс нутгийн хөгжлийн асуудлууд" сэдэвт илтгэлийг ирүүлсэн. ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч Хавсралт С-д үзүүлсэн АХБ-ны Төслийн багийн боловсруулсан үндэсний хэмжээний хөгжлийн саналуудтай холбоотой санал дүгнэлтийг хүргүүлэв.

10 дугаар сарын 18-нд АХБ-ны Төслийн багийн ахлагч нэмэлт саналуудыг ирүүлсэн бол ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч АХБ-ны Төслийн багийн үндэсний болон бүс нутгийн түвшинд авч үзсэн асуудлуудтай холбоотой саналыг (Хавсралт D-г үзнэ үү) илгээсэн.

Хавсралт Е-д үзүүлснээр 10 дугаар сарын 25-нд АХБ-ны Төслийн багийн ахлагч Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөтэй холбоотой дэлгэрэнгүй саналыг зөвлөлдөх уулзалтаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн. ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч тус саналтай танилцсан.

10 дугаар сарын 26-нд тус 2 төслийн багийн зөвлөлдөх уулзалтыг АХБ-ны төслийн офисст зохион байгуулав. АХБ-ны Төслийн багийн ирүүлсэн дэлгэрэнгүй саналын дагуу хэлэлцүүлэг хийв. Хүснэгт 5.3.1-д АХБ-ны Төслийн багийн ирүүлсэн санал, ЖАЙКА-гийн Төслийн багийн хариу тайлбарыг нэгтгэн үзүүлэв.

**Хүснэгт 5.3.1 Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн багтай хийсэн хэлэлцүүлэг, санал болон ЖАЙКА-гийн Төслийн багийн тодруулга**

| АХБ-ны Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн санал | ЖАЙКА-гийн Төслийн багийн тодруулга |
|---|---|
| **Бүлэг 2 ТХҮБ 2030 Макро эдийн засаг, байгаль орчны үзүүлэлтүүд** | |
| Хуудас 2: Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн дүн шинжилгээ, санал нь ҮХЦТ-ний хүрээнд тодорхойлсон эдийн засгийн хөгжилд тулгарч буй сорилтууд (2.3.13), нийгмийн хөгжилд тулгарч буй сорилтууд (2.3.14), байгаль орчны менежменттэй холбоотой сорилтууд (2.3.15), дүн шинжилгээтэй бүрэн нийцэж байна. | Хэлэлцэх шаардлагагүй.<br>ҮХЦТ-ний хүрээнд хатуу хог хаягдлын менежментийг нарийвчлан тусгаагүй. |
| **Бүлэг 3 Хөгжлийн загвар, алсын хараа, зорилт, стратеги** | |
| Хуудас 3: Газар тариалангийн салбарт дэвшилтэт технологи (ялангуяа дэвшилтэт техник, машин механизм) нэвтрүүлэх нь тариаланчдын мэдлэг чадвар, санхүүгийн боломжтой үл нийцэж магадгүй юм. | ҮХЦТ нь урт хугацааны төлөвлөлтийг агуулдаг.<br>Тариаланчдад дэвшилтэт технологи эзэмшүүлэх сургалт явуулж, тэдний санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах боломжтой. |

| | |
|---|---|
| Хуудас 3: Өвлийн хүлэмжийн аж ахуй эрхлэх нь гүзээлзгэнэ зэрэг нэмүү өртөг өндөртэй жимс, хүнсний ногооны хувьд ашигтай байна. | ҮХЦТ-ний хүрээнд өнөөгийн “нийтлэг ойлголт”-оор хязгаарлагдахгүйгээр хүлэмжийн аж ахуйг дорвитой хөгжүүлэхийг санал болгосон. |
| Хуудас 3: Малын халдварт өвчин гарсан тохиолдолд малчдад мэдээллийг түргэн шуурхай хүргэх, гарал үүслийг мөшгих тогтолцоо, баталгаажуулалтын системийг хөгжүүлэх зэргээр мал аж ахуйн салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх нь ач холбогдолтой байж болох юм. | МХХТ-ийг ашиглан мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах хэрэгтэй. Малчид хятадын худалдаачдыг хүлээхгүйгээр бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд борлуулах боломжтой болно. |
| Хуудас 4: Хүлэмжийн аж ахуйг зохистой эрхэлснээр (i) тариалах хугацааг уртасгах, (ii) суулгац үржүүлгийн газар болгон ашиглаж ил талбайн ургацыг нэмэгдүүлэх (iii) Монгол орны уур амьсгалд дасан зохицоогүй хүнсний ногооны сортыг нутагшуулан тариалах замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг төрөлжүүлэх (iv) улирлын турш шинэ хүнсний ногоог үйлдвэрлэх зэрэг давуу талтай. | Энэ нь одоо болон ойрын ирээдүйд хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх талаарх зүй зохистой санал бөгөөд ялангуяа суулгац үржүүлгийн газар болгон ашиглах нь зүйтэй юм. Хүлэмжийн аж ахуйг өргөнөөр эрхлэх хэрэгтэй. |
| Хуудас 6: Газар зүйн байршил болон дулаан хангамжийн системээс хамааран газрын гүний дулаан, дизель түлш эсвэл нүүрсийг халаалтад ашиглах боломжтой. | ҮХЦТ-ний хүрээнд ялангуяа Говь-Алтай аймагт газрын гүний дулааныг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх болон хүлэмжийн аж ахуйд газрын гүний дулааныг ашиглахаар тусгасан. |
| Хуудас 8: Улсын хэмжээнд бэлчээрийн зохистой менежментийг хэрэгжүүлэх, малын тоо толгойд хяналт тавих нь мал аж ахуйн салбарын нэн тэргүүний зорилт юм. | Санал нийлж байна. Харин хэрхэн хэрэгжүүлэх нь чухал.<br>ҮХЦТ-ний хүрээнд бэлчээр ашиглалтын хяналт бүхий газрыг тогтоохыг санал болгосон. |
| Хуудас 8: Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нь Монгол үндэсний соёл, уламжлалыг хадгалан хамгаалахтай холбоотойгоор малчид, иргэдийн эсэргүүцэлтэй тулгардаг. | ҮХЦТ-ний хүрээнд тодорхой байршилд зөвхөн хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхийг санал болгосон. |
| Хуудас 9: Үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт: Эрдэнэт, Дархан зэрэг томоохон хотуудын аж үйлдвэрийн парк байсан газруудыг (хуучин тогтолцооны үеийн) сэргээн засварлана. | ҮХЦТ-ний хүрээнд тухайн асуудлыг нарийвчлан тусгаагүй.<br>Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд “Төсөл хэрэгжүүлэх сан” байгуулахыг санал болгосон хэдий ч тодорхой бус байна. |
| Хуудас 9: Аялал жуулчлалын салбарын стратеги төлөвлөлт: Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч орон нутгийн иргэдийн хамт хүртээмжтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, жуулчдад зориулсан орон нутгийн бүтээгдэхүүнийг зах зээлд гаргана. | ҮХЦТ-ний хүрээнд үүнийг олон нийтэд түшиглэсэн аялал жуулчлал хэмээн тусгасан. |
| Хуудас 10: Усны нөөцийн менежмент, хөгжүүлэлтийн стратеги: Ус хангамжийн дэд бүтцийг өргөжүүлнэ. | ҮХЦТ-ний хүрээнд Орхон гол дээр урсацын тохируулга хийж, говийн бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх төслийг тусгасан. |
| **Бүлэг 5 ҮХЦТ-ний орон зайн төлөвлөлт** | |

| | |
|---|---|
| Хуудас 12: Зуунмод, Налайх дүүрэг нь нийслэлийн нутаг дэвсгэрт харьяалагдахгүй харин тэдгээрийг Улаанбаатар хотын дагуул хот болгон хөгжүүлэхээр зөвлөмж өгсөн. | ҮХЦТ-ний хүрэээнд Нийслэлийн бүсийг тодорхойлсон бөгөөд дагуул хотууд нь Нийслэлийн бүсийн удирдлагад харьяалагдана. Энэ нь эдгээр дагуул хотын нутаг дэвсгэр нь нийслэлийн хилийн цэст багтана гэсэн үг биш юм. |
| Хуудас 12: Мөрөн хотыг бүсийн хөгжлийн тулгуур төв хот болгон хөгжүүлэхээр санал болгосон. | Мөрөн хот нь аялал жуулчлалын салбараас хамааран орон нутгийн эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Мал аж ахуй эрхлэлт болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд ялгарах зүйлгүй. Тиймээс ҮХЦТ-ний хүрээнд Мөрөн хотыг орон нутгийн хөгжлийн төв хотоор тодорхойлсон. |
| Хуудас 12: Сүхбаатар хотыг бүсийн хөгжлийн тулгуур төв хот болгон хөгжүүлэхээр санал болгосон. Сонгосон үндэслэл нь тодорхойгүй байна. | ҮХЦТ-ний хүрээнд Сүхбаатар хотыг бүсийн хөгжлийн төв хот бус орон нутгийн хөгжлийн төв хотоор тодорхойлсон. |
| Хуудас 12: Баян-Өлгий: Аймгийн төвийн хүн амын тоогоор (Эрдэнэт, Дархан-Уул аймгийг эс тооцвол) улсад 3-р байранд ордог бөгөөд эдийн засагт мал аж ахуйн салбар (хэд хэдэн махны үйлдвэртэй) томоохон байр суурийг эзэлдэг. Орон нутгийн хөгжлийн төв хотоор тодорхойлсон Ховд хоттой харьцуулбал (мөн бусад хотууд) Баян-Өлгий аймгийн хүн амын тоо болон 2010-аас 2018 оны хоорондох хүн амын өсөлтийн хувь өндөр байна. | ҮХЦТ-ний хүрээнд Ховд хотыг Баруун бүсийн төв хэсгийн байршил болон дээд боловсрол, судалгаа шинжилгээ, аялал жуулчлалын зангилаа зэрэг бүсийн хөгжлийн төв хотын чиг үүргийг бэхжүүлэх боломжтойг харгалзан бүсийн хөгжлийн төвөөр тодорхойлсон. Өлгий хотын захын алслагдмал байршил нь сул тал болж байгаа бөгөөд ҮХЦТ-ний хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ болон Цагааннуур чөлөөт бүсийг хөгжүүлэхийг санал болгосон. |
| Хуудас 12: Улаангом хот нь хүн амын тоогоор бусад аймгийн төвүүдээс 4-р байранд ордог бөгөөд аймгийн эдийн засагт мал аж ахуй, газар тариалангийн салбар чухал байр эзэлдэг. Зарим үзүүлэлтийн хувьд бүсийн хөгжлийн төв хот болон орон нутгийн хөгжлийн төв хотоор тодорхойлсон зарим хотуудаас дээгүүр байна. | ҮХЦТ-ний хүрээнд Улаангом хотыг ОХУ-тай хийх худалдаа, арилжааны төв, барилгын материал, бараа бүтээгдэхүүн түгээх төвөөр тодорхойлсон. Дээр дурдсан чиг үүргээс илүүтэйгээр мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжил сайтай. |
| Хуудас 13: Мөрөн-Улиастай болон Улиастай-Алтай чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажил хийгдэж байна. | Санал болгож буй тойрог коридортой эдгээр авто замын бүтээн байгуулалтын ажлууд нийцэж байна. |
| Хуудас 13: Бүх аймгийн төв нийслэл Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон боловч Өвөрхангай, Өмнөговь, Говьсүмбэр аймгийн төв өөр хоорондоо хатуу хучилттай авто замаар холбогдсон эсэх нь эргэлзээтэй байна. | Энэ нь хөгжлийн төлөвлөлт бус өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэсэн байна. ҮХЦТ-ний хүрээнд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, бараа бүтээгдэхүүний урсгалыг харгалзан логистикийн коридорын үйл ажиллагааг төлөвлөсөн бол Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл нь уул уурхайн бүтээгдэхүүний урсгалд голчлон |

| | |
|---|---|
| | анхаарсан байна. |
| Хуудас 13: Дархан-Өндөрхааныг хатуу хучилттай авто замаар холбох эсэх нь эргэлзээтэй байна (түүнчлэн тус чиглэлийн авто зам нь тусгай хамгаалалттай газар нутгаар дайран өнгөрнө). | Зурагт энэхүү трассыг тасархай зураасаар тэмдэглэсэн. Тусгай хамгаалалттай газар нутгаар дайран өнгөрөх тул тухайн авто замыг барьж байгуулах боломжгүй. |
| Хуудас 13: Нутаг дэвсгэрийг тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоор зарим гол зангилаа хотуудад өндөр чанартай дэд бүтцийг хөгжүүлэхийг зөвлөж байна (хөгжлийн archipelagos model). | Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн багийн хөгжлийн archipelagos model-ын талаарх тайлбар тодорхой бус байна. |
| Хуудас 14: Тогтвортой, органик газар тариалан, мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх Сэлэнгэ, Булган, Төв аймгуудаас Монгол Улсын хөгжлийн ирээдүй ихээхэн шалтгаална. | ҮХЦТ-нд бүсчлэн хөгжүүлэх замаар нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийг дэмжихээр тусгасан. |
| **Бүлэг 7 Аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ** | |
| Хуудас 16: Аймгийн хөгжлийн чиг баримжаанд тусгасан хөгжлийн “тэнхлэг”-үүдийг энэхүү хүснэгтийн баруун талын баганад, ҮХЦТ-нд тусгагдсан тухайн аймгийн хөгжлийн төлөвлөлтийг хүснэгтийн зүүн талын баганад үзүүлэв. Мөн ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг Аймгийн хөгжлийн чиг баримжаанд тусгасан хөгжлийн “тэнхлэг”-үүдтэй харьцуулах боломжтойгоор харуулав. | Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд өргөн хүрээний дүн шинжилгээ хийсэнд талархалтай байна. Аймгийн хөгжлийн чиг баримжаанд тодорхойлсон хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд нь ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан саналуудтай ерөнхийдөө нийцэж байна. Аймгийн хөгжлийн чиг баримжааны тайланд микро түвшний дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан бөгөөд сумын түвшний дүн шинжилгээ нь давуу тал болж байна. |
| Хуудас 21: Дээрх хүснэгтэд нэгтгэн үзүүлсэн Аймгийн хөгжлийн чиг баримжаанд тусгасан хөгжлийн “тэнхлэг”-үүд нь ҮХЦТ-ний Аймгуудын хөгжлийн дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй ижил байна. | Санал нийлж байна. |
| Хуудас 21: Сүхбаатар: Аймгийн хөгжлийн чиг баримжаанд ижил төстэй хөгжлийн “тэнхлэг”-ийг нарийвчлан тодорхойлсон. ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт нь Аймгийн хөгжлийн чиг баримжаатай нийцэж байгаа бөгөөд арай өргөн хүрээг хамарсан байна. | Санал нийлж байна. |
| Хуудас 21: Говь-Алтай: ҮХЦТ болон Аймгийн хөгжлийн чиг баримжаанд тусгасан эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтууд ижил байна. ҮХЦТ-нд онцолсон сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх зорилт Аймгийн хөгжлийн чиг баримжаанд тусгагдаагүй байна. | ҮХЦТ-нд тусгасан сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх зорилтыг илүү нарийвчлан тусгах шаардлагатай. |

| | |
|---|---|
| Хуудас 21: Сэлэнгэ, Дархан-Уул: Тус 2 аймгийн хөгжлийн чиг баримжаа нь ҮХЦТ-нд тусгасан хөгжлийн үзэл баримтлалтай ижил төстэй байна. Аймгийн хөгжлийн чиг баримжаанд мод боловсруулах үйлдвэр болон хотын дэд бүтцийг хөгжүүлэхээр тусгаснаараа ялгаатай байна. | Мод боловсруулах үйлдвэрлэл тодорхой байршилд ач холбогдолтой байж болох хэдий ч макро болон мезо түвшний төлөвлөлтөд тусгагдахгүй. |
| Хуудас 22: Булган, Дархан-Уул: Тус 2 аймгийн хөгжлийн чиг баримжаа нь ҮХЦТ-нд тусгасан хөгжлийн үзэл баримтлалтай ижил төстэй байна. Аймгийн хөгжлийн чиг баримжаанд ЖДҮ болон мод боловсруулах үйлдвэр хөгжүүлэхээр тусгаснаараа ялгаатай байна. | ҮХЦТ-ний хүрээнд ЖДҮ-ийг дэмжих арга хэмжээг санал болгосон. |
| **Бүлэг 8 Гол төсөл, хөтөлбөр бүхий үе шаттай хөгжлийн төлөвлөгөө** | |
| Хуудас 23: Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн шинэ төмөр зам нь Говийн бүсээс БНХАУ болон Улаанбаатар хот руу нүүрс, уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх тээвэр, логистикийн шинэ коридор болно. Тавантолгойгоос Хатанбулаг сум хүртэлх хатуу хучилттай авто замын барилгын ажил эхэлсэн. Говийн бүсийн уул уурхайн бүтээгдэхүүний логистикийн төв болох Чойр хотын одоогийн үүрэг роль буурна. Логистикийн гол зангилаа болох Чойр, Сайншанд/Зүүнбаянгийн чиг үүргийг тодорхойлох нь чухал. | Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл нь уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр, логистикийн асуудалд харин ҮХЦТ нь мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, бараа бүтээгдэхүүний тээвэр логистикийн асуудалд илүү анхаарал хандуулсан байна. |
| Хуудас 23: Тухайн нутаг дэвсгэрийн үйлдвэрлэлийн өнөөгийн үйл ажиллагаанаас харахад Мөрөн ~ Дарханыг худалдаа, аялал жуулчлалын коридор гэж үзэх нь цар хүрээг бууруулсан байна. | ҮХЦТ-ний хүрээнд тухайн нутаг дэвсгэрийн зарим хэсгийг хамруулан ОХУ-тай холбосон худалдаа, аялал жуулчлалын коридор байгуулахыг санал болгосон. МХХТ болон бусад дэвшилтэт технологийн тусламжтайгаар энэхүү бүс нутгийн газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг ихээхэн нэмэгдүүлэх шаардлагатай. Энэхүү нөөц боломжид тулгуурлан ОХУ-тай бүтээгдэхүүн борлуулалт, технологийн солилцоо хийх замаар дэмжлэг үзүүлнэ. Тухайн газар нутагт зөвхөн газар тариалан, мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх нь хангалтүй юм. |
| **Бүлэг 9. Гол төсөл, хөтөлбөрийн танилцуулга** | |
| Хуудас 24: Замын-Үүдэд 900 га газрыг хөгжүүлэхээр төлөвлөж, 300 га газарт дэд бүтэц тавьсан ч үйлдвэр байхгүй байна. Алтанбулаг, Цагааннуурт бүсийг тогтоосон ч суурь дэд бүтцийг тавиагүй, үйлдвэр, үйлчилгээ байхгүй байна.<br>Үе шаттай, уян хатан арга хэмжээг цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай. | Чөлөөт бүсүүдийг үе шаттайгаар хөгжүүлэх талаар санал нэг байна: Үндэсний хөгжлийн хувьд Замын-Үүд-->Алтанбулаг-->Цагааннуур ЧБ-ийг үе шаттайгаар хөгжүүлэх ч бүс нутгийн хөгжилд эдгээр нь тус бүрдээ ач холбогдолтой. |

| | |
|---|---|
| Хуудас 24: Алтанбулагт бус Сүхбаатар хотод аж үйлдвэр, логистик, МХХТ болон үйлчилгээний салбарыг төвлөрүүлэх саналыг боловсруулсан. | Тус саналыг дахин харгалзаж үзэх шаардлагатай гэж үзэж байна. |
| Хуудас 24: Цагааннуур ЧБ байгуулахыг үр ашиг багатайд тооцож байна. Энэ бүс нутгийн аж үйлдвэрийн хөгжил хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлээр хязгаарлагдаж байна гэж үзэж байна. | ҮХЦТ-нд Цагааннуур ЧБ-д хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх саналыг санал болгосон. |
| Хуудас 24: Говийн аймгуудад зарим анхан шатны үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг санал болгосон. | Ноолуурын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээ байгуулах нь ҮХЦТ-ний МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх саналын нэг хэсэг юм.<br>ҮХЦТ-нд Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан нэмүү өртгийн сүлжээг бий болгож, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг саналыг тусгасан. |
| Хуудас 25: Аж үйлдвэрийн кластерийн хөгжлийг дэмжих агропаркуудын байршлыг оновчтой сонгох хэрэгтэй. | ХАНСХХ хүрээнд аймаг, сумын түвшинд нарийвчлан боловсруулна гэсэн хүлээлттэй байна. |
| Хуудас 25: Эрдэнэтэд уурхайн нөөц баялаг шавхагдсаны дараа хөгжүүлэх аж үйлдвэрийн төслүүд байхгүй байна. | ҮХЦТ-нд хамаарахгүй. |
| Газар тариалан, мал аж ахуй, уул уурхай, аж үйлдвэр, аялал жуулчлалын салбарын тайлан | |
| Хуудас 26: Хүнсний ногоо үйлдвэрлэлийн тухайд орон нутгийн жижиг үйлдвэрлэл болон нутгийн иргэдийн үйлдвэрлэлийг дэмжихийг санал болгосон. | Санал нийлж байна. |
| Хуудас 27: Үйлдвэрлэлийн эхний үеийн орц, ялангуяа үр, бордооны үйлдвэрлэл орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжихийг санал болгосон. | Санал нийлж байна. |
| Хуудас 28: Чацаргана жимсний эдийн засаг, байгаль орчны үр ашгийг (хүнс + гоо сайхны бүтээгдэхүүн) үндэсний бодлого, стратегид хангалттай тусгаагүй. | ХАНСХХ хүрээнд сонгогдсон аймгуудад үүнийг санал болгоно гэсэн хүлээлттэй байна. |
| Хуудас 28: АХБ-ны Төслийн багийн боловсруулсан загварыг “Мал аж ахуйд суурилсан нутаг дэвсгэрийн хөгжлийн загвар” танилцуулгад нэгтгэн харуулав. | Энэ загварыг илүү тодорхой болгож үргэлжлүүлэн боловсруулна гэсэн хүлээлттэй байна. |

АХБ-ны Төслийн багийн ахлагч энэ оны эцэс хүртэл үлдсэн 6 аймгийн аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөг боловсруулж, 2022 оны 3 дугаар сард бүх аймгуудын хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах тухай танилцуулсан.

Хавсралт А: Монгол Улсын Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулахад АХБ болон ЖАЙКА-гийн төсөл хамтран ажиллах тухай протокол

**Монгол Улсын Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулахад АХБ болон ЖАЙКА-гийн төсөл хамтран ажиллах тухай протокол**

# 1. ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Үндэслэл

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) болон Азийн хөгжлийн банк (АХБ) нь Монгол Улсын Засгийн газартай хот төлөвлөлт, хот байгуулалтын салбарын хөгжлийг дэмжих чиглэлээр урт хугацаанд хамтран ажиллаж байна. ЖАЙКА болон АХБ нь Барилга, хот байгуулалтын яаманд макро түвшний (үндэсний), мезо түвшний (бүсийн/дэд-бүсийн) болон орон нутгийн түвшний (аймаг/сум) төлөвлөлтийг агуулсан орон зайн хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх хамтарсан хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрт 2015-2016 онд хэрэгжүүлсэн АХБ-ны “Монгол Улсын хот байгуулалтын үндэсний үнэлгээ” төсөл болон ЖАЙКА-гийн 2015 - 2016 онд хэрэгжүүлсэн "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа"-ны төсөл болон холбогдох судалгаа зэрэг техникийн хамтын ажиллагааны төслүүд хамаарна. Энэхүү хөтөлбөрт 2015-2016 онд хэрэгжүүлсэн АХБ-ны “Монгол Улсын хот байгуулалтын үндэсний үнэлгээ” төсөл болон ЖАЙКА-гийн 2015-2016 онд хэрэгжүүлсэн "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа"-ны төсөл болон холбогдох судалгаа зэрэг техникийн хамтын ажиллагааны төслүүд хамаарна.

Тохиролцсоны дагуу АХБ болон ЖАЙКА-гийн үйл ажиллагааны ерөнхий зохицуулалтыг доор үзүүлэв. Үүнд:

1) АХБ нь дэд бүсийн хөгжлийн төлөвлөгөө болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, орон зайн төлөвлөгөө боловсруулна;
2) ЖАЙКА нь үндэсний болон бүсийн түвшний төлөвлөгөө (нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө, нутаг дэвсгэр, орон зайн төлөвлөгөө) боловсруулна;
3) АХБ, ЖАЙКА нь БХБЯ-тай нягт хамтран ажиллаж, ХАНСХЕТ-ийг боловсруулах ажлын хүрээнд холбогдох төслийн үр дүнг нутаг дэвсгэр, хүн амын хөгжлийн нэгдсэн бодлого, стратегид нэгтгэн ажиллана;
4) АХБ нь веб дээр суурилсан зураглалын портал, е-атлас болон хууль тогтоомжийг боловсруулах ажлыг голлон хариуцна;
5) ЖАЙКА нь газар зүйн мэдээлийн системийн асуудлыг голлон хариуцна;
6) Энэ хоёр байгууллагын аль аль нь институцийн болон чадавхийг бэхжүүлэх ажлыг өөрсдийн үйл ажиллагаанд хамруулна.

## 1.2 Протоколын зорилго

АХБ нь орон нутгийн нийгэм, эдийн засаг, орон зайн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, институцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар Монгол Улсад хүртээмжтэй, ногоон, өрсөлдөх чадвартай бөгөөд хотын тогтвортой хөгжлийг хангах стратегийн чиглэлүүдийг тодорхойлох зорилгоор Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр (KSTA MON

51106) боловсруулах техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр санаачилсан.

ЖАЙКА нь хууль тогтоомжид заасны дагуу БХБЯ-нд Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, ҮХГ-т Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл хэрэгжүүлж байна. Энэхүү протокол нь техникийн туслалцааны төслүүдийн макро, мезо, микро түвшний төлөвлөлт, төслийн үр дүнгийн уялдаа холбоог хангахын тулд АХБ болон ЖАЙКА-гийн Төслийн багуудын үйл ажиллагааг нь чиглүүлэх зорилготой юм.

Протоколд тус 2 төслийн тодорхой үр дүнгээс илүүтэй төслийн Зөвлөх багуудын хамтын ажиллагаа, үндсэн нөхцөл, ажил үүргийн хуваарилалтыг тусгасан. Үүнд:

1) Техникийн туслалцааны төслүүдийн нийтлэг зорилтууд,
2) Харилцан уялдаа бүхий арга, аргачлал,
3) ХАНСХЕТ-ийн нэмэлт агуулга,
4) Хэрэгжүүлэх механизм, үйл ажиллагаа.

### 1.3 Нэр томьёоны тодорхойлолт

Техникийн туслалцааны төслийн багуудын ажил үүргийн хуваарилалт, төслийн үр дүн зэрэгт төөрөгдөл үүсэхээс зайлсхийхийн тулд дараах нэр томьёоны тодорхойлолтыг тусгав.

- ХАНСХЕТ: Хууль тогтоомжид заагдсан Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл (БХБЯ);
- БХҮБ: Хууль тогтоомжид заагдсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (ҮХГ);
- ХАНСХХ: АХБ-ны төслийн хүрээнд боловсруулах Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр (дэд бүс, орон нутгийн түвшний);
- АХЧБТ: 21 аймаг тус бүрийн хөгжлийн алсын хараа, стратегийн зорилт, хөгжлийн чиг баримжааг тусгасан АХБ-ны төслийн хүрээнд болвсруулах Аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөө
- Макро түвшин: үндэсний түвшин
- Мезо түвшин: бүсийн* болон дэд-бүсийн* түвшин
- *Бүсүүд: Эдийн засгийн бүсийн ангилал (Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүс)
- **Дэд бүсүүд: АХБ-ны төслийн хүрээнд нутаг дэвсгэрийн дүн шинжилгээнд үндэслэн тодорхойлсон бүсийн ангилал
- Микро түвшин: аймаг, сумын түвшин
- Хэлэлцүүлгийн тэмдэглэл: ЖАЙКА-тай тохиролцсон ажлын удирдамжийн талаарх хэлэлцүүлгийн тэмдэглэл
- Хүлээн авагч байгууллага

## 2. ЗОРИЛТ, АРГА, АРГАЧЛАЛ

### 2.1 Зорилт

Техникийн туслалцааны 2 төслийн нийтлэг зорилтууд:

1) Тогтвортой, ногоон, хариуцлагатай, хүртээмжтэй хөгжлийг хангах бодлогын арга хэрэгсэл болгон ашиглах ХАНСХЕТ-ийг боловсруулахад хувь нэмэр оруулах;
2) Монголын мэргэжилтнүүдийн ХАНСХЕТ-ийг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах талаарх чадавхыг бэхжүүлэх.

### 2.2 Арга, аргачлал

Хоёр төслийн баг ХАНСХЕТ-ийн шаардлагыг хангах, Монгол Улсын Засгийн газар болон бусад оролцогч талуудад ойлгомжтой байлгах болон хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үүднээс хоорондоо нийцтэй арга, аргачлалыг ашиглаж байна. Төслийн багуудын ашиглаж буй арга, аргачлалыг хоёр талт аргачлал гэж нэрлэж болох ба дараах онцлогтой. Үүнд:

1) Боломжит өгөгдөлд суурилсан шинжлэх ухааны үндэслэлтэй дүн шинжилгээ;
2) Өргөн хүрээний оролцогч талыг хамруулсан оролцооны арга.

Төслийн зорилтод хүрэхэд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дүн шинжилгээ хийх, төлөвлөлтийн санал боловсруулахад тодорхой арга, аргачлалыг төслийн мэргэжилтнүүд тодорхойлж, ашиглана.

## 3. АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

### 3.1 Зарчим

Хоёр төслийн баг нь харилцан уялдсан, нийцтэй төлөвлөлт, саналуудыг боловсруулж, ХАНСХЕТ-ийг боловсруулахад шаардлагатай, уялдаатай санал, зөвлөмж, мэдээллээр хангана. Ингэхийн тулд төслийн багууд мэдээллээ хуваалцаж, ажлыг давхардуулахгүй байхад анхаарна.

Тодруулбал хоёр төслийн баг үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

1) 2 төслийн багийн мэргэжилтнүүд санал солилцох, төлөвлөлтийн гол асуудлуудын талаар хэлэлцэх, мэдээлэл солилцох зорилгоор хоорондоо харилцаатай байна;
2) 2 төслийн баг мэдээлэл цуглуулах, оролцогч талуудтай харилцах, дүн шинжилгээ, төлөвлөлт хийх, Монголын талын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах зэрэг үйл ажиллагааг давхардуулж хийхгүй байхад анхаарна;
3) Төслийн багууд мэдээллийг хуваалцахдаа тухайн мэдээллийг авахдаа мэдүүлсэн зорилгоос нь өөр зорилгоор ашиглах тохиолдолд мэдээлэл өгсөн байгууллагаас нь зөвшөөрөл авах нөхцөлтэйгээр хуваалцана;
4) 2 төслийн баг нь ажлын даалгаврынхаа хүрээнд ажиллах ба төслүүдээс гарах санал, үр дүнг БХБЯ УИХ-аар батлагдах ХАНСХЕТ баримт бичгийг боловсруулахад ашиглана.
5) Төслийн багууд төсөл хэрэгжүүлэх явцдаа зохион байгуулсан семинар, гол уулзалтуудынхаа танилцуулга материал, тайлангийн төслийг хоорондоо хуваалцана.

### 3.2 Ажлын хуваарилалт

Монгол Улсын макро, мезо, микро түвшний орон зайн төлөвлөлтийн агуулгыг Хавсралт хэсэгт үзүүлэв. ЖАЙКА-гийн Төслийн баг улсын болон бүсийн түвшинд ХАНСХЕТ, БХБ-ын агуулгыг хамрах Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг (ҮХЦТ)

боловсруулна. АХБ-ны төслийн хүрээнд аймгийн түвшинд ХАНСХЕТ-ийн орон зайн төлөвлөлт, аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөгөөг (АХЧБТ) 21 аймгаар боловсруулна.

Хавсралтад үзүүлсэнчлэн ҮХЦТ-нд орон зайн төлөвлөлт, ГЗБТ, бүсийн хөгжлийн хэтийн төлөв, нийгэм-эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт, салбарын хөгжлийн стратеги, хөгжлийн гол төсөл, хөтөлбөрүүд туссан байна. БХБЯ ХАНСХЕТ-ийг, ҮХГ БХБ-ыг боловсруулахад ҮХЦТ-ийг ашиглана. ЖАЙКА-гийн төслийн багийн зөвлөхүүд ҮХЦТ-г тусган ХАНСХЕТ-ийг боловсруулахад БХБЯ-нд дэмжлэг үзүүлнэ.

АХЧБТ бүрт хөгжлийн төлөвлөлтүүд, нийгэм эдийн засаг, байгаль орчны зорилтууд, тэдгээрт хүрэх прагматик шийдлүүдийг тодорхойлж, тусгахыг зорьсон. Мөн БХБЯ болон нутгийн захиргааны байгууллагад нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилготой баримт бичиг юм. Эдгээрээс гадна АХЧБТ-нд хот, нутаг дэвсгэрийн хөгжлийн зорилтыг биелүүлэхэд шаардлагатай бодлого, урамшуулал тогтолцоо, институцийн шинэчлэл бүхий үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг санал болгоно.

Улс, бүс нутгийн түвшний хөгжлийн зорилт, стратегийг ҮХЦТ-нд тодорхойлох ба АХЧБТ-үүдийг боловсруулахад санал, төлөвлөлтүүдийг тусгана. ЖАЙКА-гийн Төслийн багийн боловсруулах орон зайн төлөвлөлт, нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт нь АХБ-ны Төслийн багийн боловсруулах аймгийн түвшний хөгжлийн төлөвлөлийн суурь болно. Төслийн багууд уялдаатай санал, төлөвлөлт боловсруулахын тулд аймгийн түвшний санал, төлөвлөлтүүдийг хоорондоо солилцож, уялдуулж байна.

АХБ, ЖАЙКА-гийн төслийн багийн зөвлөхүүд техникийн туслалцааны төслүүдийн үйл ажиллагааны цар хүрээ, хуваарилалтыг уян хатан, үр дүнтэй байдлаар харилцан тохиролцож, уялдуулна. Энэ нь төслүүдийн ажлын даалгавартай зөрчилдсөн тохиолдолд төслийн багууд хоорондоо зөвшилцөж шийдвэрлэнэ.

# 4. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ

## 4.1 Төслийн хэрэгжилтийн зохион байгуулалт

ЖАЙКА-гийн төслийн хэрэгжилтийг удирдан чиглүүлэх Төслийн Хамтарсан зохицуулах хороо ажиллах ба АХ, дэд АХ-үүд байгуулагдан ажиллана. ТХЗХ-ны даргаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, дэд даргаар БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, ҮХГ-ын дарга, ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн Газрын дарга нар тус тус ажиллана. ТХЗХ-ны гишүүдийг төслийн Хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусган оруулсан. ТАХ-ийн бүрэлдэхүүнд БХБЯ, ҮХГ болон холбогдох яам, агентлагуудын төлөөлөл багтана.

Өдөр тутам нягт хамтран ажиллахын тулд ТАХ нь дэд ажлын хэсгүүдэд хуваагдаж үйл ажиллагаагаа явуулна. Үүнд: 1) хөдөө аж ахуй ба мал аж ахуй, 2) аж үйлдвэр, 3) байгаль орчин, аялал жуулчлал, 4) нийгмийн салбар ба 5) хотын дэд бүтэц ба зам тээврийн дэд бүтэц зэрэг болно. Эдгээр дэд ажлын хэсгүүд нь хуралд оролцогчдод чөлөөтэй, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

АХБ-ны төсөлд ч мөн адил төсөл хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалттай байна. АХБ-ны төслийн баг санал гаргаж, хамтран ажиллагч байгууллагуудтай хэлэлцэж тохиролцсоны дүнд ТХЗХ болон АХ-ийн дарга, гишүүдийг өөрчлөн томилж болно.

## 4.2 Зөвлөлдөх уулзалтууд

Хоёр төслийн баг гол төлөвлөлтийн асуудлуудыг хөндөж хэлэлцэх, шийдвэрлэх зорилгоор зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж байна. Зөвлөлдөх уулзалтын үеэр ажлын явцыг тайлагнаж, асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулж байна. Уулзалтад Монголын тал оролцох ба АХБ, ЖАЙКА-гийн төлөөллийг мөн урьж оролцуулна.

Зөвлөлдөх уулзалтуудын урьдчилсан товыг доорх хүснэгтэд үзүүллээ. Шаардлагатай тохиолдолд нэмэлт уулзалтуудыг зохион байгуулж болно.

| No. | Он, сар | Хэлэлцсэн асуудлууд |
|---|---|---|
| 1 | 2019 оны 8-р сар (хийсэн) | Ажлын хамрах хүрээ, ажлын хуваарилалт, хамтран ажиллах тухай протокол |
| 2 | 2019 оны 11-р сар | ҮХЦТ-ний тайлангийн эхний төсөлд үндэслэсэн хөгжлийн чиглэл, хувилбар, зорилго, стратеги г.м. |
| 3 | 2020 оны 1-р сар | Гол төсөл, хөтөлбөрүүд |
| 4 | 2020 оны 4-р сар | Хөгжлийн загвар, хувилбар, тэргүүлэх ач холбогдол бүхий төслүүд, аймгаар |
| 5 | 2020 оны 9-р сар | Шинэчилсэн ҮХЦТ, шинэчилсэн төсөл, хөтөлбөрүүд, АХЧБТ-ний төсөл |
| 6 | 2021 оны 4-р сар | Институцийн арга хэмжээ, төслийн хэрэгжилтийн зохион байгуулалт |

Зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах саналыг төслийн багийн ахлагч эсвэл дэд ахлагч гаргаж, нөгөө төслийн багийн ахлагч эсвэл дэд ахлагч саналыг хүлээж авсны дараа уулзалтыг зарлан, зохион байгуулна. Уулзалтын зохион байгуулалтыг уулзалтыг санал болгосон төслийн баг хариуцна. Зөвлөлдөх уулзалтыг Монголын тал, АХБ, ЖАЙКА-гийн хүсэлтээр зарлан хуралдуулж болно.

### 4.3 Орон нутагт хийсэн зөвлөлдөх уулзалтууд

ЖАЙКА-гийн төслийн баг аймгуудын одоогийн нөхцөл байдлыг судалж, хөгжилд тулгарч буй асуудлууд, хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлох зорилгоор 21 аймагт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж дууссан. Аймгуудад зөвлөлдөх уулзалтуудыг дараах нөхцөлүүдийн хүрээнд үргэлжлүүлэн зохион байгуулна.

1) Орон нутагт хийх зөвлөлдөх уулзалтыг 2 төслийн баг хамтран төлөвлөж, зохион байгуулна.
2) 2 төслийн баг орон нутагт зохион байгуулах зөвлөлдөх уулзалтын хуваарийг төслүүдийн хэрэгжилт, явцыг харгалзан харилцан тохиролцож тогтооно.
3) Хоёр төслийн баг гол төслүүдийг санал болгож, тэдний үр нөлөөг газарзүйн өргөн хүрээнд үнэлж, байгаль орчны стратегийн үнэлгээг (БОСҮ) хийхийн тулд аймгуудад зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулна.
4) Орон нутагт хийх зөвлөлдөх уулзалтын зардлыг 2 төслийн баг тэнцүү хувааж төлнө.

**Хавсралт:**

| | Орон зайн төлөвлөлт | ГЗБТ |
|---|---|---|
| Улс, бүс нутгийн түвшинд | | |
| Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл (ХАНСХЕТ) | Хотын зэрэглэл:<br>・Улсын нийслэл<br>・Бүсийн хөгжлийн төв хот<br>・ Орон нутгийн хөгжлийн төв хот | Зорилго: Байгалийн чухал элементүүдийн сүлжээг тодорхой гаргах<br>Газрын үндсэн зориулалт:<br>-Ойн сан<br>-Хөдөө аж ахуйн газар (Газар тариалан эрхлэлтийг дэмжих газар г.м.) |

| | | |
|---|---|---|
| | ・ Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот<br>・Хөдөө, орон нутгийн үйлчилгээний төв хот<br>Нисэх онгоцны буудал, хурдны зам, гол зам, төмөр замыг харуулсан тээврийн сүлжээ<br>Томоохон үйлдвэрийн болон нийтийн байгууламжууд<br>Бүс тус бүрийн хөгжлийн чиглэл | -Бэлчээрийн газар нутаг<br>- ТХГН (Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт<br>газар, усны нөөц бүхий газар)<br>- Хотын бүс, үйлдвэрлэлийн бүс<br>Нарийвчлал: Ерөнхий<br>Сэдэвчилсэн зураг:<br>- Байгаль орчны хувьд эмзэг газрууд<br>- Ойн сан,<br>- Газар тариалан эрхлэлтийг дэмжих газар<br>- Бэлчээрийн газар нутаг (УАӨ-т өртөж буй газар нутгийн хамт)<br>- Усны сав газар, газар доорх усны нөөц бүхий газар нутаг<br>- Ашигт малтмалын нөөц бүхий газар<br>- АЖ-ын нөөц бүхий газар |
| Бүсчилсэн хөгжлийн бодлого (БХБ) | Бүсийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн аймаг бүрийн онцлог<br>Хотын зэрэглэл: ХАНСХЕТ-тэй ижил (+аймгийн төв)<br>Аймгийн төв, аймгийн дэд төв, сумын төвийн төрийн үйлчилгээг үзүүлсэн удирдамж<br>Зам, тээврийн сүлжээ<br>Аялал жуулчлалын сүлжээ | Дээрхтэй адил |
| Аймаг, дэд бүсийн түвшинд | | |
| ХАНСХЕТ | Хотын зэрэглэл:<br>- Аймгийн төв;<br>- Аймгийн дэд төв;<br>- Сумын төв.<br>Зам, тээврийн сүлжээ;<br>Боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудыг хамарсан төрийн үйлчилгээний сүлжээ | Газрын нэгдмэл сангийн ангилал:<br>- Хот, суурин<br>- Ой<br>- Хөдөө аж ахуйн газар (Газар тариалан эрхлэлтийг дэмжих газар г.м.)<br>- Бэлчээрийн газар нутагс<br>- Улсын тусгай хамгаалалттай газар (Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт<br>газар, усны нөөц бүхий газар)<br>Нарийвчлал: аймаг, сумдын зөвшөөрлийг авч дэлгэрэнгүй хийх. |
| Орон нутгийн түвшинд | | |
| Хот, тосгоныг хөгжүүлэх төлөвлөгөө | | |
| Нарийвчилсан төлөвлөгөө | Журамд заасны дагуу | Хот, суурин газрын төлөвлөлт бүхий ГЗБТ (журамд заасны дагуу) |
| Үйл ажиллагааны төлөвлөгөө | Журамд заасны дагуу | Хот, суурин газрын төлөвлөлт бүхий ГЗБТ (журамд заасны дагуу) |

| | | |
|---|---|---|
| Сумын төвийг хөгжүүлэх төлөвлөгөө | Орон зайн төлөвлөлт байхгүй | ГЗБТ байхгүй.<br>- Сумын төв<br>- Орон сууц<br>- Сургууль<br>- Эмнэлэг<br>Ахуйн хэрэглээ, МАА эрхлэлтийн зориулалттай усан хангамж; Цахилгаан хангамжийн систем;<br>Суурин болон суурин бус газрын бэлчээрийн талбайг харуулсан ***байршлын газрын зурагтай***. |

<u>Хавсралт В: 2-р зөвлөлдөх уулзалтын тэмдэглэл (АХБ-ны Төслийн баг боловсруулав)</u>

**2-р зөвлөлдөх уулзалтын тэмдэглэл** (АХБ-ны Төслийн багийн боловсруулсан)

АХБ-ны Төслийн багийн дэд ахлагч Ш.Энхцэцэг болон ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч Др.Хашимото нар тохиролцсоны дагуу 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хоёр дахь зөвлөлдөх уулзалтыг БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболдын албан өрөөнд хийсэн.

Уулзалтад ЖАЙКА-гийн Төслийн багаас Др. Хашимото, Токура нар, АХБ-ны Төслийн багаас Ш.Энхцэцэг, П.Мөнгөнчимэг нар оролцсон ба ажиглагчаар Б.Гүнболд дарга байлцав.

Төслийн багууд санал солилцох асуудлуудаа урьдчилан бэлдсэн байсан. Уулзалтыг Др. Хашимото эхлүүлж, хамтран ажиллах тухай протокол, АХБ-ны төслийн эхлэлийн тайлан, дараагийн зөвлөлдөх уулзалтын товтой холбоотойгоор өөрийн саналаа хэлсэн.

1. АХБ-ны төслийн эхлэлийн тайлантай холбоотой саналууд:

Др. Хашимото зөвлөхүүдийн ажлын даалгавар, ажлын бүрэлдэхүүн хэсгүүдийн тайлбарыг тусгасан тайлангийн бүтэц, агуулгатай холбоотойгоор саналаа хуваалцсан. Мөн дэд бүсийн тодорхойлолт, үзэл баримтлал, аймгуудын типологи, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал болон бусад асуудлаар саналаа илэрхийлсэн. Тэрээр ЖАЙКА-гийн төслийн багийн Дунд хугацааны тайлан 1-тэй холбоотойгоор АХБ-ны төслийн багаас санал, дүгнэлт байвал ирүүлэхийг хүссэн.

2. Хамтран ажиллах тухай протокол:

Др. Хашимото хамтран ажиллах тухай протоколын хувилбарыг зөвшөөрч байгаагаа хэлсэн ба АХБ-наас хянаж, зөвшөөрсөн тохиолдолд эцэслэж болно гэв. Мөн АХБ-ны талаас гарын үсэг зурах шаардлагагүй гэж үзвэл ЖАЙКА-гийн талаас гарын үсэг зурах шаардлага тавихгүй гэв.

3. Дараагийн зөвлөлдөх уулзалт:

Др. Хашимото дараагийн зөвлөлдөх уулзалтын товыг урьдчилсан байдлаар товлохыг хүссэн. Тэрээр 2020 оны 1-р сарын 12-оос 22-ны хооронд Монгол Улсад ажиллах ба энэ үеэр дараагийн уулзалтыг зохион байгуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Үүний дараа 3-р сард Монгол Улсад ирж ажиллана. Др. Хашимототой цаг тохирч skype-аар холбогдох боломжтой гэв.

Үүний дараа хатагтай Ш.Энхцэцэг 2 төслийн багийн үйл ажиллагааны талаар санал бодлоо хэлсэн. АХБ-ны төслийн багийн боловсруулах Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөрийн (ХАНСХХ) ажлын даалгаварт Барилгын хөгжлийн төвийг ХАНСХХ-ийг боловсруулах, ЗГ-аар батлуулах ажлыг хариуцаж ажиллана гэж тусгасан. ЖАЙКА-гийн төслийн баг нь ЖАЙКА болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг (ХАНСХЕТ) боловсруулахад тус төлөвлөгөөг ашиглах юм. 2 төслийн баг аль аль нь БХТ-д ХАНСХЕТ-ийг боловсруулахад зөвлөгөө өгч, дэмжиж ажиллана. Иймд БХТ болон 2 төслийн баг төслүүдийг хэрэгжих хугацаанд гол зорилгод хүрэхийн тулд мэдээлэл, зөвлөх, мэргэжилтнүүд, үр дүнтэй харилцаа холбоо зэрэг нөөцийг ашиглан, үйл ажиллагааг давхардалгүйгээр хийж гүйцэтгэн, нягт хамтран ажиллах шаардлагатай гэсэн саналыг АХБ-ны Төслийн багийн дэд ахлагч хэлсэн ба ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч уг саналыг дэмжсэн.

Түүнчлэн АХБ-ны Төслийн багийн дэд ахлагч илүү үр дүнтэй, уян хатан байдлаар хамтарч ажиллах дараах санал, хүсэлтүүдийг дурдсан. Үүнд:

1. Др. Хашимото АХБ-ны төслийн багийн давуу тал нь Монгол зөвлөхүүд гэж хэлсэн. Хэдийгээр бид тусдаа төслийн баг болович ЖАЙКА-гийн Төслийн багтай нягт хамтран ажиллахад бэлэн байна. ЖАЙКА-гийн Төслийн багт АХБ-ны төслийн багийн Монгол зөвлөхүүдийн дэмжлэг шаардлагатай тохиолдолд дэмжиж ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлж байна. ЖАЙКА-гийн Төслийн багтай мэдээлэл, тайлан хуваалцахдаа нээлттэй байх болно. ЖАЙКА-гийн Төслийн баг мөн бидэнтэй мэдээлэл, тайлангаа хуваалцаж ажиллавал талархах болно.
2. Нөгөө төслийн багийн гаргасан тайланг үзэж танилцан, саналаа хүргүүлж байх;
3. ЖАЙКА-гийн Төслийн баг хамтран ажиллах тухай протоколд гарын үсэг зурах шаардлагагүйгээр, зөвшөөрч, баталгаажуулж байгаад талархаж байна.
4. ЖАЙКА-гийн Төслийн багаас манай багтай холбоотой байж, хамтран ажиллах хүнийг томилж өгөхийг хүсч байна.
5. Бид өөрсдийн тайландаа ЖАЙКА-гийн Төслийн багийн боловсруулсан тайлангаас мэдээлэл авч оруулах тохиолдолд мэдээллийн эх сурвалжийг дурдах ба ЖАЙКА-гийн Төслийн багаас ч мөн ийнхүү хамтарч ажиллахыг хүсч байна.
6. Мэдээ, мэдээллийн нууцлалын асуудал нь зайлшгүй яригдах асуудал тул энэ тал дээр эртнээс анхаарч, зохицуулалтуудыг хийх нь чухал юм.

Хоёр талын хэлэлцэж, тохиролцсон асуудлуудын хураангуй болон дүгнэлт:

1. ЖАЙКА-гийн Төслийн баг БХБЯ-аар дамжуулсан албан ёсны хүсэлтгүйгээр мэдээлэл, тайлангаа АХБ-ны төслийн багтай хуваалцаж байх болно. Гэсэн хэдий ч тодорхой зорилгоор цуглуулсан зарим мэдээллийг уг байгууллагаас нь зөвшөөрөл авалгүйгээр хуваалцах боломжгүй байх тохиолдол байдаг.
2. АХБ-ны Төслийн баг 12-р сард Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад ажиллахаар төлөвлөж байна. ЖАЙКА-гийн Төслийн багийн

гишүүдээс энэ ажилд биеэр оролцож чадахгүй тул эдгээр аймгуудтай холбоотой цуглуулах мэдээлэл байвал АХБ-ны Төслийн багт мэдэгдэнэ.

3. Др. Хашимото АХБ-ны төслийн эхлэлийн тайлантай холбоотой санал, дүгнэлтээ имэйлээр илгээнэ.
4. Хамтран ажиллах тухай протокол хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ба үүнийг хоёр төслийн багийн цаашдын хамтын ажиллагаанд мөрдөж ажиллана.
5. ЖАЙКА-гийн Төслийн багтай мэдээлэл солилцох чиглэлээр Төслийн багийн Монголын талын ахлагч Ц.Тунгалагтай холбогдож, хамтарч ажиллана. Харин Монголд түр томилогдон ирж ажилладаг салбарын төлөвлөлт хариуцсан япон мэргэжилтнүүдтэй холбогдож, хамтарч ажиллахад Др. Хашимото дэмжлэг үзүүлнэ.
6. Нэг төслийн баг нь нөгөө төслийн багийн боловсруулсан тайлангаас мэдээлэл авч ашиглах тохиолдолд мэдээллийн эх сурвалжийг дурдана.
7. Мэдээллийн нууцлалын асуудлыг БХБЯ-тай хэлэлцэж, зохицуулна.

<u>Хавсралт C: АХБ-ны Төслийн багийн боловсруулсан үндэсний хэмжээний хөгжлийн саналуудтай холбоотой санал, дүгнэлт (2021.10.16, ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч Ц.Хашимото)</u>

**АХБ-ны Төслийн багийн боловсруулсан үндэсний хэмжээний хөгжлийн саналуудтай холбоотой санал, дүгнэлт**
(2021.10.16, ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч Ц.Хашимото)

## 1. Хотын зэрэглэл

1) Санал болгож буй хотын зэрэглэл нь хотын зэрэглэл гэхээс илүү хотын ангилал байхаар байна. Нэгдүгээрт хүн амын тоо, Улаанбаатар хотоос алслагдсан байдал, эдийн засгийн хөгжил гэх мэт шалгууруудаас бусад шалгуур үзүүлэлтүүд нь тодорхойгүй байна. Хоёрдугаарт хотын зэрэглэлд хэт олон ангиллыг ашигласан байна.
2) ҮХЦТ-нд 4 зэрэглэл бүхий хотын зэрэглэл болон сум дундын төвийг санал болгосон. БХТ-ийн Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга Давааням ҮХЦТ-ний хотын зэрэглэлд олон зэрэглэлийг санал болгосон байна гэсэн саналаа ирүүлж байсан бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулинд улсын зэрэглэлтэй хот, орон нутгийн зэрэглэлтэй хот гэсэн хоёр зэрэглэл байдаг.
3) ҮХЦТ-нд тусгасан хотын зэрэглэл дэх хотуудын ангилал нь хуулинд заасантай ихээхэн нийцэж байна. Улаанбаатар хот нь улсын нийслэл ба 7 хотыг бүсийн хөгжлийн төв хот, орон нутгийн хөгжлийн төв хотоор санал болгосон. Арвайхээр, Улиастай хотыг орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот гэж тодорхойлсон. Сайншанд, Баянхонгор хотыг бүсийн хөгжлийн төв хот гэж тодорхойлсон ба үлдсэн 17 орон нутгийн зэрэглэлтэй хотыг орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот гэж тодорхойлсон.

## 2. Бүсчилсэн хөгжлийн загвар

4) ҮХЦТ-нд МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх үйл ажиллагааг бүсийн хөгжлийн гол стратегийн нэгээр санал болгосон бөгөөд үүнд ноолуурын үйлдвэрлэлийн кластер, сарлаг, үхэр, хонь зэрэг малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн кластерууд багтаж болно. Эдгээр кластеруудын хөгжлийг АХБ-ны "Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл"-ийн хөтөлбөрийн судалгаанд санал болгосон МАА-д суурилсан нутаг дэвсгэрийн хөгжлийн загварт тусгасанчлан нарийвчлан тодорхойлох шаардлагатай.
5) Мал аж ахуйн салбарын цаашдын хөгжилд малын тэжээл үйлдвэрлэл чухал үүрэгтэй болохыг тэмдэглэх нь зүйтэй. ҮХЦТ-нд хагас эрчимжсэн мал аж ахуй, тэжээлийн үйлдвэрлэлийг хослуулсан нэгдсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэхийг санал болгосон.
6) АХБ-ны ХАНСХХ-т санал болгож буй "Төсөл хөгжүүлэх сан"-г ашиглах талаар судалж, ТХХТ-ээр дамжуулж хэрэгжүүлэх үйл ажиллагааг илүү нарийн тодорхойлох шаардлагатай.
7) Аялал жуулчлалыг хөгжүүлэх нь бараг бүх аймгийн хөгжилд чухал ач холбогдолтой. ҮХЦТ-нд ихэнх бүс нутагт аялал жуулчлалын авто замыг сайжруулахыг санал болгож, үндэсний хэмжээнд ач холбогдолтой аялал жуулчлалын хоёр байршлыг хөгжүүлэх буюу аялал жуулчлалын гурвалжинг байгуулахыг онцолсон. АХБ-ны ХАНСХХ-т аялал жуулчлалыг нэн тэргүүнд хөгжүүлэх шаардлагатай байршлуудыг тодорхойлсныг дахин авч үзэх шаардлагатай байж болох юм.
8) ҮХЦТ-нд ЖДҮ-ийг дэмжих хэд хэдэн санал, арга хэмжээг санал болгож байгаа бөгөөд аймгийн төвүүдэд ЖДҮ-ийг хөгжүүлэх бизнес инкубатор төвүүдийг байгуулах саналыг судалж, туршилтаар хэрэгжүүлэх нь зүйтэй.
9) ҮХЦТ-ний хүрээнд усны балансын нарийвчилсан шинжилгээ хийсэн ч ойн болон усны менежмент дутагдсанаас Онги, Таац голын эхээс урсац багассаныг тайланд онцолж тусгаагүйг дурдах нь зүйтэй.

<u>Хавсралт D: АХБ-ны Төслийн багийн нэмэлт саналууд</u>

### 1. АХБ-ны Төслийн багийн нэмэлт саналууд

- Хархорин хотыг (8000 хүн амтай) Дархан (90,000 хүн амтай), Эрдэнэт (100,000 хүн амтай) хотуудын адилаар бүсийн тулгуур төв хотоор нэрлэсэн үндэслэл (хөрөнгө оруулалтын төслүүдийг шийдсэн г.м.) нь хангалтгүй байна.
- Хойд ногоон бүс буюу тогтвортой газар тариалан, МАА эрхлэлтийг дэмжих үр өгөөж ихтэй бүс нутагт аялал жуулчлалыг голчлон хөгжүүлэхийг санал болгосон байна.
- Улс орны хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх саналууд (хэдийгээр аймгуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд аялал жуулчлалыг хөгжүүлэх нь гол төлөвлөлтүүдийн нэг байдаг ч, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодит нөөц боломж нь цөөн аймагт байдаг тул бүх аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг онцлох нь ач холбогдолтой бус юм);
- Газар тариалан эрхлэлтэд дэвшилтэт технологи, 5G-г ашиглах: салбарын одоогийн нөхцөл байдал, чадавхтай төдийлөн нийцэхгүй;
- Хөгжлийн коридоруудыг байгуулж, хөрөнгө оруулалтыг эрчимтэй нэмэгдүүлж, тойрог коридорын доторх бүс нутгийн төвлөрлийг нэмэгдүүлэх: Энэ бүс

нутгийн хэмжээ нь бараг л Франц улсын газар нутгийн хэмжээтэй дүйх бөгөөд хүн амын нягтрал нь маш бага тул Япон, Хятад, Европын хүн ам голчлон төвлөрсөн хэсэг болон бусад цөөн тооны улсуудад л хэрэгжих боломжтой бүс нутгийн хөгжлийн загварыг амжилттай хэрэгжүүлж чадахгүй. Бидний хийсэн судалгаагаар УБ-Эрдэнэт-Дарханыг холбосон бүс нутагт л үүнийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

## 2. АХБ-ны Төслийн багийн үндэсний болон бүс нутгийн түвшинд авч үзсэн асуудлуудтай холбоотой санал

1) ҮХЦТ-нд санал болгосон хотын зэрэглэлээр Хархорин хот нь бүсийн хөгжлийн төв хот биш юм. Харин орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хотуудын нэг юм. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичигт Хархорин хотыг Улаанбаатар хот болон өөр 9 хотын хамт улсын зэрэглэлийн хотын ангилалд багтаасан байна. Түүнчлэн улсын нийслэлийг Хархорин хот руу нүүлгэх талаарх аргументуудыг тавьсаар байна (үүгээр зогсохгүй Улаанбаатар болон Хархорин хотыг хурдан галт тэргээр холбох саналуудыг дэвшүүлсэн байдаг). Эдгээрийг харгалзан ҮХЦТ-нд Хархорин хотыг соёлын өв, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх саналыг тусгасан. Хархорин хотыг хотын зэрэглэлийн шатлалын тухайд 4 дүгээр шатлалд буюу орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот байхаар тусгасан.

2) ҮХЦТ-нд санал болгож буй тойрог коридорын хойд хэсгийн бүс нутаг нь дэвшилтэт газар тариалан, мал аж ахуй эрхлэлт бүхий үр өгөөж ихтэй бүс нутаг юм. Ойгоор бүрхэгдсэн газар нутаг, соргог бэлчээр, байгалийн болон өв соёлын баялаг нөөц бүхий тус бүс нутагт ОХУ-тай холбосон худалдаа, аялал жуулчлалын коридор байгуулах саналыг тусгасан. Энэ санал нь бүсийн хөгжлийн алсын харааг илэрхийлж байна. Тус бүс нутагт МХХТ болон бусад дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр ХАА-н салбарын үр өгөөжийг ихээр нэмэгдүүлэх боломжтой. ОХУ-тай бүтээгдэхүүний маркетинг, технологийн солилцоо хийх замаар энэхүү нөөц боломжийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Мөн энэ бүс нутагт зөвхөн газар тариалан, мал аж ахуй эрхлээд зогсохгүй ногоон хөгжлийн бодлогын хүрээнд худалдаа, аялал жуулчлалын коридорыг байгуулж болно.

3) Бүх аймагт аялал жуулчлалын аль нэг төрлийг хөгжүүлэх нь чухал болохыг онцолсон. Аймгуудад дотоодын жуулчдыг татах зорилгоор нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь зүйтэй юм. ҮХЦТ-нд сонгогдсон байршлуудыг үндэсний хэмжээний ач холбогдол бүхий аялал жуулчлалын байршлууд гэж тодорхойлсон. Аялал жуулчлалыг хөгжүүлэх гол бүс нутгуудад ч мөн нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг орхигдуулалгүй хөгжүүлснээр олон улсын жуулчдад чиглэсэн олон талт байдлыг бий болгож, тэдний сонирхлыг илүү татах болно. ҮХЦТ-нд үндэсний хэмжээнд аялал жуулчлалын хоёр чиглэлийг онцолсон ба төрийн санаачилга, дэмжлэгтэйгээр дэд бүтэц, аялал жуулчлалын үзмэр, хот, суурин газрыг цогцоор нь хөгжүүлэх саналыг тусгасан. ҮХЦТ-нд голчлон төрөөс баримтлах бодлого, төлөвлөлтийн саналуудыг тусгасан билээ. Аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой бусад бүс нутгийн хувьд хувийн хэвшлийн оролцоо, бүтээн байгуулалтыг хангахын тулд зам, харилцааг сайжруулахад анхаарах шаардлагатай юм.

4) ҮХЦТ-нд МХХТ болон бусад дэвшилтэт технологийг бүх салбарт өргөн хүрээнд нэвтрүүлэх, ашиглахыг санал болгосон. Энэ нь өргөн уудам нутаг дэвсгэрт тархсан хүн амын нийгэм, эдийн засгийн олон төрлийн үйл

ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай юм. Монгол Улс МХХТ болон дэвшилтэт технологийн чиглэлээр бэлтгэгдсэн боловсон хүчин бүхий томоохон компаниудтай, мөн МХХТ-ийн суурь дэд бүтэц бүрдсэн учир үүнийг хэрэгжүүлэх боломжтой юм. Тухайлбал хүлэмжийн аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн автоматжуулсан хяналт зэрэгт үйлдвэрийн хэлбэрийн газар тариалан эрхлэлтийг нэвтрүүлдэг болоод буй. Энэхүү практик нь ҮХЦТ-нд тусгасан хязгаарлагдмал нөөц баялгийг үр ашигтай, тогтвортой ашиглах нийгэм, эдийн засгийн хөгжлийн загвартай нийцэж байна.

5) Монгол Улсын орон зайн, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг хийхэд хүн амын нягтрал хэт бага бүс нутгуудыг харгалзаж үзэх нь чухал юм. Нөөц боломж ихтэй бүс нутгуудад бүтээн байгуулалтыг хуваарилах нь зүйтэй ч, хүртээмжтэй байдлыг хангах үүднээс алслагдсан болон хөгжил багатай бүс нутгуудын зам харилцааг сайжруулах зэргээр бүтээн байгуулалтыг орхигдуулахгүй байхад анхаарах шаардлагатай. Ингэхийн тулд эдийн засгийн коридорыг барьж байгуулж болно. Доорх зурагт үзүүлсэнчлэн хөгжлийн нөөц ихтэй бүс нутагт коридорыг байгуулж, нийт коридорыг гол замын сүлжээгээр холбосон. Тодруулбал Нийслэлийн бүсээс бусад 5 бүсийн 5 коридороос 4-ийг тойрог коридороор холбосон. ҮХЦТ-нд тойрог коридор доторх бүс нутагт "хөрөнгө оруулалтыг эрчимтэйгээр нэмэгдүүлэх", "хүн амын нягтралыг нэмэгдүүлэх" саналуудыг тусгаагүй. Коридор бүхий сонгогдсон байршлууд мөн аялал жуулчлалын гурвалжинг хөгжүүлэх байршлуудад төсвийн хөрөнгө оруулалт хийх саналыг боловсруулсан. Коридорын хөгжлийг дагаад зам, харилцаа холбооны дэд бүтэц сайжрах ба энэ нь тойрог коридорын дагуух хөгжил багатай бүс нутгуудын хөгжилд түлхэц үзүүлнэ. УБ-Эрдэнэт-Дарханыг холбосон гурвалжинг хөгжүүлэх тал дээр санал нэгдэж байгаа хэдий ч энэхүү гурвалжинг хөгжүүлснээр тэнцвэртэй хөгжлийг хангаж чадахгүй.



Хавсралт Е: Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр (ХАНСХХ) болон Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө (ҮХЦТ) боловсруулах төслүүдийн

**Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр (ХАНСХХ) болон Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө (ҮХЦТ) боловсруулах төслүүдийн уялдаа холбоо** (ХАНСХХ-ийн Төслийн баг боловсруулав)

Энэхүү дүгнэлтийг Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр (ХАНСХХ) боловсруулах АХБ-ны Төслийн багаас ЖАЙКА-гийн Төслийн багийн боловсруулсан 10 бүлэг бүхий Үндсэн тайлан, Салбаруудын 3 тайлангаас бүрдсэн Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний Эцсийн тайлангийн төсөлд үндэслэн гаргасан.

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд санал болгож буй хөгжлийн чиг баримжааг судалж, АХБ-ны Төслийн багийн боловсруулж буй Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хийсэн дүн шинжилгээ, санал болгосон хөгжлийн чиг баримжаатай харьцуулсан болно.

**Бүлэг 2: ТХҮБ 2030 Макро эдийн засаг, байгаль орчны үзүүлэлтүүд**

Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн дүн шинжилгээ, санал нь ҮХЦТ-ний хүрээнд тодорхойлсон эдийн засгийн хөгжилд тулгарч буй сорилтууд (2.3.13), нийгмийн хөгжилд тулгарч буй сорилтууд (2.3.14), байгаль орчны менежменттэй холбоотой сорилтууд (2.3.15), дүн шинжилгээтэй бүрэн нийцэж байна.

АХБ-ны төслийн баг эдийн засгийн хөгжлийн талаар доор дурдсан 2 асуудлыг нэмж оруулах саналтай байна. Үүнд:

(1) Малын гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг нэгтгэн хөгжүүлж, мал аж ахуйн салбарт экспортод чиглэсэн боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх хэрэгтэй. Мал аж ахуйн салбар нь ажиллах хүч хамгийн их шингээсэн салбар (Улаанбаатар хотоос гадна) бөгөөд энэхүү салбар хүнд сорилттой тулгараад байна.

(2) Хүнсний аюулгүй байдлыг хангах, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортын хамаарал болон худалдааны алдагдлыг бууруулах зорилгоор тариалан эрхлэлтийг дэмжиж, зохион байгуулалтад оруулна.

АХБ-ны төслийн баг байгаль орчны менежментийн талаар доор дурдсан 4 асуудлыг нэмж оруулах саналтай байна. Үүнд:

(1) Мал аж ахуй эрхлэлт ялангуяа бэлчээр ашиглалтын менежмент сул, малын тэжээл хомс, мал сүргийн тоо толгойн хяналтгүй өсөлт зэргээс шалтгаалан нүүрстөрөгчийн шингээлт буурж, уур амьсгалын өөрчлөлтийн үр дүнд зуд г.м байгалийн гамшигт үзэгдлүүд улам бүр нэмэгдэж байна.

(2) (i) усны хэрэглээг зохицуулах замаар усны менежментийг сайжруулах; (ii) ус хэмнэлтийн схемийг (усан сан, үр ашиг) боловсруулж, усалгаатай газар тариаланг дэмжих; (iii) хот, суурин газрын хүн амыг цэвэр усаар хангах (Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд усны нөөц жигд бус тархсанаас шалтгаалан ус дамжуулах шугам сүлжээ барьж байгуулах шаардлагатай), (iv) ялангуяа хотуудын бохир ус цэвэрлэх байгууламж болон үйлдвэрийн газрын бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчилж, гүний усны бохирдлыг бууруулах шаардлагатай. Улаанбаатар хот болон нутгийн өмнөд хэсэгт орших аймгууд

нь усны хомсдолтой тулгарч байгаа бөгөөд нийт хүн амын 2/3 нь усны хомсдолтой нөхцөлд амьдарч байна.

(3) Хатуу хог хаягдлыг бүрэн цуглуулж, зайлуулан менежментийг сайжруулна. Салбарын бодлогыг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулахад (3Rs) чиглүүлэх хэрэгтэй. Улсын хэмжээнд хатуу хог хаягдлын менежмент сул байгаа нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, байгаль орчинд ихээхэн аюул учруулж байна. Энэхүү асуудал нь томоохон хотууд төдийгүй сумын төвүүдэд ч тулгамдсан асуудал болж байна. Мөн аялал жуулчлалын баазууд болон усны нөөцийн (нуур, гол) орчим хог хаяснаас газрын доройтол, усны бохирдол үүсэж байна.

(4) Ой мод нь экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалдаг тул ойн менежментийг сайжруулах шаардлагатай. Нутгийн хойд хэсгийн ой мод нь усны нөөцийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг бол өмнөд хэсгийн заган ой цөлжилтөөс хамгаалдаг.

## Бүлэг 3 Хөгжлийн загвар, алсын хараа, зорилт, стратеги

ҮХЦТ-ний хүрээнд хийсэн дүн шинжилгээ нь ХАНСХХ-тэй нийцэж байна. Доорх саналыг хүргүүлж байна. Үүнд:

<u>Хөгжлийн загвар, алсын хараа</u>

<u>Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт МХХТ, дэвшилтэт технологийг ашиглах нь</u>

Энэ нь орон нутгийн нөхцөл байдлаас шалтгаалах бөгөөд хөдөө аж ахуйн салбарт бүхэлд нь МХХТ-ийг нэвтрүүлэх шаардлагагүй юм. Ерөнхийдөө хөдөө орон нутагт дэвшилтэт технологи, техникийг ашиглах мэдлэг, чадвар сул. Тогтолцоо болон машин механизмын ашиглалт, засвар үйлчилгээ хангалтгүй, социализмын үед баригдсан ихэнх хөдөө аж ахуйн барилга байгууламж, дэд бүтэц орхигдсон. Жишээлбэл газар тариалангийн салбарт дэвшилтэт технологи, ялангуяа дэвшилтэт техник ашиглах нь тариаланчдын мэдлэг чадвар, санхүүгийн чадавхтай нийцэхгүй байж магадгүй юм. ХАНСХХ-ийн хүрээнд хийсэн дүн шинжилгээ нь хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ил талбайн тариалалтыг нэн тэргүүнд тавих (Хавсралтаас хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар үзнэ үү) шаардлагатайг харуулж байгаа бөгөөд өвлийн хүлэмжид зөвхөн нэмүү өртөг шингээсэн өндөр үнэтэй жимс, хүнсний ногоог (гүзээлзгэнэ) тариалахад ашигтай байна. Хөдөөгийн малчдын өвөлжөө, хаваржаан дахь малын хашаа хороонд элбэг байдаг өтөг бууцыг компостлож (өтөг бууцыг бичил биетнээр исгэх, чийгийн улаан хорхой оруулах) дэвшилтэт технологи ашиглах шаардлагагүйгээр орон нутагт бордоо үйлдвэрлэх боломжтой юм (доорх ишлэлийг үзнэ үү). Тариалангийн том талбайд төвийн эргэлтийн усалгааны системийг ашиглах нь үр дүнтэй байж болох бөгөөд уг системийг газар тариалан эрхэлдэг томоохон аж ахуй нэгжүүд л худалдан авах боломжтой (доорх ишлэлийг үзнэ үү).

Тухайлбал мал амьтны халдварт өвчний талаар малчдад мэдээлэл хүргэх, малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн мөшгих систем, гарал үүслийн гэрчилгээ олгох зэрэг мал аж ахуйн салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх боломжтой.

АХБ-ны Төслийн багаас дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх нь хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын хөгжлийн гол түлхүүр гэж үзэхгүй байгаа тул тухайн асуудлыг анхааралдаа авахыг зөвлөж байна.

Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөрийн хүнсний ногооны үйлдвэрлэлийн тухай хавсралтын ишлэл

1 Хүлэмжийн аж ахуй

Ил талбайд тариалах эсвэл хүлэмжид тариалах?

Дэвшилтэт техник, технологи нь хүнсний ногооны үйлдвэрлэлд тулгарч буй бүхий л саад бэрхшээлийг шийдвэрлэнэ гэдэгт ихэвчлэн итгэдэг. Аймаг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хүлэмжийн аж ахуйг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, баялаг бүтээдэг бөгөөд эцсийн дүндээ зах зээлийн эрэлт, хэрэгцээг хангах хэрэгсэл гэж тусгасаар ирсэн. Гэвч хүлэмжийн аж ахуй эрхлэх боломж, бэрхшээлийг сайтар судалж үзвэл хүлэмжийн аж ахуй нь хэрэглэгчдийг эрүүл, шинэ ургацын хүнсний ногоогоор хангахад хамгийн тохиромжтой шийдэл биш бөгөөд эдийн засгийн төрөлжилт, хөгжилд чухал нөлөө үзүүлэхгүй байж магадгүй юм.

Хүлэмжийн аж ахуйн анхны хөрөнгө оруулалтын болон ашиглалтын үеийн өртөг зардал өндөр, хүлэмжийн аж ахуй эрхлэлт нь мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадварыг шаарддаг бөгөөд тариалах талбай жижгээс шалтгаалан үйлдвэрлэлийн хүчин чадал бага байдаг.

Ил талбайд болон хүлэмжид хүнсний ногоо тариалалтыг хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардал болон үйлдвэрлэлийн хүчин чадлын хувьд харьцуулбал зөвхөн ил талбайн тариалалт нь (i) хүнсний ногооны үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, (ii) орон нутгийн иргэдийн хүнсний хэрэгцээ болон зах зээлийн эрэлтийг хангах боломжтой нь нотлогдож байна.

Гэвч хүлэмжийн аж ахуйг зүй зохистойгоор эрхэлснээр (i) ургац авах хугацааг уртасгах (ii) тарьц, суулгац үржүүлж ил талбай дахь ургацыг нэмэгдүүлэх (iii) Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд дасан зохицоогүй хүнсний ногоо тариалах замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг төрөлжүүлэх (iv) шинэ ургацын хүнсний ногоогоор бага ч атугай хангах боломжийг олгоно.

Тиймээс хүнсний ногоог ил талбайд тариалах нь орон нутгийн хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэн тэргүүний зорилт байх бөгөөд усалгааны систем, хөрс элдэншүүлэх технологи, машин техник, хүлэмж зэргийг зөв хослуулан хөгжүүлэх хэрэгтэй.





Зураг: (1) Хэнтий аймгийн Хэрлэн сум дахь ил талбайн тариалалт (2) Архангай аймгийн Эрдэнэбулган сум дахь туннелийн хүлэмжид тариалсан ногоон сонгино

<u>Хүлэмж: уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, ургац авах хугацааг уртасгах хэрэгсэл</u>

Монгол Улсад зорилго, зориулалт, онцлогийн хувьд ялгаатай хэд хэдэн төрлийн хүлэмжийг ашиглаж байна. Үүнд:

<u>Туннелийн хүлэмж буюу зуны хүлэмж</u> нь метал хүрээтэй нийлэг хальсаар бүрхэгдсэн байдаг. Хамгийн түгээмэл хүлэмжүүд нь 60 ба 120 м2 талбайтай, ойролцоогоор 2 - 4 сая төгрөгийн үнэтэй байдаг.

Туннелийн хүлэмжүүд нь дулааны улиралд температурын хэлбэлзлийг бууруулж, улаан лооль, өргөст хэмх, чинжүү, хаш зэрэг хүйтэнд мэдрэмтгий хүнсний ногоо тариалах, ногоон сонгино, бууцай зэрэг навчит хүнсний ногоо тариалж, ургац авах хугацааг ойролцоогоор 2 долоо хоногоос 1 сар хүртэл уртасгах боломжийг олгоно.

Гэвч хүлэмж нь ургацыг хавар, намрын шөнийн хүйтрэлтээс хамгаалж чадахгүй. Эдгээр хүлэмжүүд нь ихэвчлэн (i) хашаандаа хүнсний ногоо тариалж буй өрхүүд (ii) ургац авах хугацааг уртасгахаар эрмэлзэж буй хүнсний ногооны жижиг тариалан эрхлэгчид (iii) хүнсний ногооны үйлдвэрлэлийг төрөлжүүлэхээр эрмэлзэж буй дунд хэмжээний тариаланчид (iv) мод үржүүлэгчдэд тохиромжтой.





Зураг: (1) Нарнаас хамгаалсан сүүдрэвч бүхий тунеллийн хүлэмж (ii) Дархан-Уул аймгийн чацаргана үржүүлгийн газар

Нарны эрчмээр ажилладаг хүлэмж (PSGH) нь эрчим хүчний хэмнэлттэй, Монгол орны уур амьсгалд тохирсон, Төв Ази болон Орос, Өвөр Монгол зэрэг улс орнуудад өргөнөөр ашиглагддаг хүлэмж юм.Тус хүлэмж нь орон нутгийн цаг уурын нөхцөл байдлаас хамааран ургамал ургалтын хугацааг 4 сараас 9-12 сар сунгах боломжийг олгодог. Нарны эрчмээр ажилладаг хүлэмж нь чанх өмнө зүг рүү харсан, хэт ягаан туяанд тэсвэртэй давхар плёнкан буюу Plexiglas нүүртэй, 3 тал нь дулаалга бүхий орон нутгийн материалаар барьсан хана, дээвэртэй. Энэхүү хүлэмж нь өдрийн цагаар шингээж авсан энергээ ашиглан шөнийн цагаар дулаанаа барьдаг.

Тариаланчид энэхүү хүлэмжид (i) хавар эрт суулгац үржүүлж, ил талбайд шилжүүлэн суулгаснаар эрт ургац авах, ургацыг нэмэгдүүлэх (ii) 3-р сараас эхлэн навчит болон үндэстэй хүнсний ногоо тариалах (iii) зуны улиралд жимс, хүнсний ногоо ургуулах (iv) намрын улиралд навчит болон үндэстэй хүнсний ногоо ургуулах (v) жилийн турш модны суулгац болон алим, чавга зэрэг хүйтэнд тэсвэргүй жимсний модыг тарьж ургуулах боломжтой. Монгол Улсад нарны эрчмээр ажилладаг 2 төрлийн хүлэмжийг ашигладаг. Тус хүлэмжийг Geres, ADRA зэрэг олон улсын байгууллагууд нэвтрүүлснээс гадна БНХАУ-ын компаниуд зардаг.

БНХАУ-ын нарны эрчмээр ажилладаг хүлэмж нь цэцэрлэгжүүлэлтийн үйлдвэрлэлд хамгийн тохиромжтой боловч 1 м2 нь 150 мянган төгрөгийн үнэтэй байгаа нь санхүүгийн чадавхтай томоохон компаниуд авах боломжтой юм. ТББ-ын нэвтрүүлж буй нарны эрчмээр ажилладаг хүлэмжийг барилгын машин механизмын шаардлагагүйгээр барих боломжтой (70 мянган төгрөг/м2) бөгөөд орон нутгийн цаг уурын нөхцөл болон тариаланчдын хэрэгцээнд тохируулан ашиглах боломжтой юм.




Зураг: Нарны эрчмээр ажилладаг хүлэмжийн 3D загвар (Geres INGO)



Зураг: (1) Архангай, Хэнтий аймгийн нарны эрчмээр ажилладаг хүлэмжийн гаднах болон доторх байдал (Geres)

Өвлийн хүлэмж нь ихэвчлэн халаалтын системийг суурилуулсан PSGH загварын хүлэмж юм. Байршил, суурилуулсан халаалтын системээс хамааран газрын гүний дулаан, дизель түлш эсвэл нүүрсээр халааж болно. Хүлэмжид гэрэлтүүлэг хийснээр жилийн турш ямар ч төрлийн хүнсний ногоо тариалах боломжтой. Гэвч анхны хөрөнгө оруулалтын болон ашиглалтын үеийн өртөг зардал маш өндөр тул зөвхөн нэмүү өртөг шингээсэн өндөр үнэтэй жимс, хүнсний ногоог (гүзээлзгэнэ) тариалахад ашигтай. Улаанбаатар хот орчимд орчин үеийн Голланд, Америкийн шилэн хүлэмжүүд баригдсан бөгөөд гидропоник арга технологиор тариалалт

хийдэг. Гэвч өндөр үнэтэй (1 сая ам.доллар/га) бөгөөд мэдлэг, туршлага шаардлагатай тул Монгол Улсын хүнсний ногооны үйлдвэрлэлд чухал хувь нэмэр оруулна гэж үзэхгүй байна.

2 Органик бордоо

- “Монгол орны газар тариалангийн үйлдвэрлэлд органик болон химийн бордооны нөлөөллийн харьцуулалт” (А. Жавхлантуяа нар, 2019) судалгаанд газар тариалангийн үйлдвэрлэлд бордоо хэрэглэснээр ургацыг нэмэгдүүлдэг талаар тусгасан. Хөдөөгийн малчдын өвөлжөө, хаваржаан дахь малын хашаа хороонд элбэг байдаг өтөг бууцыг компостлож (өтөг бууцыг бичил биетнээр исгэх, чийгийн улаан хорхой оруулах) орон нутагт бордоо үйлдвэрлэх боломжтой юм. Бордоог фермерүүд бие дааж хийхээс гадна хэд хэдэн фермерүүд хамтран бордооны овоолго хийх боломжтой. Үйлдвэрлэсэн бордоог бусад тариаланчид болон хөдөө аж ахуйн компаниудад зарах бөгөөд энэ нь орон нутагт ажлын байрыг бий болгоно. Хот, суурин газрын хог хаягдлыг зөв зохистой байдлаар цуглуулж, ангилан ялгаснаар органик хог хаягдлыг цуглуулах боломжтой.





Зураг: Сэлэнгэ, Хэнтий аймгийн бордооны үйлдвэрлэл



Зураг: Хэнтий аймгийн Хэрлэн суманд үйлдвэрлэсэн бордоог тариалан эрхлэгч хоршоодоор дамжуулан худалдан борлуулж буй нь

- Бордооны орц, хэрэглээ, менежмент нь (i) Олон улсын стандартчилалын байгууллагаас тогтоосон бордоо, хөрс ангижруулагч, ашигтай бодисын шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай. Мөн (ii) Бордоог *тогтвортой* ашиглах, зохицуулах *олон улсын ёс зүйн дүрэм* (НҮБ-ХХААНБ, 2019), (iii) Хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүний зах зээлийн зохицуулалтын журам болон Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль (2003), Хүнсний тухай хууль (2013), Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль(2013), Органик хүнсний тухай хуулийг (2016) мөрдөнө.

3 Усалгааны систем:

<u>Дуслын усжуулалт </u>нь ус, шим тэжээлийн бодисыг хэмнэж, хөрсний гадаргуугаас эсвэл шууд хөрсний гүнээс ургамлын үндсэнд аажмаар шингээдэг бичил усалгааны систем юм. Тус усалгааны системийн зорилго нь ус, шим тэжээлийн бодисыг ургамал бүрийн үндэсний бүсэд шууд хүргэж, ууршилтыг багасгах явдал юм. Дуслын усалгааны систем нь хавхлаг, хоолой, дуслагч зэргүүдийн тусламжтайгаар ургамлыг усалдаг.

Дуслын усалгааны систем нь дизайн, угсралт суурилуулалт, засвар үйлчилгээ, ашиглалтаас хамааран гадаргын усжуулалт, усалгаатай шүршигч зэрэг бусад төрлийн усалгааны системийг бодвол илүү үр дүнтэй байдаг. Монгол Улсад Хятад, Солонгос, Израйлын дуслын усалгааны системийг ашиглаж байна. Дуслын усалгааны системийн анхны хөрөнгө оруулалтын болон ашиглалтын үеийн өртөг зардал өндөр тул тариаланчид худалдан авах боломжгүй байгаа бөгөөд татаас, хөнгөлөлттэй зээл олгох хэрэгтэй.

<u>Төвийн эргэлтийн усалгааны систем нь</u> эргэлтийн тэнхлэгийг тойрон эргэлдэж, шүршигчээр усалдаг систем юм. Эргэлтийн цамхагийн эргэн тойронд эргэлдэж, хамрах хүрээндээ дугуй хэлбэрээр усалдаг. Ихэнх төвийн эргэлийн усалгааны систем нь усаар ажилладаг байсан бол одоо цахилгаан мотороор ажилладаг. Төвийн эргэлийн усалгааны систем нь усанд хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай. Энэхүү системийг томоохон фермийн усжуулалтад ашигладаг бөгөөд томоохон компаниуд л худалдан авах санхүүгийн боломжтой.





Зураг: (1) Архангай аймгийн Тариат сумын тунеллийн хүлэмжийн дуслын усжуулалтын систем; (2) Төв аймгийн Борнуур сумын ил талбай дахь дуслын усжуулалтын систем; (3) Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ил талбай дахь төвийн эргэлтийн усалгааны систем

Эдийн засгийн хөгжлийн зорилт, стратеги

Газар тариалан

Дээр дурдсанаар газар тариалангийн салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх нь тариаланчдын чадавхад нийцэхгүй гэж үзэж байна. Томоохон хөрөнгө оруулалтад болон томоохон аж ахуйн нэгжүүд МХХТ-ийг нэвтрүүлэн, ашиглах боломжтой.

Мал аж ахуй

Хөгжлийн стратеги

Бэлчээрийн менежмент. Сүүлийн 20 жилд малын тоо толгой өссөний улмаас бэлчээрийн даац хэтэрч улмаар газрын доройтолд хүргэж, малчдын амьдралын хэв маягт нөлөөлсөн зэрэг асуудлууд орхигдсон байна. Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх, малын тоог хянах нь мал аж ахуйн салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэл юм.

Эрчимжсэн болон хагас эрчимжсэн мал аж ахуй. Уламжлалт мал аж ахуй эрхлэх нүүдлийн соёл нь эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, малчдын бүлэг, хоршоог хөгжүүлэхтэй зөрчилдөж болзошгүй юм. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах АХБ-ны Төслийн баг нь оролцогч талуудтай эрчимжсэн болон хагас эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх боломжийн талаар хэлэлцсэн. Тухайлбал эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй Сэлэнгэ аймаг дахь Гачуурт компани болон Улаанбаатар хотын дээд зэрэглэлийн зоогийн газруудад үхрийн чанартай мах нийлүүлдэг хагас эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй Булган аймаг дахь Занаду Разорбак ХХК-ийн төлөөлөлтэй уулзаж ярилцсан. Гачуурт компани нь малчдыг олноор нь ажилд авдаг бол Занаду Разорбак ХХК нь уламжлалт мал аж ахуйг эрчимжсэн фермийн аж ахуйтай хослуулан хөгжүүлдэг. Тэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэлт нь Монгол соёл, зан заншилтай нийцдэггүйгээс иргэдийн эсэргүүцэлтэй тулгардаг, эрчимжсэн фермийн аж ахуйн талаарх мэдлэг хомс, сонирхол бага байдаг талаар дурдсан. Тиймээс АХБ-ны Төслийн баг малчдын хамтын хөдөлмөрт түшиглэн хагас эрчимжсэн мал аж ахуй (мал таргалуулах, фермийн аж ахуй) хөгжүүлэхийг зөвлөж байна.

Уул уурхай

*Уул уурхайн* салбар *нь Монгол улсын эдийн засгийн* гол *хөдөлгөгч хүч хэвээр*

*байна гэж үзэхгүй байна. Тиймээс уул уурхайн салбарын тогтворгүй байдал, уул уурхай ажиллах хүчин бага шингээдэг, уул уурхайн компаниудын барьж байгуулсан нийгмийн болон олон нийтийн барилга байгууламж, дэд бүтэц хангалтгүй байгааг харгалзан өөрчлөх боломжтой.*

*Усны хэрэглээ, хүртээмж нь уул уурхайн салбарт тулгамдаж буй гол сорилт юм. Ялангуяа усны хомсдолтой өмнийн говийн аймгуудын малчид болон уул уурхайн компаниудын хоорonд зөрчил үүсэж байна. Уул уурхайн компаниудын усны хэрэглээг сайтар хянаж, зохицуулах хэрэгтэй.* Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй усны бохирдол, амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл (тусгай хамгаалалттай газар нутаг болон хязгаарлалтын бүс дэх уул уурхайн үйл ажиллагаа), шороон замаар уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт ихэссэний улмаас бэлчээрийн доройтолд хүргэх зэрэг байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Цаашид уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хаах бэлтгэл ажлын хүрээнд уул уурхайн хотуудын эдийн засгийг төрөлжүүлэх стратегийг тодорхойлох шаардлагатай. Ашигт малтмалын ордын нөөц дуусаж, уурхай хаагдсаны дараах Хэнтий аймгийн Бэрх тосгон зэрэг жишээ бий. Монгол Улсын хоёр дахь том хот Эрдэнэт нь 30 орчим жилийн дараа ийм асуудалтай тулгарна. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр хаагдсаны дараа Эрдэнэт хотод тулгарах энэхүү асуудлыг шийдвэрлэх шаардлагатай бөгөөд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах нь чухал.

Боловсруулах аж үйлдвэр

Хөгжлийн стратеги

Доор дурдсан стратегийг нэмэх саналтай байна. Үүнд:

- Мал аж ахуй, газар тариалангийн салбарт нэмүү өртгийн нэгдсэн сүлжээг хөгжүүлнэ. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах төслийн мал аж ахуйн салбарт нэмүү өртгийн сүлжээ хөгжүүлэх загварыг харна уу.
- Аймгийн төвүүдийн агро-аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийг хөгжүүлж, хувийн хэвшлийг дэмжих санхүүжилтийн схемийг боловсруулна.
- Эрдэнэт, Дархан зэрэг томоохон хотуудын аж үйлдвэрийн парк байсан газруудыг (хуучин тогтолцооны үеийн) сэргээн засварлана.

Аялал жуулчлал

Хөгжлийн стратеги

Доор дурдсан стратегийг нэмэх саналтай байна. Үүнд:

- Үйлчилгээ үзүүлэгч орон нутгийн иргэдтэй хамтран хүртээмжтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, жуулчдад орон нутгийн бүтээгдэхүүнийг борлуулна.

Зам, тээвэр, логистикийн дэд бүтэц

Хөгжлийн стратеги

Доор дурдсан стратегийг нэмэх саналтай байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг хүргэх болон мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт хийхэд дэмжлэг үзүүлэх

зорилгоор сум дундын төвүүдийн зам, тээвэр, логистикийн дэд бүтцийг байжруулна[2].

Хот байгуулалт

Хөгжлийн стратеги

Доор дурдсан стратегийг нэмэх саналтай байна. Үүнд:

- Сонгогдсон зарим сумын төвүүдийг төрийн үйлчилгээ хүргэх, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих зангилаа болгон хөгжүүлнэ.

Байгаль орчны менежмент

Тайлбар: Бүлэг 2-т тусгасан байгаль орчны менежментийн асуудлуудаас өөр асуудлыг тодорхойлсон байна.

Хөгжлийн зорилт

Доор дурдсан стратегийг нэмэх саналтай байна. Үүнд:

- Усны менежмент (Бүлэг 2-той холбоотой дээрх санал, тайлбарыг харна уу)
- Хатуу хог хаягдал (Бүлэг 2-той холбоотой дээрх санал, тайлбарыг харна уу)

(5) Ойн доройтол: Ой мод нь ургамал, ус хамгаалах, зохицуулах онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд мал бэлчээх, хууль бусаар ашигт малтмал олборлох, хүний буруутай үйл ажиллагаа зэргээс хамааран ноцтой доройтсон. Нутгийн хойд хэсгийн ой мод нь мөнх цэвдэг, усны нөөцийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг бол өмнөд хэсгийн заган ой цөлжилтөөс хамгаалдаг.

Хөгжлийн стратеги

Доор дурдсан стратегийг нэмэх саналтай байна. Үүнд:

- Ус ашиглалт, хамгаалалт, менежмент (зохицуулалтын тогтолцоо, ус хангамжийн дэд бүтэц)

Усны нөөцийн менежмент, хөгжүүлэлт

- Хөгжлийн зорилт
- Монгол орны хэмжээнд усны нөөц жигд бус тархалттай. Ялангуяа *өмнийн говийн аймгууд усны хомсдолтой тулгарч байна.*
- Хөгжлийн стратеги
- Ус хангамжийн дэд бүтцийн төслүүд

**Бүлэг 4: Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний орон зайн төлөвлөлт**

Хотын зэрэглэл, хот, суурины газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Хотын зэрэглэл

Одоогийн байдал

ҮХЦТ-ний хүрээнд ЖАЙКА-гийн Төслийн багаас санал болгож буй хотын зэрэглэлийн талаар доор дурдав.

[2] It can be noted logistic infrastructures needed at inter-soum level are very basic (warehouses with parking infrastructure for agri-processing activities mainly). Only a few settlements along key transport & trade corridors need more advanced logistic infrastructures.

Хотын зэрэглэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд:

- Хүн амын тоо,
- Засаг захиргааны нэгжийн статус: Улсын нийслэл, аймгийн төв, бусад,
- Улаанбаатар хотод хүрэх боломж,
- Бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн (БДНБ),
- Хилийн боомт хүрэх боломж,
- Дэд бүтэц (гол зам, нисэх буудал, төмөр зам).

Санал болгож буй 4 түвшний хотын зэрэглэл:

- Улсын нийслэл хот: дэлхийн хот
- Бүсийн хөгжлийн төв хот нь эдийн засаг болон төрийн үйлчилгээг хэд хэдэн аймгуудыг хамран хүргэдэг олон чиг үүрэг бүхий хот юм.
- Орон нутгийн хөгжлийн төв хот нь орон нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих тусгай чиг үүрэг бүхий хот юм.
- Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот нь төрийн үйлчилгээ хүргэх чиг үүргийг түлхүү хэрэгжүүлнэ. Эдгээр хотуудын дор сумын төвүүд хөдөөгийн үйлчилгээний чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Одоогийн байдал (улс төрийн нөлөөлөлгүй)

| Хот | Хүн ам, 2018 | Хотын зэрэглэл |
|---|---|---|
| Улаанбаатарг+Налайх+ Зуунмод | 1,428,037 | Улсын нийслэл хот |
| Эрдэнэт + Булган | 111,251 | Бүсийн хөгжлийн төв хот |
| Дархан | 86,749 | Бүсийн хөгжлийн төв хот |
| Чойбалсан | 46,710 | Бүсийн хөгжлийн төв хот |
| Мөрөн | 40,510 | Орон нутгийн хөгжлийн төв хот |
| Өлгий | 36,024 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Арвайхээр | 31,917 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Баянхонгор | 31,308 | Орон нутгийн хөгжлийн төв хот |
| Улаангом | 31,279 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Ховд | 30,068 | Орон нутгийн хөгжлийн төв хот |
| Багануур | 29,512 | Орон нутгийн хөгжлийн төв хот |
| Даланзадгад | 25,998 | Орон нутгийн хөгжлийн төв хот |
| Сайншанд | 25,023 | Бүсийн хөгжлийн төв хот |
| Сүхбаатар | 23,151 | Бүсийн хөгжлийн төв хот |
| Цэцэрлэг | 22,138 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Өндөрхаан | 21,857 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Зүүнхараа | 20,191 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Алтай | 18,931 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Замын-Үүд | 18,930 | Орон нутгийн хөгжлийн төв хот |
| Баруун-Урт | 18,252 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Улиастай | 16,696 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Чойр | 12,773 | Орон нутгийн хөгжлийн төв хот |
| Мандалговь | 12,443 | Орон нутгийн хөгжлийн төв хот |
| Бор-Өндөр | 8,981 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Хархорин | 8,958 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Ханбогд | 7,200 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |
| Цогтцэций | 6,800 | Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот |

Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах АХБ-ны Төслийн багийн дээр дурдсан хотын зэрэглэлтэй холбоотой санал:

Хотын зэрэглэлийг тогтооход ашигласан шалгуур үзүүлэлтүүдийг дурдсан хэдий ч эдгээр шалгуур үзүүлэлтэд үндэслэн хотын зэрэглэлийг хэрхэн тогтоосон талаарх тайлбар байхгүй байгаа нь санал болгож буй хотын зэрэглэлийн талаар санал бодлоо илэрхийлэх болон санал нийлэх боломжгүй байдалд хүргэж байна. Ашигласан шалгуур үзүүлэлтүүд эргэлзээ төрүүлж байна. (1a) Улаанбаатар хотод хүрэх боломж, хилийн боомт хүрэх боломж, дэд бүтэц (гол зам, нисэх буудал, төмөр зам) гэсэн 3 шалгуур үзүүлэлт хамааралгүй байна. (1b) Монгол Улсын хотууд нь улс дотроо үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээс бус экспортлох үйл ажиллагаа (Улаанбаатар, Замын-Үүдээс бусад) явуулахгүй тул тэдгээрийг гол шалгуур үзүүлэлт гэж үзэхгүй (2) БДНБ-ийг (аймгийн хэмжээний эдийн засгийн үйл ажиллагаа) харгалзан үзсэн ч салбаруудаар (жишээлбэл уул уурхайн нөлөөлөл) авч үзээгүй (3) орон сууцны хангамж, үндсэн дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж зэрэг хотын асуудлудыг тусгаагүй байна.

Найлах, Зуунмод нь Улаанбаатар хотын дагуул хотууд юм. Зуунмод хот нь Улаанбаатараас 42 км зайтай, Налайх нь Улаанбаатараас 39 км зайтай оршдог. Эдгээр хотууд хоорондоо нийлээгүй, нутаг дэвсгэрийн нэгжид харьяалагдахгүй, нэгдсэн төлөвлөлт хийгддэггүй. Тиймээс Найлах, Зуунмодыг нийслэл Улаанбаатар хотын харьяа бус дагуул хотоор тодорхойлохыг зөвлөж байна.

Эрдэнэт, Булганы хувьд ижил саналтай байна. Булган хот нь Улаанбаатараас 60 км зайтай оршдог, эдгээр хотууд хоорондоо нийлээгүй, нутаг дэвсгэрийн нэгжид харьяалагдахгүй бөгөөд хүн амын хувьд эрс ялгаатай (Эрдэнэт хот 100 мянган хүн амтай, Булган хот 10 мянган хүн амтай). Хотын зэрэглэлийн хувьд Булганыг тусад нь авч үзэхийг зөвлөж байна.

Мөрөн хот нь Эрдэнэт, Дархан хотыг үл тооцвол Чойбалсан хотын дараа орох томоохон хот бөгөөд аймгийн эдийн засгийн төлөв байдал сайн, мал аж ахуй, аялал жуулчллын салбарыг хөгжүүлэх боломжтой. Мөн боловсруулах үйлдвэр, дээд сургууль зэрэг бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээтэй. Газар зүйн байршлын хувьд Төв болон баруун Монголыг холбох зангилаа хот юм. Мөрөн хотыг бүсийн хөгжлийн төв хотоор тодорхойлохыг зөвлөж байна.

Сүхбаатар хотыг бүсийн хөгжлийн төв хотоор тодорхойлсон байна. Тодорхойлсон үндэслэл нь ойлгомжгүй байна. Дархан, Эрдэнэт хот орчим 2 бүсийн хөгжлийн төв хотууд оршиж байна.

Бүсийн хөгжлийн төв хотоор тодорхойлох гол үндэслэл нь тухайн хотууд нь бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ёстой ("Бүсийн хөгжлийн төв хот нь эдийн засаг болон төрийн үйлчилгээг хэд хэдэн аймгуудыг хамран хүргэдэг олон чиг үүрэг бүхий хот юм") бөгөөд нэг бүсэд бүсийн хөгжлийн төв хотоор 2 хотыг тодорхойлсон нь эргэлзээтэй байна. Дархан, Эрдэнэт хотын хүн амын тоо, дэд бүтэц, үйлчилгээний цар хүрээний хувьд эргэлзээгүй. Харин Сүхбаатар хот нь нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ аймгийн төвүүдээс 13 дугаар байранд эрэмбэлэгддэг харьцангуй жижиг аймаг юм.

Төрийн үйлчилгээ хүргэх орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хотоор хэд хэдэн аймгийн төвийг тодорхойлсон байна. Энэ нь доор дурдсан аймгуудын хувьд эргэлзээтэй байна. Үүнд:

- Баян-Өлгий аймаг: Аймгийн төв нь Эрдэнэт, Дархан хотуудыг эс тооцвол хүн амын тоогоороо 3-р байранд ордог бөгөөд аймгийн эдийн засагт мал аж ахуйн салбар (хэд хэдэн мах боловсруулах үйлдвэртэй) гол байр эзэлдэг. Орон нутгийн хөгжлийн төв хотоор тодорхойлсон Ховд хоттой (болон бусад хоттой) харьцуулахад 2010-2018 онуудад тус аймгийн хүн амын тоо илүү, хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь өндөр байна.

- Увс: Улаангом хот хүн амын тоогоороо аймгийн төвүүдээс 3-р байранд ордог бөгөөд эдийн засагт мал аж ахуй, газар тариалангийн салбар гол байр эзэлдэг. Орон нутгийн хөгжлийн төв хот болон бүсийн хөгжлийн төв хотоор тодорхойлсон зарим хотуудаас Улаангом хотын үзүүлэлтүүд өндөр байна.

ЖАЙКА-гийн Төслийн багийн санал болгож буй одоогийн байдалд үндэслэсэн хотын зэрэглэл нь олон талаасаа эргэлзээ төрүүлж байгаа бөгөөд энэхүү хотын зэрэглэлийг тогтоосон үнэлгээний талаар нарийвчилсан мэдээлэл шаардлагатай байна.

<u>Улс төрийн нөлөөлөлтэй хотын зэрэглэлийн хэтийн төлөв (тухайлбал тойрог коридор)</u>

- Ховд, Баянхонгор хотууд бүсийн хөгжлийн төв хотоор тодорхойлогдсон.
- Өлгий, Улаангом, Улиастай хотууд орон нутгийн хөгжлийн төв хотоор тодорхойлогдсон.

Зураг 4.3.7, 4.3.8-д тусгасан хотын зэрэглэлийн талаар тодруулах шаардлагатай (зургийн таних тэмдэг ойлгомжгүй, санал болгож буй хотын зэрэглэл тохирохгүй байна).

<u>Хот, суурины эдэлбэр газрын тохиромжтой байдлын үнэлгээ</u>

Үүнийг хот, суурины хөгжлийн асуудалтай холбоотой эсэхийг тодорхойлоогүй байна.

<u>Орон зайн төлөвлөлт</u>

<u>Тойрог коридор</u>

Тойрог коридорын үндэслэл, үр ашиг тодорхойгүй байна. Тойрог коридорын чухал холбоос замууд хэдийнээ баригдсан. Ялангуяа хойд хэсгийн Сүхбаатар, Дархан, Эрдэнэт, Мөрөн хотуудыг холбосон авто замууд баригдсан бөгөөд Мөрөн-Улиастай чиглэлийн авто зам баригдаж байна. Мөн баруун-зүүн өмнөд тээврийн коридорыг холбосон Улиастай-Алтай чиглэлийн авто замын ажил явагдаж байгааг Зураг 4.11-д үзүүлээгүй байна. Өвөрхангай, Өмнөговь, Говьсүмбэр аймгууд нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдож, харилцдаг тул тэдгээрийг хооронд нь холбох асуудал эргэлзээтэй. Энэхүү бүсийн гол тээвэрлэлт Чойр, Өмнөговийн уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд цаашид Таван Толгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор энэ байдал өөрчлөгдөнө. Дархан-Өндөрхаан чиглэлийн авто зам нь тусгай хамгаалалттай газар нутгаар дайран өнгөрөх тул эргэлзээ төрүүлж байна.

Зураг 4.11-д үзүүлсэн энэхүү тойрог коридорыг одоо байгаа авто замын сүлжээнд түшиглэн барих бус харин авто замын урт, үнэ өртгийг тооцож авто замын төлөвлөлтийн үндэс суурь болох боломжтой. Ялангуяа тойрог коридорын баруун хэсэг (зүүн-баруун хэсгийг холбосон хэвтээ 2 тэнхлэгийг харна уу) болон зүүн-өмнөд хэсэгт хамаарна.

Монгол Улсын хүн амын нягтрал, алс хол зайг харгалзан үзвэл өргөн уудам нутаг дэвсгэрт чанартай дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор том хэмжээний тойрог коридорыг байгуулах нь ихээхэн эргэлзээ төрүүлж байна.

Нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэх зарим хот, суурин газруудад чанартай дэд бүтцийг хөгжүүлэхийг зөвлөж байна (archipelagos хөгжлийн загварыг үзнэ үү).

Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган аймгуудыг үйлдвэрлэлийн цөм бүс нутагт тооцож болох юм. Эдгээр аймгуудад өндөр чанартай дэд бүтцийг барьж байгуулахад шаардлагатай хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны төвлөрөл бий. Тус бүс нутаг нь Монгол Улсын ХАА-н үйлдвэрлэлийн гол бүс нутаг ба дэд бүтэц, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл хөгжсөн гурван том хот болох Улаанбаатар, Дархан, Эрдэнэт байрладаг. Мөн хамгийн их байгалийн нөөцтэй (усны нөөц, бэлчээрийн газар) бүс нутагт тооцогддог.

<u>Хойд бүс нутгийн ногоон коридор</u>

Хойд бүс нутгийн ногоон коридорын төлөвлөлтийг тодорхой тусгаагүй. Сэлэнгэ, Булган, Төв аймаг, Хэнтий, Завхан аймгийн зарим сумдад ХАА, газар тариалан эрхлэлтийг дэмжих, хөгжүүлэх хамгийн их нөөц бололцоотой болохыг тэмдэглэх нь чухал юм. Монгол Улсад газар тариалан, мал аж ахуйн салбарыг тогтвортой, ногоон бодлогын хүрээнд хөгжүүлэх нь энэ гурван аймагт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаанаас ихээхэн хамаарна. Эдгээр аймгуудын нутаг дэвсгэрийн нэлээд хэсэг хамгаалалтад байгаа нь аялал жуулчлал хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг болно. Аймгуудын бусад сумдад газар тариалан эрхлэхдээ байгалийн баялгийг нөхөн сэргээх, эргүүлэн ашиглах хэлбэрээр эрхэлнэ.

<u>Бэлчээрийн доройтол</u>

ХАНСХХ-ийн Төслийн багийн судалснаар бэлчээрийн доройтолтой холбоотой мэдээлэл, мэдээллийн санд хэд хэдэн хязгаарлалтууд байсан. Тиймээс ГЗБГЗЗГ болон бусад холбогдох агентлагууд үүнийг анхаарч үзэх шаардлагатай.

ХАНСХХ-ийн Төслийн багийн орон нутагт ажиллаж, нэгтгэсэн мэдээлэл, судалгааны үр дүнг харахад (Зураг 4.4.16-д үзүүлсэн) Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл, Сэлэнгэ, Булган аймгийн мэдээлэл бодит байдалд төдийлөн нийцгүй байна. Тухайлбал бэлчээрийн даац хэтэрсэн газарт бэлчээрийн хяналтыг төлөвлөөгүй гэх мэт орхигдсон асуудлууд байна.

## Бүлэг 6: Бүсчилсэн хөгжлийн алсын хараа, стратеги

Эдийн засгийн шинэ бүсчлэлийг тогтоох үндэслэл тодорхойгүй байна. Шинээр тогтоосон бүсүүд нь засаг захиргааны нэгж болохгүй тул үндэсний болон орон нутгийн хөгжлийг дэмжих чиг үүрэг бүхий нутаг дэвсгэрийг зөвхөн эдийн засгийн болон газар зүйн байршлын үүднээс харгалзан үзэж тодорхойлно.

Хүн амын нягтрал маш бага байдаг, суурин газрууд хоорондоо хол зайд байршилтай байдаг зэрэг нь бүсчилсэн хөгжлийн загварыг тодорхойлоход том сорилт болдог. Орон нутгийн зарим кластеруудыг тодорхойлж болох ч бүс нутгийн түвшинд хөгжлийн нийтлэг зорилтуудыг тодорхойлох нь хүндрэлтэй. Учир нь аймгууд (i) байгаль, нийгэм-эдийн засаг, соёлын болон бусад онцлог байдлаараа харилцан адилгүй байдаг, (ii) том газар нутагтай, олон жилийн турш өөрчлөгдөөгүй засаг захиргааны нэгж ба нягтрал бага, суурин газрууд хоорондоо

хол зайд байршилтай байдаг тул эдийн засгийн коридор байгуулах боломжийг ихээр хязгаарладаг.

ҮХЦТ-ний дүн шинжилгээнээс харахад нийтлэг шинж чанартай бүс нутгийг тодорхойлоход ихээхэн хүндрэлтэй юм. Тогтоосон бүс бүрт нийтлэг бус зүйлс байсан (Хүснэгт 6.2.1 “Санал болгож буй зургаан бүсийн үндсэн онцлогууд”-ыг үзнэ үү).

ХАНСХХ-т хөгжлийн ‘archipelagos model’ загварыг санал болгосон (ХАНСХХ-ийн тайланг үзнэ үү).

## Бүлэг 7: Аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ

Дараах хүснэгтүүдэд АХЧБТ-нд тусгасан аймгийн хөгжлийн чиг баримжааг баруун баганад ҮХЦТ-нд тусгасан аймгуудын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн саналыг зүүн баганад үзүүлэв. Мөн хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломжийг харьцуулан үзүүлэв.

<u>Аймгуудын хөгжлийн хэтийн төлөв</u>

<u>Сүхбаатар аймаг</u>

| **ҮХЦТ-нд тусгасан аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл** | | **АХЧБТ-нд тусгасан аймгийн хөгжлийн чиг баримжаа** |
|---|---|---|
| • Хариуцлагатай УУ-н үйл ажиллагаа | | • Уул уурхай |
| • Эрчимжсэн МАА эрхлэлт | | • МАА-н үйлдвэрлэл ба боловсруулах үйлдвэрлэл |
| • Замыг сайжруулж аялал жуулчлалыг хөгжүүлэх | | • Гадаад, дотоодын аялал жуулчлал |
| • МАА-н бүтээгдэхүүн, ахуйн бараа бүт., барилгын материал зэргийн төрөлжсөн боловсруулах үйлдвэрлэл | | • Хотын үйлчилгээ, дэд бүтэц (нийтийн болон арилжааны зориулалтаар) |
| • Бичигтийн хилийн байгууламжийг шинэчлэх | | • Бичигтийн олон улсын хилийн байгууламжийг шинэчлэх |
| | | • Хоёрдогч хотуудын дэд бүтцийг хөгжүүлэх |
| | | • Зам холболтыг сайжруулах |
| | | • Тогтвортой хөдөө аж ахуй, малын тэжээл үйлдвэрлэл |
| **ҮХЦТ <u>Зүүн бүсийн хөгжлийн хэтийн төлөв</u>:**<br>***Хөдөө аж ахуй-худалдаа-аялал жуулчлалыг хөгжүүлсэн хилийн бүс*** | | |
| • Эрчимжсэн МАА (мах, сүү үйлдвэрлэл) | | |
| • Хил дамнасан худалдаа | | |
| • ОХУ, БНХАУ-тай хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх | | |
| | | |
| **Байгалийн нөөц** | | |
| *Тулгарч буй асуудлууд:* | | *Тулгарч буй асуудлууд:* |
| • Нам дор газар, газрын доорх усны нөөц бага | | • Сийрэг газар, газрын доорх усны нөөц бага |
| • Ойн нөөц бага | | • Ойн нөөц тун бага<br>• Бүс нутгийн газрын доройтол |
| *Нөөц боломж* | | *Нөөц боломж* |
| • Олон тооны экологийн бүс нутаг | | • Олон тооны экологийн бүс нутаг |

<u>Хэнтий аймаг</u>

| **ҮХЦТ-нд тусгасан аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл** | | **АХЧБТ-нд тусгасан аймгийн хөгжлийн чиг баримжаа** |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| • Хариуцлагатай УУ-н үйл ажиллагаа | | • МАА, хүнс үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэл |
| • МАА-г малын тэжээл үйлдвэрлэлтэй хамтатган хөгжүүлэх | | • Газар тариалан эрхлэлт, боловсруулах үйлдвэрлэл |
| • Дотоодын зах зээлд зориулсан газар тариалангийн бүтээгдэхүүн болон мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | | • Сумдыг холбосон замын сүлжээ |
| • Аялал жуулчлалыг эрүүл мэндийн салбартай хослуулан хөгжүүлэх | | • Нутгийн иргэдэд түшиглэсэн (эко) аялал жуулчлал |
| • Аймгийн төв дэх хот байгуулалт | | • Аймгийн төв дэх хот байгуулалт |
| | | |
| **ҮХЦТ <u>Зүүн бүсийн </u>хөгжлийн хэтийн төлөв**<br>***Хөдөө аж ахуй-худалдаа-аялал жуулчлалыг хөгжүүлсэн хилийн бүс*** | | |
| • Эрчимжсэн МАА (мах, сүү үйлдвэрлэл) | | |
| • Хил дамнасан худалдаа | | |
| • ОХУ, БНХАУ-тай хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх | | |
| | | |
| **Байгалийн нөөц** | | |
| *Тулгарч буй асуудлууд:* | | *Тулгарч буй асуудлууд:* |
| байхгүй | | • Цэвдэг ихтэй |
| | | • Газрын доройтол |
| *Нөөц боломж* | | *Нөөц боломж* |
| • Усны нөөц ихтэй | | • Усны нөөц ихтэй |
| • Олон тооны экологийн бүс нутаг | | • Олон тооны экологийн бүс нутаг |

<u>Баянхонгор аймаг</u>

| **ҮХЦТ-нд тусгасан аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл** | | **АХЧБТ-нд тусгасан аймгийн хөгжлийн чиг баримжаа** |
|---|---|---|
| • Аймгийн төвийн хот байгуулалт | | • Аймгийн төв болон сонгогдсон сумдад үйлдвэрүүдийг хөгжүүлэх, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх |
| • Төвтэй ойр байршилд эрчимжсэн МАА эрхлэлт | | • Мал аж ахуй, ноолуурын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх |
| • Халуун рашаан, эмийн ургамлыг ашигласан эрүүл мэндийн аялал жуулчлал | | • Малын тэжээл үйлдвэрлэл |
| • Мал аж ахуй, жимс жимсгэнэ, ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл | | • Тогтвортой аялал жуулчлал |
| • Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэл | | • Сумдыг холбосон замын сүлжээ |
| | | • Хариуцлагатай УУ-н үйл ажиллагаа |
| | | |
| **ҮХЦТ <u>Алтайн бүсийн хөгжлийн хэтийн төлөв</u>:**<br>***Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлсэн, эрчим хүчний нөөц бүхий бүс*** | | |
| • МАА-н үйлдвэрлэл ба боловсруулах үйлдвэрлэл | | |
| • Төрөлжсөн газар тариалан эрхлэлт | | |
| • Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэл | | |
| | | |
| **Байгалийн нөөц** | | |
| *Тулгарч буй асуудлууд:* | | *Тулгарч буй асуудлууд:* |

| | | |
|---|---|---|
| • Гадаргын болон газрын доорх усны нөөц | | • Гадаргын болон газрын доорх усны нөөц |
| *Нөөц боломж:* | | • Хойд хэсгийн сумдад цэвдэгтэй |
| • Олон тооны экологийн бүс нутаг | | • Газрын доройтол, цөлжилт |
| | | *Нөөц боломж* |
| | | • Олон тооны экологийн бүс нутаг |
| | | • Халуун рашаан |

## Говь-Алтай аймаг

| **ҮХЦТ-нд тусгасан аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл** | | **АХЧБТ-нд тусгасан аймгийн хөгжлийн чиг баримжаа** |
|---|---|---|
| • Газрын гүний дулаан, нарны эрчим хүчийг ашигласан сэргээгдэх эрчим хүч | | • Замын холболт |
| • Хагас эрчимжсэн МАА | | • Мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг тогтвортойгоор хөгжүүлэх |
| • Зэрлэг онгон байгаль, өв соёлын урт хугацааны аялал жуулчлалыг хөгжүүлэх;<br>• Алтай хотыг аялал жуулчлалын бааз болгон урт хугацаагаар оршин суух аялал жуулчлал. | | • Малын тэжээл үйлдвэрлэл |
| • Хотын зах зээл рүү чиглэсэн хүлэмжийн аж ахуй эрхлэлт | | • Замын холболт, дэд бүтцийн хөгжлийг дагасан аялал жуулчлал |
| **ҮХЦТ <u>Алтайн бүсийн хөгжлийн хэтийн төлөв</u>:**<br><br>***Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлсэн, эрчим хүчний нөөц бүхий бүс*** | | |
| • МАА-н үйлдвэрлэл ба боловсруулах үйлдвэрлэл | | |
| • Төрөлжсөн газар тариалан эрхлэлт | | |
| • Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэл | | |
| | | |
| **Байгалийн нөөц** | | |
| *Тулгарч буй асуудлууд:* | | *Тулгарч буй асуудлууд:* |
| • Гадаргын болон газрын доорх усны нөөц | | • Гадаргын болон газрын доорх усны нөөц |
| *Нөөц боломж* | | • Газрын доройтол, цөлжилт |
| • Олон тооны экологийн бүс нутаг | | *Нөөц боломж* |
| | | • Экологийн бүс нутаг (Говийн их Дархан цаазат газрыг оруулсан) |

## Архангай аймаг

| **ҮХЦТ-нд тусгасан аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл** | | **АХЧБТ-нд тусгасан аймгийн хөгжлийн чиг баримжаа** |
|---|---|---|
| • Мал аж ахуйн үйлдвэрлэл, боловсруулалт | | • Газар тариалан |
| • Боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих хот, суурин газрын дэд бүтцийг хөгжүүлэх | | • МАА-н салбар, хүнс үйлдвэрлэл |
| • Малын тэжээлийн үйлдвэрлэл, нэгдсэн фермерийн аж ахуй эрхлэх | | • Хүртээмжтэй аялал жуулчлал |
| • Өвлийн амралтын газрууд, резорт бүхий байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх | | • Замын сүлжээг сайжруулах |
| • МХХТ | | |

| | | |
|---|---|---|
| | | |
| **ҮХЦТ** **<u>Хангайн бүсийн хөгжлийн хэтийн төлөв</u>:**<br><br>***Нийгэм, эдийн засгийн цогц хөгжлийг хангасан бүс*** | | |
| • Газар тариалан, МАА ба боловсруулалт | | |
| • ОХУ-тай холбосон аялал жуулчлал | | |
| • МХХТ | | |
| | | |
| **Байгалийн нөөц** | | |
| *Тулгарч буй асуудлууд:* | | *Тулгарч буй асуудлууд:* |
| | | • Баруун бүс нутагт цэвдэгтэй |
| *Нөөц боломж:* | | • Зарим газраар газрын доройтол бий |
| • Экологийн бүс нутаг | | *Нөөц боломж:* |
| • Гадаргын болон газрын доорх усны нөөц ихтэй | | • Экологийн бүс нутаг |
| | | • Гадаргын болон газрын доорх усны нөөц ихтэй |
| | | • Ойн сангийн нөөц ихтэй |

## Хөвсгөл аймаг

| **ҮХЦТ-нд тусгасан аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл** | | **АХЧБТ-нд тусгасан аймгийн хөгжлийн чиг баримжаа** |
|---|---|---|
| • Жимс, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн, махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх газар тариалан, мал аж ахуй эрхлэлт | | • Газар тариалан |
| • Дэд бүтцийг хөгжүүлэх, ойн санг нэмэгдүүлэх | | • МАА-н салбар, хүнс үйлдвэрлэл |
| • Байгаль, эрүүл мэнд, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх | | • Хүртээмжтэй аялал жуулчлал |
| | | |
| **ҮХЦТ** **<u>Хангайн бүсийн хөгжлийн хэтийн төлөв</u>:**<br><br>***Нийгэм, эдийн засгийн цогц хөгжлийг хангасан бүс*** | | |
| • Газар тариалан, МАА ба боловсруулалт | | |
| • ОХУ-тай холбосон аялал жуулчлал | | |
| • МХХТ | | |
| | | |
| **Байгалийн нөөц** | | |
| *Тулгарч буй асуудлууд:* | | *Тулгарч буй асуудлууд:* |
| | | • Цэвдэг ихтэй |
| | | • Хотын дэд бүтэц, систем хөгжөөгүй |
| *Нөөц боломж:* | | *Нөөц боломж:* |
| • Гадаргын болон газрын доорх усны нөөц ихтэй | | • Газрын гадарга жигд бус (уулархаг болон нам дор бүс нутаг) |
| • Экологийн бүс нутаг | | • Гадаргын болон газрын доорх усны нөөц ихтэй |
| | | • Хойд хэсгийн сумдад ой мод ихтэй |
| | | • Экологийн бүс нутаг ихтэй |

Сэлэнгэ, Дархан-Уул аймаг

| **ҮХЦТ-нд тусгасан 2 аймгийн хөгжлийн хэтийн төлөв** | | **АХЧБТ-нд тусгасан 2 аймгийн хөгжлийн хэтийн төлөв** |
|---|---|---|
| • Шинэ технологийг ашигласан газар тариалан эрхлэлт | | • Газар тариалан, МАА-н үйлдвэрлэл |
| • МАА | | • Агро бизнес |
| • ЖДҮ-ийг дэмжих | | • Мод боловсруулалт |
| • НИТАЖ (Сэлэнгэ) | | • АҮ, ЖДҮ-ийг дэмжих |
| • Бага оврын УЦС | | • Хотын дэд бүтэц, үйлчилгээ (Дархан-Уул) |
| • МХХТ | | |
| | | |
| **ҮХЦТ <u>Хангайн бүсийн хөгжлийн хэтийн төлөв</u>:** ***Нийгэм, эдийн засгийн цогц хөгжлийг хангасан бүс*** | | |
| • Газар тариалан, МАА ба боловсруулалт | | |
| • ОХУ-тай холбосон аялал жуулчлал | | |
| • МХХТ | | |
| | | |
| **Байгалийн нөөц** | | |
| *Тулгарч буй асуудлууд:* | | *Тулгарч буй асуудлууд:* |
| • Усны нөөц (Дархан-Уул) | | • Газрын доройтол |
| *Нөөц боломж:* | | *Нөөц боломж:* |
| • Гадаргын болон газрын доорх усны нөөц (Сэлэнгэ) | | • Гадаргын болон газрын доорх усны нөөц ихтэй (Сэлэнгэ) |
| | | • Ой мод ихтэй |

Булган, Орхон аймаг

| **ҮХЦТ-нд тусгасан 2 аймгийн хөгжлийн хэтийн төлөв** | | **АХЧБТ-нд тусгасан 2 аймгийн хөгжлийн хэтийн төлөв** |
|---|---|---|
| • Мал аж ахуй, үйлдвэрлэлийг хослуулсан нэгдсэн фермерийн аж ахуй эрхлэх | | • Агро бизнес |
| • Газар тариалангийн үйлдвэрлэл | | • Газар тариалан, МАА-н үйлдвэрлэл |
| • Боловсруулах үйлдвэрлэлийг төрөлжүүлэх | | • Мод боловсруулалт |
| • Хариуцлагатай уул уурхай | | • АҮ, ЖДҮ-ийг дэмжих |
| • Хотжилт | | |
| • Соёл, эрүүл мэндийн аялал жуулчлал | | |
| | | |
| **ҮХЦТ <u>Хангайн бүсийн хөгжлийн хэтийн төлөв</u>:** ***Нийгэм, эдийн засгийн цогц хөгжлийг хангасан бүс*** | | |
| • Газар тариалан, МАА ба боловсруулалт | | |
| • ОХУ-тай холбосон аялал жуулчлал | | |
| • МХХТ | | |
| | | |
| **Байгалийн нөөц** | | |
| *Тулгарч буй асуудлууд:* | | *Тулгарч буй асуудлууд:* |
| Усны нөөц (Орхон) | | • Усны нөөц (Орхон) |
| | | • Газрын доройтол (Булган) |

| *Нөөц боломж:* | | *Нөөц боломж:* |
|---|---|---|
| • Гадаргын болон газрын доорх усны нөөц (Булган) | | • Гадаргын болон газрын доорх усны нөөц ихтэй (Булган) |
| | | • Экологийн бүс нутаг |
| | | • Ойн сангийн нөөц ихтэй |

Завхан аймаг

| **ҮХЦТ-нд тусгасан аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл** | | **АХЧБТ-нд тусгасан аймгийн хөгжлийн чиг баримжаа** |
|---|---|---|
| • Экспортын зах зээлд нийлүүлэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт | | • Бүсүүдийг холбосон дэд бүтэц |
| • Хангайн дэд бүсийн аялал жуулчлалын кластертай уялдуулсан дотоодын аялал жуулчлал | | • МАА-н салбар, ЭЗ-ийн бааз |
| • Барилгын материал үйлдвэрлэл | | • Улиастай, Тосонцэнгэлийг хотжуулах |
| • МАА салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх, хөгжүүлэх | | |
| • Улаанбаатар болон аймгийн төвийг холбосон дэд бүтэц, институцийн/ захиргааны харилцаа холбоо | | |
| **ҮХЦТ <u>Хангайн бүсийн хөгжлийн хэтийн төлөв</u>:**<br>***Нийгэм, эдийн засгийн цогц хөгжлийг хангасан бүс*** | | |
| • Газар тариалан, МАА ба боловсруулалт | | |
| • ОХУ-тай холбосон аялал жуулчлал | | |
| • МХХТ | | |
| | | |
| **Байгалийн нөөц** | | |
| *Тулгарч буй асуудлууд:* | | *Тулгарч буй асуудлууд:* |
| | | • Цэвдэг ихтэй |
| | | • Бүс нутгийн газрын доройтол |
| | | • Аймгийн төвийн (Улиастай) хотын дэд бүтэц, үйлчилгээ сул |
| *Нөөц боломж:* | | *Нөөц боломж:* |
| • Экологийн бүс нутаг | | • Ойн сангийн нөөц ихтэй |
| | | • Гадаргын болон газрын доорх усны нөөц ихтэй |
| | | • Олон тооны экологийн бүс нутаг |

Хэлэлцүүлэг

Дээрх хүснэгтүүдэд нэгтгэсэн АХЧБТ-нд тусгасан аймгийн хөгжлийн чиг баримжааны төлөвлөлтүүд нь ҮХЦТ-нд тусгасан аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй маш сайн уялдаж байна. Мөн ҮХЦТ-нд тусгасан бүсийн хөгжлийн үзэл баримтлалд АХЧБТ-нд тусгасан хөгжлийн чиг баримжааны санаанууд тусгагдсан. АХЧБТ ба ҮХЦТ-ний төлөвлөлтийн ялгаатай, ижил төстэй байдлыг харьцуулсныг дараах байдлаар хураангуйллаа.

<u>Сүхбаатар:</u> Хөгжлийн ижил төстэй төлөвлөлтүүд тусгагдсан ба АХЧБТ-нд зарим нарийвчилсан төлөвлөлтийг тусгасан байна. ҮХЦТ-нд тусгасан бүсийн хөгжлийн

төлөвлөлтүүд АХЧБТ-тэй давхцаж байгаа ч илүү өргөн хүрээг хамарч байна.

Хэнтий: ҮХЦТ, АХЧБТ-нд тусгасан аймгийг хөгжүүлэх салбарууд нь ерөнхийдөө ижил байсан ба ҮХЦТ-нд уул уурхайн салбар, АХЧБТ-нд зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх төлөвлөлтүүдийг тус тус нэмж тусгасан байна. Мөн ҮХЦТ-нд тусгасан бүсийн хөгжлийн төлөвлөлтүүд АХЧБТ-тэй давхцаж байгаа ч илүү өргөн хүрээг хамарч байна.

Баянхонгор: Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх чиглэлээр ҮХЦТ нь аймгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаж байсан бол АХЧБТ-нд зам, тээврийн сүлжээ, хариуцлагатай уул уурхайн салбарыг хөгжүүлэх төлөвлөлтүүдийг тусгасан байна. ҮХЦТ-нд тусгасан бүсийн хөгжлийн үзэл баримтлалд АХЧБТ-ний төлөвлөлтийн саналууд багтсан.

Говь-Алтай: АХЧБТ-ний эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтууд нь ҮХЦТ-ний зорилтуудтай ижил байна. Харин ҮХЦТ-нд онцолсон сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх зорилт АХЧБТ-нд тусгагдаагүй. ҮХЦТ-нд газар тариалан, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх төлөвлөлтүүд, АХЧБТ-нд зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх төлөвлөлтүүдийг онцолсон.

Архангай: АХЧБТ, ҮХЦТ-нд ижил төстэй болон ялгаатай аймгийн хөгжлийн төлөвлөлтүүдийг тусгасан байна. 2 төлөвлөгөөнд аялал жуулчлал, мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжүүлэх төлөвлөлтүүдийг тусгасан. ҮХЦТ-нд МХХТ, хотын дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөлтүүд, АХЧБТ-нд зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх төлөвлөлтүүдийг онцолсон. ҮХЦТ-ний бүсийн хөгжлийн төлөвлөлтөд АХЧБТ-ний төлөвлөлтийн саналууд багтсан байна.

Сэлэнгэ, Дархан-Уул: 2 аймгийн АХЧБТ нь ҮХЦТ-нд тусгасан тус 2 аймгийн хөгжлийн төлөвлөлтийн саналуудтай уялдаж байна. АХЧБТ-нд мод боловсруулах үйлдвэрлэл, хотын дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөлтийг тусгасан. ҮХЦТ-нд аялал жуулчлал, МХХТ, бага оврын УЦС-ыг хөгжүүлэх төлөвлөлтийг санал болгосон. Мөн ҮХЦТ-ний бүсийн хөгжлийн төлөвлөлтөд АХЧБТ-ний төлөвлөлтийн саналууд багтсан байна.

Булган, Орхон: 2 аймгийн АХЧБТ нь ҮХЦТ-нд тусгасан тус 2 аймгийн хөгжлийн төлөвлөлтийн саналуудтай уялдаж байна. АХЧБТ-нд ЖДҮ-ийг дэмжих, мод боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх төлөвлөлтийг тусгасан бол ҮХЦТ-нд аялал жуулчлал, хариуцлагатай уул уурхай, хотыг хөгжүүлэх үйл ажиллагаа, төслүүдийг санал болгосон. Мөн ҮХЦТ-ний бүсийн хөгжлийн төлөвлөлтөд АХЧБТ-ний төлөвлөлтийн саналууд багтсан байна.

Завхан: АХЧБТ болон ҮХЦТ-нд хот байгуулалт (Улиастай, Тосонцэнгэл), Улаанбаатар хот, Улиастайг холбосон зам, дэд бүтцийн сүлжээг сайжруулах төлөвлөлтүүдийг тусгасан. ҮХЦТ-нд газар тариалан, МХХТ, дотоодын АЖ-ыг хөгжүүлэх төлөвлөлтийг тусгасан бол АХЧБТ-нд МАА, эдийн засгийн суурь салбарыг дэмжих төлөвлөлтийг тусгасан байна.

ҮХЦТ-нд байгалийн нөөц баялгийн боломж болон хязгаарлалтыг АХЧБТ-нд тусгасан шиг дэлгэрэнгүй тусгаагүй. ҮХЦТ-нд усны нөөц болон экологийн бүс нутгийг дурдсан.

ҮХЦТ-тэй харьцуулахад АХЧБТ нь сумын түвшинд хийсэн дүн шинжилгээ, хөгжлийн гол асуудлуудыг сумын түвшинд тодорхойлох сумдын типологийн судалгааг хийснээрээ ялгаатай. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөг илүү оновчтой байдлаар зарим сумдын түвшинд боловсруулж болох юм.

## Бүлэг 8: Гол төсөл, хөтөлбөр бүхий үе шаттай хөгжлийн төлөвлөгөө

Гол төсөл, хөтөлбөрүүд

Сайншанд, Замын-Үүд, Говийг холбосон аялал жуулчлалын гурвалжин

Энэ бүс нутагт аялал жуулчлал хөгжөөгүй бөгөөд аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж маш хязгаарлагдмал ба жуулчдыг татах газрууд төдийлөн байхгүй. Аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлт нь жуулчдыг татах байдлын судалгаа, шинжилгээнд үндэслэдэг.

Энэхүү төсөл нь ЖАЙКА-гийн Төслийн багийн “Газар тариалан, мал аж ахуй, уул уурхай, аж үйлдвэр, аялал жуулчлалын салбарын тайлан”-д тусгасан аялал жуулчлалын салбарын дүн шинжилгээтэй уялдаагүй (“5.1.4 Монгол Улсын аялал жуулчлалын салбарын онцлог, 5.2 Монгол Улсын аялал жуулчлалын хэтийн төлөв”-ийг үзнэ үү). ХАНСХХ боловсруулах төслийн дүн шинжилгээ нь тус тайланд тусгасан нөхцөл байдлын дүн шинжилгээнээс зөрүүтэй байна (тус тайлангийн дараах хэсэгт оруулсан тайлбарыг үзнэ үү).

Мандалговь-Чойр-Сайншандыг холбосон логистикийн коридор

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн шинэ төмөр зам нь нүүрс болон бусад уул уурхайн бүтээгдэхүүнийг БНХАУ, Улаанбаатар хот руу тээвэрлэх логистикийн шинэ коридор болно. Мөн Тавантолгойгоос Хатанбулаг хүртэл шинэ зам тавих ажлууд хийгдэж байна. Чойр хотын уул уурхайн бүтээгдэхүүний логистикийн төв болох одоогийн чиг үүрэг, үйл ажиллагаа хумигдана. Чойр болон Сайншанд/Зүүнбаянгийн логистикийн чиг үүргийг (төмөр замын болон авто тээвэр) оновчтой төлөвлөх нь чухал юм.

Мөрөн-Дарханыг холбосон худалдаа, аялал жуулчлалын коридор

Энэ бүс нутаг нь газар тариалан эрхлэх, тэр дундаа малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хамгийн нөөц боломж ихтэй бүс нутаг юм. Мөн малын тоо толгой их, бэлчээрийн даац ихтэй. Үүнээс гадна усны нөөц ихтэй ба Дархан, Эрдэнэт, Мөрөн хотууд байдаг тул хот, тээврийн дэд бүтэц хөгжсөн, Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто зам, төмөр замаар холбогдсон ба томоохон үйлдвэрүүд байдаг ганц бүс нутаг юм.

Тус бүс нутгийн өнөөгийн бүтээмж, нөөц нь Монгол Улсын өөр нутаг дэвсгэрт байхгүй ба үүнийг харгалзан үзэхэд зөвхөн худалдаа, аялал жуулчлалын коридор болгон хөгжүүлэх зорилт тавих нь хангалттай бус байж болох юм.

## Бүлэг 9: Гол төсөл, хөтөлбөрийн танилцуулга

Чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийг хөгжүүлэх

Байршил: Алтанбулаг ЧБ (Сэлэнгэ аймаг), Замын-Үүд ЧБ (Дорноговь аймаг), Цагааннуур ЧБ (Баян-Өлгий аймаг).

Тайлбар: Энэ гурван чөлөөт бүсэд их хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн ч одоогоор тодорхой үр дүнд хүрээгүй байна. Юуны өмнө эдгээр бүсийг хөгжлийн нөөц боломжийн хувьд харилцан адилгүй нөөцтэй гэж үздэг. Тухайлбал Замын-Үүдэд 900 га газрыг хөгжүүлэхээр төлөвлөж, 300 га газарт дэд бүтэц барьж байгуулсан ч үйлдвэр байхгүй. Харин Алтанбулаг, Цагааннуур чөлөөт бүсийг хөгжүүлэхээр хашлага тавиад удаж байгаа ч суурь дэд бүтцийг тавиагүй, мөн үйлдвэр барьж байгуулаагүй.

Хувийн хэвшлийг татах зорилгоор илүү прагматик, уян хатан санаачилгуудыг үе

шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр байршлуудад аж үйлдвэр хөгжүүлэх нөөцтэй гэж чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан. Эдгээр бүтээн байгуулалтыг ойролцоох байршилд төлөвлөгдсөн бусад бүтээн байгуулалттай уялдуулах шаардлагатай. Чөлөөт бүсийн бүтээн байгуулалттай холбоотойгоор дараах саналууд байна. Үүнд:

Алтанбулаг ба Сүхбаатар сум: Хоёр сум хоорондоо 25 км зайтай. Сүхбаатарт үйлдвэр, логистикийн бүс байдаг. Суурь дэд бүтэцтэй (ус, цахилгаан хангамж, хуурай боомт г.м.), хүн амын тоо багагүй (2018 оны байдлаар 23 мянга) буюу шаардлагатай ажиллах хүчний нөөцтэй, төмөр замтай (Алтанбулагаар дамждаггүй). Иймд аж үйлдвэр, логистик, МХХТ, үйлчилгээг Алтанбулагт бус Сүхбаатарт төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Замын-Үүд чөлөөт бүсэд 300 га газар дэд бүтцэд холбогдсон байгаа тул цаашид дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хийж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахын тулд институцийн болон зохицуулалтын тогтолцоог оновчтой бүрдүүлэхэд анхаарах нь чухал юм. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын механизм, хөнгөлөлтийн тогтолцоог хөгжүүлж илүү стратегийн төлөвлөлтийн арга барилыг боловсруулж, ашиглах нь чухал. Энэхүү хилийн боомтоор хамгийн их зорчигч, ачаа тээврийг хийдэг ба логистикийг хөгжүүлэх өндөр нөөц боломжтой.

Цагаануур чөлөөт бүсийг хөгжүүлэх асуудал нь бодитой эсэхийг сайтар судалж үзэх шаардлагатай. Энэ бүс нутагт зөвхөн хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Энэ төрлийн үйлдвэрүүдэд цогц дэд бүтэц, үйлчилгээ (мал эмнэлэг, лаборатори, малын өвчингүй эрүүл бүс, агропарк, тэжээлийн аж ахуй г.м.) шаардлагатай ба ажиллах хүч нь аймгийн төвд байгаа тул Өлгий хотоос 65 км зайд байрлалтай Цагааннуурт шаардлагатай байгууламжуудыг дахин барьж байгуулах нь үр ашиггүй байж болох юм. Мөн Цагааннуурт бүх төрлийн инженерийн шугам сүлжээ байхгүй ба хилийн боомтоор дамжин өнгөрөх ачаа, зорчигчийн хэмжээ бага. Цагааннуурт энэ төрлийн бүтээн байгуулалтыг хийх суурь нөхцөл, эрэлт хэрэгцээ бүрдээгүй байна. Тиймээс эхний ээлжинд Замын-Үүд ЧБ-ийг хөгжүүлж, дараа нь Алтанбулаг, Цагааннуур ЧБ-ийг хөгжүүлэх нь зүйтэй юм.

<u>Аж үйлдвэрийн кластерыг хөгжүүлэх</u>

Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх байршил: ямааны ноолуурын дийлэнх хувийг нийлүүлдэг говийн аймгуудад урьдчилсан боловсруулалт хийх үйлдвэрүүдийг (доорх тойм зургийг харна уу), ноосны гарц ихтэй аймагт (ж.нь: баруун аймгууд) мөн дээрх төрлийн үйлдвэрүүдийг барьж байгуулж болох юм. Энэ төрлийн үйлдвэрүүдийг түүхий эдийг үйлдвэрлэдэг байршилтай нь ойр байгуулснаар тээврийн зардлыг бууруулж, орон нутгийн эдийн засгийг дэмжиж, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах давуу талтай.




Агро парк, Үйлдвэрлэл технологийн паркуудыг хөгжүүлэх

Энэ төрлийн төслийг аж үйлдвэрийн кластерыг хөгжүүлэх үйл ажиллагаатай хослуулахыг санал болгосон. Аль аль нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах зорилготой.

Аж үйлдвэрийн кластерын үйл ажиллагааг дэмжих агро паркуудын байршлыг оновчтой тодорхойлох шаардлагатай. Агро паркуудын байршлыг тодорхойлох үндэслэл нь тодорхойгүй байгаа бөгөөд ХАНСХХ-ийн нутаг дэвсгэрийн судалгаа, шинжилгээтэй уялдаагүй байна. ХАНСХХ-т эдгээр агропаркийг 1-р зэрэглэлийн хот, суурин газарт тэргүүлэх чиглэлээр хөгжүүлэхийг санал болгосон.

Малын тэжээл үйлдвэрлэл, усжуулалтын систем

Энэ хоёр төслийг уялдуулаагүй. Малын тэжээлийн аж ахуйг хөгжүүлэхэд усжуулалтын систем шаардлагатай.

Шаардлагатай төслүүд

Хойд бүс нутгаас өмнөд бүс нутаг руу ус татах, дамжуулах төсөл байхгүй (БОАЖЯ-ны “Хөх морь” төслийг үзнэ үү).

Эрдэнэтэд уурхайн нөөц баялаг шавхагдсаны дараа хөгжүүлэх аж үйлдвэрийн төслүүд байхгүй байна.

**Газар тариалан, мал аж ахуй, уул уурхай, аж үйлдвэр, аялал жуулчлалын салбарын тайлан**

Газар тариалангийн салбар

Монгол Улсын ТХҮБ 2030

Зорилт 3. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ.

Тус Зорилтод хүрэхэд хүндрэлтэй байж болох юм. Тариалалтаас хамаарч агротехникийн дэвшилтэт технологи, усалгааны технологийг ашигладаг. Одоо ашиглагдаж буй усалгааны систем нь маш энгийн ажиллагаатай (ил усны суваг,

зарим дуслын усалгааны систем г.м.) ба ашиглалт, засвар үйлчилгээний зардал ихтэй тул улсын хэмжээнд цөөн тооны усалгааны систем ажиллаж байна. Малын тэжээл, үр тарианы үйлдвэрлэлийн хувьд (харьцангуй том хэмжээтэй) боломжтой ч хүнсний ногооны үйлдвэрлэлийн хувьд агротехникийн дэвшилтэт технологи, усалгааны технологийг ашиглахад хүндрэлтэй тул орон нутгийн жижиг аж ахуй эрхлэгчдэд энэ тал дээр дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Жишээлбэл автомат усалгааны системийг их хэмжээний хүнсний ногоо үйлдвэрлэгч компаниуд (ж.нь: Гацуурт) ашиглах боломжтой байж болох юм. Жижиг аж ахуй эрхлэгчдийн хувьд хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээг хийхэд хүндрэлтэй.

<u>Төрөөс баримталж буй газар тариалангийн салбартай холбоотой бодлого, хөтөлбөрүүд</u>

“Орон нутгийн нөөц баялгийг, тэр дундаа ХАА-н түүхий эд материалыг зөв зохистой, оновчтой ашиглах замаар хот, хөдөөгийн ялгаатай байдлыг арилгахад түлхэц үзүүлнэ.”

Тус зорилгод хүрэхийн тулд хүнсний ногоо, төмс, лууван, өвс тариалах, хадахад нутгийн иргэдийн тариалан эрхлэлтийг дэмжих нь чухал. Хөдөө, орон нутагт хийгдэж буй томоохон хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг (Гацуурт компанийн жишээ) Улаанбаатар хот болон бусад томоохон төв газруудад байрлалтай компаниуд хийж байгаа тул орон нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөө бага байна.

<u>Газар тариалангийн салбартай холбоотой бусад мэдээлэл</u>

<u>Газрын доройтол</u>

“Химийн бордоог их хэмжээгээр ашиглаж байгаатай холбоотойгоор газар тариалан эрхэлдэг өрхүүдтэй харьцуулахад аж ахуйн нэгжүүдэд нөхцөл байдал илүү хүндээр тусч байна.”

Хөрс элдэншүүлэлт, дан хөрс, салхины хамгаалалтгүй байх зэрэг нь илүү нөлөө үзүүлж буй шалтгаанууд юм.

“Тэг элдэншүүлэлт”

Энэ техникийг Монголын нөхцөлд ашиглах боломжтой гэдэгтэй санал нэгдэж байгаа ч эрдэмтэн, судлаачдын дунд хэрэглээ нь маргаан өрнүүлдэг глифосатыг их хэмжээгээр ашигладаг болохыг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Үүний нөлөө гол мөрөн болон газар доорх усанд ямар байх вэ гэдгийг судлах шаардлагатай. Мөн глифосатыг ашиглахаас өмнө нөлөөллийн үнэлгээний судалгаа хийх шаардлагатай.

<u>Хоршоод</u>

"Үйлдвэрлэлд илүү сайн орцыг нийлүүлэх"

Үйлдвэрлэл дэх орц, ялангуяа үр, бордооны орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжихийг зөвлөж байна.

<u>Хүлэмжийн аж ахуй</u>

“Хүлэмжийн нэгж талбайн үйлдвэрлэл өвлийн улиралд зуны улирлаас илүү их байдаг.”

Өвөл, зуны улирлын тариалалт өөр байдаг. Нэгж талбайд ноогдох үйлдвэрлэл хаврын улиралд хамгийн их байдаг ба хүлэмжийг тарьц, суулгацын үйлдвэрлэлд

ашигласан тохиолдолд ил талбайн ургацыг нэмэгдүүлдэг.

“Хүлэмжийн тариалалтыг өвлийн улиралд түлхүү хийхэд анхаарах хэрэгтэй.”

Өвлийн улиралд тарьсан хүнсний ногоо тэжээллэг чанар бага байдаг.

<u>Хөгжлийн чиглэл, зорилго, зорилтууд</u>

“Биомасс хийн генератор ашиглан агаараас ус үүсгэх”

Нүүрс ашигласан эрчим хүчний үйлдвэрлэлийн зардал маш бага байхад энэ технологийг түгээж, хэрэглээг нь нэмэгдүүлэх нь бодитой бус юм.

“Улаанбаатар хотын хүнсний хаягдлыг ашиглан бордоо хийх”

Улаанбаатар хот орчмын аж ахуйд хамааралтай. Бусад аж ахуйн хувьд тариаланчидтай хамтран ажиллаж, бууцны бордоог үйлдвэрлэлийн талбайн ойролцоо байрлалаас авах нь үр дүнтэй.

Бордоо үйлдвэрлэхэд өндөр технологи бүхий байгууламж шаарддаггүй. Үүнийг тариалан эрхлэгч бүр хийж, орон нутгийн нэмүү өртгийг нэмэгдүүлэх боломжтой. ХАНСХХ боловсруулах төслийн багийн судалснаар амжилттай хэрэгжсэн жишээнүүд байна. Хөрсний үржил шим, түүнийг сайжруулах менежмент, бордооны үйлдвэрлэлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

“Бага оврын азотын бордооны үйлдвэр”

Монгол дахь бууцын хэмжээг харгалзаж үзэхэд шаардлагагүй. Малчны хотхон бүрт азот байна.

“Хөрс элдэншүүлэх машин механизм”

Дээр дурдсанчлан энэ технологи нь их хэмжээний глифосат ашигладаг. Энэ технологийг ашиглаж болох ч хөрс, усны бохирдлыг хэрхэн аль болох бага байлгах вэ гэдгийг судлах шаардлагатай.

"Байгалийн мөсийг ашигласан мөсөн хөргүүр"

Монголд өвлийн улиралд нийлүүлэлтийн дулаан хэлхээ шаардлагатай. Япон технологийг ашиглаж болох ч газар доорх зоорь ашиглалттай харьцуулсан дүн шинжилгээ хийх шаардлагатай.

“МХХТ ашиглалт ба бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох технологи”, “Ухаалаг аж ахуй”

Тавигдах шаардлага: (1) орцын нэр, найрлагыг мэддэг байх шаардлагатай (ж.нь фермерүүд ашиглаж буй хятад пестицидийн найрлагыг төдийлөн сайн мэддэггүй); (2) үр ашигтай хяналтын тогтолцоог бий болгох.

Нисгэгчгүй онгоц ашиглах нь өндөр өртөгтэй бөгөөд тариаланчид хэрэглэж дадаагүй. Өөрөө удирдлагатай машин: засвар үйлчилгээг хэрхэн хийх вэ, ХАА-н салбарынханыг хэрхэн сургах вэ (Улаанбаатар хот болон томоохон суурин газруудаас бусад газарт механикч, электроникийн мэргэжилтнүүдийн хүртээмж бага).

Хөдөө аж ахуйн салбарт энгийн технологийг ухаалаг технологид тооцдог ба энэ нь Монголын нөхцөлд нийцэх технологи юм.

“Жимс жимсгэнэ”

Үндэсний хөгжлийн бодлого, стратегид чацаргана жимсний эдийн засаг, байгаль

орчны үр ашиг (хоол тэжээл+гоо сайхны бүтээгдэхүүн) хангалттай тусгагдаагүй байдаг.

"Хүйтэн гинжин хэлхээ: цахилгаанаар ажилладаг үндсэн хүйтэн агуулах"

Хүйтэн агуулах нь газар доорх зоорь бөгөөд үүнийг оросууд нэвтрүүлсэн. Зөвхөн гэрэлтүүлэгт л цахилгаан шаардлагатай.

МАА-н салбар

Эрчимжсэн МАА

Монгол Улсад эрчимжсэн МАА эрхлэлтийг нэмэгдүүлэх нь амаргүй байж болох юм. Эрчимжсэн МАА эрхлэх нь нүүдлийн мал аж ахуй эрхлэхээс өөр ба малчдын хөдөлмөр эрхлэлтийг хангаж чадахгүй. Тиймээс малчдын хөдөлмөр эрхлэлтийг хангасан хагас эрчимжсэн МАА эрхлэлтийг дэмжиж болох юм. Тухайлбал Улаанбаатар хотын тансаг зэрэглэлийн ресторануудыг чанартай үхрийн махаар хангадаг Булган аймагт байрлалтай “Xanadu Razorback” компанийг үүсгэн байгуулсан Канадын иргэн Жереми Тиссений боловсруулсан үйл ажиллагааны загвар байна.

ХАНСХХ боловсруулах төслийн багийн боловсруулсан санал болгож буй цогц загварыг “Мал аж ахуйд суурилсан нутаг дэвсгэрийн хөгжлийн загвар” танилцуулгад хураангуйлан үзүүлсэн.

Аялал жуулчлалын салбар

Аялал жуулчлалын салбарын тоо мэдээг бүрэн цуглуулж чаддаггүй гэдэгтэй санал нэгдэж байна.

Түүнчлэн улсын болон аймгийн түвшний төлөвлөлтийн баримт бичигт жуулчдыг ялангуяа гадаадын жуулчдыг татахуйц газруудыг оновчтой тодорхойлоогүй байдаг. ГЗБГЗЗГ-ын боловсруулсан зургаас харахад жуулчдын сонирхлыг бага татдаг эсвэл огт татдаггүй газрууд болон сонирхлыг ихээр татдаг газруудыг ялгаж үзүүлээгүй байгаа ба зарим байгалийн аялал жуулчлалын гол чиглэлүүдийг тодорхойлоогүй байна. Мөн байршил бүрийг тусад нь харуулсан нь аялал жуулчлалын кластерыг хөгжүүлэх үүднээс харахад дутагдалтай байна (ж.нь: хоёр байршил ижил зүйлээр жуулчдыг татах боломжтой ч нэг нь аялал жуулчлалын гол кластерт багтаж байгаа, хатуу хучилттай замаар холбогдсон бол энэ байршил илүү хөгжих боломжтойд тооцогдоно).

Аялал жуулчлалын байршлын нягтралд үндэслэсэн судалгаа (хуудас 5-22) нь аялал жуулчлалын үндсэн газрууд болон сонирхол бага татах газруудыг (ялангуяа гадаадын жуулчдын) ижил байдлаар авч үзсэн тул зохих үр дүн харагдахгүй байна.

Тиймээс бид дараах байдлаар ажилласан. Үүнд:

- Одоогийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхэд статистик мэдээлэл болон аялал жуулчлалын агентлагуудтай хийсэн ярилцлагад үндэслэсэн чанарын мэдээллийг хоёуланг нь ашиглах;
- Эрэлтийн шинжилгээнд үндэслэн жуулчдын сонирхлыг илүү татаж буй аялал жуулчлалын газруудыг тодорхойлох;
- Аялал жуулчлалын кластерын хандлагад үндэслэн аялал жуулчлалын газруудыг хөгжүүлэх боломжийг тодорхойлох;

- Орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжсэн тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх загвар боловсруулах.

# Бүлэг 6 ҮХЦТ-г сурталчлан таниулах үйл ажиллагаа

## 6.1 Сурталчлан таниулах семинар

### (1) ҮХЦТ-г сурталчлан таниулах семинар

ЖАЙКА-гийн Төслийн баг Монгол Улсад сүүлчийн томилолтоор ажиллах үеэр Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг оролцогч талуудад танилцуулах семинарыг зохион байгуулсан. Семинарын зорилгыг доор дурдав (Хавсралт А үзнэ үү). Үүнд:

1) ҮХЦТ-ний саналыг тусгаж, ХАНСХЕТ, БХҮБ-ын баримт бичгийг эцэслэн боловсруулж батлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ҮХЦТ-г сурталчлан таниулах;
2) ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй хөгжлийн загвар, алсын хараа, хөгжлийн стратегийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх;
3) ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй төслүүдийн талаар танилцуулж, дэмжүүлэн аль болох эрт хэрэгжүүлэх.

Семинарыг Новотел зочид буудалд танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. 50 оролцогч биечлэн, 100 орчим оролцогч цахимаар оролцсон. Семинарт Монгол болон Япон улсын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төлөөлөл, хэвлэл мэдээлэл, төрийн байгууллагуудын төлөөлөл, бие даасан зөвлөхүүд, АХБ-ны Төслийн багийн гишүүд, ЖАЙКА-гийн Төв байгууллагын Зөвлөх баг оролцов. Тус семинарт Булган, Хөвсгөл, Дорноговь, Сэлэнгэ, Увс, Говьсүмбэр, Хэнтий, Дундговь аймгийн төлөөлөл цахимаар оролцсон. Хавсралт В-д семинарт оролцогчдын нэрсийг үзүүлэв.

ЖАЙКА-гийн Токио дахь төв байгууллагын төлөөлөл семинарыг нээж үг хэлэв. БХБЯ/БХТ, ҮХГ-ын төлөөлөл болон ЖАЙКА-гийн Төслийн баг илтгэл тавьсны дараа ЖАЙКА-гийн зөвлөх баг тайлбар хийж, асуултуудад хариулсан. Профессор Ониши бүс нутаг, орон нутгийн түвшинд захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд эдийн засгийн салбарыг дэмжих МХХТ-ийг ашиглах ач холбогдлыг онцолсон. Профессор Күбота ҮХЦТ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийг тодорхойлоход хувь нэмэр болно гэдэгт итгэж байгаагаа илэрхийлэв. Профессор Сэта ҮХЦТ-г боловсруулахад оролцогч талуудын оролцооны аргыг ашигласан нь түүнийг хэрэгжүүлэхэд чухал болохыг онцлов. Семинарын хоёрдугаар хагаст БХБЯ, ҮХГ, БХТ, Төслийн баг панел хэлэлцүүлэг зохион байгуулж, БХБЯ-ны ХБГХБХЗГ-ын дарга модератор хийсэн бөгөөд семинарт оролцогчдын асуултад хариулт өгөв. ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга семинарын үйл ажиллагааг хааж, үг хэлэв.

Семинарт оролцогчдын саналыг QR код уншуулж авах талаар тайлбарлав. Хүснэгт 6.1.1-д семинарт оролцогчдоос ирсэн саналыг нэгтгэн үзүүлэв. Оролцогчид семинарыг үр дүнтэй болсон гэж үнэлсэн. 21 оролцогч асуултад хариулснаас 3 хүн маш үр дүнтэй, 10 хүн үр дүнтэй, 7 хүн дунд зэргийн үр дүнтэй, 1 хүн үр дүн муутай гэж үнэлсэн байна. ҮХЦТ нь Алсын хараа 2050-ын хэрэгжилтийг дэмжих төлөвлөлтийн баримт бичиг болох талаар оролцогчид мэдээлэл авч чадсан нь харагдаж байлаа. Семинарт оролцогчид ХАНСХЕТ, БХҮБ, ҮХЦТ зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоог

сайжруулах, олон нийтийн оролцоог хангах, ҮХЦТ-г сурталчлан таниулах, хэлэлцүүлэг хийх шаардлагатайг онцлов. Мөн төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь чухлыг тэмдэглэв.

**Хүснэгт 6.1.1 ҮХЦТ боловсруулах төслийн семинарт оролцогчдын санал, зөвлөмж**

| 1.Хүйс | 2. Байгууллага | 3. Таны хувьд энэхүү семинарыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? | 4. Хурлын зохион байгуулалтын талаар үнэлгээ өгнө үү? | 5. ҮХЦТөлөвлөгөөний танилцуулга (Илтгэгч Ц.Хашимото) -аас та ойлгосноо хуваалцана уу? | 6. ХАНСХЕТ-ийн танилцуулга (Илтгэгч С. Давааням) -аас та ойлгосноо хуваалцана уу? | 7. БХЗХ боловсруулах тухай болон БХҮБ-ын танилцуулга (Илтгэгч Д.Эрдэнэбаяр) -аас та ойлгосноо хуваалцана уу? | 8. ҮХЦТ, ХАНСХЕТ, БХҮБ зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүд хэрхэн уялдаж байгааг тодорхойлно уу? | 9. Монгол улсад олон төсөл хөтөлбөрүүд, бодлогын баримт бичгүүд боловсруулагдаж ирсэн боловч хөгжлийн олон асуудал тулгарсаар байгаа шалтгааныг юу гэж бодож байна ? | 10. Дээрх хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлснээр ирэх 10, 20 жилийн дараа Оролцогч таны болон бидний хойч үеийнхний амьдрал хэрхэн өөрчлөгдөх талаар таны төсөөлөл юу вэ? | 11. Цаашид ямар сургалт, хэлэлцүүлэг, хамтын ажиллагаа зохион байгуулах шаардлагатай вэ? | 12. Энэхүү хуралтай холбогдуулан санал бодлоо хуваалцана уу? |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Эр | Эрдэмтэн, Судлаач | Муу | Сайн | Ямар нэгэн төлөвлөгөө санал болгож байгаа юм байна. Гэсэн ч бүх зүйл Монголчуу | Хотын статусын нөхцөл байдлын тухай ярив. | Маш ойлгомжтой илтгэл байв. Хөгжлийн төвийг тодорхойлохдоо тодорхой онол | Уялдаа нь тодорхой ойлгогдохгүй байна. | Бодлого гэдэг бол зорилтот үйл ажиллагаа. Цаг үргэлж сайжирч боловсронгуй болж байх ёстой. | Улсын хөгжлийн зорилтын бичиг баримт нэгдэж гарч байгаа н сайн. Гэвч хэрэгжүүл | Энэ төлөвлөлтийн талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээ | Хурал хийж байгаа нь сайн хэрэг. Төлөвлөгөөн дотор дэвшилтэт технологи гэдэг үг |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | даас хамаарна гэсэн утгыг илэрхийлсэн. | | ашигласан нь сайн байв. | | Гэтэл энэ гэдрэг холбоо ажилладаггүй. Аль нэг ЗГ ямар нэг зорилго дэвшүүлээд л орхидог. Тиймээс хэн ч эргэж хөгжүүлдэггүй учраас бүх зүйл цаасан дээрээ түүхийгээрээ үлддэг. Анхандаа төлөвлөгөө боловсронгуй байх албагүй, чиг баримжаа өгдөг байхад л хангалттай. Тиймээс аливаа төлөвлөгөөнд тасралтгүй сайжруулалтын механизмтай байх нь чухал. | элтийг анхаарах хэрэгтэй. | р сайн сурталчлах шаардлагатай. Ингэснээр бодит олон талын оролцоо хангагдах юм. | олон гол газар дурдагдав. Гэтэл дэвшилтэт технологи гэж юу болох, түүнд шаардагдах дотоодын хүний нөөцийн нийлүүлэлт, түүний системийн бүтэц зэрэг нь тодорхой ороогүй байна. |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Эр | Эрдэмтэн, судлаач | Их сайн | Их сайн | Хотын зэрэглэл, статус болон эдийн засгийн шинэ бүсчлэлийн аргазүй, үндэслэл нь бусад судалгаан уудаас ямар ялгаатай вэ? | ХАНСХЕТ-ийн судалгааны нэгдсэн аргазүй, арга, аргачлалын талаар дэлгэрүүлж ярина уу. | Бүлэг суурингийн төвүүдийн тодорхойлохдоо нийгмийн шалгуур үзүүлэлтүүдэд эрүүл мэндийн, боловсролын болон соёлын салбарын барилга, байгууламжийн шинэ, хуучныг авч ашигладаг нь ямар үндэслэлтэй вэ? | ҮХЦТ болон БХБ-уудын эдийн засгийн бүсчлэл нь, ҮХЦТ болон ХАНСХЕТ нь хотуудын зэрэглэл, статус асуудлаар ойролцоо үр дүнтэй байна гэж ойлголоо. | Шалтгаан нь хэрэгжүүлэхэд шаарлагатай хөрөнгийн эх үүсвэрийг хангалттай тусгаж чадаагүй. | Өмнөх бодлогуудтай харьцуулахад илүү цогц болсноос гадна уялдаа холбоо нь сайжирсан учраас хэрэгжүүлж чадвал хөгжлийн түвшин сайжирна гэж найдаж байна. | Өнөөгийн байдлын судалгааг шинжлэх ухааны байгууллагаар хийлгэх шаардлагатай. | Хурлын талаар оролцогч бүрийн саналыг QR код ашиглан авсан нь хүн бүрийн оролцоог хангасан шинэлэг хэлбэр байна. |
| Эр | БХБЯ | Маш их сайн | Маш их сайн | Ирээдүйн хөгжилд их ач холбогдолтой төсөл. | Монгол Улс энэ бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулах шаардлагатай. | ХАНСХЕТ - тэй уялдуулах нь зүйтэй. | Эцэслэн сайтар нэгтгэх. | Уялдаа байхгүй. | МУ г эрчимтэй хөгжиж, бүс нутагтаа тэргүүлэх улс болно. | Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хамтын ажиллагааг тодорхой болгох чиглэлээр | Семинарын хугацаа богино байна |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Эм | Бусад албан тушаалтан | Их сайн | Их сайн | ҮХЦТ-ний эцсийн тайлангийн талаар | АНСХЕТ-ийн явцын талаар | Хөгжлийн бодлогын талаар | Боловсруулалтын түвшинд уялдаатай | Харилцан уялдаа холбоо муутай. ЗГ-ын бодлого тогтворгүй. | хариулаагүй | Олон нийтийг хамруулсан нэвтрүүлэг бэлтгэж танилцуулах | Маш чухал семинар боллоо |
| Эр | БХБЯ | Их сайн | Их сайн | Тийм | Тийм | Тийм | Зохион байгуулалт чухал | Бүтэц, систем | Улс төрийн шийдэл жигд байх хэрэгтэй | Дараагийн шатны төлөвлөлт шаардлагатай | Шийдвэр гаргагч нарт сайн ойлгуулах |
| Эм | ҮХГ | Их сайн | Их сайн | Алсын хараа 2050 бодлогийн баримт бичиг болон ҮХЦТ уялдаа, хэрэгжилтэд үзүүлж болох дэмжлэг. | Ажлын явц болон 89 хөгжлийн төвийг тогтоогоод байгааг | Бүсийн төвийг, тодорхойлох арга зүй болон БХБ ын төслийн танилцуулга. | Уялдуулах хэрэгтэй, 60-70 хувь уялдаж байна. | Хэрэгжилт хангалтгүй, хяналт шинжилгээ хийдэггүй. | Мэдэхгүй | Хэрэгжилтэд чиглэсэн, тогтвортой хөгжил, | Чухал мэдээлэл авлаа |
| Эр | Эрдэмтэн, судлаач | Маш их сайн | Маш их сайн | Алсын хараа 2050-г бодитоор хэрэгжүүлэх бодлогын бичиг баримт гэж | Төсөл судалгааны түвшинд явж байгаа гэж ойлголоо. | Улсын хэмжээнд хийсэн судалгаа, хөгжлийн чиглэлийн бичиг баримт гэж ойлголоо. | Бүсчлэл, тулгуур хотууд уялдаагүй байлаа. ҮХЦТ, БХҮБ-д 6 бүс байхад | Бодлогын бичиг баримтууд уялдаагүй. Давхардсан агуулгатай судалгаа олон хийгддэг. Орон нутаг | Бүсийн хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, орон нутгийн санхүүгийн бие даасан | Иргэдийн оролцоо, Нутгийн зөвлөл, Аймгуудын ЗДТГ-ын төлөөллийг оролцуулсан | Бүх илтгэлийн бичиг баримтыг урьдчилан тарааж, хэлэлцүүлгийн цагаа урт болговол |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ойлголоо. | | | ХАНСХЕТ-д 8 бүс байна. БХҮБ-д бүлэг суурин 83 байхад ХАНСХЕТ-д 89 байна. Тулгуур хот ҮХЦТ-нд 7 байхад ХАНСХЕТ-д Замын-Үүд Хархорины талаар түлхүү ярилаа | төвөөс хэт хараат учир төсөл хөтөлбөрүүд улс төрөөс их хамаардаг. | байдал бага хэвээр байвал БХБЯ-ны ХАНСХЕТ болон Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө өнөөс ихээхэн хамаарахаар харагдаж байна. ҮХГ болон Яамны үйл ажиллагааны давхардал, үүрэг, чиглэлийг тодотгох хэрэгтэй болов уу | хэлэлцүүлэг хэрэгтэй болов уу. | илүү үр дүнтэй байх болов уу. |
| Эр | Бусад албан тушаалтан | Их сайн | Их сайн | ХАНСХЕТ, БХҮБ баримт бичгийн суурь судалгаа | Судалгаа хийгдэн боловсруулалт бүрэн хийгдээгүй | ХАНСХЕТ-тэй нягт уялдан гаргасан загварыг хэрэгжүүл | Харилцан уялдаатай ажиллас ан гэх ч | Улс төрийн асуудал болон эдийн засгийн чадавхтай | Амьдрах орчин сайжран хот хөдөөгийн ялгаа | Төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг сайжруула | Хурлын мэдээлэл хангалттай ойлголт өглөө. |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зөвлөмж өгөх ҮХЦ төлөвлөгө ө гэж ойлголоо. | эцсийн хувилбар нь гараагүй төлөвлөгө ө байна. | ж бүс нутаг, орон нутгийн хөгжлийн эдийн засаг ажлын байрыг нэмэгдүүл эн үр дүн гаргах нь зүйтэй байна | яг харьцуул алт хийж уялдааг нь тодорхой лох шаардла гатай байна. | холбоотой гэж үзэж байна. | багасан, эдийн засгийн чадавх нэмэгдэхэ эр харж байна. | х тогтмол сургалтыг зохион байгуулах | |
| Эр | Бусад албан тушаал тан | Их сайн | Их сайн | | | | | | | | |
| Эм | Бусад албан тушаал тан | Их сайн | Их сайн | | | | | | | | |
| Эр | Эрдэмт эн судлаа ч | Сайн | Их сайн | | | | | | | | |
| Эр | БХБЯ | Их сайн | Их сайн | | | | | | | | |
| Эр | Эрдэмт эн судлаа ч | Сайн | Сайн | | | | | 1. Үндсэн хуулийн үзэл баримтлалт ай нийцсэн хөгжлийн хөтөлбөр , бодлогыг боловсруул | Хөгжлийн бодлогыг хэрэгжүүл сэнээр бий болох үр дүн иргэдийн амьдралд хэрхэн | | Нилээд хэд хэдэн удаа хийж аль болох олон иргэдийн саналууд ыг сонсвол |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | даггүй<br>2, Олон хөтөлбөр, бодлогуудаа, хуулиудаа хооронд нь уялдуулах арга, аргачлал байхгүй.<br>3. Оновчтой хэмжүүр үзүүлэлтүүдийг боловсруулж, хэрэглэдэггүй. | нөлөөлөх талаар дүгнэлт хийх загвар, хэмжүүр байхгүй байна. | | оновчтой. |
| Эр | Бусад албан тушаалтан | Их сайн | Сайн | Сайн.гэхдээ слайдын үсэг хэт их уншиж амжаагүй байсан | Их сайн | Их сайн | Тиймээ, холбогдож байгаа | Улс төрийн шалтгаан, тогтворгүй байдал | Сайжирна байх.Гэхдээ амьдралын өртөг их гарна байх | Шинэ сэтгэл санаа,технологит түшиглэсэн аж амьдрал | |
| Эм | Эрдэмтэн судлаач | Сайн | Их сайн | | | | | | | | |
| Эр | Бусад | Их сайн | Маш их сайн | . | | | | Бодлогын баримт бичгийн боловсруулалт харьцангуй | Улс орны хөгжил дэвшил, байгаль, орчин, нийгмийн | | Цаашид бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сайн хийгддэг. Харин хэрэгжүүлэх асуудал дээр маш муу байдаг. | үзүүлэлтүүд сайжирна гэсэн төсөөлөлтэй байна. | | байгууллага бүртэй хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж ажиллахаас гадна хөрөнгө, санхүүгийн асуудлыг Сангийн яам, ҮХГ зэрэг гол байгууллагууд урт хугацаагаар төлөвлөж ажиллах шаардлагатай. |
| Эр | Бусад албан тушаалтан | Сайн | Сайн | | | | | | | | |
| Эр | Бусад албан тушаалтан | Маш их сайн | Их сайн | | | | | Нэгдсэн цогц төлөвлөгөө байхгүй, бодлого нэртэй ч бодит байдалтай таардаггүй байсан | Хамгийн өндөр хувилбараар төсөөлж байна. Монголчууд хангалттай | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | цалинтай, харьцангуй эрүүл орчинд амьдарч, орон нутагтаа илүү сайхан амьдарч, орлого олох боломжууд нэмэгдсэн, Гадаадад байгаа Монголчууд ч эх орондоо ирж байгаагаар төсөөлж байна | | |
| Эр | Бусад албан тушаалтан | Их сайн | Сайн | | | | | | | | |
| Эр | Эрдэмтэн судлаач | Сайн | Сайн | ҮХЦТ-ний төлөвлөгөө судалгаа сайтай, цаашид төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд газар | | | уялдахгүй байна. | Олон яамдуудад нэг асуудлыг тал бүрээс нь салгаж бодлого болгоод байна. | Эдийн засгийн бүсчилсэн хөгжил нь ирээдүйд олон салбарт шинэчлэлт хийнэ. | | Энэ хэлэлцүүлэг цаг үеэ олсон арга хэмжээ болж байна. Шийдвэр |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нутгийн бүсчлэлийг нарийвчлан газын шугам байгууллагдахтай холбогдуулан тооцох. | | | | | Ялангуяа боловсролын салбарт. | | гаргагчдын түвшинд бодлогод тусгах нь чухал гэж бодож байна. |
| Эм | Бусад албан тушаалтан | Сайн | Сайн | Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө алсын хараа 2050 баримт бичгийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх хүчин зүйлсийн талаар | Орон нутгийн хөгжлийн бодлого цаашид хийгдэх ажил болон төлөвлөлт | Хэрхэн уялдаж ажиллаж буй болон хэн яг юу хийх, ямар үр дүнд хүрэх талаар илүү тодорхой болгох | Хөгжлийн олон асуудал дундаас хамгийн чухал нь аль хэсгийг тулгуур болгож харах иргэний оролцоо чухал гэдийг мэдрүүлэх | Хөтөлбөрүүд хоорондоо уялдах шаардлагатай | Онлайн орчинд ажиллах чадвар нь илүү хөгжсөн байх, асуудлыг шийдэхийн тулд технологиор шийддэг болсон байх | Жил бүр сайжраад явах саналуудыг авдаг байх цаашид тогтвортой байх | Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд иргэн бүрийн оролцоо чухал гэдийг мэдрүүлэх |

### (2) МХХТ-ийн инкубацийн талаарх семинар

Монгол Улсын урт хугацааны хөгжлийг хангахад мэдээллийн технологийн гүйцэтгэх үүрэг болон ҮХЦТ-ний хүрээнд бүх салбарт МХХТ-ийг нэвтрүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч байгааг харгалзан 2021 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр МХХТ-ийн инкубацийн талаарх семинарыг цахимаар зохион байгуулсан.

Семинарт үдээс өмнө мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Монголын тэргүүлэх ААН-үүд, ЖДҮ эрхлэгчид, гарааны бизнес эрхлэгчид оролцсон бол үдээс хойш Монгол Улсын мэдээллийн технологийн салбарт нэвтрэх сонирхолтой Японы тэргүүлэх ААН-үүд, ЖДҮ эрхлэгчид, гарааны бизнес эрхлэгчид оролцсон. Семинар зохион байгуулах төлөвлөгөөг Хавсралт С-д үзүүлэв. Семинарыг үдээс өмнөх болон үдээс хойшхи гэсэн 2 хэсэгтэйгээр зохион байгуулсан. Семинарт үдээс өмнө 70 орчим оролцогч, үдээс хойш 60 орчим оролцогч тус тус оролцсон.

Семинарын үеэр мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Монголын талын оролцогчид доорх асуудлыг хөндөв. Үүнд:

- Оюуны үйлдвэрлэлд мэдээллийн технологийн хэрэглээг нэвтрүүлж, Монгол Улсын имижийг бүрдүүлэх;
- COVID-19 цар тахлын нөлөөгөөр олон салбарт МХХТ-ийг ашиглах боломжийг нэмэгдүүлсэн;
- Цаг хугацаа ихээхэн шаардагддаг тул Монголын болон Японы компаниудын хооронд харилцаа холбоог хэрхэн тогтоох вэ; ЖАЙКА болон Монгол Улсын МХХТ-ийн салбарын одоогийн хамтын ажиллагааны нэг хэсэг нь гарааны бизнесийг дэмжих явдал гэдгийг тайлбарлав;
- Монголын болон Японы компаниудын хооронд бага зардлаар харилцаа холбоог тогтооход "Бизнесийн санаа/саналыг нягтлан баталгаажуулах" судалгааг хамтран хийх нь үр дүнтэй;
- Монгол Улсын банк, санхүү, даатгал зэрэг зарим салбарт МХХТ-ийн хэрэглээ сайн хөгжсөн;
- МХХТ-ийн хэрэглээг үр дүнтэй нэвтрүүлж, хөгжүүлэхийн тулд төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд МХХТ-ийн хэрэглээг ижил түвшинд хүргэх шаардлагатай;
- МХХТ-ийн хэрэглээг үр дүнтэй нэвтрүүлж, хөгжүүлэхэд төрийн байгууллага болон хувийн компаниудын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай; Тухайлбал худалдан авах ажиллагааг ил тод болгох, хялбарчлах замаар гарааны компаниудын мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй;
- МХХТ-ийн үйлчилгээний зах зээлийг хөгжүүлэхэд олон нийтэд мэдээллийн технологийн мэдлэг боловсрол олгох нь чухал.

Семинарын үеэр Японы талын оролцогчид Монгол Улс дахь МХХТ-ийн салбарын бизнесийн орчны талаар хэлэлцэв. Үүнд:

- Математик, компьютерийн шинжлэх ухааны олон улсын тэмцээнд Монголын оролцогчид өндөр амжилт үзүүлж байгаа нь Монголчууд мэдээллийн технологийн чиглэлээр бизнес эрхлэх чадвартайг илтгэж байна;

- Монгол Улс цахим засаглалыг хөгжүүлэх талаар Японоос илүү байж магадгүй юм;
- Венчур хөрөнгө оруулалтын (venture capital) хүртээмж хязгаарлагдмал тул гарааны бизнес эрхлэлтэд санхүүжилт татахад хүндрэлтэй;
- 4G хөдөлгөөнт холбооны системийг Улаанбаатар хот төдийгүй 21 аймаг, 330 сумд нэвтрүүлсэн хэдий ч аймаг, сумдад хүртээмж хязгаарлагдмал байна;
- COVID-19 цар тахлын улмаас цахим санхүүгийн үйлчилгээ, гүйлгээ хийх үйлчлүүлэгчдийн тоо ихээхэн нэмэгдсэн;
- Гадаадад ажиллаж, амьдарч байгаад буцаж ирсэн Монголчуудын гарааны бизнес эрхлэлт нэмэгдэж байгаа бөгөөд "Бизнесийн санаа/саналыг нягтлан баталгажуулах" үйл ажиллагаанд тулгуурлан ажиллаж байна;
- Монгол Улсын МХХТ-ийн зах зээл нь "Бизнесийн санаа/саналыг нягтлан баталгажуулах" хамгаалагдсан хязгаарлагдмал орчинд ажиллах боломжтой;
- Монгол Улсын гарааны бизнес эрхлэгчдийг Японы компаниудтай холбоо тогтооход Монгол-Японы Бизнесийн зөвлөл болон дундын оффис, ЖАЙКА-гийн гарааны бизнесийг дэмжих MonJa хөтөлбөрийн хүрээнд дэмжиж ажиллана;
- 5G хөдөлгөөнт холбооны системийг Монгол Улсад нэвтрүүлэх туршилт эхэлсэн хэдий ч хүчин чадал, хурд хязгаарлагдмал байгаагаас шалтгаалан хэрэглэх эсэх нь эргэлзээтэй байна;
- Олон нийтэд дижитал бичиг үсгийн мэдлэг боловсрол олгох шаардлагатай;
- МХХТ-ийн экосистемийг МХХТ-ийн хэрэглэгчдийг нэгтгэх замаар бэхжүүлэх хэрэгтэй.

ҮХЦТ-нд олон салбарт МХХТ ашиглахыг онцолсон ба эдгээр семинараас ҮХЦТ-г хэрэгжүүлэх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхтэй холбоотойгоор дараах асуудлуудыг анхаарч үзэх нь чухал. Үүнд:

1. Зарим салбарт МХХТ-ийн хэрэглээ Японтой харьцуулахад Монголд илүү байгаа бөгөөд COVID-19 цар тахлын нөлөөгөөр ҮХЦТ-нд санал болгосон хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, нийгмийн үйлчилгээ зэрэг олон салбарт МХХТ-ийг ашиглах боломж нэмэгдсэн;
2. Монгол хүний чадамжтай байдал, бүх сумыг 4G системд хамруулсан зэрэг нь МХХТ-ийг өргөн хүрээнд нэвтрүүлэх үндсэн нөхцөл болж байна;
3. ЖАЙКА нь гарааны бизнесүүд, бизнесийн санаа/саналыг нягтлан баталгаажуулах судалгааны төслүүдэд үзүүлдэг дэмжлэгээ цаашид ч үргэлжлүүлж, Монгол, Японы компаниудыг холбох замаар бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
4. Цаашид МХХТ-ийг ашиглахад (5G системийг нэвтрүүлэх) олон нийтэд мэдээллийн технологийн мэдлэг боловсрол олгох нь чухал бөгөөд ҮХЦТ-нд санал болгосноор МХХТ-д суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь үр дүнтэй байж болох юм.

## 6.2 ҮХЦТ-г сурталчлан таниулах видео танилцуулга

ҮХЦТ-г сурталчлан таниулах видео танилцуулга хийх ажлыг Монгол Улсын мэргэжлийн байгууллагуудын дунд тендер зарлаж, гэрээгээр гүйцэтгүүлсэн.

Сурталчилгааны видео танилцуулга хийх ажлын удирдамжийг Хавсралт D-д үзүүлэв.

Ажлын удирдамжид тусгасан зорилтуудыг доор дурдав. Үүнд:

1) ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг үр дүнтэй, сонирхолтой байдлаар видеогоор үзүүлэх
2) ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй төслүүдийн хэрэгжилтийг дэмжих.

Сонгон шалгаруулалтаар шалгарсан компани болон ЖАЙКА-гийн Төслийн баг харилцан зөвшилцөж сурталчилгааны видео танилцуулгыг хийсэн бөгөөд ажлын явцын дунд видеоны агуулга, хамрах хүрээг өөрчилсөн. ЖАЙКА-гийн хүсэлтийн дагуу ҮХЦТ-ний семинарын үеэр үзүүлэх богино хэмжээний видео танилцуулгыг бэлдсэн. Семинарын үеэр үзүүсэн богино хэмжээний видео танилцуулгыг нягталж, бүрэн хэмжээний видео танилцуулгыг бэлдсэн.

Хасралт А:

## Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн семинар

1. **Хугацаа:** 2021 оны 10 дугаар сарын 27 (Лхагва)
2. **Семинар зохион байгуулах газар:** Novotel зочид буудлын 4 давхрын хурлын танхимд (танхимын болон цахимаар хосолсон хэлбэрээр)
3. **Зорилго:**
   1) ҮХЦТ-ний саналыг тусгаж, ХАНСХЕТ, БХҮБ-ын баримт бичгийг эцэслэн боловсруулж батлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ҮХЦТ-г сурталчлан таниулах;
   2) ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй хөгжлийн загвар, алсын хараа, хөгжлийн стратегийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх;
   3) ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй төслүүдийн талаар танилцуулж, дэмжүүлэн аль болох эрт хэрэгжүүлэх.
4. **Семинарт оролцогчид:**

   Монгол Улсын холбогдох яамд, байгууллагуудын төлөөлөл, аймгуудын удирдлагын төлөөлөл, хувийн хэвшил, их, дээд сургууль болон залуучуудын төлөөлөл г.м
   ЖАЙКА, ЖАЙКА-гийн Зөвлөх хороо (ЖЗХ), ЖАЙКА-гийн Төслийн баг (ЖТБ)
5. **Хөтөлбөр:**

| **Нэр** | **Илтгэгч/оролцогчид** | **Цаг** |
|---|---|---|
| Семинарын нээлт | ЖАЙКА-гийн Токио дахь төв байгууллагын Нийгмийн дэд бүтцийн хэлтэсийн орлогч дарга А. Цубоике | 10:00 ~ 10:05 |
| Семинарын нээлт | БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн<br>ҮХГ-ын дарга Х.Батжаргал | 10:05 ~ 10:15 |
| Видео үзүүлэх | ЖАЙКА-гийн Төслийн баг | 10:15 ~ 10:20 |
| Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний танилцуулга | ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч Ц.Хашимото | 10:20 ~ 11:05 |
| Талархлын үг | ЖАЙКА-гийн Зөвлөх хороо | 11:05 ~ 11:15 |
| ҮХЦТ-тэй холбоотой асуулт, хариулт | Семинарт оролцогчид | 11:15 ~ 11:40 |
| Цайны завсарлага | | 11:40 ~ 11:55 |
| ХАНСХЕТ-ийн танилцуулга | БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат | 11:55 ~ 12:15 |
| БХЗХ боловсруулах тухай болон БХҮБ-ын танилцуулга | ҮХГ-ын Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Эрдэнэбаяр | 12:15 ~ 12:35 |
| ХАНСХЕТ, БХҮБ, БХЗХ-тэй холбоотой асуулт, хариулт | Семинарт оролцогчид | 12:35 ~ 13:05 |
| Панел хэлэлцүүлэг | БХБЯ, БХТ, ҮХГ, ЖАЙКА-гийн Төслийн баг | 13:05 ~ 13:55 |
| Семинарын хаалт | ЖАЙКА-гийн Суурин төлөөлөгч Э.Тамүра, БХБЯ | 13:55 ~ 14:00 |

| | | |
|---|---|---|
| Өдрийн зоог | | 14:00 ~ |

Хавсралт В:

**ҮХЦТ боловсруулах төслийн семинарт оролцогчдын нэрсийн жагсаалт**

Огноо: 2021/10/27

Хугацаа: 10:00～14:00

Байршил: Новотел зочид буудал ( Танхим болон онлайн)

Семинарын сэдэв: **ҮХЦТ боловсуулах төслийн семинар**

| No. | Нэр | Байгууллага | Албан тушаал | Оролцсон байдал |
|---|---|---|---|---|
| 1 | Б. Гүнболд | БХБЯ | Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга | Танхим |
| 2 | Д. Бэлэгсайхан | БХБЯ | ХБГХБХЗГ-ын ахлах шинжээч | Танхим |
| 3 | С. Дэнсмаа | БХБЯ | ХБГХБХЗГ-ын шинжээч | Танхим |
| 4 | Г. Балжмаа | БХБЯ БХТ | Судлаач | Танхим |
| 5 | Эрико Тамура | ЖАЙКА | Монгол дахь төлөөлөгчийн газар | Танхим |
| 6 | Тайга Койзүми | ЖАЙКА | Монгол дахь төлөөлөгчийн газар | Танхим |
| 7 | Б. Заяа | ЖАЙКА | Монгол дахь төлөөлөгчийн газар | Танхим |
| 8 | Тасүкэ Ёшида | ЖАЙКА | Монгол дахь төлөөлөгчийн газар | Танхим |
| 9 | Е. Дондмаа | АХБ, AHURP төсөл | Зөвлөх | Танхим |
| 10 | Гантөмөр | БХБЯ | Шинжээч | Танхим |
| 11 | Мөнгөнчимэг | АХБ, ХАНСХХ төсөл | Хот төлөвлөгч | Танхим |
| 12 | Стефан Милхауд | АХБ, ХАНСХХ төсөл | Төслийн ахлагч, Хот төлөвлөгч | Танхим |
| 13 | Н. Энхзул | | Продюссер | Танхим |
| 14 | С. Давааням | БХБЯ, БХТ | Хэлтсийн дарга | Танхим |
| 15 | Л. Долгор | Залуу судлаачдыг дэмжих сан | Судлаач | Танхим |
| 16 | Алтанбагана | ШУА, Газар зүй, геоэкологийн хүрээлэн | Судлаач | Танхим |
| 17 | Г. Лувсанжамц | Токиогийн их сургууль | | Танхим |
| 18 | Н. Наранцацралт | ҮХГ | мэргэжилтэн | Танхим |
| 19 | Ш.Энхцэцэг | АХБ, ХАНСХХ төсөл | Төслийн дэд ахлагч | Танхим |
| 20 | Х. Оюунбаяр | ГЗБГЗЗГ | Хэлтсийн дарга | Танхим |
| 21 | Н. Шинэ-Оргил | ГЗБГЗЗГ | Хэлтсийн дарга | Танхим |
| 22 | Чинбат | МУИС | Профессор | Танхим |
| 23 | Д.Эрдэнэбаатар | МУИС | Профессор | Танхим |
| 24 | О. Одгэрэл | ЗТХЯ | Шинжээч | Танхим |
| 25 | Ц. Отгонхүү | ШУА, Газар зүй, геоэкологийн хүрээлэн | Судлаач | Танхим |
| 26 | М. Баяржаргал | ШУА, Газар зүй, геоэкологийн хүрээлэн | Судлаач | Танхим |

| No. | Нэр | Байгууллага | Албан тушаал | Оролцсон байдал |
|---|---|---|---|---|
| 27 | М. Амаржаргал | ҮХГ | Гэрээт ажилтан | Танхим |
| 28 | Б. Оюунтүлхүүр | ҮХГ | Гэрээт ажилтан | Танхим |
| 29 | Б. Бямбажав | БХБЯ | Зөвлөх | Танхим |
| 30 | Ц.Ихбаяр | ГЗБГЗЗГ | Ахлах мэргэжилтэн | Танхим |
| 31 | Б. Одбаатар | ГЗБГЗЗГ | Ахлах мэргэжилтэн | Танхим |
| 32 | Ж. Номин | Залуу судлаачдыг дэмжих сан | Захирал | Танхим |
| 33 | Д. Ганзориг | Unread | Нийтлэлч | Танхим |
| 34 | А.Нармандах | ҮХГ | Мэргэжилтэн | Танхим |
| 35 | Д. Болормаа | БХБЯ | Ахлах шинжээч | Танхим |
| 36 | Ш. Гэрэлээ | ХААИС | Мэргэжилтэн | Танхим |
| 37 | Ц. Баярбат | БХБЯ | ХБГХБХЗГ-ын дарга | Танхим |
| 38 | С.Дэнсмаа | БХБЯ | Шинжээч | Танхим |
| 39 | Цүёоши Хашимото | ЖАЙКА-н Төслийн баг | Төслийн ахлагч | Танхим |
| 40 | Ц. Тунгалаг | ЖАЙКА-н Төслийн баг | Үндэсний ахлагч | Танхим |
| 41 | Мариэ Такетани | ЖАЙКА-н Төслийн баг | Зөвлөх | Танхим |
| 42 | Б. Болорчимэг | ЖАЙКА-н Төслийн баг | Зөвлөх | Танхим |
| 43 | Б.Мөнгөнсаран | ЖАЙКА-н Төслийн баг | Орчуулагч | Танхим |
| 44 | Ж. Болормаа | ЖАЙКА-н Төслийн баг | Зохицуулагч | Танхим |
| 45 | Баянтуул | | Синхрон орчуулагч | Танхим |
| 46 | Баатар | Орчуулга | Төхөөрөмж хариуцагч | Танхим |
| 47 | С. Орхон | ХНХЯ | Мэргэжилтэн | Танхим |
| 48 | Одгэрэл | Орчуулга | Төхөөрөмж хариуцагч | Танхим |
| 49 | Д. Эрдэнэбаяр | ҮХГ | Хэлтсийн дарга | Танхим |
| 50 | Рэнчинбазар | Алсын хараа 2050 | Зөвлөх | Танхим |
| 51 | Казүсама Санүй | ЖАЙКА-н төв байгууллага | Орлогч захирал | Онлайн |
| 53 | Күбота | ЖАЙКА-н Зөвлөх Хороо | | Онлайн |
| 54 | Ониши | ЖАЙКА-н Зөвлөх Хороо | Дарга | Онлайн |
| 55 | Кобэ Нобүюки | ЖАЙКА-н төв байгууллага | | Онлайн |
| 56 | Угтахбаяр | ЗТХЯ | | Онлайн |
| 57 | Ф. Сэта | ЖАЙКА-н Зөвлөх Хороо | | Онлайн |
| 58 | Даваацэрэн Нармандах | Токиогийн их сургууль | | Онлайн |
| 59 | П. Мөнгөнчимэг | | | Онлайн |
| 60 | Тамираа | | | Онлайн |
| 61 | Эрдэнэчулуун | ХААИС | | Онлайн |
| 62 | Хүний хөгжил судалгаа, сургалтын төв | ТББ | | Онлайн |
| 63 | Мөнхчулуун | | | Онлайн |
| 64 | Угтахбаяр | ЗТХЯ | | Онлайн |
| 65 | Л. Сугар | ҮХГ | | Онлайн |
| 66 | Б. Ганцоож | Удирдлагын академи | | Онлайн |

| No. | Нэр | Байгууллага | Албан тушаал | Оролцсон байдал |
|---|---|---|---|---|
| 67 | Алтантуяа | БШУЯ | | Онлайн |
| 68 | Л. Долгор | БХТ | | Онлайн |
| 69 | О. Чинбаяр | ГЗБГЗЗГ | | Онлайн |
| 70 | Г. Мөнхзул | ГЗБГЗЗГ | | Онлайн |
| 71 | Галаарид | “Технож” Бизнес Инкубатор Төв | | Онлайн |
| 72 | Цэенханд | ШУА, | | Онлайн |
| 73 | Увс аймаг | ГЗБГЗЗГ | | Онлайн |
| 74 | Д. Мөнхсайхан | БОАЖЯ | | Онлайн |
| 75 | Бямбасүрэн | Удирдлагын академи | | Онлайн |
| 76 | Анхбилэг | | | Онлайн |
| 77 | А. Пүрэвсүрэн | | | Онлайн |
| 78 | Энхболд | Хот төлөвлөлт, судалгааны институт | | Онлайн |
| 79 | Н. Шинэ-Оргил | ГЗБГЗЗГ | ХБХ-ийн дарга | Онлайн |
| 80 | Золооноо | | | Онлайн |
| 81 | БХТ | | | Онлайн |
| 82 | Түвшинтөгс | Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн | | Онлайн |
| 83 | Ш. Нарантуяа | БШУЯ | | Онлайн |
| 84 | Номин-Эрдэнэ | ГЗБГЗЗГ | | Онлайн |
| 85 | Д. Алтанзагас | ГЗБГЗЗГ | | Онлайн |
| 86 | Бэрцэцэг | ҮХГ | | Онлайн |
| 87 | Булган аймаг | ГХБХБГ | | Онлайн |
| 88 | Хөвсгөл аймаг | ГХБХБГ | | Онлайн |
| 89 | Тэгшбаяр Сундуйжав | | | Онлайн |
| 90 | Билэгдэлгэр | Дорноговь аймаг | ГХБХБГ | Онлайн |
| 91 | Цүбоикэ Асука | ЖАЙКА-н төв байгууллага | Нийгмийн дэд бүтцийн хэлтсийн орлогч дарга | Онлайн |
| 92 | Мөнхзул | | | Онлайн |
| 93 | Түмэндэлгэр | | | Онлайн |
| 94 | Баярбилэг Алтансүх | | | Онлайн |
| 95 | Энх-Эрдэнэ | ГЗБГЗЗГ | | Онлайн |
| 96 | Б. Хангал | Сэлэнгэ аймаг | ГХБХБГ | Онлайн |
| 97 | Булган | | | Онлайн |
| 98 | Чимэгээ | Говьсүмбэр аймаг | ГХБХБГ | Онлайн |
| 99 | Бэгзсүрэн | МУИС | | Онлайн |
| 100 | Д. Жаргалсайхан | Залуу судлаачдыг дэмжих сан | | Онлайн |
| 101 | Мэндсайхан | | | Онлайн |
| 102 | Содчимэг | | | Онлайн |
| 103 | Дорноговь | | | Онлайн |
| 104 | Нямбаяр | Хөвсгөл аймаг | ГХБХБГ | Онлайн |
| 105 | Баярхүү | Хэнтий аймаг | ГХБХБГ | Онлайн |
| 106 | Б. Батдэмбэрэл | ШУТИС | | Онлайн |
| 107 | Л. Оюунчимэг | ҮХГ | | Онлайн |

| No. | Нэр | Байгууллага | Албан тушаал | Оролцсон байдал |
|---|---|---|---|---|
| 108 | Билэгээ | Хэнтий аймаг | ГХБХБГ | Онлайн |
| 109 | Ж.Эрхэмтөгс | | | Онлайн |
| 110 | Нацагням | Соёлын яам | | Онлайн |
| 111 | Ганзориг | Говьсүмбэр | ГХБХБГ | Онлайн |
| 112 | Б. Наранбат | Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл | | Онлайн |
| 113 | Угантуяа Энхбаяр | | | Онлайн |
| 114 | Б. Данаасүрэн | Удирдлагын академи | | Онлайн |
| 115 | Үүрцайх | ЗГХЭГ | | Онлайн |
| 116 | Эрдэнэбаатар Дашдондог | | | Онлайн |
| 117 | Мөнх-Эрдэнэ | ЗГХЭГ | | Онлайн |
| 118 | З. Энхболд | Хууль зүйн яам | | Онлайн |
| 119 | Энхмэнд | Дундговь аймаг | ГХБХБГ | Онлайн |
| 120 | Акацүка | ЖАЙКА-н төв байгууллага | | Онлайн |
| 121 | М. Эрдэнэбаяр | НҮБ, Хөгжлийн хөтөлбөр | Зөвлөх | Онлайн |
| 122 | Даваацэрэн | | | Онлайн |
| 123 | Цэвэлмаа | | | Онлайн |
| 124 | Түвшинбаяр Жамьянхорлоо | | | Онлайн |
| 125 | Алтансувд Сэнгэдорж | Удирдлагын академи | | Онлайн |
| 126 | Э.Соёлмаа | | | Онлайн |
| 127 | Мягмарсүрэн | | | Онлайн |
| 128 | Д.Мөнх-Од | ЗГХЭГ | | Онлайн |
| 129 | Ариунтуул Нацаг | Удирдлагын академи | | Онлайн |
| 130 | Б. Нацагсүрэн | | | Онлайн |
| 131 | Г.Дулмаа | Удирдлагын академи | | Онлайн |
| 132 | Тогтох | ҮХГ | Зөвлөх | Онлайн |
| 133 | Ганзориг | Булган аймаг | ГХБХБГ | Онлайн |
| 134 | Шүрэнчимэг | Удирдлагын академи | | Онлайн |
| 135 | Амада | ЖАЙКА-н төв байгууллага | Дэд бүтцийн менежментийн газрын захирал | Онлайн |
| 136 | Г.Энх-Амгалан | ХААИС | | Онлайн |
| 137 | Мөнхзолбоо Пүрэв | | | Онлайн |
| 138 | Ядмаа Чойжамц | | | Онлайн |
| 139 | Дулмаа Ганболд | | | Онлайн |
| 140 | Үжин | | Япон улсаас | Онлайн |
| 141 | З.Амарзаяа | | | Онлайн |
| 142 | Цэгий | БХТ | | Онлайн |
| 143 | Хандаа Тошиюүки | | Япон улсаас | Онлайн |
| 144 | Чинбаяр | ГЗБГЗЗГ | | Онлайн |
| 145 | Эрдэнэбат | | | Онлайн |

| No. | Нэр | Байгууллага | Албан тушаал | Оролцсон байдал |
|---|---|---|---|---|
| | Батболд | | | |

Хавсралт C: ижитал шилжилтийн шинэ чиг хандлага сэдэвт семинар

**Дижитал шилжилтийн шинэ чиг хандлага сэдэвт семинар**

1. Үндэслэл

Монгол Улс нь төрөөс үзүүлж буй дижитал үйлчилгээ, мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн хувьд бусад хөгжиж буй улс орнуудтай харьцуулахад давуу байдалтай байна. Монгол Улсын нийт ажиллагсадын 1.1% нь МХХТ-ийн салбарт ажиллаж байгаа хэдий ч мэдээлэл технологийн чиглэлээр суралцаж буй оюутны тоо тогтмол өсөж байгаагаас харахад хүний нөөцийн нийлүүлэлт хангалттай байхаар байна. Гэвч МХХТ-ийн салбарыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих тогтолцоо хангалтгүй байна.

ҮХЦТ-ний хүрээнд дижитал шилжилт, МХХТ-ийн салбарт холбогдох байгууллагуудын үзүүлж буй дижитал үйлчилгээ, дижитал үйлдвэрлэл болон зарим салбарт мэдээллийн технологи, МХХТ-ийг нэвтрүүлэх боломжийн талаар судалсан. Түүнчлэн МХХТ-ийн салбарын хүний нөөц, институцийн асуудлуудыг авч үзсэн.

ЖАЙКА-гийн төслийн баг нь дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилгоор холбогдох байгууллагууд, төслийн баг болон МХХТ-ийн салбарын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор семинар зохион байгуулахаар төлөвлөж байна. Тус семинарт дэвшилтэт технологи нэвтрүүлэхээр зорьж буй болон сонирхож буй төрийн байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг урьж оролцуулна.

2. Семинарын зорилго

ҮХЦТ-ний хүрээнд санал болгосон салбаруудад дэвшилтэт технологи нэвтрүүлснээр Монгол Улсын хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулна. ҮХЦТ-ний Дижитал шилжилт, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын тайланд тухайн салбарт мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, ашиглах талаар жишээгээр тайлбарласан хэдий ч хөгжлийн асуудлыг илүү өргөн хүрээнд шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх шаардлагатай байна.

Тиймээс ЖАЙКА-гийн төслийн баг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх боломжийн талаар хэлэлцэх зорилгоор 2021 оны 11дүгээр сард семинар зохион байгуулна. Семинар нь Монгол Улсын МТ/МХХТ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудаас бизнесийн шинэ санаа, санал авах, хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэх, зарим төслүүдийг хэрэгжүүлэх зорилготой.

Дээр дурдсанаар 1) Монгол Улсын хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах 2) МХХТ-ийн салбарт хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх юм.

3. Семинар зохион байгуулах хугацаа

2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр (Пүрэв). *Семинарыг хоёр хэсэгтэйгээр

зохион байгуулна.

- Үдээс өмнөх семинар (10:00-12:00, Монголын цагаар): Монголын ААНБ-уудад зориулсан;
- Үдээс хойших семинар (15:00-17:00, Японы цагаар): Японы ААНБ-уудад зориулсан.

4. Монголын ААНБ-уудад зориулсан МХХТ-ийн семинарын зохион байгуулалт (үдээс өмнөх семинар)

- Семинарын нэр: Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний МХХТ, дижитал шилжилттэй холбоотой төлөвлөлтийг танилцуулах семинар – Дижитал шилжилтийн шинэ чиг хандлага –
- Зохион байгуулагч: Монгол Улсын Засгийн газар (ҮХГ, БХБЯ, ХХМТГ) болон ЖАЙКА
- Семинарыг зохион байгуулах газар: цахимаар (Zoom)
- Хэл: Япон, Монгол хэл дээр синхрон орчуулгатай явагдана.
- Зорилго:

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнд тусгасан МХХТ-ийн салбарын төлөвлөлт болон судалгааны үр дүнд үндэслэн МХХТ, дижитал шилжилтийг Монгол Улсын хөгжлийн хөтөлбөрт тусгах, салбаруудын үйл ажиллагаанд, нэвтрүүлэх, ашиглахад түлхэц үзүүлэх

- Оролцогчид: Монголын тэргүүлэх ААН-үүд, ЖДҮ эрхлэгчид, гарааны бизнес эрхлэгчид г.м.
- Оролцогчдод урилга тараах: ҮХГ, БХБЯ, ХХМТГ, МҮХАҮТ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж тараана.
- Хөтөлбөр (10:00-12:00, Монголын цагаар)

(1) 10:00-10:05 Семинарын нээлт, ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Э.Тамүра
(2) 10:05-10:20 Семинарын нээлт, Монгол Улсын Засгийн газар (ҮХГ, БХБЯ, ХХМТГ)
(3) 10:20-10:25 "Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө болон МХХТ-ийн салбарын төлөвлөлт" илтгэл, ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч Ц.Хашимото (5 минут)
(4) 10:25-10:35 "Монгол Улсын МХХТ, дижитал шилжилтийн салбарын судалгааны үр дүн" илтгэл, ЖАЙКА-гийн Төслийн багийн дэд ахлагч Ё.Кавамүра (10 минут)
(5) 10:35-11:05 "Хувийн хэвшлийн үйл ажиллагаа дахь дижитал шилжилтийн шинэ чиг хандлага" илтгэл (урьдчилсан байдлаар), IBM Japan компанийн гүйцэтгэх захирал н.Никами (30 минут)
(6) 11:05-11:35 "Руандагийн Засгийн газрын үндэстнийг сурталчлах зорилго бүхий дижитал шилжилт" илтгэл (урьдчилсан байдлаар), Кообэгийн Мэдээлэл зүйн дээд сургуулийн профессор н.Яманака (30 минут)
(7) 11:35-12:00 Асуулт, хариулт

5. Японы ААНБ-уудад зориулсан МХХТ-ийн семинарын зохион байгуулалт

- Семинарын нэр (урьдчилсан байдлаар): Монгол Улсын мэдээллийн технологи, гарааны бизнесийн салбарт зориулсан бизнесийн семинар
- Зохион байгуулагч: ЖАЙКА

- <u>Семинарыг зохион байгуулах газар</u>: цахимаар (Zoom)
- <u>Зорилго</u>: Монгол Улсад бизнесээ өргөжүүлсэн Японы мэдээлэл технологийн компаниудын Монголын зах зээлд нэвтэрсэн бизнесүүдийн жишээ, Монгол дахь мэдээлэл технологийн компаниуд, гарааны бизнесүүдийн талаар танилцуулах
- <u>Оролцогчид</u>: Монгол Улсын мэдээллийн технологийн салбарт нэвтрэх сонирхолтой Японы тэргүүлэх ААН-үүд, ЖДҮ эрхлэгчид, гарааны бизнес эрхлэгчид г.м.
- <u>Оролцогчдод урилга тараах</u>: ЖАЙКА (холбогдох агентлаг, байгууллагууд, JETRO, Жижиг, дунд үйлдвэр, бүс нутгийн инновацийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Unread г.м. оролцуулан)
- <u>Хөтөлбөр</u> (15:00-17:00, Японы цагаар)

(1) 15:00-15:05 Семинарын нээлт, ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Э.Тамүра

(2) 15:05-15:10 "Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө болон МХХТ-ийн салбарын төлөвлөлт" илтгэл, ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч Ц.Хашимото (5 минут)

(3) 15:10-15:20 "Монгол Улсын МХХТ, дижитал шилжилтийн салбарын судалгааны үр дүн" илтгэл, ЖАЙКА-гийн Төслийн багийн дэд ахлагч Ё.Кавамүра (10 минут)

(4) 15:20-15:30 "Мэдээлэл технологи, гарааны бизнесээр дамжуулж улс үндэстнийг сурталчлах үйл ажиллагааны тойм" илтгэл, ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дэд бүтэц, хувийн хэвшлийн салбар хариуцсан төлөөлөгч Т.Койзүми (10 минут)

(5) 15:30-15:45 "Цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia систем", ХХМТГ (15 минут)

(6) 15:45-16:00 "Мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал болон хэтийн төлөв" илтгэл (Урьдчилсан байдлаар)

(7) 16:00-16:15 "Монгол Улсад бизнесээ өргөжүүлж буй мэдээллийн технологийн компаниудын кейс судалгааны танилцуулга" илтгэл, Dentsu Data Artist Mongol.

(8) 16:15-16:25 "Монгол Улс дахь гарааны бизнесүүдийн амжилтын түүх болон гарааны бизнесийн экосисмемийн танилцуулга" илтгэл, (Урьдчилсан байдлаар)

(9) 16:25-17:00 Асуулт, хариулт

<u>Хавсралт D: Сурталчилгааны видео танилцуулга хийх ажлын удирдамж</u>

**Сурталчилгааны видео танилцуулга хийх ажлын удирдамж**

1. Удиртгал

Улаанбаатар хотын эдийн засаг болон хүн амын хэт төвлөрөл нь агаар, усны бохирдол, замын түгжрэл зэрэг тулгамдсан асуудлуудыг үүсгэж байгаа бөгөөп хот болон хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдалд хүргэсэн. Хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны тэнцвэргүй хуваарилалтаас үүдсэн эдгээр болон бусад асуудлыг шийдвэрлэхийн тулд Монгол Улсын хэмжээнд хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах шаардлага тулгарсан.

Тиймээс Монгол Улсын Засгийн газраас Япон улсын Засгийн газарт хандан Япон улсын туршлагыг ашиглан хот, хөдөөгийн илүү тэнцвэртэй, хүртээмжтэй хөгжлийг дэмжих Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулахад туслалцаа үзүүлэх хүсэлт тавьсан. ЖАЙКА-гийн Төслийн баг нь Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын хооронд төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулсны дараа 2019 оны 1 дүгээр сараас төслийн үйл ажиллагааг эхлүүлсэн.

2021 оны 7 дугаар сарын байдлаар ҮХЦТ-г эцэслэн боловсруулж байгаа тул төслийн үр дүнг төрийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэд зэрэг бүх оролцогч талуудад сурталчлан таниулах шаардлагатай байна. Тиймээс видео танилцуулга нь ҮХЦТ-г сурталчлан таниулах хэрэгсэл болно гэж үзэж байна.

2. Зорилго

Ажлын удирдамжид тусгасан зорилтуудыг доор дурдав. Үүнд:

3) ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг үр дүнтэй, сонирхолтой байдлаар видеогоор үзүүлэх
4) ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй төслүүдийн хэрэгжилтийг дэмжих.

3. Ажлын төлөвлөгөө

Ажлын төлөвлөгөөг урьдчилсан байдлаар доор үзүүлэв. Үүнд:

| | |
|---|---|
| 2021 оны 8-р сарын эхээр: | Гэрээ байгуулах |
| 2021 оны 8 сарын 20: | Ажлын явцын талаарх дунд хугацааны тайлан |
| 2021 оны 9-р сарын 3: | Төслийн семинарын үеэр үзүүлэх богино хэмжээний видео танилцуулга бэлдэх |
| 2021 оны 10-р сарын 6: | Бүрэн хэмжээний видео танилцуулгыг бэлдэж, хүлээлгэн өгөх |
| 2021 оны 10-р сарын 20: | Видео танилцуулгыг эцэслэн боловсруулж, хүлээлгэн өгөх |

4. Видео танилцуулгыг бэлдэх үйл ажиллагаа

ЖАЙКА-гийн Төслийн багийн ҮХЦТ боловсруулах төслийн хүрээнд боловсруулсан тайлан, тоо баримт, гэрэл зураг зэрэг олон материал байгаа бөгөөд видео танилцуулга бэлдэхээр шалгарсан компанид гэрээ байгуулсны дараа тэдгээрийг хүлээлгэж өгнө.

Тус компани нь дээр дурдсан материалуудыг ашиглахаас гадна төслийн хамтран ажиллагч байгууллагуудын төлөөллөөс ярилцлага авах зэргээр нэмэлт материал бэлтгэн, холбогдох үзэгдэлд зориулж зураг, дүрслэл, анимейшн хийж сурталчилгааны видео танилцуулгыг боловсруулна.

9 дүгээр сарын дундуур зохион байгуулахаар төлөвлөж буй ҮХЦТ-ний семинарын үеэр үзүүлэх богино хэмжээний видео танилцуулгыг бэлдэж ирүүлнэ. Семинарын оролцогчдын санал болон семинарын үйл ажиллагааг нэмж тусган, сайжруулж бүрэн хэмжээний видео танилцуулгыг эцэслэн боовсруулна. Видео танилцуулгын шинэчилсэн хувилбарыг ЖАЙКА-гийн Төслийн багт хянуулахаар ирүүлэх бөгөөд ЖАЙКА-гийн Төслийн баг хүлээн зөвшөөрсний дараа видео танилцуулгын эцсийн хувилбарыг хүлээлгэж өгнө.

Видео танилцуулгыг Монгол хэлээр, англи, япон хэлний хадмал орчуулгатайгаар

бэлдэнэ (нийт 3 төрлийн видео танилцуулга байна. Үүнд: 1. Зөвхөн Монгол хэлээр 2. Монгол хэлээр, англи хэлний хадмал орчуулгатай 3. Монгол хэлээр, япон хэлний хадмал орчуулгатай). ЖАЙКА-гийн Төслийн баг япон хэлний хадмал орчуулгыг бэлдэхэд тусална. Текст унших, хөгжим зэргийг тухайн компани хариуцна. Видео танилцуулгын агуулгын төслийг доор хүснэгтэд үзүүлэв. Видео танилцуулга боловсруулах компани болон ЖАЙКА-гийн Төслийн баг харилцан зөвшилцөж, видеоны агуулгыг өөрчилж болно.

**Видео танилцуулгын агуулга (төсөл)**

| | Агуулга | Сэдэв | Ашиглах материал | Хугацаа (min.) |
|---|---|---|---|---|
| 1 | Танилцуулга | Монгол Улсын тухай танилцуулга: өнгөрсөн үеэс өнөөг хүртэл | Видео эсвэл архивын материал | 1.0 |
| 2 | Ярилцлага | Видео ярилцлага:<br>ЗГХЭГ, БХБ-ын сайд, ҮХГ-ын дарга<br>a. Монгол Улсын онцлог (орчин үеийн);<br>b. Бодлого, төлөвлөлт: Алсын хараа 2050<br>c. ЖАЙКА-гийн хамтын ажиллагаа | Ярилцлага авах | 1.0 |
| 3 | ҮХЦТ боловсруулах төсөл | Хэлэлцүүлгийн тэмдэглэл; ҮХЦТ-ний танилцуулга<br>Зорилго, төслийн хэрэгжилтийн зохион байгуулалт | ҮХЦТ-ний материал (1) | 0.5 |
| 4 | Одоогийн байдал | Монгол Улсын байгаль орчин, нийгэм, эдийн засгийн байдлын талаарх танилцуулгыг видео, графикаар үзүүлэх | ҮХЦТ-ний материал (2)<br>Видео, график | 0.5 |
| 5 | Олон нийтийн оролцоо | Олон нийтийн оролцоо бүхий Оролцогч талуудын нэгдсэн хурал (ОТНХ), Залуучуудын төлөөллийг оролцуулсан ОТНХ<br>Аймгуудад зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, семинарууд; | ҮХЦТ-ний материал (3)<br>Аймгийн хэлэлцүүлэг, семинарын видео/фото зургууд | 1.0 |
| 6 | Хөгжлийн алсын хараа | Монгол Улсын байр суурь; үнэт зүйл<br>Хөгжлийн алсын хараа | ҮХЦТ-ний материал (4) | 1.0 |
| 7 | Хөгжлийн хувилбарууд | Хөгжлийн 4 хувилбарын тодорхойлолт, харьцуулалт | ҮХЦТ-ний материал (5) | 2.0 |
| 8 | Орон зайн төлөвлөлт | Хотын зэрэглэл; зам, тээврийн гол сүлжээ; газар зохион байгуулалтын төлөвлөгөө | ҮХЦТ-ний материал (6) | 1.0 |
| 9 | Санал болгож буй төсөл, хөтөлбөрүүд | Төсөл, хөтөлбөрүүдийн ангилал<br>Гол төсөл, хөтөлбөрүүд | ҮХЦТ-ний материал (7) | 2.0 |
| 10 | Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөр | Эдийн засг йн бүсчлэл<br>Санал болгож буй 6 бүсийн Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрүүд | ҮХЦТ-ний материал (8) | 2.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Визуал танилцуулга + видео<br>Хөрөнгө оруулалт:<br>a. Мал аж ахуйн үйлдвэрийн кластер; b. Нүүрсэд түшиглэсэн үйлдвэрийн кластер; c. МХХТ-ийн төслүүд | ҮХЦТ-ний материал (9) Видео/фото зураг г.м | 2.0 |
| 12 | Төгсгөл | Зураг | Видео, график | Нийт 15 мин орчим |

* ЖАЙКА-гийн Төслийн баг нь видео танилцуулга боловсруулах компанид ҮХЦТ-тэй холбоотой (1) - (9) материалыг өгнө.

* ЖАЙКА-гийн Төслийн баг нь хамтран ажиллагч байгууллагуудтай хэлэлцсэний үндсэн дээр видеоны агуулгыг өөрчилж болно.

5. Холбогдох материал

ЖАЙКА-гийн Төслийн баг өмнө нь ҮХЦТ-ний талаар видео танилцуулга боловсруулсан. Энэхүү видео танилцуулгыг үзэх боломжтой. ЖАЙКА-гийн Төслийн баг мөн өөр улс оронд хэрэгжүүлсэн төслийн видео танилцуулгын материалыг өгнө.

Доорх линкээр орж үзнэ үү.

 ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан өмнөх видео танилцуулга: https://www.youtube.com/watch?v=vYIzaxjBFYo

 Филиппины төслийн видео танилцуулга: https://www.youtube.com/watch?v=IONXpkZy3xU

 Мавританийн видео танилцуулга: https://www.youtube.com/watch?v=auTtybekoLw

# Бүлэг 7 Дүгнэлт

## 7.1 Төслийг хэрэгжүүлсэн хугацаа болон хөгжлийн шинэ загвар руу шилжих хэрэгцээ, шаардлага

2018 оны 8-р сарын 22-нд Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА-гийн төлөөлөл Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах техникийн хамтын ажиллагааны төслийн Хэлэлцүүлгийн тэмдэглэлд гарын үсэг зурсан. 2019 оны 1 дүгээр сарын 9-нөөс ЖАЙКА-гийн Төслийн баг Монгол Улсад томилолтоор ажиллаж, төслийн үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд түүнээс хойш Монголын талын хамтран ажиллагч байгууллагуудтай хамтран ажилласаар байна. 2020 оны 3 дугаар сараас COVID-19 цар тахлын улмаас Монгол Улсад томилолтоор ажиллахыг түр зогсоосон бөгөөд ЖАЙКА-гийн Төслийн баг болон Монголын талын хамтран ажиллагч байгууллагууд нь цахим уулзалт хийх, имэйлээр харилцах зэргээр үргэлжлүүлэн хамтран ажиллаж, гадаадын зөвлөхүүдийн зөвлөгөөний дагуу төслийн Монгол мэргэжилтнүүд нэмэлт мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн. ЖАЙКА болон БХБЯ, ҮХГ тохиролцсоны дагуу ҮХЦТ боловсруулах төслийн хэрэгжилтийг 2021 оны 7 дугаар сараас 12 дугаар сарыг дуустал сунгасан. COVID-19 цар тахлын нөхцөл байдлыг үл харгалзан ЖАЙКА-гийн Төслийн багийн гишүүд 10 дугаар сарын 10-наас 29-ний хооронд Монгол Улсад сүүлчийн томилолтоор ажилласан.

Сүүлийн 3 жилийн хугацаанд дэлхий даяар хөгжлийн тухай ойлголт эрс өөрчлөгдсөн. Ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт нэмэгдсэнтэй холбоотойгоор амьдралын хэв маяг, нийгэм, эдийн засгийн бүтцэд зарчмын өөрчлөлт хийх шаардлагатай байгааг өнгөрсөн онд нийтээрээ хүлээн зөвшөөрсөн. COVID-19 цар тахал нь амьдралын хэв маяг, нийгэм, эдийн засгийн бүтцийг өөрчлөх шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрөхөд нэмэлт хүчин зүйл болсон. Энэ нь хүн төрөлхтөн, эх дэлхийгээ аврахын тулд хөгжлийн загварыг өөрчлөх зайлшгүй шаардлагатайг илэрхийлж байна.

## 7.2 ҮХЦТ-ний хүрээнд хөгжлийн шинэ загвар руу шилжих нь

3 жилийн өмнө Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулж эхлэх үед Монгол Улсын тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг хангахын тулд хөгжлийн шинэ загвараар хөгжих шаардлагатайг тодорхойлсон. Монгол Улс 1990 оноос өмнө социалист орон байсан бол түүнээс хойш зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжсэн. Хамгийн чухал нь Монгол Улс НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан хөгжлийн шинэ загвар руу шилжих шилжилтийг эхлүүлсэн. 2010 оны үед уул уурхайн салбараас хамаарсан эдийн засгийн өндөр өсөлтийг тогтвортой хадгалах боломжгүй, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа нэмэгдсэн тул энэ нь зүй ёсны үйл явц юм.

Монгол Улс НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан хөгжлийн шинэ загвар руу шилжиж буй нь сайшаалтай. Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хөгжлийн ямар загвараар хөгжихийг тодорхой заагаагүй. Мөн Тогтвортой хөгжлийн зорилтуудад заасан зарим зорилтууд нь хоорондоо зөрчилддөг. Тиймээс Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулах явцад хоорондоо

уялдаа холбоо бүхий зорилтуудтай хөгжлийн загварыг хэрхэн томьёолох талаарх асуудалтай тулгарсан. Энэхүү хөгжлийн загвар нь нэг талаас Монгол Улсын геополитикийн байршил болон заяагдмал нөөц баялагт тулгуурласан нөгөө талаас Монголын ард түмний уламжлалт соёл, үнэт зүйлд суурилсан Монгол Улсын өвөрмөц онцлогийг хадгалсан байх шаардлагатай. Энэхүү шаардлагад нийцүүлэн ҮХЦТ-г боловсруулах сорилттой тулгарсан.

Дэлхий даяар нүүрснээс эрчим хүч үйлдвэрлэж, ашиглахыг хүчтэй эсэргүүцэж байгаа хэдий ч Монгол Улс нь эрчим хүчний импортын хараат байдлыг бууруулах, нүүрс экспортолж гадаад валютын орлого олох, эрчим хүчний хэрэглээгээ нүүрсэд түшиглэсэн дотоодын эх үүсвэрээр хангах тулд нүүрсийг үргэлжлүүлэн олборлох шаардлагатай байна. Нийгэм, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, орон зайн хөгжилд тулгуурлан хөгжлийн шинэ загвар руу шилжих нь бодит сорилт бөгөөд богино болон дунд хугацаанд нүүрс, уул уурхайн салбарт түшиглэн бүтцийн өөрчлөлтөд шаардлагатай хөрөнгийн хуримтлалыг бий болгох шаардлагатай.

## 7.3 ҮХЦТ ба хөгжлийн шинэ загвар руу шилжихтэй холбоотой сорилт

### (1) Дэд бүтцийн мега төслүүдийг тусгаагүй

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг энэхүү сорилтыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахаар боловсруулсан бөгөөд төлөвлөлт, саналыг тусгасан. Тухайлбал ҮХЦТ-ний хүрээнд цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах зорилгоор нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцыг шинээр барьж байгуулахаар санал болгоогүй бөгөөд цахилгаан дамжуулах шугамыг өргөтгөхөөр тусгасан. Харин ҮХЦТ-ний хүрээнд зарим бүс нутгийн нар, салхи, ус, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний нөөцөд түшиглэн бүс нутгийн сэргээгдэх эрчим хүчний систем байгуулахыг санал болгосон. Мөн цэвэр эрчим хүчний судалгаа, хөгжүүлэлт хийхийг зөвлөж байна.Түүнчлэн ҮХЦТ-нд нүүрс болон бусад уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх шинэ төмөр замын бүтээн байгуулалт зэрэг дэд бүтцийн мега төслүүдийг тусгаагүй болно. Энэ нь дэд бүтцийн мега төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагагүй гэсэн үг биш бөгөөд энэ төрлийн төслүүдийг нарийн төлөвлөж, үе шаттайгаар уялдуулж хэрэгжүүлэх шаардлагатай..

### (2) Аж үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлэх

ҮХЦТ-ний хүрээнд уул уурхай, мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэлд суурилсан төрөл бүрийн аж үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлэх стратегийг баримтална. Өөрөөр хэлбэл дотоодын болон экспортын хязгаарлагдмал зах зээлд анхдагч бүтээгдэхүүн нийлүүлэхээс илүүтэй энгийн болон нэмүү өртөг шингэсэн боловсруулалт хийж, төрөл бүрийн бүтээгдэхүүн түүний дотор өндөр үнэтэй экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийн кластеруудыг байгуулах хэрэгтэй. Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийн кластеруудыг байгуулснаар Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд нэмүү өртгийн сүлжээ бий болно. Энэ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлээд зогсохгүй Монгол Улс экспортын бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах, борлуулах талаар идэвх, санаачилгатай ажиллах боломжийг олгоно.

### (3) Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх нь

Аж үйлдвэрийн кластерууд, анхан шатны үйлдвэрлэлийн бүсүүд, анхан шатны боловсруулалт хийх орон нутгийн хотууд, нэмүү өртөг шингэсэн боловсруулалт хийх бүсийн хөгжлийн төв хотууд, хэрэглэгчид болон экспортын баазыг тээвэр, логистик, харилцаа холбооны сүлжээнд үр дүнтэйгээр холбох шаардлагатай. Энэхүү зорилгоор ҮХЦТ-ний хүрээнд нийт 21 аймгийг өөр хооронд нь болон Улаанбаатар хоттой зардлын хувьд үр ашигтайгаар холбож, Монгол Улсын хэмжээнд орон зайн төлөвлөлтийг оновчтой болгох саналыг дэвшүүлсэн. Тээвэр, логистик, харилцаа холбооны сүлжээнд үр дүнтэйгээр холбогдсон аж үйлдвэрийн кластеруудын хөгжил нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, бүс нутгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.

Санал болгож буй тойрог коридор нь үүнд чухал үүрэг гүйцэтгэнэ. Уг коридор нь ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй хотын зэрэглэлийн ангиллын хувьд дээгүүр эрэмбэлэгдсэн хотуудыг хооронд нь холбож, ОХУ, БНХАУ-тай хөрш зэргэлдээ орших аймгуудаас бүтээгдэхүүнээ тэдгээр улсын экспортын зах зээл рүү шууд гаргах болон зам, тээврийн гол сүлжээгээр дамжуулан олон улсын зах зээлд шууд бусаар нэвтрэх боломжийг сайжруулна. Бүс нутгийн орон зайн хөгжлийг оновчтой болгох өөр арга зам нь хотын зэрэглэлийн дагуу эрэмбэлэгдсэн зарим хотуудын чиг үүргийг сайжрулах явдал юм. Эдгээр хотууд нь төрийн үйлчилгээг хэд хэдэн аймгуудыг хамран хүргэнэ.

### (4) МХХТ-ийг нэвтрүүлж, ашиглах нь

ҮХЦТ-ний хүрээнд эдийн засгийн хөгжлийг хангах,төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор бүхий л салбарт МХХТ-ийг ашиглахыг онцгойлон санал болгож байна. Ухаалаг хөдөө аж ахуйг дэмжих, хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэх, Мал аж ахуйн салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох систем нэвтрүүлэх, аялал жуулчлалын салбарын мэдээллийн сан байгуулах, эрүүл мэндийн мэдээллийн төв байгуулах зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхэр санал болгож байна.

ҮХЦТ-ний хүрээнд малчид, орон нутгийн иргэд болон орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагуудын харилцаа, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх Орон нутгийн мэдээллийн платформ байгуулах, хөдөө орон нутгийн сургуульд хамрагдаагүй, завсардсан хүүхдүүд болон дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдад зайны сургалт явуулах боломжийг турших Зайны сургалтын туршилт, МХХТ-ийн салбарт хувийн хэвшил болон их, дээд сургуулиудын хамтын ажиллагаа бий болгох Хувийн хэвшил болон их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг туршилтын төслүүдийг хэрэгжүүлсэн. Мөн Монгол Улсын МХХТ-ийн экосистемийг сайжруулах зорилгоор МХХТ-ийн хэрэглээ болон түүнийг дэмжих тусгай хөтөлбөрийг санал болгосон.

ҮХЦТ-ний хүрээнд онцолсон аж үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлэх, орон зайн төлөвлөлтийг оновчтой болгох, МХХТ-ийг нэвтрүүлэх үйл ажиллагааг мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластераар жишээ болгон Зураг 7.1.1-д үзүүлэв. Түүнчлэн малын бэлчээр, анхан шатны боловсруулалт хийх орон нутгийн хотууд, нэмүү өртөг шингэсэн боловсруулалт хийх бүсийн хөгжлийн төв хотууд, экспортын баазыг тээвэр, логистик, харилцаа холбооны сүлжээнд үр дүнтэйгээр холбохоос гадна цахим гүйлгээнд ашиглах төхөөрөмж, хэрэгсэл бүхий цахим гүйлгээний системийг үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай.

**Зураг 7.3.1 Тээвэр, логистик, харилцаа холбооны сүлжээнд үр дүнтэйгээр холбосон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластер**

